

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН *Албан хэрэгцээнд*
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗАР



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ



Улаанбаатар хот
2022 он

Хянасан:

ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга,
цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар

Эмхтгэсэн:

ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын
дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч,
цагдаагийн хурандаа М.Азжаргал

ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын
дотоод аудит хариуцсан ахлах байцаагч,
цагдаагийн хурандаа Б.Намгинжав

ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын
дотоод аудит хариуцсан ахлах байцаагч,
цагдаагийн хошууч Ё.Мөнхзул

ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын
дотоод аудит хариуцсан ахлах байцаагч,
цагдаагийн ахмад Э.Анхчимэг

Эхийг бэлтгэсэн:

ЦЕГ-ын Хэвлэл, мэдээллийн төвийн
Мэдээлэл бэлтгэх, Хэвлэх хэсгийн эх бэлтгэгч,
цагдаагийн ахмад Х.Бат-Энэрэлт

Д/д	Гарчиг	Хуудас
1	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын хэрэгжилтэд хийх дотоод аудит	7
2	“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.9-д заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа Эрүүлжүүлэх, саатуулах төвийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит	17
3	Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дэх зөвлөл, комисс, хороо, баг, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит	28
4	“Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд хийх дотоод аудит.	45
5	Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит	51
6	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдалд хийх дотоод аудит	56
7	ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН /2021 оны 2 дугаар улирлын байдлаар/	64
8	“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны автомашины ашиглалтад хийсэн дотоод аудит.	72
9	Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтэд хийх дотоод аудит.	81
10	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлт	90
11	ЦЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу болон ЦЕГ-ын удирдлагаас өгсөн чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн аудит, түүний мөрөөр харьяа алба, анги, байгууллага, нэгжид хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт, үр дүнг тооцон танилцуулга	95

- | | | |
|----|--|-----|
| 12 | Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага дахь “Шилэн дансны тухай” хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх дотоод аудит | 99 |
| 13 | “Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга байгууламжийн ашиглалт, насжилтын байдалд” дотоод аудит | 109 |
| 14 | Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Нарстай” дахь хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит | 123 |
| 15 | “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2021” арга хэмжээний хэрэгжилтэд хийх дотоод аудит | 129 |
| 16 | “Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалт, дадлагын төв”-ийн үйл ажиллагаанд дотоод аудит” | 133 |
| 17 | “Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдалд” хийсэн дотоод аудит” | 142 |
| 18 | “Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”-д хийсэн дотоод аудит | 154 |
| 19 | “Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”-д хийсэн дотоод аудит | 161 |
| 20 | Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит | 169 |
| 21 | Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд хийх гүйцэтгэлийн дотоод аудит. | 175 |
| 22 | Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудит | 181 |
| 23 | Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудит | 187 |

24	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдалд хийх дотоод аудит.	193
25	“Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдалд хийсэн дотоод аудит”	200
26	“Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь “Цагаан шонхор” амралтын газрын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит”	220
27	“Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит”	226
28	Аудитын зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тооцсон дүнгийн тухай	234
29	Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит”	236
30	“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын шалтгаан нөхцөлийн байдалд дүн шинжилгээ хийсэн талаар	243
31	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн нийцлийн аудит.	249
32	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2022 онд дотоод аудитын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан	256
33	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан	270
34	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээ	277
35	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2023 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээ	290

ӨМНӨТГӨЛ ҮГ

Улсын салбарт дотоод аудитыг нэвтрүүлж, хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 онд Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд дотоод аудитын нэгжийг шинээр байгуулж, алба хаагчдыг шаардлагатай сургалтад хамруулан мэргэшүүлсэн.

Дотоод аудит нь байгууллагын стратеги, зорилго, зорилтыг хэрэгжүүлэх явцад үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, оновчтой тодорхойлох, байгууллагын засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл явц, үр нөлөөг үнэлж, тэдгээрийг сайжруулахад удирдлагын багт дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн баталгаажуулах ба зөвлөх үйл ажиллагаа байдаг.

Өнгөрсөн хугацаанд тус нэгжээс гүйцэтгэлийн, нийцлийн, үйл ажиллагааны болон санхүүгийн чиглэлээр дотоод аудитыг үр дүнтэй хэрэгжүүлж, цагдаагийн байгууллагын удирдлагыг бодит мэдээллээр хангахын зэрэгцээ аудитын явцад илэрсэн эрсдэл бүхий асуудал, зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмжийг тухай бүр холбогдох нэгжид хүргүүлж, биелэлт, үр дүнг тогтмол тооцон ажиллаж ирсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад дотоод аудитын тогтолцоог нэвтрүүлснээр байгууллага зорилго, зорилтдоо саадгүй хүрэх, ирээдүйн зорилго чиглэлээ оновчтой тодорхойлох, дотоод хяналтын үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ажлын бүтээмж, сэтгэл ханамж дээшлэх, үйлчилгээний чанарт ахиц гарах, байгууллагын засаглал сайжрах ач холбогдолтой.

Иймд Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас 2021, 2022 онд хэрэгжүүлсэн дотоод аудитын тайлангийн энэхүү эмхтгэлийг цахим хэлбэрээр гарган Та бүхэнд хүргүүлж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтан, алба хаагч бүр албан хэрэгцээнд зориулсан энэхүү эмхтгэлийг уншиж судлан мэдээлэл, сургамж авах, аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сайн үйлс бүхэн дэлгэрч, сайн засаглал бэхжих болтугай.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

ДОТООД АУДИТЫН УРЬДЧИЛСАН ТАЙЛАН

2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/НА-2020/11

Аудитын хугацаа: 2020.10.07- 2020.11.25

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Д.Борхүү

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг сурталчлахтай холбогдсон харилцаа нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн 5.1-д “Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.1, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлого” баримт бичиг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-аар тус тус зохицуулагдаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6.1-д “...үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв, санхүүгийн болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн төрөлтэй байна”,

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын 135.4.1-д “...үйл ажиллагааны, хүний нөөцийн, шилэн дансны ил тод байдал гэсэн төрөлтэй байна” гэж тодорхойлсон.

Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлого” баримт бичгийн хэрэгжилтийг хангах, иргэдийн оролцооны бодитой, тэгш боломжийг бүрдүүлэх, төрийн үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрх, байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийг ханган баталгаажуулах зорилгоор Цагдаагийн төв байгууллагын албан ёсны www.police.gov.mn сайтыг ажиллуулж иржээ.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах үйл ажиллагаанд Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс 2017, 2018, 2019 онд хяналт шинжилгээ хийж, 100 хувийн биелэлттэй дүгнэж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнасан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын хэрэгжилтэд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг баталгаажсан мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход чиглэгдэнэ.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын хэрэгжилтийн байдалд сүүлийн 3 жилийн байдлаар хяналт тавьсан үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

Харин Шилэн дансны тухай хуулийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2-т заасны дагуу улирал бүр шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгдэж, дүнг Хууль зүй, дотоод хэргийн болон Сангийн яаманд хүргүүлж байгаа тул аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ аудит хийгдэх нэгжүүдийн удирдлага, алба хаагчидтай хийх уулзалт ярилцлагын удирдамж, аудитын хүрээнд шалгах мэдээлэл, түүнийг нотлох аргыг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж мөрдсөн.

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, алба хаагчдад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын хэрэгжилтийн байдалд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаанд удирдлага болгох эрх зүйн актууд, алба хаагчдын ажил үүргийн хуваарь, үйл ажиллагааны дэс дараалал, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, түүнд тавих хяналт, удирдлагын талаарх мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, алба хаагчдын ажил, үүргийн гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, Цагдаагийн төв байгууллагын албан ёсны [www. police.gov.mn](http://www.police.gov.mn) цахим хуудаст тавигдсан мэдээлэлтэй биечлэн танилцсан болно.

Аудитын явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг боловсруулж, түүнийг Санхүү аж ахуй алба, Мэдээллийн технологи, холбооны төв, Хэвлэл, мэдээллийн төв, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга нартай уулзаж танилцуулан, ярилцлага хийсэн.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ын 3.1-д “Байгууллага нь цахим хуудасны агуулга, бүтэц, хөгжүүлэлтэд тавигдах шаардлагыг тодорхойлсон MNS 6285:2011 Монгол Улсын стандартыг хангасан албан ёсны цахим хуудсыг үүсгэж, хуульд заасан мэдээллийг ойлгомжтой байдлаар байрлуулж, олон нийтэд түгээнэ”, 3.2-д “Байгууллага нь хуульд заасан мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд тухай бүр байрлуулах үүрэг хүлээнэ”, 3.8-д “Хуульд заасан мэдээллийг шинэчилсэн, өөрчилсөн тохиолдолд өмнөх мэдээллээ цахим хуудасны “архив” хэсэгт хадгалж, энэ тухай мэдээллийг байрлуулна” гэж заажээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 135.4.1-д “Мэдээллийн ил тод байдал нь а/үйл ажиллагааны; б/хүний нөөцийн; в/шилэн дансны талаарх гэсэн гурван төрөлтэй байна. Уг журмын 135.4.3-д “Энэ зүйлийн 135.4.1 дэх хэсгийн “а”-д заасан мэдээлэл /маягт: ЦБҮАЖ №135.41а/-ийг Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж, мөн хэсгийн “б”-д заасан мэдээлэл /маягт: ЦБҮАЖ №135.41б/-ийг Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж, мөн хэсгийн “в”-д заасан мэдээлэл / маягт: ЦБҮАЖ №135.41в/-ийг Санхүү, аж ахуйн алба тус тус хариуцаж цахим сайтад мэдээлэл оруулахаар тогтоосон байна.

Гэтэл Цагдаагийн төв байгууллагын албан ёсны www.police.gov.mn цахим сайтын нүүр хуудаст “Бидний тухай”, “Мэдээ”, “Хууль эрх

зүй”, “Тусгай зөвшөөрөл”, “Олон нийтийн цагдаа”, “Хүний нөөц”, “Шилэн данс” үндсэн цэсүүдэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой 81 мэдээ, мэдээллийг байршуулахаар журамласан боловч, үндсэн болон дэд цэсүүдэд мэдээлэл оруулах эрх бүхий алба хаагчид холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь оруулаагүй, шинэчлэн өөрчлөлт хийгээгүй, хуучирсан мэдээллийг архивлаагүй, мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, тодорхой байдлаар цахим сайтын бүтцэд байршуулаагүй байна.

Тухайлбал: Журмын 135.4.3-д зааснаар Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс 2018 онд “Бидний тухай” үндсэн цэсийн “Алсын хараа”, “Одоогийн бүтэц, бүрэлдэхүүн, удирдлагуудын товч намтар, ажлын туршлага, мөндчилгээ”, “Газар, нэгж”, “Хэлэлцүүлэг”, “Олон улсын гэрээ”, мөн “Сургалт” үндсэн цэсийн “Хууль, дүрэм, журам”, “Дотоод сургалт”, 2016 онд “Элсэлт сонгон шалгаруулалт”, “Гадаад сургалт”, 2015 онд “Сэрэмжлүүлэг”, “Спорт мэдээ”, “Соёл урлаг”, “11-11 төв”, “Монгол цагдаа 95”, “Хууль, дүрэм, журам”, “Зөвлөмж, арга зүйн зөвлөгөө”, “Зайны сургалт”, “Ажлын байран дахь сургалт”, 2014 онд “Тусгай зөвшөөрөл” үндсэн цэсийн “хөдөлгөөний аюулгүй байдал”, “Галт зэвсэг сум”, “Олон нийтийн цагдаа” үндсэн цэс, Хүний нөөц, сургалт хариуцсан нэгжүүдээс “Хүний нөөц” үндсэн цэсийн “Мэдээ, мэдээлэл” дэд цэсүүдэд мэдээлэл оруулсан байгаа боловч шинэчлээгүй байна.

Энэ нь цахим сайтад мэдээлэл оруулах, хянах чиг үүрэгтэй Төлөвлөлт, зохион байгуулалт болон Хүний нөөцийн хэлтэс, Санхүү, аж ахуйн албад нь өөрсдийн мэдээлэл оруулах чиг үүргээ зөвхөн тайлбар, мэдээлэл бэлтгэх чиг үүрэгтэй Хэвлэл, мэдээллийн төв, Сургалтын нэгдсэн төв, Бүртгэл хяналтын төв, Аюулгүй байдлын хэлтэс, Статистик мэдээллийн хэлтэс, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс болон харъяа алба, нэгжүүдэд шилжүүлснээр стандартын шаардлага, журмын хэрэгжилтийн талаарх дотоод хяналт суларч, доголдол үүссэн байна.

Иймд журмын хэрэгжилтийг хангахын тулд Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс нь байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг, Хүний нөөцийн хэлтэс нь хүний нөөцийн талаарх мэдээллийг, Санхүү, аж ахуйн алба нь шилэн дансны мэдээллийг бусад алба, нэгж буюу тайлбар, мэдээлэл бэлтгэгч нараас гаргуулан авч, хянан баталгаажуулж, цахим сайтад нийтэлж байх шаардлагатай байна.

3.2 Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлөөс 2016 онд баталсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага /MNS 6285:2016/-ын 4.1.15-т заасан “Вэбсайтын мэдээллийг нийтлэхээс өмнө хянасан байвал зохино”, 4.2.4-т “Хэрэглэгчидтэй харилцах агуулгатай байх /Өргөдөл, гомдол, санал файлаар болон онлайн авах, хариу өгөх, зөвлөгөө, ажлын зар/”, 4.3.6-д “Вэбсайт бусад программ, вэбсайтай мэдээлэл солилцох болон ижил техник, программны орчинд мэдээллээ

хуваалцах боломжтой байхыг шаардана. Хуваалцсан мэдээллийг хэрэглэгч хэрэглэх боломжтой байх хэрэгтэй”, 4.3.7-д “Вэбсайт шинэчлэн өөрчлөгдөх боломжтой байхыг шаардана. Шинэчлэн өөрчлөлтөд мэргэжлийн баг, хөгжүүлэгч вэбсайтад засвар хийх, сайжруулах, шинэчлэхийг хэлнэ”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /код 135/ журам”-ын 135.2.4-д “Цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн самбар дахь мэдээлэл нь утга, агуулгын хувьд хоёрдмол санаа агуулаагүй, хэрэглэгчдэд ойлгогдохуйц, нэг мөр томъёологдсон байна” гэж заасан.

Төрийн аливаа байгууллага нь үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдуулан өөрийн цахим хуудас дахь мэдээллийн сангаас хуульд заасан мэдээллийг иргэн, хуулийн этгээд саадгүй авах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байдаг.

Мэдээллийн ил тод байдлыг цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн самбар ашиглах, алба хаагч мэдээлэл өгөх байдлаар хангах бөгөөд байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн хэрэгслээр сурталчилж, олон нийтэд мэдээлж, танилцуулах арга замаар хэрэгжүүлдэг.

Цагдаагийн төв байгууллагын www.police.gov.mn цахим сайтыг ижил төстэй чиг үүрэг хэрэгжүүлдэг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Онцгой байдлын ерөнхий газар, Дотоод хэргийн Их сургууль, Оюуны өмчийн газар зэрэг нийт 15 төрийн байгууллагын цахим сайтын үйл ажиллагаатай харьцуулахад, Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлөөс 2016 онд баталсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага /MNS 6285:2016/-ын 4.1.15-т заасан “Вэбсайтын мэдээллийг нийтлэхээс өмнө хянасан байвал зохино”, 4.2.4-т “Хэрэглэгчидтэй харилцах агуулгатай байх”, 4.3.6-д “Вэбсайт бусад программ, вэбсайтта мэдээлэл солилцох болон ижил техник, программын орчинд мэдээллээ хуваалцах боломжтой байхыг шаардана. Хуваалцсан мэдээллийг хэрэглэгч хэрэглэх боломжтой байх хэрэгтэй”, 4.3.7-д “Вэбсайт шинэчлэн өөрчлөгдөх боломжтой байхыг шаардана. Шинэчлэн өөрчлөлтөд мэргэжлийн баг, хөгжүүлэгч вэбсайтад засвар хийх, сайжруулах, шинэчлэхийг хэлнэ”, 4.5-д “Хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулж аудио, видео хэлбэрээр мэдээллийг вэбсайтад тавьсан байхыг шаардана. Видео мэдээлэл нь текст тайлбар агуулсан байхыг шаардана. Аудио, видео хэлбэрийн мэдээлэл нь түгээмэл төрлийн форматаар бичигдсэн байхыг шаардана. Видео хэлбэрийн мэдээлэлд дохионы хэл агуулсан байх нь зүйтэй” гэсэн

шаардлагуудыг хангаагүй байна.

Энэ нь цагдаагийн байгууллагын хэмжээнд цахим сайтын мэдээллийг нийтлэхээс өмнө хянадаггүй, сайтын бүтэц, зохион байгуулалт, дэс дараалал ойлгомжгүй, хэрэглэгчидтэй харилцах агуулга тодорхой бус / Өргөдөл, гомдол, санал файлаар болон онлайн хэлбэрээр авах, хариу өгөх, зөвлөгөө, ажлын зар, иргэдэд үзүүлэх үйлчилгээний төрлүүдийг нүүр хуудсанд байрлуулах, ойлгомжтой, хурдан шуурхай нэвтрэх боломжийг бүрдүүлэх/, вэб сайтыг хөгжүүлэх, сайжруулалт хийх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан албан тушаалтан байхгүй байгаагаас шалтгаалсан гэж үзэхээр байна.

Тухайлбал: цахим сайтын “Түргэн холбоос” хэсэгт цагдаагийн алба хаагчтай холбоотой мэдээлэл авах 126 дугаарын утас гэж бичигдэх текстийг “Цагдаагийн ерөнхий газартай холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах утасны дугаар” гэж утга, найруулгын хувьд алдаатай оруулсан, тавигдсан зарим мэдээлэл нь утга найруулга, агуулга, зөв бичих дүрмийн хувьд алдаатай, логикийн хувьд дэс дараалал, уялдаа холбоогүй, үндсэн вэбсайтаас гадна бүх нэгжүүд өөрсдийн цахим хуудас үүсгэсэн, оруулсан мэдээлэлд нь байгууллага нэгжийн дарга нараас тавих хяналт суларснаас цаг хугацааны хувьд шинэчлэгдээгүй, хуучирсан мэдээлэлтэй, оруулсан зарим мэдээлэл нь төв байгууллагын мэдээлэлтэй давхардсан, ихэнх холбоснуудаар нэвтэрч үзэхэд, дотор нь мэдээлэл оруулаагүй, “Галт зэвсэг”, “Галт зэвсэг, сум” гэсэн дэд цэсэд байгаа мэдээлэл нь утга, агуулгын хувьд ижил төстэй, “Олон нийтийн цагдаа” үндсэн цэсэнд иргэдийн хамгийн ихээр хандалт хийж, мэдээлэл авдаг “Жолооны үнэмлэх” дэд цэсийг оруулсан нь иргэдээс мэдээлэл авахад хүндрэлтэй асуудлууд үүсгэжээ.

Иймд цагдаагийн төв байгууллагын албан ёсны цахим сайтыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2016 онд баталсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага /MNS 6285:2016/-д нийцүүлэн, хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээг цахимаар үзүүлэх, тэдний санаа бодол, сэтгэгдэл, сэтгэл зүйг тандан судлах, түүний үр дүнд боловсруулалт хийж, хариу арга хэмжээ төлөвлөх, мэдээ, мэдээллийг үнэн бодитой, хурдан шуурхай, хүртээмжтэй байдлыг хангаж, олон нийтэд ойлгомжтой хүргэх хэлбэрээр /аудио, видео г.м/ шинэчлэн сайжруулалт хийх шаардлагатай байна.

Мөн Хэвлэл, мэдээллийн төвд цахим сайтад тогтмол хөгжүүлэлт, сайжруулалт, дүн шинжилгээ хийх ажил хариуцсан ахлах мэргэжилтний орон тоог шинээр бий болгох нь зүйтэй байна.

3.3 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын 135.2.7-д “Цагдаагийн байгууллагын дарга цахим хуудсанд мэдээллийг оруулах, өөрчлөх, устгах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг

ханган ажиллах асуудлыг хариуцсан ажилтны үйл ажиллагаанд нь хяналт тавина”, 135.6.4-д “Бүх шатны цагдаагийн байгууллагын дарга нь байгууллагынхаа мэдээллийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг сурталчлах үйл ажиллагаанд биечлэн хяналт тавьж ажиллана”, 135.7.4-т “Энэ журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт шинжилгээг Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын ажил хариуцсан нэгж хийж, зөвлөмж, дүгнэлт гаргана” гэж заасан.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны шинэчилсэн зохион байгуулалтын бүтцээр хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын чиг үүргийг Дэд даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс Захиргааны удирдлагын газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст шилжүүлсэн. Иймд дээрх чиг үүргийг Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан алба хаагчид уг журмын хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцон, цагдаагийн байгууллагын удирдлагыг баталгаажсан мэдээллээр хангаж байх нь зүйтэй байна.

Цахим сайтад мэдээлэл оруулах чиг үүрэгтэй нэгжүүдээс цагдаагийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах үйл ажиллагаанд удирдлагаас тавих дотоод хяналт сул, тэднээс цахим сайтад нэвтэрч, цахим хуудсанд тавигдсан мэдээллийг өдөр тутам хянах, тухайн мэдээллүүд хэрэглэгчдэд хир хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар хүрч байгаа эсэх, уг мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс гаргаж байгаа сэтгэгдэл /comment/-тэй танилцаж ажиллаагүйгээс шалтгаалан хяналтын үйл ажиллагаанд доголдол үүсчээ.

Цахим сайтад тавигдсан мэдээлэл, түүнийг хянасан байдалд дүн шинжилгээ хийхэд байгууллагын үйл ажиллагаа болон хүний нөөцийн талаар тавигдсан мэдээлэлд Төлөвлөлт, зохион байгуулалт болон Хүний нөөцийн хэлтсийн дарга нараас тавих хяналт суларсан бол Шилэн дансны талаар тавигдсан мэдээллийг Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс нэгтгэн боловсруулж, Санхүү, аж ахуйн алба зохих журмын дагуу хяналт тавьж оруулсан байна.

Цаашид холбогдох цагдаагийн байгууллага, нэгжийн дарга нараас цахим хуудсанд мэдээлэл оруулах, өөрчлөх, устгах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах асуудал хариуцсан ажилтны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим сайтын мэдээлэлтэй биечлэн танилцаж байх, дээрх журмын хэрэгжилтэд улирал бүр явцын хяналт шинжилгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар

баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ыг бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Цахим сайтад мэдээлэл оруулах, хянах чиг үүрэгтэй Төлөвлөлт, зохион байгуулалт болон Хүний нөөцийн хэлтэс нь мэдээлэл оруулах эрхийг зөвхөн тайлбар, мэдээлэл бэлтгэх чиг үүрэгтэй Хэвлэл, мэдээллийн төв, Сургалтын нэгдсэн төв, Бүртгэл хяналтын төв, Аюулгүй байдлын хэлтэс, Статистик мэдээллийн хэлтэс, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэс болон харьяа алба, нэгжүүдэд шилжүүлж, хянан баталгаажуулаагүй мэдээллийг оруулсан байна.

Иймд журмын хэрэгжилтийг хангахын тулд Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс байгууллагын үйл ажиллагааны, Хүний нөөцийн хэлтэс хүний нөөцийн талаарх мэдээллийг бусад алба, нэгж буюу тайлбар, мэдээлэл бэлтгэгч нараар гаргуулан авч, хянан баталгаажуулж, цахим сайтад оруулж байх нь зүйтэй байна.

Хоёр. Цагдаагийн байгууллагын албан ёсны цахим сайтын мэдээллийг нийтлэхээс өмнө хянадаггүй, сайтын бүтэц, зохион байгуулалт, дэс дараалал ойлгомжгүй, хэрэглэгчидтэй харилцах агуулга тодорхой бус, цахим сайтын байнгын хөгжүүлэлт, сайжруулалт байхгүй байгаагаас шалтгаалж, Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2016 онд баталсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага / MNS 6285:2016”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээг цахимаар үзүүлэх, тэдний санаа бодол, сэтгэгдэл, сэтгэл зүйг тандан судлах, түүний үр дүнд боловсруулалт хийж, хариу арга хэмжээ төлөвлөх, мэдээ, мэдээллийн үнэн бодитой, хурдан шуурхай, хүртээмжтэй байдлыг хангаж, олон нийтэд ойлгомжтой хүргэх /аудио, видео г.м/, Хэвлэл, мэдээллийн төвд цахим сайтад тогтмол хөгжүүлэлт, сайжруулалт, дүн шинжилгээ хийх ажлыг хариуцсан ахлах мэргэжилтний орон тоог шинээр бий болгож ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлэхээр байна.

Гурав. Цагдаагийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах үйл ажиллагаанд удирдлагаас тавих дотоод хяналт сул, цахим сайтад оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, найдвартай, хүртээмжтэй байдалд явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэхгүй байгаа нь дээрх үйл ажиллагаанд доголдол үүсэхэд нөлөөлсөн байна.

2017 онд Цагдаагийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын чиг үүргийг Захиргааны удирдлагын газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст шилжүүлснээр тус хэлтсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд уг журмын хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцон, цагдаагийн байгууллагын удирдлагыг баталгаажсан мэдээллээр хангаж

байх нь зүйтэй байна.

Иймд дээрх журмын 135.7.4-т “Энэ журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт шинжилгээг Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын ажил хариуцсан нэгж хийж, зөвлөмж, дүгнэлт гаргана” гэж заасныг “Энэ журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт шинжилгээг Төлөвлөлт, зохион байгуулалтын ажил хариуцсан нэгж...” гэж нэмэлт өөрчлөлт оруулж, уг ажлыг эзэнтэй болгож хариуцуулах шаардлага бий болсон байна.

Цаашид холбогдох цагдаагийн байгууллага, нэгжийн дарга нар цахим хуудсанд мэдээлэл оруулах, өөрчлөх, устгах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах ажил хариуцсан ажилтны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим сайтын мэдээлэлтэй биечлэн танилцах, дээрх журмын хэрэгжилтэд улирал бүр явцын хяналт шинжилгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллах шаардлагатай байна.

5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэлд суурилан аудитын объектыг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх саналтай. Үүнд:

5.1.Цахим сайтад мэдээлэл оруулах, хянах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийн удирдлагууд байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, шилэн дансны талаарх мэдээллийг бусад алба, нэгж буюу тайлбар, мэдээлэл бэлтгэгч нараас гаргуулан авч, хянан баталгаажуулж, цахим сайтад нийтлэгч байх /CAAA, ТЗБХ, ХНХ/;

5.2.Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн 2016 онд баталсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага /MNS 6285:2016/-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Хэвлэл, мэдээллийн төвд хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээг цахимаар үзүүлэх, цахим сайтад тогтмол хөгжүүлэлт, сайжруулалт, дүн шинжилгээ хийх ажлыг хариуцсан ахлах мэргэжилтэн /вэбсайт хөгжүүлэгч/-ий орон тоог шинээр бий болгох, тухайн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ТЗБХ, ХМТ, ХНХ/;

5.3.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын 135.7.4-т “Энэ журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт шинжилгээг Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын ажил хариуцсан нэгж хийж, зөвлөмж, дүгнэлт гаргана” гэснийг “Энэ журмын хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт шинжилгээг Төлөвлөлт, зохион байгуулалтын ажил хариуцсан нэгж хийж, зөвлөмж, дүгнэлт гаргана” гэж өөрчлөлт оруулах /ХХ/;

5.4.Цагдаагийн холбогдох байгууллага, нэгжийн дарга нараас цахим хуудсанд мэдээлэл оруулах, өөрчлөх, устгах, мэдээллийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах ажил хариуцсан ажилтны үйл

ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим сайтын мэдээлэлтэй биечлэн танилцаж байх /СААА, ТЗБХ, ХНХ, ХМТ/;

5.5. Дээрх журмын хэрэгжилтэд улирал бүр явцын хяналт шинжилгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллахад анхаарах /СААА, ТЗБХ, ХНХ, ХМТ/.

6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Аудитын урьдчилсан тайлантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Төлөвлөлт зохион байгуулалт, Хуулийн болон Хүний нөөцийн, Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтсүүд, Хэвлэл, мэдээлэл болон Мэдээлэл технологи холбооны төвүүдээс ирүүлсэн “Удирдлагын тайлбар”-ыг энэхүү тайланд хавсаргав.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

Ж.БОЛД

ШИЙДВЭР:

.....

.....

.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Р.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.БОРХҮҮ

Ажлын баримт 3001/
ЦЕГ-ХШДАХ/ҮА-2020/12

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ж.БОЛД ТАНАА**

2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.9-д заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа Эрүүлжүүлэх, саатуулах төвийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар, Эрүүлжүүлэх, саатуулах байр бүхий Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргүүд дэх цагдаагийн газар

Аудитын объект: Цагдаагийн байгууллагын албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2020/12

Аудитын хугацаа: 2020.10.26-2020.11.30

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Ү.Очирбуд

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллагын албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Црхидан согтуурахтай тэмцэх тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулиуд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-629/ журам”-аар зохицуулагдаж байна.

Улсын хэмжээнд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа

Эрүүлжүүлэх, саатуулах төв, Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар, Нийслэлийн 7 дүүрэг, 21 аймаг дахь цагдаагийн газар, хэлтэс, сум дундын цагдаагийн 7 хэлтэс, нийт 37 эрүүлжүүлэх, саатуулах байранд албадан эрүүлжүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

1.1. Хүний нөөцийн талаар:

Батлагдсан орон тоогоор Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа Эрүүлжүүлэх, саатуулах төвд дарга 1, эмч /ахлах байцаагч/ 5, эмч 12, цагдаа 31, цагдаа-жолооч 2, үйлчлэгч 3, нийт 54, Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байранд эмч 4, цагдаа 8, нийт 12, Дүүргүүд дэх цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байранд эмч /ахлах байцаагч/ 5, эмч 25, цагдаа 60, цагдаа-жолооч 20, нийт 110, Аймгууд дахь цагдаагийн газар, хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байранд эмч /ахлах байцаагч/ 11, эмч 78, цагдаа 108, нийт 197 орон тоотойгоор ажиллаж байна.

Дээр дурдсан 37 эрүүлжүүлэх, саатуулах байранд энэ оны 11 дүгээр сарын 17-ны байдлаар Эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга 1, эмч /ахлах/ 21, эмч 119, цагдаа 207, цагдаа-жолооч 22, үйлчлэгч 3, нийт 373 алба хаагч ажиллаж байгаа нь батлагдсан нийт орон тооноос эмч /ахлах/ 2, эмч 8, цагдаа 23, нийт 33 орон тоо дутуу ажиллаж байна.

1.2. Эрүүлжүүлэх байрны үйл ажиллагааны талаар:

Улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд 271349 хүн, хоногт дунджаар 247 хүн эрүүлжүүлэгдсэн, 2018 онд 85540 хүн эрүүлжүүлэгдсэнийг 2017 онтой харьцуулахад 657 нэгж буюу 0.75 хувиар буурч, 2019 онд 111076 хүн эрүүлжүүлэгдсэнийг 2018 онтой харьцуулахад 25236 нэгж буюу 29.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Энэ оны эхний 09 сарын байдлаар нийт 78316 хүнийг албадан эрүүлжүүлснээс орон нутагт 22224, нийслэлд 56092, нийт эрүүлжүүлэгдсэн хүний 6690 буюу 7.9 хувь нь эмэгтэйчүүд байгааг урьд оны мөн үетэй харьцуулахад эрүүлжүүлсэн хүн 3583 буюу 4.5 хувиар буурч, эмэгтэй хүн 429 буюу 6.8 хувиар өсчээ.

1.3. Эрүүлжүүлэх байрны орчин нөхцлийн талаар:

Улсын хэмжээнд 1964-2017 оны хооронд ашиглалтад орсон нийт 37 байрыг албадан эрүүлжүүлэх, саатуулах чиглэлээр ашиглаж байгаагийн 28 нь орон нутагт, 9 нь нийслэлд, эдгээрээс 19 нь тусдаа байранд, 18 нь цагдаагийн газар, хэлтсийн байранд үйл ажиллагаа явуулж байна.

Нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа Эрүүлжүүлэх, саатуулах төв болон дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтсийн 8 эрүүлжүүлэх байрны 5 буюу 55.5 хувь нь 1964-1987 онд, 3 буюу 33.3 хувь нь 1993-2010 онд, 1 буюу 11.1 хувь нь 2017 онд тус тус ашиглалтад орсон, тэдгээрийн 12 буюу

54.5 хувь нь тухайн цагдаагийн газар, хэлтсийн байрны хонгилд байрлаж байна.

Цагдаагийн байгууллагаас эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцлийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд үндэслэл бүхий саналыг үе шаттай хүргүүлсэнээр 2018-2020 онд “Архидан согтуурахтай тэмцэх сан”-ийн хөрөнгө оруулалтаар 758.5 сая төгрөгийн урсгал засвар, тохижилтын ажлыг хийжээ. Тухайлбал; 2018 онд согтуурлын түвшин тогтоох “6820” багаж болон яаралтай тусламжийн үед хэрэглэгдэх “Дефибрилятор” худалдан авахад 316.0 сая төгрөг, 2019 онд 31 байранд агааржуулалтын системийн оруулах, сорох сэнс /винтлятор/, 38 байранд нян устгах, ариутгах төхөөрөмж, эм, тариа хадгалах зориулалт бүхий бага оврын хөргөгч, 11 ширхэг угаалгын машин худалдан авахад 337.5 сая төгрөг, энэ онд 31 байранд агаар цэвэршүүлэгч, 11 байранд чанар стандартад нийцсэн хяналтын камерын цогц системийг суурилуулахад 105.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Гэвч одоо ажиллаж байгаа эрүүлжүүлэх байруудаас “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандарт, шаардлагыг хангасан цогц байр байхгүйгээс сүүлийн 3 жилд мэргэжлийн хяналтын байгууллагаас 54 дүгнэлт, прокурорын байгууллагаас 87 шаардлага авчээ.

1.4. Эрүүлжүүлэх байранд ашиглагдаж байгаа эм, тариа, техник хэрэгсэл:

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүст үйлчлэх эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн болон үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавигдах шаардлагыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартаар зохицуулсан бөгөөд стандартын “А” хавсралтад 23 нэр төрлийн техник хэрэгсэл, тусгай хэрэгсэл, эд зүйлсийг, “В” хавсралтад 28 нэр төрлийн эм, 21 нэр төрлийн тариа, 12 нэр төрлийн боолтын материал, 38 нэр төрлийн багаж, хэрэгсэлтэй байхаар заасан.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, тариа, боолтын материалын зардалд дүүрэг дэх цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байранд улиралд 75.000 төгрөг, орон нутагт 60.000 төгрөг төсөвлөгдөн зарцуулагдаж байна.

1.5. Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлс төлөлтийн талаар:

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан

эрүүлжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлж, эрүүлжүүлэх байранд 24 цаг хүртэл хугацаагаар байлгах, 14 дүгээр зүйлд эрүүлжүүлэх үйлчилгээний төлбөрийг цагдаагийн байгууллагын төсөвт төвлөрүүлэн, эрүүлжүүлэх үйлчилгээнд зарцуулахаар заасан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-д зааснаар үндсэн 7 төрлийн үйлчилгээнд нэг иргэнээс нийт 4150 төгрөг, нэмэгдэл 5 төрлийн үйлчилгээнд үзүүлсэн үйлчилгээний төрөл, гүйцэтгэлээс хамааран 100-600 төгрөгийн нэмэгдэл төлбөр авахаар тогтоожээ.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас авсан мэдээллээр 2017 онд 49290 хүнийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 167.116.000 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 188.841.463 сая, 2018 онд 51976 хүнийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 186.360.000 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 197.606.496 сая, 2019 онд 73498 хүнийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 165.160.000 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 199.054.860 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Харин энэ оны эхний 9 сарын байдлаар 50932 хүнийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 125.370.900 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 159.726.173 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1.Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.9-д заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төвийн үйл ажиллагаанд аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, албадан эрүүлжүүлэх, саатуулах үйлчилгээтэй холбоотой хууль, журам, үйл ажиллагааг боловсронгуй болгох, илэрсэн алдаа, дутагдлыг залруулах, эрсдэлийг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход чиглэнэ.

2.2.Аудитын цар хүрээ

Аудитын зорилгыг хангах хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар, эрүүлжүүлэх, саатуулах байр бүхий дүүрэг дэх цагдаагийн газруудын эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааг хамруулсан.

2.3.Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ Цагдаагийн байгууллагын албадан эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудтай

танилцаж, аудит хийгдэх цагдаагийн 6 нэгжийн удирдлага, алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, аудитад шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг цуглуулж, нэгтгэн дүгнэсэн.

Мөн Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас нэгтгэн гаргадаг “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” эмхэтгэл, Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны Статистик мэдээллийн нэгдсэн сан-www.1212.mn вэб сайтаас зарим шаардлагатай тоон мэдээлэл болон 2020 онд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газраас Эрүүлжүүлэх, саатуулах байр, түүний нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа, мэдээллийг аудитын үйл ажиллагаанд ашигласан болно.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1. Эрүүлжүүлэх, саатуулах байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа Эрүүлжүүлэх, саатуулах төв болон Төмөр зам дахь цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байранд 3, бусад дүүргүүд дэх цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байруудад 1-2 үйлчлэгч ажиллаж байна.

Тухайн байрууд 1 үйлчлэгчтэй бол 08:00-17:00 цаг, 2 үйлчлэгчтэй бол 08:00-19:00 цаг хүртэл, 3 үйлчлэгчтэй бол ээлжээр 24/48 цаг ажиллуулж байна. Энэ нь ид ачааллын үеэр эрүүлжүүлэх байрны цэвэрлэгээ, үйлчилгээ доголдох, эрүүл ахуйн стандарт, шаардлага зөрчигдөх эрсдэл үүсэхээр байна.

Мөн алба хаагчид 24 цагийн үүрэг гүйцэтгээд өглөө ээлжнээс буусан ч орой рапортод суух, амрах өдрөө тодорхой хугацаагаар эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа нь алба хаагчдын эрүүл мэнд, үүрэг гүйцэтгэх чадвар, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх магадлалтай тул 48 цаг бүтэн амраах шаардлагатай байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн болон бусад үйлчилгээг сайжруулах, ажлын ачааллыг бууруулж, гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, Төмөр зам дахь цагдаагийн газар, Эрүүлжүүлэх байр бүхий нийслэл дэх цагдаагийн хэлтсүүдэд шинээр эмч 4, цагдаа 20, үйлчлэгч 15, нийт 39 орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгаа талаар судалгааг НХЖХОНАБХА-аас гаргажээ.

3.2. Нийслэлийн хэмжээнд албадан эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа 6 байр нь “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартад заагдсан “... ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын

шаардлагыг хангахуйцаар халуун хүйтэн ус, бохирын систем, байгалийн гэрэлтүүлэг, агаарын байнгын солилцоог хангах ердийн болон механик, агааржуулалтын систем бүхий орчин, нөхцлийг бүрдүүлсэн байх, нэг хүнд 2 м²-аас доошгүй талбай ногдохоор ерөөтэй байх, ерөө нь эрүүл ахуйн шаардлага хангахуйц хөнжил, гудас, цагаан хэрэглэл, нөмрөгтэй байх зэрэг ерөнхий шаардлагыг бүрэн хангахгүй байна.

3.3. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-д заасан нэмэгдэл үйлчилгээний төлбөрийг эмнэлгийн анхны тусламж үзүүлэхэд 1 удаа 500, хувцсанд хөнгөн цэвэрлэгээ хийхэд 1 удаа 500, утсаар яриулахад 1 удаа 200, гэрт нь явганаар болон автомашинаар хүргэхэд 1 км 350, халуун цай 1 аяга 100, халуун кофе 1 аяга 250, ундаа 1 шил 300, халуун хоол 1 порц 600 төгрөг байхаар зохицуулсан боловч Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төвөөс бусад цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, саатуулах байранд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, стандарт хангасан гал тогоо, зориулалтын тоног төхөөрөмж байхгүй, “тогооч”-ийн орон тоо батлагдаагүй зэргээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна.

3.4. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Эрүүлжүүлэх үйлчилгээний төлбөрийг цагдаагийн байгууллагын төсөвт төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасны дагуу албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна” гэж заасан боловч энэ оны эхний 9 сарын байдлаар албадан эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагааны орлогоос уг үйл ажиллагаанд зарцуулахаар хуваариласан, зарцуулсан тохиолдол байхгүй байна.

Дээрх хураамж, орлого нь эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, ахуй нөхцөлийг сайжруулахад зарцуулахгүй байгаагаас шалтгаалан эрүүлжүүлэгдсэн хүнд өгөх цэвэр ус, ариун цэврийн цааснаас эхлэн алба хаагчдад өдөр тутам хэрэглэгдэх резинэн бээлий, амны хаалт дутмаг, төсөв нь хүрэлцэхгүй байна.

3.5. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, тариа, боолтын материалын зардалд Нийслэлийн 1 эрүүлжүүлэх, саатуулах байранд 300.000, орон нутагт жилд 240.000 төгрөг төсөвлөгдөж байгаа нь дунджаар 1 үйлчлүүлэгчид 19 төгрөг зарцуулах тооцоо гарч, төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан эрүүлжүүлэгдсэн хүнд эмнэлгийн тусламжийг шаардлагын түвшинд шуурхай үзүүлж чадахгүй байгаагаас хүний амь нас эрсдэх нөхцөл байдал үүсч болзошгүй байна. Тухайлбал, нийслэлд 1 нэгжид оногдох эм, тариа, багаж хэрэгслийн сарын зардалд 25.000 төгрөг төсөвлөдөг бөгөөд алба

хаагчдын эрүүл мэнд, халдвар, хамгааллын журмыг сахихад нэн тэргүүнд хэрэглэгдэж байгаа нэг удаагийн бээлий 50 ширхэгийн савлагаатай нь 20.000 төгрөг, үүнийг 2-3 хоногт хэрэглээд дуусдаг, ухаангүй согтуу хүний артерийн даралт унаж, зүрхний хэм алдагдсан үед амь насыг аврах зайлшгүй шаардлагатай цагт хэрэглэх адерналин, кофейн, кордиамин, лидокайн зэрэг чухал шаардлагатай тариануудын үнэ өндөр, хүрэлцээ хангалтгүй байна.

3.6. Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвөөс 2009 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 стандарт”-д заасан хөдөлмөрийн хортой нөхцлийн 3.3 дугаар ангилалд “Эрүүлжүүлэх, баривчлах байрны алба хаагчид ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажиллаж байна” гэсэн дүгнэлт гарсан байна.

Дээрх дүгнэлтэд “Алба хаагчдын 68.0 хувьд биед нь тууралт үүсэх, маажууртай болох, шүдний паалан унах, цооролт бий болох зэрэг шинж тэмдэг ихээр илэрсэн нь алба хаагчдын эрүүл мэндэд ч хортойгоор нөлөөлж байна” гэжээ.

Иймд Эрүүлжүүлэх, саатуулах байр буюу хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа алба хаагчдын ажилласан жил болон хөдөлмөрийн цалин хөлсөнд тохирсон тодорхой төрлийн нэмэгдэл олгуулах, алба хаагчдыг уг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.7. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэхэд эрүүл мэндийн байгууллага болох Яаралтай түргэн тусламж буюу 103-ын эмч тухайн этгээдийн биед ил харагдах гэмтэл, шарх байгаа эсэх болон даралт, зүрхний цохилтыг хэмжсэн төдийхнөөр үзлэгийг дуусгаж “эрүүлжүүлж болно” гэсэн бичиг /нарийн хуудас гэж нэрлэгдэх/ хийж өгдөг ба цагдаагийн алба хаагчид уг бичгийн дагуу тухайн этгээдийг хүлээн авч Эрүүлжүүлэх, саатуулах байранд хүргэж, эрүүлжүүлж байна.

Гэвч уг этгээдийн биеийн байдал гэнэт мууддаг, эмнэлгийн яаралтай болон сэхээн амьдруулах мэргэжлийн тусламж үзүүлэхэд шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэл хомс, түргэний эмч нарын мэдлэг чадвар дутмаг, мөн тухайн этгээдийн эрүүл мэндийн байдал сулаас шалтгаалан цагдаагийн байгууллагын Эрүүлжүүлэх, саатуулах байранд хүргэгдэж ирээд нас барсан тохиолдол цөөнгүй гарч байгаа тул ухаангүй согтуу, эргэлзээ бүхий этгээдийг эмнэлгийн байгууллагын хараа хяналтад авч байх, боломжтой нөхцөлд эмнэлгийн байгууллагад шилжүүлэх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй байна.

3.8. Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын албаны дүрэмт хувцас, хэрэглэлд эвгүй үнэр шингэдэг,

амархан бохирддог зэргээс шалтгаалан тогтмол угааж цэвэрлэх, ариутган арчилдагаас эдэлгээний чанар муудаж, түргэн элэгддэг бөгөөд хувцас хэрэглэх хугацаа нь хэв журам сахиулах үүрэг бүхий бусад алба хаагчдынхтай адил байдгаас нэг алба хаагч жилд 80.000-100.000 төгрөгөөр хувийн оёдлын цехүүдээр албаны дүрэмт хувцас хувиараа оёулж өмсөх тохиолдол элбэг байна.

Иймд Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын дүрэмт хувцас олгох эдэлгээний хугацааг богиносгох, шаардлага хангасан тусгай хувцас, хэрэглэлээр хангах асуудлыг шуурхай шийдвэрлэх шаардлагатай байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичиг, бодит нөхцөл байдалд үндэслэн цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх үйл ажиллагаанд дараах сайжруулалтыг хийх шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Нийслэлийн хэмжээнд албадан эрүүлжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа 6 байр нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартад заагдсан “... ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангахуйцаар халуун хүйтэн ус, бохирын систем, байгалийн гэрэлтүүлэг, агаарын байнгын солилцоог хангах ердийн болон механик, агааржуулалтын систем бүхий орчин, нөхцлийг бүрдүүлсэн байх, нэг хүнд 2 м²-аас доошгүй талбай ногдохоор өрөөтэй байх, өрөө нь эрүүл ахуйн шаардлага хангахуйц хөнжил, гудас, цагаан хэрэглэл, нөмрөгтэй байх” гэсэн ерөнхий шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Иймд нийслэлийн хэмжээнд стандарт шаардлага хангасан нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих асуудлыг судалж, төсвийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Хоёр. Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвөөс 2009 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 стандарт”-д заасан хөдөлмөрийн хортой нөхцөлийн 3.3 дугаар ангилалд “Эрүүлжүүлэх, баривчлах байрны алба хаагчид нь ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажиллаж байна” гэсэн дүгнэлт гаргасан байна.

Иймд Эрүүлжүүлэх, саатуулах байр буюу хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа алба хаагчдын ажилласан жил болон хөдөлмөрийн цалин хөлсийг тодорхой хувиар нэмж тооцох асуудлыг судалж, шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-д заасан нэмэгдэл үйлчилгээний төлбөрийг эмнэлгийн анхны тусламж үзүүлэхэд 1 удаа 500, хувцсанд хөнгөн цэвэрлэгээ хийхэд 1 удаа 500, утсаар яриулахад 1 удаа 200, гэрт нь явганаар болон автомашинаар хүргэхэд 1 км 350, халуун цай 1 аяга 100, халуун кофе 1 аяга 250, ундаа 1 шил 300, халуун хоол 1 порц 600 төгрөгөөр тооцож, үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан боловч Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төвөөс бусад дүүргүүдийн эрүүлжүүлэх, саатуулах байранд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, стандарт хангасан гал тогоо, зориулалтын тоног төхөөрөмж байхгүй, орон тоо дутуу байгаагаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн болон бусад үйлчилгээг сайжруулах, ажлын ачааллыг бууруулж, гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, Төмөр зам дахь цагдаагийн газар, Эрүүлжүүлэх байр бүхий нийслэл дэх цагдаагийн хэлтсүүдэд шинээр эмч 4, цагдаа 20, үйлчлэгч 15, нийт 39 орон тоо дутагдалтай байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Эрүүлжүүлэх үйлчилгээний төлбөрийг цагдаагийн байгууллагын төсөвт төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасны дагуу албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна” гэж заасан боловч энэ оны эхний 09 сарын байдлаар албадан эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагааны орлогоос уг үйл ажиллагаанд зарцуулахаар хуваарилсан, зарцуулсан тохиолдол байхгүй байна.

Дөрөв. Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын албаны дүрэмт хувцас, хэрэглэлд эвгүй үнэр шингэдэг, амархан бохирддог зэргээс шалтгаалан тогтмол угааж цэвэрлэх, ариутган арчилдагаас эдэлгээний чанар муудаж, түргэн элэгддэг бөгөөд хувцас хэрэглэх хугацаа нь хэв журам сахиулах үүрэг бүхий бусад алба хаагчдынхтай адил байдгаас нэг алба хаагч жилд 80.000-100.000 төгрөгөөр хувийн оёдлын цехүүдээр албаны дүрэмт хувцас хувиараа оёулж өмсөх тохиолдол элбэг байна.

Иймд Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын дүрэмт хувцас олгох эдэлгээний хугацааг богиносгох, шаардлага хангасан тусгай хувцас, хэрэглэлээр хангах асуудлыг шуурхай шийдвэрлэх шаардлагатай байна.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

5.1. Нийслэлийн хэмжээнд Стандарт, хэмжил зүйн газрын даргын

2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартад нийцсэн нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих асуудлыг судалж, төсвийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах /СААА, НХЖХОНАБХА, НЦУГ, ГХХ/;

5.2. Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвөөс 2009 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001 стандарт”-д заасан хөдөлмөрийн хортой нөхцөлийн 3.3 дугаар ангилалд заасныг үндэслэн Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажилласан жил болон хөдөлмөрийн цалин хөлсийг тодорхой хувиар нэмж тооцох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, НХЖХОНАБХА, НЦУГ, ХХ/;

5.3. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор уг журамд заагдсан үндсэн болон нэмэгдэл үйлчилгээний төлбөрийг зах зээлийн бодит үнэлгээнд үндэслэн шинэчлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, НХЖХОНАБХА, НЦУГ, ХХ/;

5.4. Эрүүлжүүлэх, саатуулах байрны аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн болон бусад үйлчилгээг сайжруулах, ажлын ачааллыг бууруулж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харъяа Эрүүлжүүлэх, саатуулах төв, Төмөр зам дахь цагдаагийн газар, Эрүүлжүүлэх байр бүхий нийслэл дэх цагдаагийн хэлтсүүдэд шинээр эмч 4, цагдаа 20, үйлчлэгч 15, нийт 39 орон тоо дутуу байгаа асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /НХЖХОНАБХА, НЦУГ, ХНХ/;

5.5. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Эрүүлжүүлэх үйлчилгээний төлбөрийг цагдаагийн байгууллагын төсөвт төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасны дагуу албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах /СААА, НХЖХОНАБХА, НЦУГ/;

5.6. Эрүүлжүүлэх, саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын дүрэмт хувцас олгох, эдэлгээний хугацааг богиносгох, шаардлага хангасан тусгай хувцас, хэрэглэлээр хангах асуудлыг шуурхай судалж, шийдвэрлэх /СААА, НХЖХОНАБХА, НЦУГ/;

5.7. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албадан эрүүлжүүлэх /код-629/ журам”-ын 629.3-т “Албадан эрүүлжүүлэх” гэсэн тодорхойлолтоос “... зөрчил үйлдсэн холбогдогчийн согтуурсан, мансуурсан байдлыг тогтоох зорилгоор 24 цаг хүртэлх хугацаагаар түр саатуулан албадан эрүүлжүүлж болно” гэснийг хасах /НХЖХОНАБХА, ХХ/;

5.8. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д “Эрүүлжүүлэх үйлчилгээний төлбөрийг цагдаагийн байгууллагын төсөвт төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасны дагуу албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаанд зориулан зарцуулна” гэсэн заалтыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албадан эрүүлжүүлэх /код-629/ журам”-д нэмж оруулах /НХЖХОНАБХА, ХХ/;

5.9. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 8.8.3-д “Үйлчлүүлэгчийн цусны даралт унасан, нэмэгдсэн, судасны цохилтын тоо түргэссэн, хүүхэн хараанд өөрчлөлт үүссэн эсэхийг үзэж, ийм шинж тэмдэг, бусад зовиур илэрсэн тохиолдолд эмчийн хяналтад авч, тусламж үзүүлэн нэн даруй түргэн тусламж дуудан эмнэлэгт шилжүүлэх” гэсэн заалтыг нэмж тусгах /НХЖХОНАБХА, ХХ/.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2021 оны 03 дугаар сарын 30-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Р.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Ү.ОЧИРБУД

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ж.БОЛД ТАНАА

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дэх зөвлөл, комисс, хороо, баг, ажлын хэсгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дэх байнгын /байнгын бус/ үйл ажиллагаатай, орон тооны /орон тооны бус/ зөвлөл, комисс, хороо, баг, ажлын хэсэг болон тэдгээртэй ижил төстэй бусад бүтцийн үйл ажиллагаа

Аудитын төрөл, код: Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/ГА-2021/01

Аудитын хугацаа: Удирдлагын шийдвэрээр аудитын багийн гишүүн эргүүлд нэмэгдлээр томилогдон ажилласантай холбогдуулан аудитын хэрэгжих хугацаа ажлын 10 хоногоор хойшилсон.

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа А.Отгонсүх

1. ТАНИЛЦУУЛГА

Аудитын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжээс цуглуулсан мэдээлэл, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаас авсан түүвэр судалгаанаас үзвэл цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжүүдэд 38 төрлийн зөвлөл, комисс, баг болон тэдгээртэй ижил төстэй бүтэц байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байна /Хавсралт 1/.

Үүнээс цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд ганцхан байдаг бүтэц 13, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу байгуулагдах ёстой ч байгуулагдаагүй, байгуулах хэрэгцээ, шаардлага үүсээгүй, эсхүл байгуулагдсан эсэх нь тодорхойгүй, энэ талаар хариуцсан нэгжээс мэдээлэл ирүүлээгүй бүтэц 9, үйл ажиллагаа явуулаагүй удсан, идэвхгүй байдалд орсон бүтэц 5 байна /Хавсралт 2/.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний 2.1-т заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллага дахь орон тооны /орон тооны бус/, байнгын /байнгын бус/ зөвлөл, комисс, баг, ажлын хэсэг болон тэдгээртэй ижил төстэй бусад бүтцийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь дотоод аудитын зорилго юм.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дэх зөвлөл, комисс, баг, ажлын хэсэг болон тэдгээртэй ижил төстэй бусад бүтцийн үйл ажиллагааг хамруулсан бөгөөд тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй, нэг удаагийн шинжтэй ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан зөвлөл, комисс, баг, ажлын хэсгийн үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дээрх зөвлөл, комисс, баг, ажлын хэсэг болон тэдгээртэй ижил төстэй бүтцийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт, 2020 оны үйл ажиллагааны талаарх мэдээллийг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэсэн.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, бусад эрх зүйн актын дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжид байгуулагдсан байвал зохих зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийн талаарх мэдээллийг түүвэрлэн авч, аудитад ашигласан.

Монгол Улсад Коронавируст цар тахал дэгдсэн нөхцөл байдалтай уялдуулан халдвар, хамгааллын дэглэмийг сахиж, аудитыг аль болох эрсдэлгүй, зайнаас хэрэгжүүлэх бодлого баримталж, цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан аудитын тайлан бичиж, санал, зөвлөмжийг боловсруулсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дээрх зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 3а/1344 дугаартай албан бичиг хүргүүлсний дагуу нийт 53 байгууллага, нэгжээс мэдээлэл ирүүлсэнээс Мөрдөн байцаах алба, Санхүү, аж ахуйн алба, Бүртгэл хяналтын төв, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас шаардлага хангахуйц, иж бүрэн мэдээллийг ирүүлжээ.

Харин Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Тээврийн цагдаагийн алба, Баянзүрх, Багануур дүүрэг, Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай, Ховд аймаг дахь цагдаагийн газар, хэлтсээс аудитын шаардлага хангахгүй, дутуу мэдээллийг ирүүлсэн байна.

Тухайлбал, Тээврийн цагдаагийн алба нь Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн мэдээллийг нэгтгэж ирүүлээгүй, бусад нэгжүүдээс хариуцсан зөвлөл, комисс, багийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг дутуу, эсхүл хамааралгүй мэдээлэл /нэг удаагийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулагдсан ажлын хэсэг, сахилга, ёс зүйн зөрчил, эрүү, хэв журмын нөхцөл байдлын мэдээ г.м/-ийг ирүүлжээ.

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, Аюулгүй байдлын хэлтэс, Хар тамхитай тэмцэх газар, "Хүч" спортын хороо, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Дотоодын цэргийн 05 дугаар ангиас албан бичгийн хариуг ирүүлээгүй байна.

3.2 Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжид байгуулагдан, үйл ажиллагаа явуулбал зохих зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцээс огт байгуулагдаагүй, байгуулагдсан эсэх нь тодорхойгүй, эсхүл байгуулагдсан ч үйл ажиллагаа нь зогсонги байдалд орж, чиг үүргээ хэрэгжүүлээгүй байдал цөөнгүй байна.

Тухайлбал, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг чиг үүрэгтэй Бодлогын зөвлөл 2015, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй, тайлангийн 2 дугаар хавсралтын 2, 3 дахь хэсэгт заасан нэр бүхий 5 зөвлөл, комисс, баг байгуулагдсан эсэх нь тодорхойгүй, хариуцсан нэгжээс тэдгээрийн үйл ажиллагааны талаар ямар нэгэн тайлбар, мэдээлэл ирүүлээгүй байна.

3.3 Аудитын явцад зарим байгууллага, нэгжээс холбогдох зөвлөл, комисс, багийн мэдээллийг ирүүлээгүй нь тэдгээрийг тушаалаар байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлээгүй, холбогдох чиг үүргийг зохих ёсоор хэрэгжүүлээгүй, энэ талаар удирдлагаас тавих хяналт сул байгааг харуулж байна.

Жишээлбэл, холбогдох журмын дагуу цагдаагийн байгууллага бүрт байвал зохих Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Салбар зөвлөл, Дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус Ажлын хэсэг, Эрсдэлийг удирдах орон тооны бус баг, Түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг хариуцах орон тооны бус зөвлөл, Дүн шинжилгээ, судалгааны баг, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлах бүртгэх орон тооны бус байнгын комисс, Баримт бичиг нягтлан шалгах комисс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн талаарх мэдээллийг нэр бүхий алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд ирүүлээгүй байна /Хавсралт 1/.

3.4 Соёл, соён гэгээрүүлэх ажлын /Код 940/ журам, Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах /Код 941/ журамд "алба хаагчдын санал санаачлага, сайн дурын үндсэн дээр сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах зөвлөл, баг, хамтлагийг **байгуулж болно**" гэж заасан нь тэдгээрийг байгуулахгүй ч байж болохоор зохицуулагдсан байна.

Гэтэл дээрх зөвлөл, баг, хамтлаг нь алба хаагчдад чиглэсэн олон чухал чиг үүргийг хариуцахаар, цаашилбал хэрэгжүүлсэн ажлын дүн мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнаж байхаар журамласан нь тэдгээрийг зайлшгүй байгуулж, үйл ажиллагаанд оруулах хэрэгцээ шаардлагыг харуулж байна.

4. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хариуцсан чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулахын тулд дотооддоо байнгын болон байнгын бус ажиллагаатай олон тооны зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийг байгуулж ажиллуулахаар журамлан зохицуулжээ.

Нэгэнт тухайн бүтцийг байгуулж, ажиллуулах хэрэгцээ, хууль зүйн үндэслэл, шаардлага байгаа нөхцөлд түүнийг зохих ёсоор байгуулж, үйл ажиллагааг нь тасралтгүй, хэвийн явуулж, үр дүнг тооцох зайлшгүй шаардлагатай.

Иймд энэхүү тайланд дурдсан үйл ажиллагаа нь доголдож саатсан, чиг үүргээ зохих журмын дагуу хэрэгжүүлэхгүй байгаа зөвлөл, комисс, багийг хэвийн ажиллагаанд оруулах, шаардлагатай бол холбогдох журмын зохицуулалтыг шинэчилж өөрчлөх нь бодит нөхцөл байдалд нийцэхээр байна.

Нөгөө талаас байгууллага, нэгжийн удирдах албан тушаалтан бүр өөрийн хариуцсан нэгжид байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, удирдлагын хариуцлага, хяналт, оролцоо, дэмжлэгээ сайжруулах шаардлагатай байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын өргөн бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоос хамаарч олон тооны зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийг байгуулж, ажиллуулах шаардлага байдаг ч үйл ажиллагаа, чиг үүрэг, ажлын давхардлаас зайлсхийх нь чухал юм.

Иймд аудитын багаас цагдаагийн байгууллага, нэгж дээрх Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг Сахилга, ёс зүйн зөвлөлтэй, Дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийг Эрсдэлийг удирдах багтай, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй, Соён гэгээрүүлэх багийг Биеийн тамир, спортын хамтлагтай бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааг нь нэгтгэн зохион байгуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд үндэслэн, цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дээрх зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийн үйл ажиллагаа, түүнд холбогдох удирдлагын хариуцлага, хяналт, оролцоо, дэмжлэгийг сайжруулах, аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлэх саналыг илтгэн танилцуулж байна. Үүнд:

Эрүүгийн цагдаагийн алба, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс, Хуулийн хэлтэс, Аюулгүй байдлын хэлтэс, Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга нарт:

- Энэхүү тайлан, түүний 2 дугаар хавсралтад дурдсан, үйл ажиллагаа нь доголдож саатсан, чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхгүй байгаа өөрийн нэгжийн хариуцсан зөвлөл, комисс, баг, хороо, ажлын хэсгийг хэвийн ажиллагаанд оруулахад анхаарах, шаардлагатай бол холбогдох журмын зохицуулалтыг шинэчлэх талаар саналаа Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх;

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн дарга нарт:

- Энэхүү тайлан, түүний 1 дүгээр хавсралттай сайтар танилцаж, холбогдох журмын дагуу өөрийн нэгж дээр байгуулагдсан байвал зохих зөвлөл, комисс, баг, тэдгээртэй ижил төстэй бүтцийг байгуулах, бүрэлдэхүүнийг шинэчлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлж, үр дүнг тооцох, тэдгээрт тавигдах удирдлагын хяналт, оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх;

- Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийн талаарх танилцуулгыг энэ оны 07 дугаар сарын 01-ний дотор Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын нэр дээр ирүүлэх.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл:



Хавсралт 1

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА, НЭГРЖ ДЭХ ЗӨВЛӨЛ, КОМИСС, БАГ, АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Бүтцийн нэр	Эрх зүйн зохицуулалт	Бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг	Үйл ажиллагааны талаар холбогдох нэгжээс ирүүлсэн мэдээлэл, тайлбар
1	Бодлогын зөвлөл	ЦБУАЖ-ыг боловсруулах хэрэгжүүлэх журам Код-103.4.2	Зөвлөлийг дэд дарга ахалж, нбд-аар Хуулийн асуудал хариуцсан нэгжийн алба хаагч, гишүүдийг Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилоно. Зөвлөл нь журмын төслийг боловсруулах, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, төсөл боловсруулах, батлагдсан журмыг нийт алба хаагчдад түгээх, бүртгэх, хэрэгжилтэд судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэгтэй.	Хуулийн хэлтсээс ирүүлсэн мэдээлэлд 2020 онд ЦБУАЖ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тушаал 41 гаргаж, цдцаб-д хүргүүлсэн тухай дурдсан. Бодлогын зөвлөл нь 2015 оноос хойш хуралдаагүй, үйл ажиллагаа явуулаагүй тухай тайлбарыг өгсөн.
2	Даргын зөвлөл	Даргын зөвлөл байгуулах, асуудал хэлэлцэх журам Код-104.3.1	Цагдаагийн төв байгууллага харьяа алба нэгж, дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь зөвлөх эрх бүхий орон тооны бус зөвлөлтэй байна.	Уг зөвлөлийн бүтэц, 2020 оны үйл ажиллагааны талаарх мэдээллийг ДЦШ, ТАГ, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Төв аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.
3	Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөл, салбар зөвлөл	Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх журам Код-109.6.1	Зөвлөлийн дарга нь ЦЕГ-ын дэд дарга, нбд нь АБХ-ийн дарга, гишүүдэд НЦУГ, СААА, ЗУГ, ДЦШ, ТЗБХ, ХШДАХ, ТНХ, ХНХ, СГАСХ, НХЖОХНАБХА, МТХТ, ЦДЦСНТ, ХМТ, БХТ-ийн дарга нар байна. Цагдаагийн байгууллага бүрт "Салбар зөвлөл" байж, дарга нь ахална. 109.6.4. Салбар зөвлөл нь зөвлөлөөс гаргасан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохиосон ажлын явц, үр дүнд сар бүр хэлэлцэн дүгнэлт өгч, ажлын тайлан, мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор зөвлөлийн даргын нэр дээр ирүүлнэ.	Уг салбар зөвлөлийг байгуулж, ажиллуулсан талаарх мэдээллийг МБА, ТЦА, ЭююЦА, СХДЦГ, СБДЦГ, НДЦХ, Дорнод, Завхан, Төв, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.
4	Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар хороо	Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх журам Код-109.7.1	Салбар хорооны дарга нь ЦЕГ-ын дарга, орлогч дарга нь ТДЦ, нбд нь ТЗБХ-ийн алба хаагч /АТТ-д зааснаар/ байна.	Уг хорооны талаар ЦЕГ-ын ТЗБХ-ээс мэдээлэл ирүүлээгүй.

5	ЦДЦ-ийн алба хаагч, ажиллагсдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл	Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх журам Код-109.9.3	109.7.7. Салбар хорооны нарийн бичгийн дарга нь алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын тайлан мэдээг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор авч нэгтгэн, Үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын албанд хүргүүлэх ажлыг хариуцна.	Хуулийн хэлтсээс ирүүлсэн мэдээлэлд ЦЕГ-ын даргын 2020 оны А/163 дугаар тушаалын 4-р хавсралтаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан. Зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2020.10.23-нд цахимаар зохион байгуулж, 1 ажлын чиглэл, 1 зөвлөмж хүргүүлсэн тухай дурджээ
6	Жендэрийн дэд зөвлөл	Зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх журам Код-109.10.1	109.9.3. Хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах зөвлөлийн ажлын алба нь цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгж байна.	Мөн уг зөвлөлийг байгуулж, ажиллуулсан тухай мэдээллийг ЭЦА, МБА, ТЦА, МДШШУА, ЭкоЦА, ДЦ-805, ТАГ, МШУТ, БХТ, ГХХХ, Автобааз Төв архив, Сүлд, БГДЦГ, СХДЦГ, СБДЦГ, ХУДЦГ, ЧДЦГ, Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.
			109.10.1. Цагдаагийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ажлын Дэд зөвлөл /цаашид "Дэд зөвлөл" гэх/ нь алба хаагчийн жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн хууль тогтоомиж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, хэрэгжилтийн талаар цагдаагийн төв байгууллагын даргад зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ажиллана.	Уг зөвлөлийг байгуулж ажиллуулсан эсэх нь тодорхойгүй, энэ талаар ЦЕГ-ын ТЗБХ-ээс ямар нэг мэдээлэл ирүүлээгүй байна.

7	Үнэлгээний баг	Алба хаагчийн ажлыг үнэлэх журам Код-111.4.9	<p>109.10.2. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах дүрмийг цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр батална.</p> <p>109.10.3. Дэд зөвлөл нь үйл ажиллагааны тайлангаа цагдаагийн төв байгууллагын даргад жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тайлангах бөгөөд шаардлагатай мэдээллийг тухай бүр танилцуулж ажиллана.</p> <p>111.4.9. Цагдаагийн төв байгууллагын дарга Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мөргөшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4.1 дэх хэсэгт заасан цагдаагийн байгууллагын үнэлгээний багийг жил бүрийн 6, 12 дугаар сард багтаан байгуулж, албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг 6 дугаар сарын 20-ны дотор, сүүлийн хагас жилийн үнэлгээг 12 дугаар сарын 20-ны дотор баталгаажуулна.</p>	<p>ЭЦА, ГХХХ, СХДЦГ, СБДЦГ, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл аймаг дахь цагдаагийг газраас ирүүлсэн.</p>
8	Дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсэг	Дотоод аюулгүй байдлыг хангах журам Код-113.3.4	<p>113.3.4. Орон тооны бус ажлын хэсгийн ахлагч нь хавсралт ЦБҮАЖ №113.34/-д заасны дагуу шууд томилогдох бөгөөд ажлын хэсэг нь 3-5 гишүүнтэй байна.</p> <p>113.3.5. Орон тооны бус ажлын хэсэг нь байгууллагын даргын удирдлага дор улирал тутам хуралдах, дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хийж гүйцэтгэсэн ажил, цаашид авч хэрэгжүүлэх биелэлт, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх саналаа гаргаж, дотооддоо хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Уг ажлын хэсгийг байгуулж, ажиллуулсан тухай мэдээллийг ЭЦА, МБА, НХЖХОНАБХА, ТЦА, МДШШУА, ЭкоЦА, СААА, НЦУГ, ДЦШ, ДЦ-805, ДЦ-809, ТАГ, ЦДЦСНТ, МШУТ, БХТ, ЭСТ, ХҮТ, ГХХХ, Автобааз, Төв архив, Сүлд, БГДЦГ, БЗДЦГ, СХДЦГ, СБДЦГ, ХУДЦГ, ЧДЦГ, НДЦХ, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>
9	Сургалт арга зүйн зөвлөл	Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх журам Код-118.9.2	<p>118.9.2. Цагдаагийн төв байгууллагын "Сургалт арга зүйн зөвлөл"-ийг Иргэний зөвлөлийн гишүүн, Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын төлөөлөл, Мэдээлэл нэгтгэн боловсруулах ажил хариуцсан нэгж, Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж,</p>	<p>Уг зөвлөлийг ЦЕГ-ын даргын 2017 оны А/257 дугаар тушаалаар байгуулж, 2020 оны А/06 дугаар тушаалаар бүтэц бүрэлдэхүүнийг шинэчилсэн байна. Зөвлөлийн дарга нь ЦЕГ-ын дэд дарга, нарийн бичгийн даргаар СТАСХ-ийн дарга, гишүүдэд ХШДХА, СААА-ны</p>

10	НХЖХОНАБХГХЗУСА-ыг Зохицуулах зөвлөл	НХЖХОНАБХГХЗУСА-ыг Зохицуулах зөвлөл ажиллах журам Код-119.2.1	цагдаа, дотоодын цэргийн сургалт хариуцсан нэгжийн дарга нар болон бусад алба хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулна. 118.9.3.Зөвлөл доорх үйл ажиллагааг явуулна. 119.2.1.Зөвлөл нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын хэмжээнд үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах чиг үүргийг гүйцэтгэнэ. 119.2.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг цагдаагийн төв байгууллагын дарга томилж, чөлөөлнө. 119.2.3.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд сард 1-эс доошгүй хуралдана. 128.1.Зөвлөлийн чиг үүрэг нь цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, сургалт, судалгааны ажлын бодлого, чиглэлийг тодорхойлох, нэвтрүүлэн туршихаар бэлтгэж буй ажил, эрх зүйн актын төсөлд онол, арга зүйн зөвлөмж гаргах юм. 128.3.2.Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхийг ТЗБХ-ээр уламжлан албад, Сургалт хариуцсан нэгж эзлэх ба бүрэлдэхүүнийг ЦЕГ-ын даргын тушаалаар батална. 128.3.6.Зөвлөлийн дотоод зохион байгуулалтын ажилд зөвлөлийн даргын хүсэлтээр ЦЕГ-ын ТЗБХ-ийн алба хаагчийг оролцуулна. 137.3.2.Цагдаагийн төв байгууллагын Захиргааны удирдлагын газар, харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд нь өөрийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр эрсдэл үнэлж, эрсдэлийг удирдах орон тооны бус баг томилгох, хариу арга хэмжээг төлөвлөж, биелэлт, үр Дүнг тооцож ажиллана.	Сөнх, МДШУА-ны ЗУХ, ЦДЦСНТ, ДЦШ-ын ЗУЦАЗЭХ-ийн дарга, ДХИС-ын Цагдаагийн сургуулийн дэд захирал зэрэг нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөл нь 2020 онд 1 удаа хуралдсан тухай мэдээллийг СТАСХ-ээс ирүүлсэн байна.
11	Эрдэмтдийн зөвлөл	Эрдэмтдийн зөвлөл ажиллуулах журам Код-128.1	Уг зөвлөл байгуулагдаагүй байна.	УСХ-ээс ирүүлсэн мэдээлэлд ЦЕГ-ын даргын 2021.01.13-ны ердийн А/16 дугаар тушаалаар тус зөвлөлийг дарга, нбд, 13 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан, зөвлөл нь 2019 оноос хойш хуралдаагүй, үйл ажиллагаа явуулаагүй тухай дурджээ.
12	Эрсдэлийг удирдах орон тооны бус баг	ЦБУА-ны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам Код-137.3.2	Уг орон тооны бус багийг байгуулж, ажиллуулсан тухай мэдээллийг ЭЦА, МБА, НХЖХОНАБХА, ТЦА, МДШУА, ЭкоЦА, НЛУГ, ДЦШ, ДЦ-806, ЦДЦСНТ, МШУТ, БХТ, ЭСТ, ГХХХ, Автобааз, БгдЦг, БздЦг, БНДЦХ, СХДЦг, СБДЦг, ХудЦг, ЧдЦг, НДЦХ, Архангай, Баян-Өлгий, Булган,	

	<p>Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Эвэрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>	
<p>13</p>	<p>Орон тооны бус зөвлөл /Эрэн сурвалжлах ажиллагаа/</p>	<p>Эрэн сурвалжлах журам Код-229.11.2</p>
<p>14</p>	<p>Тусгай хэрэгслийг /Тусгай хэрэгслийн ашиглалтын хугацаа тогтоох/</p>	<p>Тусгай хэрэгслийг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох журам Код-236.5.1</p>
<p>15</p>	<p>Мөрдөн шалгах ажиллаганы Мэргэжлийн зөвлөл</p>	<p>Мөрдөн шалгах ажиллаганы мэргэжлийн зөвлөл, түүний үйл ажиллагааны чиглэл журам Код-306.2.1</p>
<p>Уг зөвлөлийг байгуулж, ажиллуулсан талаарх мэдээллийг ХУДИЦГ, НДЦХ, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Төв аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>	<p>Уг зөвлөлийг байгуулсан талаарх мэдээллийг ХУДИЦГ, НДЦХ, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Төв аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>	<p>Уг комиссыг байгуулах хэрэгцээ, шаардлага үүсээгүй тул байгуулагдаагүй талаарх мэдээллийг СААА-наас ирүүлсэн.</p> <p>Уг зөвлөлийг байгуулж, ажиллуулсан талаарх мэдээллийг МБА, ЭкоЦА-наас ирүүлсэн.</p> <p>ЭЦА-нд уг зөвлөлийг 2019 онд байгуулж ажиллуулсан бөгөөд 2020 онд ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй талаар мэдээлэл ирүүлсэн.</p>

				<p>ажиллагаа явуулах албаны даргаас бичгээр өгөх зааварчилгыг боловсруулна.</p> <p>322.3.5. Түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг хариуцаж мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг нутаг дэвсгэр, чиглэл хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн хэмжээнд байгуулж, сар тутам түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг Мөрдөн байцаах албанд ирүүлнэ.</p>	<p>МБА-наас албаны даргын тушаалаар уг зөвлөлийг байгуулах гэж байгаа тухай, 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй талаар мэдээлэл ирүүлсэн байна.</p>
<p>16</p> <p>Орон тооны бус зөвлөл /Түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт/</p>	<p>Түдгэлзүүлсэн хэрэгт хийх ажиллагаа журам Код-322.3.5</p>	<p>Орон тооны бус зөвлөл /Түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт/</p>		<p>Уг баг байгуулагдаагүй боловч ЦЕГ-ын даргын 2021.03.05-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар МТХТ-ийн бүтэцэд шинээр Цахим мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийг байгуулж, орон тоог батлуулсан байна.</p>	
<p>17</p> <p>Цахим мэдээллийн аюулгүй байдлын баг</p>	<p>Цахим мэдээллийн аюулгүй байдлын баг, үйл ажиллагааны чиглэл Код-700.2/113</p>	<p>Цахим мэдээллийн аюулгүй байдлын баг, үйл ажиллагааны чиглэл Код-700.2/113</p>		<p>2/113.2.1.АББ-ийг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар байгуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p> <p>2/113.2.2.АББ нь цагдаагийн байгууллага дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан дэд даргын шууд удирдлаганд ажиллаж, нерийн бичгийн даргаар мэдээлэл технологи хариуцсан нэгжийн дарга, гишүүдэд аюулгүй байдал, төрийн нууц, кибер аюулгүй байдал, мэдээллийн технологи хариуцсан алба хаагчаас бүрдсэн байна.</p>	
<p>18</p> <p>Мэдээллийн технологи, харилцаа холбооны Бодлогын зөвлөл</p>	<p>Мэдээллийн технологи, харилцаа холбооны Бодлогын зөвлөл Код-700.2/100</p>	<p>Мэдээллийн технологи, харилцаа холбооны Бодлогын зөвлөл Код-700.2/100</p>		<p>"Мэдээллийн технологи, харилцаа, холбооны зөвлөл", "Мэдээллийн технологи, харилцаа, холбооны стратеги, төлөвлөлт, бодлого" зэрэг 2 дэд журам батлагдаагүй байгаа тул тус зөвлөл одоогоор үйл ажиллагаа явуулаагүй тухай мэдээллийг МДЦШУА-наас ирүүлсэн.</p>	<p>технологи, харилцаа, холбооны зөвлөл", "Мэдээллийн технологи, харилцаа, холбооны стратеги, төлөвлөлт, бодлого" зэрэг 2 дэд журам батлагдаагүй байгаа тул тус зөвлөл одоогоор үйл ажиллагаа явуулаагүй тухай мэдээллийг МДЦШУА-наас ирүүлсэн.</p>
<p>19</p> <p>Холбооны техникийн байнгын комисс</p>	<p>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгслийн эзэмших, хадгалах, бүртгэл хөтлөх журам Код-715.8.3</p>	<p>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгслийн эзэмших, хадгалах, бүртгэл хөтлөх журам Код-715.8.3</p>		<p>ЦЕГ-ын даргын 2017 оны А/97 дугаар тушаалаар "Мэдээллийн технологи, харилцаа, холбооны техникийн байнгын комисс" байгуулагдсан.</p> <p>Тус комисс нь хөрөнгө актуулах хүсэлт гаргасан цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2017 онд 249,</p>	<p>технологи, харилцаа, холбооны зөвлөл", "Мэдээллийн технологи, харилцаа, холбооны стратеги, төлөвлөлт, бодлого" зэрэг 2 дэд журам батлагдаагүй байгаа тул тус зөвлөл одоогоор үйл ажиллагаа явуулаагүй тухай мэдээллийг МДЦШУА-наас ирүүлсэн.</p>

			<p>720.1.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээлэл, холбоо, технологийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засаар үйлчилгээ, холболт, техник хэрэгсэл стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих, сургалт, өргөтгөл суурилуулалтыг хийж гүйцэтгэх</p> <p>720.4.1.Захиалтын дагуу мэдээлэл, холбооны инженерийн багийг томилж, хийгдэх ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Мэдээлэл, шуурхай удирдлагын эсхүл Мэдээллийн технологи, харилцаа холбооны ажил хариуцсан нэгжийн даргаар батлуулна.</p>	<p>2018 онд 76, 2019 онд 180, 2020 онд 217, 2021 оны 1 дүгээр улиралд 108 дүгнэлт үйлдэн баталгаажуулж, СААА-нд хүргүүлж ажиллажээ.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас хүсэлт ирсэний дагуу тухайн багийг байгуулж ажиллуулдаг тухай мэдээллийг МДШШУА-наас ирүүлнэ.</p>
20	Мэдээлэл, холбооны инженерийн баг	Мэдээлэл, холбооны инженерийн баг томилон ажиллуулах журам Код-720	<p>721.4.3.Дүн шинжилгээ, судалгааны ажлыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын тушаалаар хавсралт /Маягт ЦБҮАЖ№721.43/-ын дагуу томилогдсон дүн шинжилгээ, судалгааны баг гүйцэтгэнэ.</p>	<p>Уг багийг байгуулж, ажиллуулсан талаарх мэдээллийг ЭЦА, МБА, НХЖХОНАБХА, ТЦА, ЭюЦА, БГДЦГ, БЗДЦГ, ХУДИЦГ, ЧДЦГ, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>
21	Дүн шинжилгээ, судалгааны баг, Кримнологи судалгааны баг	Дүн шинжилгээ, судалгаа хийх журам Код-721 ГХЗУС журам Код-227.4.5	<p>809.3.10.Зам тээврийн ослын улмаас эвдэрч гэмтсэн болон ажилд гарах боломжгүй болж саатсан тээврийн хэрэгслийг техникийн байнгын комиссоор шалгуулан акт тогтоолож, учирсан хохирлоос гадна цагдаагийн шуурхай албаны автомашин саатуулсан ашиглалтан төлбөрийг буруутай этгээд, албан тушаалтан, автомашин хариуцагч,жолоочоор төлүүлнэ.</p>	<p>Уг комиссыг байгуулж ажиллуулсан талаарх мэдээллийг МДШШУА, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>
22	Техникийн байнгын комисс	Цагдаагийн албанд ашиглагдах тээврийн хэрэгсэлд хяналт тавих журам Код-809.3.10	<p>816.4.1.Зөвлөл нь цагдаагийн төв байгууллагын соён гэгээрүүлэх, Сүлд чуулга, хяналт сан хөмрөг, Төв архив, санхүү, аж ахуй, хяналт шалгалтын нэгжийг төлөөлсөн 5-7 гишүүнтэй байна.</p>	<p>Сүлд чуулгын музейн сан хөмрөг хариуцсан ажилтнаас тодруулахад уг зөвлөлийг одоогоор байгуулаагүй тухай дурдсан.</p>
23	Үзэмэр худалдан авах зөвлөл	Музейд түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийг худалдан авах, хүлээлгэн өгсөн иргэн, байгууллагыг урамшуулах журам Код-816		

			<p>орон тооны бус байнгын комиссыг томилон ажиглуулна.</p>	<p>Төв, Хэнтийн аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>
26	Сайн дурын зөвлөл, баг	Соёл, соён гэгээрүүлэх ажил Код-940	<p>940.3.1.Энэ журмын 940.2-т заасан соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хандив, тусламж үзүүлэх аян өрнүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлөвс урьдчилан сэргийлэх, мэдээлэл солилцох, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулах зорилгоор алба хаагчдын санал санаачилгаар сайн дурын үндсэн дээр зөвлөл, баг /цаашид "Зөвлөл" гэх/-ийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад байгуулж болно.</p>	<p>Сахилга, ёс зүйн зөвлөл: /МБА, ТЦА, ЭкоЦА, НЦУГ, БХТ, ГХХХ, МШУТ, Төв архив, БГДЦГ, ХУДЦГ, ЧДЦГ, НДЦХ, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий/</p> <p>Эмэгтэйчүүдийн зөвлөл: /МБА, БХТ, Сулд, СХДЦГ, СБДЦГ, БНДЦХ, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Сүхбаатар, Хэнтий/</p> <p>Ахлагчийн зөвлөл: /Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Төв/</p> <p>Соён гэгээрүүлэх баг: /ТАГ, МШУТ, ГХХХ, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Хэнтий/</p> <p>Эцэг, эхийн зөвлөл: /ЧДЦГ, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Сүхбаатар, Төв, Хэнтий/</p> <p>Гэр бүлийн зөвлөл: /ХУДЦГ, Баянхонгор, Дундговь, Хэнтий/</p> <p>Залуучуудын зөвлөл: /Баянхонгор, Төв/</p>
27	Биеийн тамир, спортын хамтлаг	Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах журам Код-941	<p>941.6.1.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор алба, нэгж, нутаг дэвсгэр харуусан цагдаагийн байгууллагуудад биеийн тамир, спортын хамтлаг байгуулж болно.</p> <p>941.6.4.Хамтлаг нь бие бүрэлдэхүүний дунд нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр зохиох ажлын төлөвлөгөө жил бүрийн эхний сард багтаан байгууллагын даргаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Уг хамтлагийг байгуулж ажиллуулсан талаарх мэдээллийг МБА, ТЦА, ЭкоЦА, ТАГ, МШУТ, ГХХХ, БГДЦГ, СХДЦГ, НДЦХ, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтийн аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.</p>

28	Баримт бичиг нягтлан шалгах комисс	Архив, албан хэрэг хөтөлгөөний тухай хуулийн 9 зүйл	Байгууллагын баримтын агуулаа, бүрэлдэхүүнийг тодорхойлох, баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгож авах болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй.	Уг комиссыг байгуулж ажиллуулсан талаарх мэдээллийг ЭЦА, МБА, ТЦА, МДШУА, СААА, НЦУГ, ДЦ-805, ТАГ, МШУТ, БХТ, ГХХХ, Төв архив, СХДЦГ, СБДЦГ, ЧДЦГ, НДЦХ, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Төв аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн байна.
29	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 зүйл	Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих зэргээр ХАБЭАТХ-ийн 23.3 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.	Уг зөвлөлийг байгуулж, ажиллуулсан тухай мэдээллийг ЭЦА, НХЖХОНАБХА, МДШУА, ЭкоЦА, НЦУГ, ДЦ-809, МШУТ, БХТ, Автобааз, Төв архив, Сүүж-Уул, Сүлд, БГДЦГ, СХДЦГ, СБДЦГ, ХУДЦГ, ЧДЦГ, НДЦХ, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Төв, Увс, Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газраас ирүүлсэн.
30	Үнэлгээний хороо	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.1 зүйл	47.1 Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дэд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.	ТЦА, МШУТ, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорнод аймаг дахь цагдаагийн газраас Үнэлгээний хороо байгуулж ажиллуулсан талаарх мэдээлэл ирүүлсэн.
31	Төв архивын дэргэдэх арга зүйн зөвлөл	Төрийн архивын ажлын үндсэн зааврын 9.3.3	Тус зөвлөл нь Төв архивын дэд даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй, архивын эрдэм шинжилгээ, арга зүйн ажлыг зохицуулах, архивын нэгдсэн бүртгэлийг хянан хэлэлцэх, зөвлөмж, чиглэл өгөх, арга зүйн зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус нэгж юм.	Төв архивын дэргэдэх арга зүйн зөвлөлийн хурлыг 8 удаа зохион байгуулж, нийт 42 байгууллагын 206 бүртгэл, 11884 хадгаламжийн нэгжийг хянан хэлэлцүүллээ.
32	Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл	Төрийн албаны тухай хууль тогтоомж	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 370 дугаар тогтоолоор Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон. Салбар зөвлөлийн дарга нь ЦЕГ-ын дарга, гишүүдэд ЦЕГ-ын тэргүүн дэд, дэд дарга, ЗУГ, ХНХ, ХуХ-ийн дарга, нбд-аар ХНХ-ийн алба хаагч ажиллаж байна.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн мэдээг жил бүрийн 01 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 01-ний дотор хургуулж байна.

Товчилсон үгийн тайлал:

ЭЦА- Эрүүгийн цагдаагийн алба
МБА- Мөрдөн байцаах алба
ТЦА- Тээврийн цагдаагийн алба
НХЖХОНАБХА- Нийтийн хэв журам хамгаалах,
олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба
МДШШУА- Мэдээлэл, дүн шинжилгээ,
шуурхай удирдлагын алба
ЭкоЦА- Экологийн цагдаагийн алба
СААА- Санхүү, аж ахуйн алба
НЦУГ- Нийслэлийн цагдаагийн удирдах газар
ДЦШ- Дотоодын цэргийн штаб
ДЦ-805, ДЦ-809- Дотоодын цэргийн дугаар анги, тусгай салбар
ТАГ- Тусгай ажиллагааны газар
МТХТ- Мэдээллийн технологи, холбооны төв
ЦДЦСНТ- Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв
МШУТ- Мэдээлэл, шуурхай удирдлагын төв

БХТ- Бүртгэл хяналтын төв
ХҮТ- Хангалт үйлчилгээний төв
ЭСТ- Эрүүлжүүлэх саатуулах төв
УСХ- Урьдчилан сэргийлэх хэлтэс
ГХХХ- Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс
Сүлд- Сүлд чуулга
БГДЦГ- Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар
БЗДЦГ- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар
СХДЦГ- Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар
СБДЦГ- Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар
ХУДЦГ- Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар
ЧДЦГ- Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар
БНДЦХ- Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс
НДЦХ- Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс
Архангай г.м.- Армаг дахь цагдаагийн газар, хэлтсийг
тухайн аймгийн нэрээр нь оруулсан.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА,
НЭГЖ ДЭХ ЗӨВЛӨЛ, КОМИСС, БАГ, АЖЛЫН ХЭСГИЙН
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Бүтцийн нэр	Үйл ажиллагааг нь хариуцсан нэгж
<i>Нэг. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд нэг байдаг бүтэц</i>		
1.1	Бодлогын зөвлөл /Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын төслийг боловсруулах, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах г.м/	Хуулийн хэлтэс
1.2	Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Салбар хороо	Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс
1.3	Жендэрийн дэд зөвлөл	Тодорхойгүй
1.4	Сургалт, арга зүйн зөвлөл	Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс
1.5	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл	Урьдчилан сэргийлэх хэлтэс
1.6	Эрдэмтдийн зөвлөл	Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс
1.7	Тусгай комисс /Тусгай хэрэгслийн ашиглалтын хугацааг тогтоох/	Санхүү, аж ахуйн алба
1.8	Цахим мэдээллийн аюулгүй байдлын баг	Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба
1.9	Мэдээллийн технологи, харилцаа холбооны Бодлогын зөвлөл	
1.10	Холбооны техникийн байнгын комисс	
1.11	Үзмэр худалдан авах зөвлөл	Сүлд чуулга
1.12	Төв архивын дэргэдэх Арга зүйн зөвлөл	Төв архив
1.13	Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөл	Хүний нөөцийн хэлтэс
<i>Хоёр. Байгуулагдаагүй, байгуулах хэрэгцээ шаардлага үүсээгүй, байгуулагдсан эсэх нь тодорхойгүй, энэ талаар холбогдох нэгжээс мэдээлэл ирүүлээгүй бүтэц</i>		
<i>2.1 Байгуулагдаагүй бүтэц</i>		
2.1.1	Эрдэмтдийн зөвлөл	Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс
2.1.2	Цахим мэдээллийн аюулгүй байдлын баг	Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба
<i>2.2 Байгуулах хэрэгцээ, шаардлага үүсээгүй бүтэц</i>		
2.2.1	Тусгай комисс /Тусгай хэрэгслийн ашиглалтын хугацаа тогтоох/	Санхүү, аж ахуйн алба
2.2.2	Үзмэр худалдан авах зөвлөл	Сүлд чуулга

<i>2.3 Байгуулагдсан эсэх нь тодорхойгүй, энэ талаар хариуцсан нэгжээс мэдээлэл ирүүлээгүй бүтэц</i>		
2.3.1	Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөл	Аюулгүй байдлын хэлтэс
2.3.2	Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Салбар хороо	Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс
2.3.3	Жендэрийн дэд зөвлөл	Тодорхойгүй
2.3.4	Цагдаагийн төв байгууллагын Дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус Ажлын хэсэг	Аюулгүй байдлын хэлтэс
2.3.5	Цагдаагийн төв байгууллагын Захиргааны удирдлагын газрын Эрсдэлийг удирдах орон тооны бус баг	Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар
<i>Гурав. Үйл ажиллагаа явуулаагүй удсан, идэвхгүй байдалд орсон бүтэц</i>		
3.1	Бодлогын зөвлөл /Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын төслийг боловсруулах, шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах г.м/	Хуулийн хэлтэс
3.2	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл	Урьдчилан сэргийлэх хэлтэс
3.3	Мөрдөн шалгах ажиллагааны Мэргэжлийн зөвлөл	Эрүүгийн цагдаагийн алба
3.4	Орон тооны бус зөвлөл /Түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг хариуцах/	Нутаг дэвсгэр, чиглэл хариуцсан цагдаагийн байгууллага, нэгж
3.5	Мэдээллийн технологи, харилцаа холбооны Бодлогын зөвлөл	Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТЭС**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд хийх дотоод аудит.

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2021/02

Аудитын хугацаа: 2021.05.17- 2021.06.04

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Д.Борхүү, Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Х.Хатанбаатар

1. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба, нэгжүүдээс гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10, Цагдаагийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалтуудыг удирдлага болгон холбогдох зөрчлийг арилгуулахаар “Мэдэгдэл” бичиж байна.

Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан /мөрдөгч, зөрчил шалган шийдвэрлэх эрхтэй алба хаагчид/-аас мэдэгдэл бичих эрх зүйн үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц мөрдөгч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргана.

Мөн зүйлийн 2 дахь хэсэг “Хуулийн этгээд нь мөрдөгч, прокурорын мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай мөрдөгч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй”, Гэмт хэрэг,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.1.10 дахь хэсэг “Нутгийн захиргааны байгууллага, хариуцсан нутаг дэвсгэр, чиг үүрэгт хамаарах хуулийн этгээд, түүний албан тушаалтанд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл болон түүнийг арилгах тодорхой арга хэмжээний талаар мэдэгдэл, зөвлөмж хүргүүлэх, 30.2 дахь хэсэг “Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 13.1.4 дэх хэсэгт зааснаас бусад этгээдийн мэдэгдэл, зөвлөмж, шаардлагыг хүлээн авсан хуулийн этгээд түүний дагуу тодорхой арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй”, 47.2 дахь хэсэг “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж тус тус тодорхойлон зохицуулсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох нэгж, байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан / мөрдөгч, зөрчил шалган шийдвэрлэх эрхтэй алба хаагчид/-аас гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэн гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах чиглэлээр хуульд заасан үндэслэл журмын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн мэдэгдэл, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, түүний үр дүнг тооцсон байдал.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, алба хаагчдад танилцуулж, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд удирдлага болгох эрх зүйн актууд, алба хаагчдын ажил үүргийн хуваарь, үйл ажиллагааны дэс дараалал, учирч болзошгүй эрсдэл, түүнд тавих хяналтын талаарх мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, алба хаагчдын ажил, үүргийн гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, Мөрдөн байцаах албанаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай биечлэн танилцсан.

Аудитын явцад Мөрдөн байцаах болон Нийтийн хэв журам хамгаалах,

олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Тээврийн цагдаагийн алба, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтэс, тасгийн дарга нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, санал хүсэлтийг сонгон, цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайлангийн төслийг боловсруулсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/111 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /Код 701/”, мөн даргын 2018 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх /Код 702/” журамд зааснаар санг бүрдүүлэхдээ Мөрдөн байцаах албаны мөрдөгч нараас бусад нэгжийн алба хаагчид мэдэгдэл бичиж, хариу авсан талаар санд огт шивж оруулаагүй байна.

3.2 Цагдаагийн байгууллагын хэмжээнд эрх бүхий алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 2021 оны 01 дүгээр улирлын байдлаар 4496 мэдэгдэл бичиж, 3715-т нь хариу авсан ба энэ нийт бичсэн мэдэгдлийн 82.6 хувь болж байна.

Тайлангийн хугацаанд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад 1346 шаардлагыг хүргүүлж, 1261-д нь хариу авсан байна. Энэ нийт бичсэн шаардлагын 93.6 хувийг эзэлж байна.

Мэдэгдэл, шаардлагын дагуу зохих арга хэмжээ авч, хуулийн хугацаанд хариу ирүүлээгүй 52 иргэн, 59 аж ахуй нэгжид хариуцлага тооцсон мэдээг тайланд тусгасан боловч санд оруулж шивээгүйгээс шалтгаалан дээрх тоон мэдээ болон хариуцлага тооцсон этгээдийн талаарх мэдээлэл сангаас харагдахгүй байна.

Иймд дээрх тоон мэдээг нягтлах зорилгоор аудитын хүрээнд цугларсан мэдээллийг Цагдаагийн байгууллагын “system.police.gov” нэгдсэн сангийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад, 4496 мэдэгдэл шивсэн гэх боловч бодит тоо нь 3281 байх бөгөөд 1215 мэдэгдлээр зөрүүтэй, 1346 шаардлага огт шивэгдээгүй байна.

3.3 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/186 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт”-ийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс цагдаагийн байгууллагын харьяа нэгжүүдээс ирүүлсэн мэдээлэл дэх мэдэгдэл, шаардлага хүргүүлсэн, биелэлт тооцсон талаарх мэдээ, тайлан зөрүүтэй гарч байгааг тогтоож, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр Тэргүүн дэд даргын энэ оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 2/179 дугаартай албан бичгээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг хүргүүлсэн байна.

Дотоод аудитын ажлын хүрээнд дээрх үүргийн биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийн тооцоход алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд тухайн чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

3.4 Нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс иргэд, аж ахуй нэгж, байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлж байгаа мэдэгдэл, шаардлага нь хэлбэр, агуулга, утга, найруулгын хувьд алдаатай, үйлдэгдсэн хэрэг, зөрчил бүрт адилхан шалтгаан нөхцөл дурдаж хэт ерөнхий байдлаар бичсэн, хуульд заасан нэг сарын хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй, төсөв хөрөнгө шаардлагатай / камер суурилуулах, гэрэлтүүлэг хийх/ ажил, арга хэмжээг даалгах зэрэг оновчгүй, шаардлага хангахгүй мэдэгдэл, шаардлагыг боловсруулсан байна.

3.5 Мэдэгдэл, шаардлагын мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг тооцох, хариуцлага хүлээлгэх байдал хангалтгүй байгаагаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, ач холбогдол алдагдах эрсдэл үүсч байна.

Энэ нь мэдэгдэл, шаардлагыг бодит нөхцөл байдалд үндэслэн бичихгүй, оновч муутай, ажил хийсэн дүр эсгэж зөвхөн тоо мэдээг есгөсөн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэдэгдэл, шаардлага бичсэн байдлаар буруу ташаа ойлгосон, үр дүн, биелэлтийг тооцох асуудлыг орхигдуулсан, түүний хэрэгжилтэд удирдлагаас тавих хяналт сул байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд дараах байдлаар сайжруулалт хийж, эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

Нэг. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/111 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /Код 701/”, мөн даргын 2018 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх /Код 702/” журмын хэрэгжилтийг хангах зорилгоор “system.police.gov” нэгдсэн санд цагдаагийн байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж байгаа мэдэгдэл, шаардлага бүрийг шивж оруулсан байх, санд шивж оруулсан мэдэгдэл, шаардлагын тоо, биелэлт тооцсон хувийг тухайн нэгжийн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцох нэг шалгуур үзүүлэлт болгох;

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын энэ оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 2/179 дугаартай албан бичгээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлсэн үүргийн

1.8 дахь заалтын биелэлтийг 2021 оны 07 дугаар сарын 22-ны байдлаар тооцож, явцын дүнг Тэргүүн дэд даргад танилцуулж, биелэлт хангалтгүй байгаа байгууллагын дарга нарт хариуцлага тооцох, биелэлт тасарсан ажил, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тогтоож, зөвлөмж хүргүүлэх;

Гурав. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас иргэд, аж ахуй нэгж, байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлж байгаа мэдэгдэл, шаардлага нь хэлбэр, агуулга, утга, найруулга хувьд алдаатай, алба нэгж, алба хаагч бүр өөр өөрийнхөөр бичиж байгаа нь албан бичгийн стандарт шаардлага хангахгүй байгаа тул холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “мэдэгдэл”, “шаардлага”-ыг загварын төсөл боловсруулж, батлуулан, үйл ажиллагаанд мөрдүүлэх;

Дөрөв. Мэдэгдэл, шаардлагын мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг тооцож, хариуцлага хүлээлгэх байдал хангалтгүй байгаагаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, ач холбогдол буурч болзошгүй байна.

Энэ нь мэдэгдэл, шаардлагыг бодит нөхцөл байдалд үндэслэн тодорхой ажил зохиолгох хэмжээнд томьёолж бичихгүй зөвхөн тоо мэдээг өсгөх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэдэгдэл, шаардлага бичсэн байдлаар буруу ташаа ойлгон, үр дүн, биелэлтийг тооцох асуудлыг орхигдуулсан, түүний хэрэгжилтэд шат шатны удирдлагаас тавих хяналт сул байгаагаас шалтгаалж байна.

Иймд мэдэгдэл, шаардлагын мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг бодитой тооцох, мэдэгдэл, шаардлагыг бодит нөхцөл байдалд үндэслэн эрх зүйн үндэслэл, шаардлагыг дурдаж, үр дүнд хүрэхүйц албан бичгийн стандарт, шаардлагад нийцсэн байдлаар боловсруулахад эрх бүхий албан тушаалтнууд анхаарах;

5.ЗӨВЛӨМЖ

5.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/111 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /Код 701/”, мөн даргын 2018 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх /Код 702/” журмын хэрэгжилтийг хангах зорилгоор “system.police.gov” нэгдсэн санд цагдаагийн байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж байгаа мэдэгдэл, шаардлага бүрийг шивж оруулсан байх, санд шивж оруулсан мэдэгдэл, шаардлагын тоо, биелэлт тооцсон хувиар тухайн нэгжийн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцоход анхаарах. /УСХ-ээс зохион байгуулж, ХХ, МБА, ЭЦА, НХЖХОНАБХА-тай хамтран ажиллах/;

5.2. Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын энэ оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 2/179 дугаартай албан бичгээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлсэн үүргийн

1.8 дахь заалтын биелэлтийг 2021 оны 07 дугаар сарын 22-ны байдлаар тооцож, дүнг танилцуулах /УСХ-ээс зохион байгуулж, МБА, ЭЦА, НХЖХОНАБХА-тай хамтран ажиллах/;

5.3. Цагдаагийн байгууллагаас иргэд, аж ахуй нэгж, байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгахаар хүргүүлж байгаа мэдэгдэл, шаардлага нь хэлбэр, агуулга, утга, найруулга хувьд алдаатай, албан бичгийн стандарт шаардлага хангахгүй байгаа тул холбогдох алба, нэгжүүдээс санал авч, “мэдэгдэл”, “шаардлага”-ын загвар боловсруулж, батлуулан үйл ажиллагаанд хэвшүүлэх. /УСХ-ээс зохион байгуулж, ХХ-тэй хамтран ажиллах/;

5.4. Цагдаагийн байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж байгаа мэдэгдэл, шаардлагын мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнг бодитой тооцох, мэдэгдэл, шаардлагыг илэрсэн шалтгаан, нөхцөл байдалд үндэслэн эрх зүйн үндэслэл, албан бичгийн стандарт, шаардлагад нийцсэн байдлаар боловсруулахад шат шатны удирдлагаас хяналт тавьж ажиллах. /УСХ-ээс зохион байгуулж, МБА, ЭЦА, НХЖХОНАБХА, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хамтран ажиллах/.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл:

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.БОРХҮҮ

Ажлын баримт-2004

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсэг, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын сэтгэл зүйчдийн үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын сэтгэл зүйчдийн үйл ажиллагаа.

Аудитын төрөл, код: Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ- ХШДАХ/ ГА-2021/05

Аудитын хугацаа: 2021.05.03-2021.06.18

Аудитын багийн ахлагч: Хяналт, шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт, шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа М.Азжаргал

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд 55 сэтгэл зүйчийн орон тоотойгоос өнөөдрийн байдлаар ажиллаж байгаа 43, жирэмсний амралттай 7, сул орон тоо 5 байна.

Ажиллаж байгаа 43 алба хаагчаас 33 алба хаагч судалгаанд хамрагдсан ба судалгааны дүнг харуулбал;

№	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ажиллаж байгаа сэтгэл зүйч нарын талаарх мэдээлэл	Үзүүлэлт	Хариулт	Хувь
1	Сэтгэл зүйчээр ажилласан хугацаа	0-3	2	6.06
		4-6	11	33.33
		7-10	12	36.36
		11-14	5	15.15
		15 дээш	3	9.09
2	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажилласан жил	0-3	7	21.21
		4-6	9	27.27
		7-10	6	18.18
		11-14	7	21.21
		15 дээш	4	12.12

3	Цалингийн шатлал, зэрэглэл	ТТ-13	1	1.82
		ТТ-12	7	12.73
		ТТ-11	4	7.27
		ТТ-10	6	10.91
		ТТ-9	37	67.27

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын сэтгэл зүйчдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг нь тооцох, цагдаагийн төв байгууллагын дарга, удирдлагыг мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн мэргэжлийн давтан сургалтыг хариуцан явуулах чиг үүрэг бүхий Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст оруулж зохион байгуулсан байна.

Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлын үр дүнг тооцох, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах асуудлыг Аюулгүй байдлын хэлтсийн Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсэг, харин алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах асуудлыг тухайн байгууллагын дарга нар хариуцан зохион байгуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаа нь Төрийн албаны болон Цагдаагийн албаны тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчдыг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-938/” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд явагдаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолт”-д зааснаар удирдах ажилтны удирдлагын болон харилцааны хэв маягийг тодорхойлох, мэргэжлийн нөлөө үзүүлэх, санал асуулга авч, шинжилгээ хийх, алба хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, нийт алба хаагчдыг сэтгэл зүйн дарамт, стрессээс урьдчилан сэргийлэх, тэдэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн судалгаа, сэтгэцэд оношилгоо хийх, сургалт, мэдээлэл хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал хийх, гэрч, хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх, мэргэшлийн сонгон шалгаруулалт, албан тушаал дэвшихэд нь сэтгэл зүйн ярилцлага хийх гэсэн нийтлэг ажил, үүрэг гүйцэтгэхээр тодорхойлжээ.

Аюулгүй байдлын хэлтэст дээрх нэгж байгууллагдахаас өмнө 2001 оноос 2021 он хүртэлх хугацаанд сэтгэл зүйчдийн ажил, үүргийн хуваарь тодорхой бус, тэдний ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлт

байхгүй, бүтэц, зохион байгуулалт, орон тооны хувьд хаана харьяалагдах, аль нэгжээс мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах талаар сэтгэл зүйчид нэгдсэн ойлголт, мэдээлэлгүй явж ирсэн байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйч орон тоонд ажиллаж буй алба хаагчдын үйл ажиллагаа”-нд дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Аудитад цагдаа, дотоодын цэргийн байгууллагад сэтгэл зүйчийн орон тоонд ажиллаж буй алба хаагчдын чиг үүрэг, үйл ажиллагаа, ажлын үр дүнг хамруулна.

Ингэхдээ тэдгээрийн ажлын байрны үндсэн чиг үүрэг буюу сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд тулгуурлах бөгөөд цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулаагүй болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын сэтгэл зүйчдийн ажлын мэдээ, тайлантай танилцаж, ажлын орчин нөхцөл, сэтгэл ханамжийн талаарх судалгааг авч, Хүний нөөцийн болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Аюулгүй байдлын хэлтсийн Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсэг, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа сэтгэл зүйч нартай ярилцлага хийгдсэн.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх / код 938/ журам”-ын 938.8.1-д “Цагдаагийн сэтгэл зүйчийн өдөр тутмын үйл ажиллагааг тухайн байгууллагын дарга хариуцаж, үнэлэх бөгөөд мэргэжил, арга зүйгээр хангах ажлыг нийслэлд Нийслэлийн цагдаагийн удирдах газар, бусад алба, нэгж болон орон нутагт сургалт хариуцсан нэгж хариуцна” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд сэтгэл зүйчийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байхгүй, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн ажлын дүн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр авч, нэгтгэн үнэлж, дүгнэсэн, Цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулсан тухай баримт материал байхгүй байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйч нь ажлаа улирал, жилээр төлөвлөж, алба хаагчийн ажлыг үнэлэх журамд заасны дагуу тайлан, мэдээг гаргаж, шууд удирдах даргадаа танилцуулан

үнэлүүлж, дүнг цагдаагийн төв байгууллагын хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгжид улирал бүр тайлагнах, цагдаагийн төв байгууллагын хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж, цагдаагийн нэгж, байгууллагын сэтгэл зүйчийн тайлан, мэдээ, үнэлгээг нэгтгэн илтгэх хуудсаар цагдаагийн төв байгууллагын удирдлагад хагас, бүтэн жилээр танилцуулж, нэгж, байгууллагуудад мэдээлэл хүргүүлэх эрх зүйн зохицуулалттай боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Үүнээс шалтгаалан сэтгэл зүйчдийн үйл ажиллагаа урсгалаар явагдах, сэтгэл, сэтгэл зүйн чиглэлийн мэргэжлийн нэгж байхгүйгээс сэтгэл зүйчдийг удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах үйл ажиллагаа тасалдах, чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод хамаарахгүй ажил, үүргийг гүйцэтгэх, удирдлага, хамт олны дунд сэтгэл зүйч мэргэжлийн талаарх ойлголт дутмаг байгаа нь тэднийг алба, мэргэжилдээ хандах хандлагыг сулруулах эрсдэл үүсэхээр байна.

3.2 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ын 938.7.1-д “Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйч нь мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгайлан тохижуулсан өрөөтэй байх бөгөөд өрөөнд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэлтэй байна” гэж заасан боловч судалгаанд хамрагдсан 32 анги, байгууллагаас зориулалтын өрөө, тасалгаа байхгүй 9, өрөөний гэрэлтүүлгийн хэрэгсэл байхгүй 10, компьютер, дагалдах хэрэгсэл байхгүй 4, хөгжмийн хэрэгсэл байхгүй 24, зурагт, дэлгэцгүй 22, проектор байхгүй 25, дуу, дүрсний бичлэгийн хэрэгсэл байхгүй 25, судалгааны арга зүй, дагалдах хэрэгсэл байхгүй 14, бусад орчин үеийн ашиглагдаж байгаа оношилгоо, сэтгэл зүйн багаж, техник хэрэгсэл байхгүй 27 анги, байгууллага байна.

3.3 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ын 938.5.9-д “Цагдаагийн сэтгэл зүйчийн ажиллаж байгаа байгууллагын удирдлага нь сэтгэл зүйчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагаа нэмэгдүүлэхэд байнга суралцаж, өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн сургалтад хамрагдах, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний явцад гарсан ололт, амжилт, шинэлэг арга хэлбэр, бүтээлч ажлыг бусад байгууллагын сэтгэл зүйчидтэй туршлага, мэдээллээ солилцон ажиллах, мэргэжлийн чиглэлээр онол, практикийн хуралд оролцох, илтгэл, тавих, нийтлэх, гарын авлага, зөвлөмж, тараах материалыг боловсруулж, ашиглах зэрэг ажилд дэмжлэг үзүүлж, шаардлагатай тохиолдолд төлбөрийг хариуцаж болно” гэж заажээ.

Гэтэл судалгаанд хамрагдсан 33 сэтгэл зүйчдийн 14 буюу 42.4 хувь нь сэтгэл зүйчийн ажлыг бодитой дүгнэдэггүй, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад орох зайлшгүй шаардлагатай, 20 буюу 60.6 хувь нь удирдах албан тушаалтнууд сэтгэл зүйчийн ажлыг ойлгодоггүй, дэмждэггүй, үл

ойшоодог, нууц хадгалдаггүй, 28 буюу 84.8 хувь нь үндсэн ажил, үүргээ гүйцэтгэж чаддаггүй, албан тушаалын тодорхойлолтод заагаагүй ажил, үүргээ хариуцуулдаг гэжээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад ажиллаж буй нийт 50 сэтгэл зүйчдийг ажилласан жилээр ангилан үзвэл 4-10 жил ажилласан 23 алба хаагч буюу 46, 3 хүртэл жил ажиллаж байгаа 15 алба хаагч буюу 30, 11-ээс дээш жил ажиллаж байгаа 11 алба хаагч буюу 22 хувийг эзэлж байна. Тэднээс эрх зүйч мэргэжлээр суралцаж төгссөн, суралцаж байгаа 25 алба хаагч буюу 50 хувь нь байна.

Мөн алба хаагчдаас сэтгэл зүйч албан тушаалд ажиллах явцдаа эрх зүйчээр суралцаж төгсөөд өөр төрөл, мэргэжлийн алба руу шилжин ажиллах тохиолдол нилээдгүй гарч байна.

Энэхүү байдал нь төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст ажиллаж байгаа сэтгэл зүйч албан тушаалын цолны зэрэглэл /цагдаагийн ахмад, цалингийн шатлал ТТ-9/-тэй холбоотой төдийгүй цаашид сэтгэл зүйч мэргэжлийн үнэлэмж буурах, энэ мэргэжлээр тогтвортой ажиллах алба хаагчгүй болох, сэтгэл зүйчдийн үйл ажиллагаанд доголдол үүсэх эрсдэлтэй байна.

3.4 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ын 938.6.4-т “Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд хамрагдсан алба хаагчид сэтгэл зүйн картыг нээж, хөтлөх бөгөөд алба хаагч шилжсэн тохиолдолд тухайн байгууллагын сэтгэл зүйчид шилжүүлэх ба халагдсан, тэтгэвэрт гарсан тохиолдолд хувийн хэрэгт нь хадгална” гэж заасан.

Гэвч судалгаанд хамрагдсан 32 анги, байгууллагын сэтгэл зүйчид 2018 онд 1652, 2019 онд 1784, 2020 онд 1214 нийт 4650 алба хаагчдад сэтгэл зүйн карт нээсэн боловч алба хаагчдын шилжилт, хөдөлгөөнийг хийгээгүй, картыг шинээр томилогдсон нэгж рүү нь явуулдаггүй, халагдсан, тэтгэвэрт гарсан тохиолдолд хувийн хэрэгт хадгалах зэргээр баяжилт хөдөлгөөн хийх, хянах, баримтжуулах үйл ажиллагаа хангалтгүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйч орон тоонд ажиллаж буй алба хаагчдын үйл ажиллагаанд дараах байдлаар сайжруулалт хийж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

Нэг. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст сэтгэл зүйчдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг тооцох, цагдаагийн төв байгууллагын дарга, удирдлагыг мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн давтан сургалтыг хариуцан явуулах чиг үүрэг бүхий Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсгийг байгуулсан нь оновчтой шийдэл болсон байна.

Иймд тухайн нэгжээс сэтгэл зүйчийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах, сэтгэл зүйчийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн ажлын дүн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр авч, үнэлж, дүгнэх, Цагдаагийн төв байгууллагын удирдлагыг бодит мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.

Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ын 938.7.1 “Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйч нь мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх тусгайлан тохижуулсан ерөөтэй байх бөгөөд ерөөнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэлтэй байна” гэсэн заалтын хэрэгжилтийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд хангуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох.

Гурав. Төрийн албаны болон Цагдаагийн албаны тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчдыг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолт”-д нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ыг шинэчлэн боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулах.

Дөрөв. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд хамрагдсан алба хаагчдын сэтгэл зүйн байдлын талаарх мэдээллийн санг цахимжуулж, хүний нөөцийн мэдээллийн сантай холбох асуудлыг судалж шийдвэрлэх, баяжилт хөдөлгөөнийг шуурхай хийх, хяналт, нууцлал, ашиглалтыг сайжруулах.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

5.1. Цагдаагийн сэтгэл зүйчийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа сэтгэл зүйчдийн ажлын дүн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр авч, үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулах /АБХ, ХНХ, ТЗБХ, ЦДЦАБ/;

5.2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ын 938.7.1 дэх заалтын хэрэгжилтийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд хангуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох /АБХ, ЦДЦАБ/;

5.3. Төрийн албаны болон Цагдаагийн албаны тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчдыг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолт”-д нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх /код 938/ журам”-ыг шинэчлэн боловсруулж, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /АБХ, ХХ, ЦДЦАБ/;

5.4. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд хамрагдсан алба хаагчдын сэтгэл зүйн байдлын талаарх мэдээллийн санг цахимжуулж, хүний нөөцийн мэдээллийн сантай холбох асуудлыг судалж шийдвэрлэх, баяжилт хөдөлгөөнийг шуурхай хийх, хяналт, нууцлал, ашиглалтыг сайжруулах /АБХ, ХНХ, МТХТ, ЦДЦАБ/;

5.5. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

5.6. Аудитын хүрээнд сэдэвт тусгагдсан асуудлаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 32 нэгж, болон удирдлага, сэтгэл зүйчидтэй ярилцлага хийж, саналыг тайланд тусгасан болохыг илтгэн танилцуулъя.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл:

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2021 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ж.БОЛД ТАНАА

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдалд хийх дотоод аудит

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага.

Аудитын төрөл, код: Санхүүгийн аудит, ЦЕГ-ХШДАХ/СА-2021/06

Аудитын хугацаа: 2021.05.24- 2021.06.25

Аудитын багийн гишүүн Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын шийдвэрээр цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийн дагуу нутаг дэвсгэрт нэмэлтээр эргүүлийн үүрэг гүйцэтгэсэнтэй холбогдуулан аудитын хэрэгжих хугацаа ажлын 10 хоногоор хойшилсон болно.

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Аудитын ажлыг эхлэхийн өмнө, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлагуудад аудит хийх зорилго цар хүрээг танилцуулж, хамтран ажиллах хүсэлтээ илгээснээр холбогдох мэдээллийг цуглуулж, дүгнэлт хийсэн.

Аудитын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын эзэмшилд байгаа барилга, байгууламжийн чанар, ашиглалт, бүртгэл, эдэлбэр газрын зөвшөөрөл, захирамж, газрын /м.кв-ын/ хэмжээ, өмчийн бүртгэлээс шалтгаалан үүссэн маргаан байгаа эсэх талаар тодруулж, судалгаа хийлээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын эзэмшин, ашиглаж буй нийт 426 эдэлбэр газар дээр контор, кобан, Түр хамгаалах болон Эрүүлжүүлэх, саатуулах байр, зуслан, спорт заал, сургалтын төв, цэргийн анги, амралт сувилал, автограж зэрэг аж ахуйн зориулалтаар /Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа нэгжид 158, Нийслэлийн цагдаагийн газар, дүүрэг дэх цагдаагийн хэлтэст 70, хөдөө орон нутгийн цагдаагийн байгууллагын эзэмшиж буй газар 625/ нийт 138.170.104.626.56 төгрөгийн

дансны үнэлгээтэй 856 барилга, объект байрлаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагын эзэмшилд байгаа барилга, байгууламжийн чанар, ашиглалт, бүртгэл, эдэлбэр газрын зөвшөөрөл, захирамж зэрэгт 2017 оны 04 дүгээр улиралд ажлын хэсэг томилон шалгалт явуулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулан холбогдох нэгжүүдэд үүрэг, ажлын чиглэл өгсөн байна.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21- ний өдрийн 193 дугаар тогтоолын дагуу эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга, байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан хийж гүйцэтгэсэн байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

“Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдал”-д дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход энэхүү аудитын зорилго оршино.

2.2 Аудитын цар хүрээ:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын эзэмшилд байгаа барилга, байгууламж, тэдгээрийн чанар, ашиглалт, бүртгэл, эдэлбэр газрын зөвшөөрөл, захирамжийн хүчин төгөлдөр байдал зэргийг хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт:

Дотоод аудитыг хэрэгжүүлэхийн тулд түүнд шаардлагатай хууль, тогтоомж, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлагаас албан бичгээр болон цахим хэлбэрээр мэдээллийг авч нэгтгэж, тулган баталгаажуулах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх аргуудыг ашиглан дүгнэлт хийлээ.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 2017 оны 04 дүгээр улиралд Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагын эзэмшилд байгаа барилга, байгууламжийн чанар, ашиглалт, бүртгэл, газрын зөвшөөрөл, захирамж зэргийг ажлын хэсэг томилон шалгасан бөгөөд түүний мөрөөр илэрсэн алдаа, дутагдал, зөрчлийг шийдвэрлэх талаар холбогдох нэгжүүдэд чиглэл өгөгдсөн байх бөгөөд 2021 оны 6 дугаар сарын байдлаар түүний биелэлт, үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

3.1 Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, 11 дүгээр хорооллын зам дагуу байрлаж байсан тус дүүргийн нэгдүгээр хэлтсийн 3 хэсгийн кобаны

барилга нь 1989 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад орсон бөгөөд 2,109,700 төгрөгийн өртөгтэй данс бүртгэлд тусгагдсан. Уг газрын барилга дээр Нийслэлийн Засаг даргын 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 125 тоот захирамжаар цагдаагийн кобан, хорооны барилга шинээр барих зөвшөөрөл олгосныг үндэслэн цагдаагийн кобаныг 2005 оны 6 дугаар сард буулган “Өсөх 5 эрдэнэ” ХХК-иар барилга бариулахаар гэрээ хийсэн боловч өдийг хүртэл баригдаагүй байна.

Мөн дүүргийн Засаг даргын 2011 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 437 тоот шийдвэрээр хороо, цагдаагийн хэсгийн нэгдсэн цогцолбор, орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаатай 0299591 дугаартай газар эзэмших гэрчилгээ олгогдсон ч түүнийг хаяж үрэгдүүлжээ.

2005 оны 6 дугаар сард “Өсөх 5 эрдэнэ” ХХК нь Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай тус хорооны цагдаагийн барилгыг өөрийн хөрөнгөөр барих гэрээ хийсэн боловч барилга баригдаагүй хэвээр байна.

Иймд 2012 оноос хойш одоог хүртэл Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас газар эзэмших эрхтэй холбоотой асуудлаар хөрөнгийн маргаан үүсгэн шийдвэрлүүлэхээр харьяа шүүхэд гомдол гарган ажиллаж байна.

3.2 Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Улсын Багшийн Их Сургуулийн урд байрлах цагдаагийн хэсгийн кобан нь байгууллагын дансанд 1,911,735 төгрөгийн үнийн дүнтэй бүртгэгдэж, 1998 оноос одоог хүртэлх хугацаанд тус дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэс болон Замын цагдаагийн хэлтсийн 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид ашиглаж байгаа ч газар эзэмших эрхийн бүртгэл хийгдэж, гэрчилгээ аваагүй байна.

3.3 Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Жанжин Д. Сүхбаатарын талбайн урд байрлах цагдаагийн пост нь балансад 387,013 төгрөгийн данс бүртгэлтэй, 2016 онд хуучин постыг буулган шинээр барьж тус дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 6 алба хаагч /24:48 цагаар/ байрлан нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэж байна. Пост байрлах газар нь эзэмших эрхийн бүртгэл хийгдэж, гэрчилгээ аваагүй байна.

3.4 Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо, 100 айл дахь цагдаагийн пост нь 881,999 төгрөгийн данс бүртгэлтэй боловч газар нь данс бүртгэлд тусгагдаагүй, гэрчилгээ аваагүй байна.

Тухайн газрыг эзэмших эрхийн талаар “Пирамид өргөө” ХХК-тай шүүхийн маргаантай байсан тул Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж, тус шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11/ШШ2018/0019 дугаартай захирамж гарч, тухайн компани нь 100 хувь өөрийн хөрөнгөөр постын байрыг барьж ашиглалтад оруулах, талууд үл хөдлөх хөрөнгийг 50:50 хувиар өмчлөх, газрыг 50:50 хувиар эзэмших байдлаар барилгын ажил гүйцэтгэх гэрээ хийжээ.

Мөн барилга баригдаагүй нөхцөлд “Пирамид өргөө” ХХК нь Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст газрыг үл маргах

журмаар шилжүүлэн өгөхөөр харилцан тохиролцсон ба одоо барилгын ажил 99.0 хувийн гүйцэтгэлтэй, улсын комиссын даалгавар гүйцэтгэгдэж, комисс хүлээн авсны дараа ашиглалтад оруулахаар байна.

3.5 Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо, Ойчдын 1-1 хаягт байрлах тус дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн барилга нь данс бүртгэлд тусгагдаагүй, орлогод авагдаагүй, 000439182 тоот газар эзэмших гэрчилгээтэй байна.

Газар эзэмших гэрчилгээ нь 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 15 жилийн хугацаанд конторын зориулалтаар олгогдож, барилга нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдсан ч гүйцэтгэгч компаниас эдэлгээний явцад учирсан эвдрэл, гэмтлийг засварлаж өгөөгүй, маргаантай байдаг шалтгаанаар улсын комисс хүлээж аваагүй байна.

3.6 Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо, 7 буудал дахь 30м² хоосон газрыг дүүргийн Засаг даргын 2015 оны А/450 дугаар захирамжаар тус дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтэст цагдаагийн кобаны зориулалтаар эзэмшүүлсэн байна. Гэвч одоогоор кобан баригдаагүй, 7 буудлын автобусны буудал, автомашины зогсоол байрлаж байна.

3.7 Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, “Авто-вокзал”-ын хашаанд байрлах “Иргэдэд үйлчлэх төв” нь данс бүртгэлд 17,350,200 төгрөгөөр бүртгэгдэж, 2013 онд ашиглалтад оржээ.

Уг төвийг тус дүүргийн хэсгийн байцаагч, цагдаа нар үйл ажиллагаа явуулахдаа ашиглаж байгаа бөгөөд цэвэр, бохир усны шугамд холбоогүй, газар эзэмших эрхийн гэрчилгээгүй байна.

3.8 Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах 116,2 м/кв талбайтай 1 давхар барилга нь 2004 онд ашиглалтад орсон, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газарт данс бүртгэлтэй, газар эзэмших гэрчилгээтэй, 2016, 2018, 2021 онуудад урсгал засвар хийгдэж байсан байна.

Албаны үйл ажиллагаа явагдаж байна гэдэг байдлаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газраас тайлан ирүүлсэн боловч бодит байдлаар 2018 оноос хойш үйл ажиллагаа явагдаагүй байна.

3.9 Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, “Бөмбөгөр худалдааны төв”-ийн зүүн талд байрлах кобаны барилга нь 54м/кв талбай бүхий 0177818 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй, Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн үндсэн хөрөнгийн дансанд 6,000,000 /зургаан сая/ төгрөгийн өртөгтэй бүртгэгдсэн байна.

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс уг кобаны барилгыг 2000-2008 онд үйл ажиллагаандаа ашиглаж байсан. Гэвч 2014 онд “Оршил” ХХК нь тухайн кобаны барилгад тулган, агаараар давуулан 16 давхар барилгыг барьсан нь кобаны барилгыг ашиглах, сэргээн засварлах боломжгүй болгожээ.

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсээс Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн анхан шатны шүүхэд кобаны барилгыг ашиглах, сэргээн засварлах боломжгүй болсон шалтгаанаар хохирол барагдуулах, шинээр барилга, байгууламж бариулах асуудлаар хандсан

боловч хариуцагч тал тодорхой болоогүй гэсэн шалтгааны улмаас шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн байна. Иймд дахин шүүхэд нэхэмжлэл гаргахаар ажиллаж байна.

3.9 Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Төв байрны баруун талд 2002 онд 187м/кв талбайд шуурхай албаны зориулалтаар /албаны/ 5 автомашины тоосгон граж барьж ашиглалтад оруулснаар албаны бэлэн байдлыг ханган ажиллаж байжээ.

Тус цагдаагийн хэлтсийн дарга асан, цагдаагийн хурандаа П.Батбаатар 2016 онд “Альфа кредит” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 5 автомашины гражийг буулган барилгын ажил эхлүүлсэн боловч 2015-2017 онуудад ажиллаж байсан Цагдаагийн ерөнхий газар болон Санхүү, аж ахуйн албаны дарга, тус дүүргийн удирдлагуудын шийдвэрээр хийгдсэн ажил тухай бүр өөрчлөгдсөнөөс шалтгаалан өнөөдрийн байдлаар данс бүртгэлд тусгагдсан болон газар эзэмших эрхийн гэрчилгээтэй дулаан граж нь бодитоор баригдаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

2013 онд Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтсийн аж ахуйн ажилтны орон тоог татан буулгаснаар барилга байгууламж, хөрөнгийн чанар байдал, засвар үйлчилгээнд тавигдах хяналт суларч, газар эзэмшилт, ашиглалт, кадастрын хэмжээнд хяналт тавих ажил хариуцах эзэнгүй болсноос дээрх зөрчлүүд гарахад нөлөөлжээ.

Санхүү, аж ахуйн албанаас хийгдсэн шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил, дутагдал, зөвлөмжийн дагуу тодорхой хэсэг нь засагдсан хэдий ч Нийслэлийн цагдаагийн газар болон дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтсийн удирдлагад өгөгдсөн зарим үүргүүд хэрэгжээгүй байгаа нь маргаантай асуудлууд нэг мөр шийдвэрлэгдэхгүй байх шалтгаан болж байна.

Аудитыг Улсын онцгой комиссоос тогтоосон дэглэм, журмын хүрээнд төв, орон нутгийн нэгж тус бүрээр орж газар дээр ажиллах боломжгүй байсан тул Санхүү, аж ахуйн албанаас урьд хийгдсэн шалгалтын дүнгийн хэрэгжилт, тэдгээрийн өгсөн тайлбар, мэдээллийг шаардан авч, тулган баталгаажуулж ажилласан болно.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын багаас цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд үндэслэн илэрсэн асуудлыг арилгуулах, шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох нэгж, албан тушаалтанд дараах зөвлөмжийг хүргүүлэх саналтай байна. Үүнд:

5.1 Санхүү, аж ахуйн албанд:

5.1.1 Цагдаагийн байгууллагын хэмжээнд барилга, байгууламж, газар эзэмших бүртгэлийн нэгдсэн сан үүсгэн барилгын ашиглалт, хамгаалалт, их засвар, урсгал засварын мэдээллийг тогтмол оруулж цахим хувийн хэрэг хөтлөх, мөн газар эзэмших гэрчилгээ, гэрээ, хугацаа,

төлбөр тооцоо, кадастрын зураглал зэргийг нэгтгэн харуулах, хянах, бүртгэлжүүлэх, удирдах, тухайн газар дээрх объектын зураг зэргийг харуулах боломжтой нэгдсэн програм хангамжтай болох талаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албатай хамтран ажиллах.

5.1.2 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын газар болон үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхийн маргаантай нэгжүүдийн судалгааг гаргаж, маргаантай асуудлыг тэдгээрийг шуурхай эцэслэн шийдвэрлэх талаар Хуулийн хэлтэс болон холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах.

5.2 Хүний нөөцийн хэлтэст:

5.2.1 Дүүргүүд дэх цагдаагийн газар, хэлтэст аж ахуйн ажилтны орон тоог бий болгох нөхцөл боломжийг судлан, шийдвэрлүүлэх.

ЗУРГАА. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдалд хийх дотоод аудитын хүрээнд дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтсийн удирдлагуудад өгөгдсөн үүргийн хэрэгжилтийг авч, тодруулга хийн ашигласан болохыг илтгэн танилцуулъя.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл: _____

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

Ч.ЭРДЭНЭБОЛОР

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

/2021 оны 2 дугаар улирлын байдлаар/

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагаас 2021 оны 2 дугаар улиралд байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдал, тухайн хуулийн хэрэгжилтийг хангах талаар Цагдаагийн ерөнхий газраас авч хэрэгжүүлсэн ажлыг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

НЭГ. МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛЖ БАЙГАА БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ:

Шилэн дансны тухай хуулийн 3.1-д заасны дагуу 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын шилэн дансны мэдээлэл хариуцсан 58 албан тушаалтнаас нэгдсэн системд 16 төрлийн мэдээллийг байршуулж, олон нийтэд тайлагнасан байна.

ХОЁР. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ:

Мэдээлэл байршуулсан давтамжийг хугацаагаар тооцож үзэхэд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар нэг байгууллага 16 төрлийн мэдээг давтамжтайгаар 74 удаа, системийн хэмжээнд нийт 3763 мэдээллийг 100 хувь мэдээлсэн ба тайлант хугацаанд байршуулаагүй мэдээ байхгүй, 23 мэдээг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийн байдлыг дүгнэж үзвэл дундаж үзүүлэлтээр **99.3 хувьтай** байна.

ГУРАВ. БАЙРШУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ:

Цагдаагийн ерөнхий газраас Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 6 төрлийн мэдээллийг жил, хагас жил, сар бүр, тухай бүр гэсэн хугацааны давтамжтайгаар байршуулж байна.

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

1. Мэдээллийг төрөл, байршуулсан хугацаагаар нь ангилсан байдал:

№	Байршуулах мэдээллийн төрөл	Байршуулах мэдээ	Мэдээлсэн	Хугацаандаа	Хоцорсон	Байршуулаагүй мэдээлэл
1	2	3	4	5	6	7
1. Төсөв гүйцэтгэл						
1	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	424	424	424	-	-
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	318	318	316	2	-
4	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	-	-	-	-	-
5	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)	-	-	-	-	-
6	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	318	318	313	5	-
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
8	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
9	Санхүүгийн тайлан (Хагас жилээр)	-	-	-	-	-
10	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	53	53	52	1	-
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт						
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	53	53	52	1	-
2	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	371	371	370	1	-
3	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	318	318	315	3	-

4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	318	318	314	4	-
5	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жил)	-	-	-	-	-
3. Бусад						
1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	318	318	318		-
2	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	318	318	314	4	-
3	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-
4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	318	318	317	1	-
5	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	318	318	318	-	-
6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)	318	318	317	1	-
НИЙТ ДҮН		3763	3763	3739	23	-

2. Мэдээллийг нэгж, байршуулсан хугацаагаар нь харуулсан байдал:

№	Нэгжийн нэр	Байршуулах мэдээ	Байршуулсан мэдээ		Хувиар
			Хугацаандаа	Хоцорсон	
1	Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба	74	74	-	100
2	Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар	74	74	-	100
3	Эрүүгийн цагдаагийн алба	74	74	-	100
4	Тээврийн цагдаагийн алба	74	74	-	100
5	Мөрдөн байцаах алба	74	74	-	100
6	Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба	74	68	6	92
7	Экологийн цагдаагийн алба	74	74	-	100
8	Эргүүл хамгаалалтын газар	74	74	-	100
9	Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар	74	73	1	98.6
10	Цагдаагийн ерөнхий газрын Автобааз	74	74	-	100
11	Цагдаагийн ерөнхий газрын Гэрээт хамгаалалт	74	74	-	100
12	Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төв	74	74	-	100
13	Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төв	74	74	-	100
14	Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хороо	74	73	1	98.6
15	Цагдаагийн ерөнхий газрын цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын "Сүүж уул" сэргээн засах сувилал	74	71	3	95
16	Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулга	74	74	-	100

17	Дотоодын цэргийн дугаар анги 05	74	73	1	98.6
18	Дотоодын цэргийн дугаар анги 805	74	74	-	100
19	Архангай аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
20	Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
21	Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
22	Булган аймаг дахь цагдаагийн газар	74	73	1	98.6
23	Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
24	Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
25	Дорноговь аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
26	Дорнод аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
27	Дундговь аймаг дахь цагдаагийн газар	74	70	4	95
28	Завхан аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
29	Орхон аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
30	Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
31	Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
32	Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
33	Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
34	Төв аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
35	Увс аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
36	Ховд аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
37	Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар	74	73	1	98.6

38	Хэнтий аймаг дахь цагдаагийн газар	74	74	-	100
39	Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс	74	74	-	100
40	Дорноговь аймаг Замын үүд дэх сум дундын цагдаагийн хэлтэс	74	74	-	100
41	Сэлэнгэ аймаг дахь Мандал сумын цагдаагийн хэлтэс	74	74	-	100
42	Сэлэнгэ аймаг дахь Сайхан сумын цагдаагийн хэлтэс	74	74	-	100
43	Өвөрхангай аймаг дахь Хархорин сум дундын цагдаагийн хэлтэс	74	74	-	100
44	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	74	74	-	100
45	Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар	74	73	1	98.6
46	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар	74	74	-	100
47	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар	74	74	-	100
48	Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар	74	74	-	100
49	Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар	74	74	-	100
50	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар	74	74	-	100
51	Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	74	74	-	100
52	Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	74	70	4	94.6
53	Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	74	74	-	100
НИЙТ ДҮН		3763	3740	23	99.3

ДӨРӨВ. ЦАХИМ ХУУДАСНЫ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВЬСАН БАЙДАЛ:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой гарч буй алдаа зөрчлийг арилгах, сайжруулах зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын

төлөвлөгөө"-ний 2.12-т заасны дагуу энэ оны 2, 7 дугаар сард 2 удаа дотоод аудит хийж гүйцэтгэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын 2020 оны жилийн эцсийн аудитын тайлан, мэдээг нэгтгэн гаргаж, хуулийн хэрэгжилтийг хангах талаар цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан ажлын тайланг, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 3/18 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд цахим болон бичгээр хүргүүлсэн.

Үндэсний аудитын газраас 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, 7897 мэдээллээс 7561 мэдээллийг хугацаанд нь 336 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлснийг "Шилэн дансны мэдээлэл" хэсэгт тайлагнаж, 415/АО160060 дугаартай "Зөрчил арилгуулах тухай" албан шаардлага ирүүлсэн.

Мөн Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Сүхбаатар дүүрэг дэх болон, Баянхонгор, Хөвсгөл, Хэнтий, Говьсүмбэр, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дундын цагдаагийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийслэл болон тухайн орон нутаг дахь аудитын газраас аудит хийж, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, цалингаас бусад 5 саяас дээш гүйлгээг илүү, дутуу оруулж, өссөн дүнгээр мэдээлээгүй, тендер шалгаруулалттай холбоотой нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг мэдээлээгүй, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбар, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг мэдээлээгүйгээс албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Шилэн дансны хуульд заасан мэдээллийг өөрийн байгууллагын болон www.shilendans.gov.mn гэсэн цахим хуудсанд үнэн зөв, бүрэн мэдээлж, улирлын тайланг хуулийн хугацаанд илгээх талаар болон 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн байгууллагын мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах үүргийг Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн даргын 2021 оны 3а/35, 3а/2203 дугаар албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн.

ТАВ. ДҮГНЭЛТ:

Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагаас шилэн дансны цахим хуудсанд 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 3763 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан бөгөөд хугацаанд нь 3740, хугацаа хоцорч 23 мэдээлэл байршуулсан.

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийн дүнг нэгтгэж үзвэл дундаж үзүүлэлтээр **99.3 хувьтай** байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд хугацааны хувьд 99.3 хувьтай байгаа ч олон нийтэд 100 хувь мэдээлэгдсэн нь төсвийн ил тод байдал хангагдаж, иргэдээс төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бий болгосон байх тул уг хуулийн үндсэн зорилтын хэрэгжилт “**ХАНГАЛТТАЙ**” **ТҮВШИНД** байна гэж дүгнэв.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны автомашины ашиглалтад хийсэн дотоод аудит.

Аудитын төрөл, код: Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/ГА-2021/11

Аудитын хугацаа: 2021.10.14- 2021.11.12

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Д.Борхүү, цагдаагийн хурандаа Б.Намгинжав.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын Автобааз нь анх 1926 онд Дотоодыг хамгаалах газрын харъяанд 5 алба хаагчийн орон тоо, “Дож” маркийн автомашинтай “Дотоодыг хамгаалахын граж” нэртэй байгуулагдсан байна.

1990 онд “Дотоодыг хамгаалахын граж”-ыг Нийгмийг аюулаас хамгаалах яамнаас салган “Цагдаагийн ерөнхий газрын Автобааз” гэж нэрлэсэн ба түүний бүтэц, орон тоог Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/59, 2019 оны А/71, 2021 оны Б/108 дугаар тушаалаар 3 удаа шинэчлэн баталсан байна.

Өнөөдрийн байдлаар офицер 26, ахлагч 201, энгийн 30, нийт 257 орон тоотойгоор цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах албаны болон тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр түргэн шуурхай үйлчилж, техникийн бэлэн байдлыг хангах, засвар, үйлчилгээг стандартын дагуу гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Одоо офицер 1, ахлагч 10, энгийн 3, нийт 14 орон тоо дутуу байна.

Автобааз нь өнөөдрийн байдлаар өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 323, Нийслэлийн цагдаагийн газрын өмчид бүртгэлтэй 342, нийт 665 автомашины ашиглалтад хяналт тавьж, эргүүл, жижүүр, эрүүлжүүлэх, шуурхай ажил, тээвэр үйлчилгээ, тусгай зориулалтын болон аж ахуй, хөдөө ажлын чиглэлээр Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаа дотоодын цэргийн анги, байгууллагад албаны автомашинаар үйлчилгээ үзүүлж байна.

Автомашинуудыг үйлдвэрлэсэн улсаар нь ангилвал: Солонгос 587, Япон 79, Орос 86, Хятад 34, Герман 8, Америк 1, Франц 83 автомашин байна.

Зориулалтаар нь ангилвал: Суудлын 394, бага оврын микробус 102, туулах чадвар сайтай автомашин /Жийп /123, том болон дунд оврын автобус 7, тусгай зориулалтын автомашин 17, ачааны 8, мотоцикль 12, чиргүүл 2 байна.

Үйлчилгээний төрлөөр ангилвал: Шуурхай албан ажлын 229, дуудлагын 234, жижүүрийн 42, эргүүлийн 135, эрүүлжүүлэх ажлын 8, тусгай зориулалтын 17 тээврийн хэрэгсэл байна.

Насжилтаар ангилвал: 0-5 жил ашиглагдаж байгаа 289, 6-10 жил ашиглагдаж байгаа 283, 2010 ба түүнээс өмнөх оны 93 тээврийн хэрэгсэл байна.

“Автомашинуудыг тоо, хоногийн гүйлтийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар “Цагдаагийн ерөнхий газар болон түүний харъяа алба, нэгжийн автомашинуудыг тоо, хоногийн гүйлтийн хэмжээ”-г нэгдүгээр, “Нийслэлийн цагдаагийн удирдах газрын болон түүний харъяа нэгжийн автомашинуудыг тоо, хоногийн гүйлтийн хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар баталжээ.

Дээрх тушаалаар автомашинуудыг ашиглалт, хоногийн гүйлтийн хэмжээнд байнгын хяналт тавьж, төсөв хэтрүүлэхгүй ажиллахыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч, ахлах нягтлан бодогч нарт үүрэг болгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, аж ахуйн албаны даргад даалгасан байна.

Санхүү, аж ахуйн албанаас шатахууны тооцооллыг сар бүр хийж, албаны даргаар батлуулдаг ба албаны автомашиныг Автобаазын даргын шийдвэрээр техникийн хувийн хэрэг нээн ашиглалтын хэсгийн дарга, техникийн тоо бүртгэгч нараас цагдаа жолоочид хүлээлгэн өгч, хэрэглэгч байгууллагуудын үйлчилгээнд ажиллуулж байна. Үүнд:

а/ Цагдаагийн ерөнхий газар болон түүний харъяа алба, нэгжийн автомашинаас Цагдаагийн ерөнхий газрын зөвлөлийн гишүүдэд 13, Цагдаагийн ерөнхий газрын хэлтсийн дарга нарт 14, Санхүү, аж ахуйн албанд 2, Мөрдөн байцаах албанд 14, Эрүүгийн цагдаагийн албанд 27, Тээврийн цагдаагийн албанд 49, Экологийн цагдаагийн албанд 9, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд 14, Эрүүл, хамгаалалтын газарт 22, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд 4, Дотоодын цэргийн штабт 4, Хар тамхитай тэмцэх газарт 9, Тусгай ажиллагааны газарт 9, Төмөр зам дахь цагдаагийн газарт 8, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэст 4, Бүртгэл хяналтын төвт 2, Хангалт үйлчилгээний төвд 2, Мэдээлэл технологийн төвд 2, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст 3, “Хүч” спорт хороонд 1, Төв архивт 1, Хэвлэл мэдээллийн төвд 2, Сүлд чуулгад 1, Автобаазад 20, тусгай зориулалтад 16, хүн тээвэрт 7, ачаа тээвэрт автомашин 8, /дугуйт

мотоцикл 12/ Ахмадын холбоонд 1, ашиглалтын хугацаа норм дууссан үлдэх өртөггүй актлах саналтай 43 нийт, 323 автомашин хэрэглэгч байгууллагад үйлчилж байна.

б/ Нийслэлийн цагдаагийн удирдах газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашинаас Нийслэлийн цагдаагийн удирдах газарт 16, Мөрдөн шалгах газарт 9, Нийтийн хэв журам хамгаалах газарт 7, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газарт 2, Баянгол дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст 13, Баянгол дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст 13, тус газрын Замын цагдаагийн хэлтэст 1, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газарт 2, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 13, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 14, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэст 12, тус газрын Замын цагдаагийн хэлтэст 1, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газарт 2, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 17, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 12, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэст 10, тус газрын Замын цагдаагийн хэлтэст 1, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газарт 2, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 13, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 15, тус газрын Замын цагдаагийн хэлтэст 1, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газарт 2, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 14, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 14, тус газрын Замын цагдаагийн хэлтэст 1, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газарт 2, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 10, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 11, тус газрын Замын цагдаагийн хэлтэст 1, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэст 2, Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 2, Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 1, Сүүж-Уул амралтад 1, Дотоодын цэргийн штабт 2, Бүртгэл хяналтын төвд 1, Эрүүгийн цагдаагийн албанд 2, аж ахуй үйлчилгээнд 2, тусгай зориулалтад 2, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасагт 1, бэлэн байдлын нөөцөд 1, актлах саналтай 29, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст олгох ашиглалтад байсан хуучин автомашины хуваарьт орсон 65, нийт 342 тээврийн хэрэгсэл автомашин хэрэглэгч байгууллагад үйлчилж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн албанд ашиглагдах тээврийн хэрэгсэлд хяналт тавих журам /код-809/-ын 809.3.4-д заасны дагуу цагдаагийн алба, нэгжийн даргад үйлчилдэг автомашин 07:00-07:30, тасаг, хэсэгт болон жижүүр, эргүүл, эрүүлжүүлэх, саатуулах байранд үйлчилдэг автомашин 08:00-08:30 цагт, бичгээр захиалсан дуудлагын автомашин захиалсан цагаар Автобаазын жижүүрийн шалгах механикт автомашины техникийн байдал, жолоочийн эрүүл мэнд, биеийн байдал, холбогдох бичиг баримтыг шалгуулж хэрэглэгч албан тушаалтан, байгууллагын мэдэлд очин ажиллаж байна.

Мөн журмын 809.3.21-т “Автомашин хэрэглэгч байгууллагын удирдах албан тушаалтан нь автомашины ашиглалт, хадгалалт,

хамгаалалтад өдөр тутмын хяналт тавьж, Автобаазтай хамтран ажиллана”, мөн 809.5.2-т “Автомашиныг хэрэглэгчид очсон цагаас эхлэн замын хуудсанд тэмдэглэл хийж, буулгах хүртэлх хугацаанд жолоочийн сахилга хариуцлага, автомашины ашиглалтын байдлыг автомашин хэрэглэгч байгууллага, албан тушаалтан хариуцна” гэж заасны дагуу хэрэглэгч байгууллагын дарга нараас тогтмол хяналт тавьж, хамтран ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын парк шинэчлэлт, нөхөн хангалтын хүрээнд: 2021 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаанд ашиглахаар БНСУ-д үйлдвэрлэсэн “Хьюндай Соната-8” маркийн 2, “Киа рио” маркийн 175, “Киа спортеж” маркийн 77, Япон улсад үйлдвэрлэсэн “Тоёота Ландкрузер-200” маркийн 1, “Тоёота хайс” маркийн 1, «Ниссан Патрол Y61» маркийн 13, «Yamaha Cruх YD110» маркийн мотоцикль 2, ОХУ-д үйлдвэрлэсэн “Уаз-Хантер 315195” маркийн 1, “Газ газель некст” маркийн 4, нийт 275 тээврийн хэрэгсэл нөхөн хангалтаар ирснийг хүлээн авч, ажил үйлчилгээнд гаргасан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар: 2020 онд цагдаагийн байгууллагын парк шинэчлэлт, нөхөн хангалтын хүрээнд Франц улсад үйлдвэрлэсэн “Ренаулт Дастер” маркийн 76, Япон улсад үйлдвэрлэсэн “Ниссан Патрол” маркийн 1, “Ниссан Урван” маркийн 2, Цагдаагийн ерөнхий газрын даргын орлогод авах тушаалаар Япон улсад үйлдвэрлэсэн “Тоёота Ландкрузер-200” маркийн 2, “Ямаха YD110” маркийн 4, Солонгос улсад үйлдвэрлэсэн “Хьюндай Элентра” маркийн 9, “Хьюндай Грандер” маркийн 1, “Хьюндай Соната-8” маркийн 1, “Хьюндай старекс” маркийн 1, “Хьюндай Вэню” маркийн 14, ОХУ-д үйлдвэрлэсэн “Уаз-Хантер 315195” маркийн 1, “Газ газель некст” маркийн 1, нийт 112 тээврийн хэрэгсэл нөхөн хангалтаар ирснийг хүлээн авч, цагдаа жолооч нарт техникийн хувийн хэрэг нээлгэн хариуцуулж ажил, үйлчилгээнд гаргасан байна.

Улаанбаатар цагдаагийн хүрээний автомашинуудын албаны бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 онд давхардсан тоогоор 7816 автомашинд 678 ширхэг техникийн байнгын комиссын актыг үндэслэн 13.302 ширхэг 552.021.921 /таван зуун тавин хоёр сая, хорин нэгэн мянга, есөн зуун хорин нэг/ төгрөгийн сэлбэг хэрэгсэл олгосон бол 16 автомашины гүйлт, норм хүрээгүй сэлбэгийн үнийн зөрүү төлбөр 302.053 /гурван зуун хоёр мянга, тавин гурав/ төгрөгийг эзэмшигч, цагдаа жолоочоор төлүүлж, сэлбэгийг олгожээ.

Мөн 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 4586 автомашинд 349 ширхэг техникийн байнгын комиссын актыг үндэслэн 8813 ширхэг 329.216.078 /гурван зуун хорин есөн сая, хоёр зуун арван зургаан мянга, далан найм/ төгрөгийн сэлбэг хэрэгсэл олгосон бол 20 автомашины гүйлт, норм хүрээгүй сэлбэгийн үнийн зөрүү төлбөр 598.817 /таван зуун ерэн найман мянга, найман зуун арван долоо/ төгрөгийг эзэмшигч, цагдаа жолоочоор төлүүлж, сэлбэгийг олгосон байна.

Автомашины засвар, үйлчилгээ, шатахуун, тослох материал зарцуулалт, сэлбэгийн элэгдэл хорогдлын байдлыг хүснэгтээр харуулбал;

д/д	Он	Нэр	Тоо хэмжээ
1	2020 онд	Шатахуун	1.261.054.107
		Тос	62.150.344
		Сэлбэг	298.113.494
Нийт дүн			1.621.317.945
2	2021 онд	Шатахуун	850.672.418
		Тос	48.182.915
		Сэлбэг	190.944.912
Нийт дүн			1.089.800.245

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автомашины ашиглалтад дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, цаашид учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр холбогдох нэгж, байгууллагад зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Цагдаагийн ерөнхий газрын Автобаазад үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашины ашиглалтын үйл ажиллагааг хамруулсан болно.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг аудитад хамрагдах нэгжийн удирдлага болон алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, авто баазаас албаны автомашины тоо, хуваарь, томилгоо, цагдаа жолооч нарын ажил, үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагааны дэс дараалал, учирч болзошгүй эрсдэл, түүнд тавих хяналтын талаарх мэдээлэл, аудитад шаардлагатай баримт бичгүүдийг гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, алба хаагчдын ажил, үүргийн гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, Авто баазаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай биечлэн танилцсан.

Аудитын явцад Авто бааз, Дүүргүүд дэх цагдаагийн газрын харьяа хэлтсийн Эрүүгийн цагдаагийн болон Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчдөөс 9 асуулга бүхий хуудсаар санал, асуулга авч, газар, хэлтсийн дарга нар болон мөрдөгч, цагдаа жолооч нартай уулзалт, ярилцлага

зохион байгуулж, санал хүсэлтийг сонсон, цугларсан мэдээлэл, баримтад тулгуурлан тайланг боловсруулсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд “Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан” гэдэгт “Засгийн газрын агентлагийн дарга” гэж тодорхойлсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/247 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн албанд ашиглагдах тээврийн хэрэгсэлд хяналт тавих /код 809/ журам”-ын 809.3.1-д “Цагдаагийн албаны автомашиныг зориулалтаар нь албан ажлын, шуурхай албаны /хөтөч/, тусгай зориулалтын дуудлагын, эргүүл /шургам замын, машинт/, жижүүр, харуул хамгаалалт, аж ахуйн үйлчилгээний...” гэж ангилан заажээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/59 дугаар тушаалаар Автобаазын бүтэц, орон тоо шинэчлэгдэн батлагдсанаас хойш 27 нэгжийн 41 автомашин нэмэгдсэн боловч цагдаа жолоочийн орон тоо нэмэгдээгүй байна.

3.2 Албаны автомашины хүртээмжийн байдлыг тодорхойлох зорилгоор Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дүүргүүд дэх цагдаагийн газрын харьяа хэлтсийн Эрүүгийн цагдаа болон Мөрдөн байцаах тасгийн 282 мөрдөгчдөөс авсан санал, асуулгаар 135 буюу 47.8 хувь “хангалтгүй”, 54 буюу 19.1 хувь нь “албаны машиныг зөвхөн тасгийн дарга унадаг тул тэр бүр олдоод байдаггүй” гэсэн байна.

Мөн цагдаа жолооч нар тогтвортой ажиллах байдал дутагдалтай, цагдаагийн хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгуудад 1, Мөрдөн байцаах тасагт 2 албаны автомашин ашиглагдаж байгаагаас Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын харьяа хэлтсийн Эрүүгийн цагдаагийн болон Мөрдөн байцаах тасгийн дарга нар албаны автомашиныг алба хаагчдадаа ашиглуулдаггүй талаар дурьдсан байна.

Албаны автомашины шатахуун хангалтгүй, автомашины багтаамж бага, туулах чадвар муу, тасгийн дарга, эсвэл зарим алба хаагчдын машин ашиглах ажилд давхардал үүсдэг, цагдаа жолоочийн орон тоонд алба хаагч хурдан томилж өгдөггүй, цагдаа жолооч нар хурдан солигддог, тэднийг ээлжийн амралттай үед орлох алба хаагч томилогддоггүй, шинээр томилогдсон алба хаагчдын хувьд албаны тээврийн хэрэгсэл ашиглах тухай ойлголт, мэдээлэл хомс тул хувийн автомашинаар албан үүргээ гүйцэтгэдэг, ийнхүү үүрэг гүйцэтгэхдээ машинаа дүрмийн бус газар байршуулснаас торгуулж, ачуулах, зам тээврийн осолд өртөх, шатахуун хүрэлцэхгүй үед хувиасаа шатахуун хийх зэрэг хүндрэлтэй асуудал үүсч байгаа талаар саналаа илэрхийлсэн байна.

3.3 Өнөөдрийн байдлаар 36 цагдаа жолооч албан үүргээ гүйцэтгэж явахдаа зам тээврийн осол, зөрчилд холбогдсоноос 11 буюу 36.5 хувьд алба хаагчийн буруутай, 25 буюу 63.5 хувьд иргэдийн буруутай үйлдэл тогтоогдсон байна.

Зам тээврийн осол, зөрчил алба хаагчдын 33 буюу 91.6 хувийг 25-40, 3 буюу 8.4 хувийг 40 дээш насны цагдаа жолооч нар эзэлж байна.

Нийт зөрчлийн 68.0 хувь нь өдрийн цагаар, 32.0 хувь нь оройн цагаар үйлдэгдсэн ба дийлэнх нь Замын хөдөлгөөний дүрмийн “Тээврийн хэрэгсэл байрлан явах”, “Уулзвар нэвтрэх” заалтуудыг зөрчсөнөөс үүдэлтэй байна.

3.4 Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн даргын зөвшөөрлийг үндэслэн 2020-2021 оны эхний 10 сарын байдлаар 11 алба хаагчийг автомашинаар үйлчилж буй дарга нарыг нь дагалдуулж, холбогдох цагдаагийн алба, нэгж, газар, хэлтэст шилжүүлэн томилсон байна.

3.5 Дотоод аудитын явцад Автобаазын удирдлагаас 2020-2021 онд алба хаагчдын гэр бүлтэй цахимаар хийсэн 5 удаагийн уулзалтын нотломжтой танилцахад алба хаагчдын ар гэрээс дараах хүндрэлтэй асуудал байгаа талаар дурдсан байна. Тухайлбал, Хөдөлмөрийн хууль баримталдаггүй, тогтмол илүү цагаар ажиллуулдаг, зарим дарга нараас хувийн дэлгүүрийнхээ бараа, бүтээгдэхүүнээ зөөлгөдөг, ажлын бус цагаар хувийн ажилд дайчилдаг гэжээ.

3.6 Автобаазын барилга байгууламж, автомашины аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангахад 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа энгийн жижүүрүүдийн хүлээх үүрэг, хариуцлагын хувьд шаардлагын түвшинд хүрэхгүй, энгийн ажилтнуудаас хэрэглэгч байгууллагын зарим нэг удирдах албан тушаалтан зандрангуй загнаж, харьцсанаас үл ойлголцол үүсч байсан талаар Автобаазын удирдлагатай хийсэн ярилцлагад дурьдагдаж байлаа.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны автомашины ашиглалтад хяналт тавих үйл ажиллагаанд дараах байдлаар сайжруулалт хийх шаардлагатай гэж аудитын багаас дүгнэж байна. Үүнд:

Нэг. Цагдаа жолооч нарын зам тээврийн осол, хэрэгт холбогдсон тохиолдол бүрт албаны шалгалт явуулж, түүний мөрөөр зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, дүнг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст ирүүлж байх шаардлагатай байна.

Хоёр. Цагдаа-жолооч нарын гэр бүлийн гишүүдээс Автобаазын удирдлагад гаргасан “Хөдөлмөрийн хууль баримталдаггүй, тогтмол

илүү цагаар ажиллуулдаг, зарим дарга нар хувийн дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүнээ зөөлгөдөг, ажлын бус цагаар хувийн ажилд дайчилдаг” гэсэн мэдээлэлд холбогдох шалгалтыг явуулж, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагыг бодит мэдээллээр хангах нь зүйтэй байна.

Гурав. Автобаазын барилга байгууламж, автомашины аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангахад 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа 20 /Ашиглалтын хэлтсийн 1, 2, 3 дугаар хэсгийн 12, Техник, үйлчилгээ засварын хэлтсийн засварын хэсгийн 4, ерөнхий диспетчер 4/ диспетчерийн албан тушаал /ажлын байр/-ыг харуулын цагдаа албан тушаал /ажлын байр/-д шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

5.3ӨВЛӨМЖ

5.1. “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад нийцүүлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/210 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн албанд ашиглагдах тээврийн хэрэгсэлд хяналт тавих” /Код-809/ журам”-ыг шинэчлэн боловсруулж, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, ХХ, Автобааз/;

5.2. Цагдаа жолооч нараас зам тээврийн осол, хэрэгт холбогдсон тохиолдол бүрт албаны шалгалт явуулж, түүний мөрөөр зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст ирүүлж байх /СААА, Автобааз/;

5.3. Цагдаа-жолооч нарын гэр бүлийн гишүүдээс Автобаазын удирдлагатай уулзах үедээ гаргасан “Хөдөлмөрийн хуулийг баримталдаггүй, тогтмол илүү цагаар ажиллуулдаг, зарим дарга нар хувийн дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүнээ зөөлгөдөг, ажлын бус цагаар хувийн ажилд дайчилдаг” гэх мэдээллийг Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлж, шийдвэрлүүлэх /АБХ, Автобааз/;

5.4. Автобаазын барилга байгууламж, автомашины аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангахад 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа 20 диспетчерийн албан тушаал /ажлын байр/-ыг харуулын цагдаа албан тушаал /ажлын байр/-д шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, ХНХ, Автобааз/;

5.5. Автобаазын цагдаа жолоочийн орон тоог шуурхай нөхөн бүрдүүлж, жолооч бүрэлдэхүүнийг тогтвор, суурьшилтай ажиллуулахад анхаарах /СААА, ХНХ, Автобааз/;

5.6. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

.....
.....
.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.БОРХҮҮ

АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтэд хийх дотоод аудит.

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж

Аудитын объект: 2019-2020 оны Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээн дэх Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтийн байдал.

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ/ХШДАХ/2021/12

Аудитын хугацаа: 2021.10.27-2021.11.24

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгаагаар хангагдах үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 803, 804, 908, 924, 932, 935, 948 зэрэг эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, бусад тогтоол шийдвэртэй уялдуулан Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолон Санхүү, аж ахуйн албанаас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2019, 2020 оны төсөв, дараа оны төсвийн төсөөллийг боловсруулан хүргүүлснээс 2019 онд 200.2, 2020 онд 234.1 тэрбум төгрөгийн төсөв батлагджээ.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дээрх батлагдсан төсвийн хүрээнд 2019 онд 213.5, 2020 онд 252.1 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Аудитын ажлын хүрээнд хамарсан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын төсвийн гүйцэтгэлээс авч үзэхэд:

1. **2019 оны байдлаар:** Төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 131.1, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3.046,4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4.531,7, хангамж, бараа материалын зардалд 7.990,2, нормативт зардалд 7.181,5, эд хогшил, урсгал засварын зардалд 4,440,6, томилолт, зочны зардалд

998.9, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 19.148,1, бараа үйлчилгээний бусад зардалд 3.476,7, урсгал шилжүүлэгт 31.539,8 тэрбум төгрөг;

2. **2020 оны байдлаар:** Төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 154.271,5, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3.989,4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 5.241,9, хангамж, бараа материалын зардалд 10.137,9, нормативт зардалд 12.958,6, эд хогшил, урсгал засварын зардалд 8.433,4, томилолт, зочны зардалд 668.995,3, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 17.481,4, бараа үйлчилгээний бусад зардалд 4.232,8, урсгал шилжүүлэгт 34.656,2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ хуулийн 87 дугаар зүйлийн 87.3, 87.6 дахь заалтад цагдаагийн алба хаагч хөдөө орон нутагт томилогдоход тэдний ар гэрийг ажлын байраар хангах, ажилгүй байх үеийн нийгмийн даатгалыг төлөх, нүүх уналга, ачаа тээшний зардлыг олгох зэргээр ар гэрт үүсдэг бэрхшээлийг боломжийн хэмжээнд шийдэхээр тусгаж өгсөн бөгөөд Төв, Булган, Ховд, Завхан, Хөвсгөл, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар нь шилжин ирсэн алба хаагчийнхаа тогтвор, суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлж, тэдний амьдралд чухал нөлөө үзүүлэх ажлыг өөрийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас уг хуулийн 87 дугаар зүйлийн 87.7. " Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч цагдаагийн алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна" гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж 2019 онд 20, 2020 онд 23 суралцагч цагдаагийн алба хаагчид цалин хөлсний зардалд нийт 332.299,6, эрүүл мэндийн даатгалын зардалд 6.646, 2019 онд 16, 2020 онд 15 суралцагч цагдаагийн алба хаагчид ирж буцах унааны зардалд нийт 28.083,9 мянган төгрөг зарцуулжээ. /Хүснэгт 1/

Хүснэгт 1

Аудитад хамрагдах он	Суралцагч цагдаагийн алба хаагчид олгосон зардал /мян.төгрөг/				
	алба хаагчийн тоо	Цалингийн зардалд	ЭМД-ын зардалд	Ирж, буцах тээврийн зардал	
2019	20	152.774	3.056	16	12.827
2020	23	179.525	3.590	15	15.256
Дүн		332.299	6.646		28.083

Мөн хуулийн 87.8-д "Энэ хуулийн 87.7-д заасан сургуульд цагдаагийн байгууллагын захиалгаар суралцаж байгаа сонсогчийн дүрэмт хувцасны болон ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна" гэсэн заалтын дагуу цагдаагийн байгууллагын захиалгаар суралцаж буй 2019 онд 71, 2020 онд 71 сонсогчдод цалин хөлсний зардалд нийт 1.041.266,2, эрүүл мэндийн даатгалын зардалд 20.807,4, 2019, 2020 онд тус бүр 69 сонсогчдод ирж буцах унааны зардалд нийт 116.989,3 мянган төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт 2

Аудитад хамрагдах он	Сонсогчид олгосон зардал /мян.төгрөг/				
	Сонсогчийн тоо	Цалингийн зардалд	ЭМД-ын зардалд	Ирж, буцах тээврийн зардал	
2019	71	509.790	10.199	69	51.860
2020	71	531.475	10.608	69	65.129
Дүн		1.041.266	20.807		116.989

Хангалт, үйлчилгээний төвөөс 2019 онд 20 сонсогчид 6.337,4 мянган төгрөгийн 177 ширхэг /иж бүрдэл/, 2020 онд 17 сонсогчид 6.337,4 мянган төгрөгийн 135 ширхэг /иж бүрдэл/ нийт 38 нэр төрлийн дүрэмт хувцасыг тавьж олгосон байна.

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний 2.5-т заасны дагуу Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтэд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, үр дүнг тооцоход аудитын зорилго чиглэгдсэн болно.

2.2 Аудитын хамарсан цар хүрээ

Дээрх зорилгын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: 2019-2020 онд Цагдаагийн байгууллагын 50 нэгжийн Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтийн байдал, түүнтэй холбоотой зардал, тайлбар

зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Коронавирус (Ковид-19)-ын цар тахлын нөхцөл байдлаас хамаарч албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, алба хаагчаас судалгаа авч дүгнэхийн тулд зөвхөн цахимаар ирүүлсэн мэдээллийг аудитын объектод хамрууллаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаа, дотоод цэргийн анги, байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг зэрэг цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааг хангах харилцааг зохицуулсан хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцаж судалсан.

Цагдаагийн байгууллагын 50 нэгжээс ирүүлсэн Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг авч, түүвэрлэх, нэгтгэх аргыг аудитын тайланд ашиглаж, нотлох баримтыг бэлтгэлээ.

Аудитын хүрээнд нотолгоо цуглуулах зорилгоор 2019, 2020 оны байдлаар цагдаа, дотоодын цэргийн 50 анги, байгууллагаас хуулийн хэрэгжилтийн мэдээллийг авснаас гадна холбогдох 126 алба хаагчидтай хамтран ажиллаж, уг хуулийн хэрэгжилт, гарч буй хүндрэл бэрхшээл, шалтгаан болон хэрэгжүүлж байгаа болон цаашид хийхээр төлөвлөж буй ажил арга хэмжээний талаар цахим ярилцлага хийсэн.

Аудитын дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулахдаа аудитын явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурласан болно.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.2. “Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно” гэсэн заалтын хэрэгжилтийн талаар цагдаагийн байгууллагын 50 нэгжээс ирүүлсэн мэдээллээс авч үзэхэд хүсэлт ирүүлсэн алба хаагч байхгүйгээс төсөвт тусгуулаагүй, зардал байхгүй гэх шалтгаанаар уг хуулийн заалт хэрэгжээгүй байна.

3.2 Хуулийн 87 дугаар зүйлийн 87.3. “Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.” гэсэн заалтын хэрэгжилт

аудитад хамрагдсан цагдаагийн 50 нэгжээс 47 байгууллага буюу 94.0 хувьд өргөдөл, хүсэлт ирүүлсэн алба хаагч байхгүй гэсэн шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-908/-ын 908.2.10-т “Цагдаагийн төв байгууллагын хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж нь шилжин ажиллаж буй алба хаагчийн нэгдсэн судалгааг, тухайн байгууллага шилжин ажиллагсдын бүртгэлийг тус тус хөтөлнө” гэж тусгасан.

Иймд Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсээс ирүүлсэн мэдээллээс үзэхэд орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсээс шилжин ажиллах болсон алба хаагчийн 2019 онд ажилгүй болсон 88 эхнэр, нөхрийн /иргэний/ судалгааг гаргасан боловч Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн эсэх нь тодорхой бус байна.

Харин 2020 онд Санхүү, аж ахуйн албанд 5б/5996 дугаар албан бичгээр 65 иргэний /эхнэр, нөхөр/-ийн мэдээллийг нэгтгэн хүргүүлж, дээрх иргэдийн ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож олгох талаар арга хэмжээ авч, ажиллах шаардлагатай байгааг уламжилсан байна.

Энэ талаар Санхүү, аж ахуйн алба ямар арга хэмжээ авч, ажилласан талаар мэдээлэл ирүүлээгүй тул хэрэгжилт хангагдаагүй гэж үзэхээр байна.

Харин цагдаагийн төсөвт нэгжүүдээс Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар 2020 онд хүсэлт гаргасан 1 офицерийн эхнэрийг Тариалан сумын цэцэрлэгт, Төв аймаг дахь цагдаагийн газар нь 2019 онд офицер 3, ахлагч 2 нийт 5, 2020 онд офицер 1, ахлагч 2, нийт 3 алба хаагчийн эхнэрийг төрийн болон хувийн хэвшлийн 8 байгууллагад ажилд оруулах зохион байгууллагын арга хэмжээ авсан болно.

Мөн Булган аймаг дахь цагдаагийн газар 2019 онд офицер 3, ахлагч 1, нийт 4 алба хаагчийн эхнэрийг Бугат сумын цэцэрлэгийн багш, Булган сумын ХААМСҮТ-д багш, “Мобиком корпораци” ХХК-д харилцагчийн менежер, Сайхан сумын цэцэрлэгт багш, 2020 онд офицер 2, ахлагч 1, нийт 3 алба хаагчийн эхнэрийг Хялганат тосгоны эмнэлэг, Сайхан сумын эмнэлэгт, Бүрэгхангай сумын дунд сургуульд, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар 2019 онд офицер 1, ахлагч 1, нийт 2 алба хаагчийн эхнэрийг Шүүхийн шинжилгээний албанд, Олон нийтийн цагдаагийн ажлын байраар хангаж алба хаагчийн амьдралд дэмжлэг болсон байна.

3.3 Хуулийн 87 дугаар зүйлийн 87.6. “Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор цагдаагийн байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.” гэсэн заалтын хэрэгжилт

аудитад хамрагдсан цагдаагийн 50 нэгжээс 47 байгууллага буюу 94.0 хувьд нь алба хаагчаас хүсэлт ирдэггүй учраас хэрэгждэггүй гэсэн байна.

Харин Ховд аймаг дахь цагдаагийн газар 2020 онд 1 алба хаагчид ачаа тээшний зардалд 480.000, Завхан аймаг дахь цагдаагийн газар 1 алба хаагчид уналгын зардалд 945.000, Төв аймаг дахь цагдаагийн газар 2019 онд 2 алба хаагчид уналгын зардалд 354.000, 2020 онд 1 алба хаагчид 177.000, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар 2019 онд 3 алба хаагчид 5.550.000 төгрөгийн ачаа тээшний зардлыг алба хаагчдад тус тус тооцож олгожээ.

3.4 Энэ хуулийн 87 дугаар зүйлийн 87.9. “Цагдаагийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:

87.9.1.төрийн тусгай алба хаасан хугацааны;

87.9.2.албан ажлын онцгой нөхцөлийн;

87.9.3.цагдаагийн мэргэжлийн зэргийн;

87.9.4.эрдмийн зэрэг, цолны;

87.9.5.хуульд заасан бусад гэж заасан байна.

Дээрх нэмэгдлүүдээс 87.9.3-т заасан “цагдаагийн мэргэжлийн зэрэг”-ийн нэмэгдлийг олгох үйл явц нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-948/ “Алба хаагчийг мэргэжлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах” журмаар зохицуулагддаг бөгөөд цагдаа, дотоодын цэргийн нийт алба хаагчдад 2019-2020 онд олгогдоогүй байна.

3.5 Аудитаар цугларсан мэдээллээс үзэхэд Цагдаа, дотоодын цэргийн хэмжээнд 2019 онд 21, 2020 онд 25, 2021 оны эхний хагас жилийн байдлаар 23 мэргэшсэн нягтлан бодогч ажил, үүрэг гүйцэтгэж байна.

Үүнээс 2021 оны байдлаар Цагдаагийн төв байгууллагад 6, харьяа алба, газар, хэлтэс, Дотоодын цэргийн ангид 9, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, харьяа дүүрэг дэх цагдаагийн газарт 2, орон нутагт 6 байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.9.5-д заасан “хуульд заасан бусад” нэмэгдэл буюу хамрагдах мэргэшсэн нягтлан бодогчид олгох нэмэгдлийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох” /код-924/ журмын 924.6.4-т заасны дагуу зохицуулдаг хэдий ч 2020 онд 22 алба хаагчид олгож, 3 алба хаагчид олгоогүй, мөн 2021 оны байдлаар 20 алба хаагчид олгож, 3 алба хаагчид олгоогүй нь харилцан адилгүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйл нь эдийн засгийн баталгааны 10 заалттай. Иймд энэ хуулийн заалт нэг бүрчлэн хэрэгжиж цагдаагийн байгууллагын алба хаагчдын нийгмийн асуудлыг

шийдвэрлэхэд асар ач холбогдолтой юм.

Энэ хуулийн 87 дугаар зүйлийн 87.3, 87.6 дахь заалтад цагдаагийн алба хаагч хөдөө орон нутагт томилогдоход тэдний ар гэрийг ажлын байраар хангах, ажилгүй байх үеийн нийгмийн даатгалыг төлөх, нүүх уналга, ачааны тээшний зардлыг олгох зэргээр ар гэрт үүсдэг бэрхшээлийг зохих хэмжээнд шийдэхээр тусгаж өгсөн бөгөөд Төв, Булган, Ховд, Завхан, Хөвсгөл, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрууд шилжин ирсэн алба хаагчийнхаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлж, тэдний амьдралд чухал нөлөө үзүүлэх ажлыг өөрийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

2. Аудитад хамрагдсан цагдаагийн 50 нэгжээс ирүүлсэн Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн эдийн засгийн баталгааны хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, энэ хуулийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох 126 алба хаагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэлийг авч нэгтгэхэд алба хаагчдын энэ хуулийн холбогдох заалтуудын талаарх эрх зүйн мэдлэг дутмаг байдгаас хүсэлт гаргадаггүй учир тухайн байгууллага төсвийн төсөөлөлд тусгадаггүй, зарим заалтыг хэрхэн хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт тодорхой бус, төсөв, санхүүгийн байдлаас шалтгаалан хуулийн заалт бүрийн хэрэгжилт харилцан адилгүй байна гэж дүгнэлээ.

3. Аудитад хамрагдсан цагдаагийн 50 нэгжийн алба хаагчдаас ээлжийн амралтын хугацаандаа 2 жилд нэг удаа эхнэр, нөхрийн төрсөн нутагтаа ирж очсон талаар судалгаа байхгүй, мөн 47 нэгж шилжин ирсэн алба хаагчийн ажилгүй болсон эхнэр /нөхөр/-ийн мэдээлэл, судалгааг хангалттай хийдэггүй, алба хаагчийн гэр бүлийн хүнийг ажлаар хангаагүй, эсвэл иргэдийн ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож олгох талаар арга хэмжээ авч ажиллаагүйгээс хуулийн 87 дугаар зүйлийн 87.2 дахь заалт хэрэгжээгүй, 87.3, 87.6 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

4. Цаашид дээрх нэгжүүдэд нийтлэг байдлаар илэрсэн асуудлыг нэг бүрчлэн судалж, дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлээ. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны талаар алба хаагчдад нэгдмэл ойлголт өгч, сургалт зохион байгуулах;

- Уг хуулийн хэрэгжилтэд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах;

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд шилжин ажиллагсдын бүртгэлийг хөтөлж, шилжин ирсэн алба хаагчийн ажилгүй болсон эхнэр /нөхөр/-ийн мэдээлэл, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж, алба хаагчийн гэр бүлийн хүнийг ажлаар хангаагүй аль эсвэл иргэдийн ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож олгосон талаар тухайн байгууллагын

хүний нөөцийн ажилтан, нягтлан бодогчийн ажлын хооронд хэрхэн мэдээллээ солилцож ажиллах зохицуулалтыг журамд тусгах;

- Цагдаагийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг олгох талаар арга хэмжээ авч ажиллах;

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан алба хаагчдад олгох асуудал харилцан адилгүй байгааг судалж, нэг мөр болгон шийдвэрлэх;

- Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн хэрэгжилт хангалтгүй байгаа зарим хэсэг дэх заалтын шалтгаан нөхцлийг судалж, шаардагдах зардлыг төсвийн төсөөлөлд тусган дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, шийдвэрлүүлэх.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр дараах санал, зөвлөмжийг танилцуулж байна. Үүнд:

5.1 Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан цагдаагийн алба хаагчдад үзүүлэх эдийн засгийн баталгааны талаар нэгдмэл ойлголт өгч, хууль сурталчлах зорилгоор алба хаагчдад сургалт зохион байгуулах /ХХ, СГАСХ, ЦДЦАБ/;

5.2 Цагдаагийн албаны тухай хуулийн 87 зүйлд заасан баталгааг эдлэх эрх үүссэн нийт алба хаагчдын /шилжин томилогдсон алба хаагчийн ажилгүй болсон эхнэр, нөхөр/ судалгааг гаргах, шаардагдах зардлыг батлагдсан төсөвт багтаан олгох, хүрэлцэхгүй тохиолдолд дараа жилийн төсвийн төсөөлөлд тооцоолон тусгаж, холбогдох хууль журмын дагуу дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, шийдвэрлүүлэх /СААА, ХНХ, ЦДЦАБ/;

5.3 Шилжин ирсэн алба хаагчийн ажилгүй болсон эхнэр /нөхөр/-ийг ажлын байраар хангасан эсэх, хангаагүй бол тухайн иргэдийн ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож олгох талаар судалгааг тухайн байгууллагын Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн холбогдох материалыг бүрдүүлэн тогтоосон хугацаанд өөрийн байгууллагын санхүүд гарган өгч, хамтран ажиллах зохицуулалтыг журамд нарийвчлан тусгах /СААА, ХХ, ХНХ/;

5.4 Цагдаагийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тогтоож, олгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах /СААА,ЗУГ/;

5.5 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан алба хаагчдад албан тушаалын үндсэн цалингийн 15 хувиар тогтоон сар бүр олгож байх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, ХХ/;

5.6 Энэ хуулийн хэрэгжилтэд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах /СААА, ЦДЦАБ/;

5.7 Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын

арга хэмжээ авч, дүнг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Ё.МӨНХЗУЛ

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН
2021 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021.12.08

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Биелэлт	Хувь
Төлөвлөлтийн зорилт 1.Цагдаагийн байгууллагын дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх				
1.1	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод аудит, эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах	Жилдээ	<p>Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу «Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал» сэдвээр тус бүр 1 цагийн цахим сургалт зохион байгуулж, 15 алба хаагчийг хамруулсан.</p> <p>2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Санхүү, аж ахуйн албаны 2021 оны 6/1424 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу "Дотоод аудитын ойлголт", "Шилэн дансны хуулийн хэрэгжилт" сэдвээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 53 нэгжийн 201 алба хаагчдад 1 цагийн, 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Төв байрны газар, хэлтсийн алба хаагчдад Монгол банкнаас мэргэжилтэн урьж "Финтек ба крипто" валютын таллаарх ойлголт" сэдвээр 3 цагийн сургалт зохион байгуулсан.</p>	100
1.2	Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн, ач холбогдлыг цагдаагийн байгууллагын дотоод болон гадаад орчинд сурталчлах	Жилдээ	<p>Дотоод аудитын чиглэлээр 2021 онд хийсэн ажлын товч мэдээллийг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 3а/9487 дугаартай албан бичгээр Хэвлэл, мэдээллийн төвд хүргүүлэн Цагдаагийн ерөнхий газрын цахим сайтад байршуулж, сурталчлах арга хэмжээ авсан.</p>	100

1.3	Дотоод аудиторуудыг чадавжуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын үндэсний дотоод аудиторуудын холбооноос зохион байгуулах сургалтуудад хамруулах	Жилдээ	2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Сангийн яамнаас зохион байгуулсан "Улсын секторын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого" сэдэвт цахим сургалтад санхүүгийн аудит хариуцсан 3 алба хаагчийг хамруулсан. 2021 оны 11 дүгээр сарын 01-нээс 22-ны өдрүүдэд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан "Аудиторын эрх олгох" цахим сургалт"-д санхүүгийн аудит хариуцсан 1 алба хаагчийг хамруулсан.	80.0
1.4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тухайн оны дотоод аудитын жилийн төлөвлөгөө боловруулж батлуулах, биелэлтийг гаргаж, ХЗДХЯ-нд хүргүүлэх	Хагас бүтэн жилд	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөний төслийг боловруулан, 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулж, жилийн эцсийн байдлаар биелэлт, үр дүнд тооцоход 98.8 хувьтай дүгнэгдэж, дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулахаар хүргүүлсэн.	100
Төлөвлөлтийн зорилт 2. Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, байгууллага, алба хаагчийн хэрэгцээ шаардлага, тухайн аудитын ач холбогдол, үр дүнг харгалзан дотоод аудитыг хэрэгжүүлэх				
2.1	Цагдаагийн байгууллага, нэгж дээрх орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг, комисс, багийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	3 дугаар сард	Цагдаагийн байгууллага, нэгж дээрх орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг, комисс, багийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 2 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн За/3037 дугаарын албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч байна.	100
2.2	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны автомашины ашиглалтад дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	9 дүгээр сард	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны автомашины ашиглалтад дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 6 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн За/8842 дугаарын албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн алба, Хуулийн болон Аюулгүй байдлын хэлтэс, Автовазаад хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн дотор тооцохоор байна.	100
2.3	Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн удирдлагын тогтвортой байдал, төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	5 дугаар сард	Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн удирдлагын тогтвортой байдал, төрийн албаны зарчмын хэрэгжилтэд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 6 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн За/9508 дугаарын албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Захираганы удирдлагын газар, Хүний нөөцийн болон Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор тооцохоор байна.	100

2.4	Цагдаагийн алба хаагчдын ял шийтгэлийн байдал, Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь хэсгийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлэн, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	5 дугаар сард	Цагдаагийн алба хаагчдын ял шийтгэлийн байдал, Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь хэсгийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, холбогдох зөвлөмжийг Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллаж байна.	100
2.5	Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтэд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 7 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн За/9416 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр тооцооор байна.	10 дугаар сард	Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтэд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 7 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн За/9416 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр тооцооор байна.	100
2.6	Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 4 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн За/4714 дугаартай албан бичгээр холбогдох цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 53 нэгжид хүргүүлж, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар авч, нэгтгэн дүгнэсэн.	3 дугаар сард	Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 4 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн За/4714 дугаартай албан бичгээр холбогдох цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 53 нэгжид хүргүүлж, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар авч, нэгтгэн дүгнэсэн.	100
2.7	Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	9 дүгээр сард	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, холбогдох шийдвэр, зөвлөмжийг 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн За/4740 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж байна.	100
2.8	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдлад дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	5 дугаар сард	"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдла"д дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 3 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн За/4953 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.	100

2.9	Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох./Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд дотоод аудит хийх/	3 дугаар сард	Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 7 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 3а/3019, 3а/3018, 3а/3017 дугаартай албан бичгээр холбогдох 48 нэгжид хүргүүлсэн.	100
2.10	Байнга давтагддаг санхүүгийн зөрчлийг арилгах чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох./Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автомашины үндсэн агрегат, зангилаа, сэлбэг хэрэгслийн эдлэлтэний нормын тооцоонд дотоод аудит хийх/	3 дугаар сард	Байнга давтагддаг санхүүгийн зөрчлийг арилгах чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, 5 заалт бүхий зөвлөмжийг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 3а/3959, 3а/3960 дугаартай албан бичгээр холбогдох 11 нэгжид хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100
2.11	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах	Хагас, бүтэн жилээр	Үндэсний аудитын газраас Хууль зүй, дотоод хэргийн яамаар уламжлан ирүүлсэн цагдаагийн байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын шалгалтаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмж, албан шаардлагын биелэлт, Шилэн Дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүү, аж ахуйн алба болон Дотоодын цэргийн 805 дугаар ангиас холбогдох тайлбарыг гаргуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01/580, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын энэ оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 3/399 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	100
2.12	Цагдаагийн байгууллага, нэгжээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах	2, 7 дугаар сард	Шилэн дансны тухай хуулийн 2021 оны хэрэгжилтэд хяналт тавьж, 2021 оны 03 сарын 29-ны өдрийн 3а/2203, 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Дэд даргын 3/163 дугаар албан бичгээр 7 заалт бүхий үүрэг, ажлын чиглэлийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлж, 53 анги, байгууллагаас цахимаар хүлээн авч, дүнг 22 үзүүлэлтээр нэгтгэн тооцсон.	100

2.13	Шилэн дансны хууль тогтоомжийн ХЗДХЯ, Үндэсний газарт тайлагнах хэрэгжилтийг аудитын	Улирал бүр	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны 1,2,3 дугаар улирлын тайланг цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагаас цахимаар хүлээн авч, 22 үзүүлэлтээр нэгтгэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын энэ оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 3/145, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүнд дэд даргын энэ оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2/268, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын энэ оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 3/339 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.	100
2.14	Цагдаагийн удирдлагын төлөвлөгөөт бус дотоод аудитыг хэрэгжүүлэх	Жилдээ	Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр "Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын оронтооны талаарх мэдээлэл", "Жолоодох эрх олгох үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж", "Цагдаагийн ерөнхий газрын төв байгууллага, түүний харьяа зарим нэгжийн цаалингийн шатлал, зэрэглэл болон нэмэгдэл цаалингийн байдал"-д 3 сэдвээр төлөвлөгөөт бус дотоод аудит хийж, тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, зөвшөөрсний дагуу 14 заалт бүхий зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн.	100
Нийт 18 ажил, арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 1 байна.			98.8	

ТАНИЛЦСАН:
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
МӨН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

А.ДАВААСҮРЭН

М.АЗЖАРГАЛ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

ТАНИЛЦУУЛГА

2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД**

Зөвлөмжийн биелэлт тооцсон
дүнгийн талаар

ЦЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу болон ЦЕГ-ын удирдлагаас өгсөн чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн аудит, түүний мөрөөр харьяа алба, анги, байгууллага, нэгжид хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт, үр дүнг тооцон танилцуулж байна.

Нэг. Хэрэгжүүлсэн дотоод аудитын ажлын чиглэлээр:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний дагуу "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны галт зэвсэг, хэрэглэлийн хадгалалт, хамгаалалтад холбогдох эрх зүйн актын хэрэгжилт", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгж дэх зөвлөл, комисс, баг, ажлын хэсгийн үйл ажиллагаа", "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын зарцуулалт, эргэн төлөлтийн байдалд дотоод аудит хийж", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автомашины үндсэн агрегат, зангилаа, сэлбэг хэрэгслийн эдэлгээний нормыг тооцох ажиллагаа", "Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаа", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдал", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаа", "Цагдаагийн алба хаагчдын ял шийтгэлийн байдал, Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь хэсгийн хэрэгжилт", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автомашины ашиглалт", "Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн удирдлагын тогтвортой байдал, төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилт", "Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн хэрэгжилт", "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" сэдвээр нийт **12** дотоод аудит хийж, тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулан гаргасан шийдвэрийн дагуу **64** заалт бүхий зөвлөмжийг холбогдох цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад

хүргүүлэн ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын орон тооны талаарх мэдээлэл”, “Жолоодох эрх олгох үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж”, **“Цагдаагийн ерөнхий газрын төв байгууллага, түүний харьяа зарим нэгжийн цалингийн шатлал зэрэглэл болон нэмэгдэл цалин олгогдсон байдал” сэдвээр төлөвлөгөөт бус 3 дотоод аудит хийж, тайланг** Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулан, шийдвэрийн дагуу **13** заалт бүхий зөвлөмжийг холбогдох алба, нэгжид хүргүүлсэн.

Авч хэрэгжүүлсэн аудитын байдлыг хүснэгтээр харуулбал:

д/д	Аудитын төрөл	Дотоод аудит		Нийт дүн
		Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	
1	Үйл ажиллагааны	2	-	2
2	Гүйцэтгэлийн	4	-	4
3	Нийцлийн	3	2	5
4	Санхүүгийн	3	1	4
Нийт дүн:		12	3	15

Цагдаа дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн 77 заалт бүхий 16 зөвлөмжийн биелэлтийг тооцож үзэхэд: Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад шууд танилцуулагдсан 3, биелэлтийг хугацаанд нь тооцсон 8, биелэлт тооцох хугацаа болоогүй 5 зөвлөмж байна. Хэрэгжилтийг тооцсон зөвлөмжийн биелэлт дундаж үнэлгээгээр 90.3 хувьтай байна. Судалгааг хүснэгтээр хавсаргав/

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны 1,2,3 дугаар улирлын тайланг цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагаас цахимаар хүлээн авч, 22 үзүүлэлтээр нэгтгэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын энэ оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/145, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын энэ оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 2/268, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын энэ оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 3/339 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хагас жилийн байдлаар дотоод аудит хийж, 5 заалт бүхий зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлсэн бол 2021 оны 4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийгдэж байна.

Үндэсний аудитын газраас Хууль зүй, дотоод хэргийн яамаар уламжлан ирүүлсэн цагдаагийн байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын шалгалтаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүү, аж ахуйн алба болон Дотоодын цэргийн 805 дугаар ангиас холбогдох тайлбарыг гаргуулан, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01/580, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын энэ оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 3/399 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, цаашид алдаа, дутагдал гаргахгүй ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авснаар энэ оны 12 дугаар сарын байдлаар зөвлөмжийн биелэлт 97.0, төлбөрийн актын барагдуулалт 100, албан шаардлагын хэрэгжилт 96.0 хувьтай байна.

2021 оны 12 дугаар сарын байдлаар Цагдаагийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөний биелэлт 98,8 хувьтай байна.

Хоёр. Дүгнэлт:

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний дагуу 12, Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр **төлөвлөгөөт бус** 3, нийт 15 дотоод аудит хийгдэж, төлөвлөгөөний хэрэгжилт 98,8 хувьтай байна.

2. Цагдаа дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн 16 зөвлөмжийн 77 заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үзэхэд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад шууд танилцуулагдсан 3, хугацаанд нь биелэлт тооцсон 8, биелэлт тооцох хугацаа болоогүй 5 зөвлөмж байна. Зөвлөмжийн хэрэгжилт дундаж үнэлгээгээр 90.3 хувьтай байна.

Гурав. Санал.

1. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол, Сангийн яамнаас сүлжээгээр хүргүүлж буй зөвлөмж, заавар, Цагдаагийн байгууллагын удирдлагаас Шилэн дансны тухай хууль

тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт мэдээлэл, ажлын чиглэл хүргүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулъя.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

.....

.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

Ажлын баримт 3001/
ЦЕГ/ХШДАХ/2021/НА-14

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага дахь “Шилэн дансны тухай” хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллага

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ/ХШДАХ/2021/НА-14

Аудитын хугацаа: 2022.01.11

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төсөв санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/” журам болон бусад холбогдох эрх зүйн акт зэрэг баримт бичгээр зохицуулагдаж байна.

Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс нь цагдаа, дотоодын цэргийн 53 байгууллагын шилэн дансны аудитын тайланг улирал бүр хүлээн авч нэгтгэн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд мэдээ, тайланг хүргүүлдэг.

Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл /2021 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

№	Мэдээлэл байршуулсан цэс	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Хугацаандаа байршуулсан	Хоцорсон	Байршуулаагүй
1	Төсөв, санхүү	9	2597	2597	2537	60	0
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	2067	2067	2018	49	0
3	Бусад	6	3233	3233	3160	73	0
Дүн		20	7897	7897	7715	182	0

Үндэсний аудитын газар болон нийслэл, орон нутаг дахь аудитын газраас цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг үзэж, нийт 20 төрлийн 7897 мэдээлэл байршуулахаас 7561 мэдээг хугацаанд нь, 336 мэдээ хугацаа хоцорч байршуулсан алдааг дахин давтахгүй байх зөвлөмж өгсөн ба 13 зөвлөмж, 4 албан шаардлага авсан байна.

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.14 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан, хүргүүлж, төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулахад дотоод аудитын зорилго оршино.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагаас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг аудитад хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тавигдсан хугацаа, агуулга, үнэн зөв, ойлгомжтой, иж бүрэн байдлыг тулган баталгаажуулсан болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны байгууллагын админ эрхтэй хэрэглэгчийн аудитын тайланд татагдаж байгаа мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулгалаа.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Засгийн газрын шилэн дансны нэгдсэн цахим хуудасны байгууллагын админ эрхтэй хэрэглэгчийн аудитын тайланд татагдаж байгаа мэдээллийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулгахад дэд цэсний мэдээлэл бүрэн татагдахгүй байна. Иймээс шилэн дансны нэгдсэн цахим хуудасны аудитын тайлангаар татагдсан тоон мэдээлэл нь хэрэглэгчийн хэсэгт байршуулсан мэдээллээс зөрөөтэй байна.

3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг нэгтгэн үзэхэд, нийт 20 төрлийн 7897 мэдээлэл байршуулахаас 7715 хугацаанд нь, 182 мэдээ хугацаа хоцорч байршуулжээ. /Хавсралт- 1/

Нийслэл, орон нутаг дахь аудитын газраас 2020 онд хийсэн санхүүгийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр зөрчил, дутагдал заагдаж, нийт 13 зөвлөмж, 4 албан шаардлага авсан 17 нэгжээс дахин хугацаа хоцорч мэдээллийг байршуулсан 12 нэгж байна. Үүнд:

Нийслэлийн цагдаагийн удирдах газар 4, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар 2, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар 1, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар 11, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 4, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар 2, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар 17, Дорнод аймаг дахь цагдаагийн газар 2, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар 9, Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар 1, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс 8, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс 10 мэдээллийг тус тус хоцорч байршуулсан.

3.3 Аудитын хүрээнд шилэн дансны цахим хуудасны 3 дэд цэсэнд байршуулсан мэдээллийг тулгаж үзэхэд дараах асуудал илэрлээ.

Төсөв, санхүү дэд цэсэнд хавсралтад заасан маягтын үзүүлэлтийг дутуу нөхөх, байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулахгүй байх, “PDF формат”-аар байршуулаагүй, мэдээлэл нь цаг хугацаандаа баталгаажуулснаар харагдаж байгаа боловч тухайн мэдээлэл нь хоосон, хамааралгүй мэдээлэл байршуулах зэрэг алдаа байна. Үүнд:

- Экологийн цагдаагийн алба, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар болон Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүд “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”, “Худалдан авах ажиллагааны тайлан” зэрэг хэсэгт бүтэн жилээр мэдээлэл оруулаагүй;

- Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар нь “Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан”, “Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан”, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” зэрэг хэсгүүдэд хагас жилээр мэдээллээ хугацаандаа байршуулсан мэтээр тэмдэглэгээ хийгдсэн боловч уг хүснэгт хоосон байна;

- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар “Байгууллагын батлагдсан төсөв” хэсэгт мэдээлэл оруулаагүй, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” хэсэг хоосон, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” хэсэгт тухайн сард гарсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрийг хүснэгтийн дагуу бөглөөгүй;

- Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулга “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” зэрэг хэсгүүдийн мэдээллийг хүснэгтийн дагуу бүрэн мэдээлээгүй;

- Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар нь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” хэсгийн мэдээллийг дутуу оруулсан, “Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан” хэсэгт хагас жилээр мэдээлэл байршуулаагүй;

- Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” хэсэгт мэдээллийг 1-6 сарын хугацаанд шивж оруулаагүй, 12 дугаар сард хүснэгтийн дагуу бөглөөгүй зэрэг алдаа тус тус илэрч байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд олон нийтэд 100 хувь мэдээлэгдсэн нь төсвийн ил тод байдал хангагдаж, иргэдээс төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бий болгосон тул уг хуулийн үндсэн зорилтын хэрэгжилт “**ХАНГАЛТТАЙ**” түвшинд байна. Харин шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийн дүнг нэгтгэж үзвэл дундаж үзүүлэлтээр **97.6** хувьтай байна гэж дүгнэв.

Байршуулсан мэдээллийг тулган үзэхэд, хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн байршуулсан 25, хугацаа хоцорч мэдээлэл байршуулсан 28 байгууллага байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2020 онд хийсэн дотоод аудитын дүнгээр нийт 7897 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулж, хугацаа хоцорсон 336 мэдээлэл байжээ.

Харин 2021 оны байдлаар хугацаа хоцорч 182 мэдээлэл байршуулсан нь зөрчил, дутагдал **47 хувиар буурсан** сайн үр дүн

харагдах боловч шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа батлагдсан хавсралт маягтын дагуу бүрэн нөхдөггүй, байршуулсан мэдээллээ сайтар нягтлаагүйгээс байршуулсан мэдээлэл нь хоосон эсвэл буруу байх тохиолдол их гарч байна.

Хэд хэдэн данс бүхий цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хувьд санхүүгийн программаас мэдээллийг нэгтгэн татах болон данс бүрээр хавсралт маягт нэмэх боломжгүйгээс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг гараар шивдэг нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

Цаашид цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол, Сангийн яамнаас сүлжээгээр хүргүүлж байгаа зөвлөмж, заавар болон Цагдаагийн байгууллагын удирдлагаас Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр хүргүүлсэн зөвлөмж, үүрэг, ажлын чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын багаас тулган баталгаажуулсан мэдээлэл, аудитын үр дүнд үндэслэн илэрсэн асуудлыг арилгуулах чиглэлээр Санхүү, аж ахуйн албанд дараах зөвлөмжийг хүргүүлэх саналтай байна. Үүнд:

5.1 Цагдаагийн байгууллагын хэмжээнд Нийслэл, орон нутаг дахь аудитын газраас 2020 онд хийсэн санхүүгийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр зөрчил, дутагдал заагдсан хэдий ч 2021 онд дахин мэдээллийг хоцорч байршуулсан 12 нэгжид сануулж, цаашид давтан гаргуулахгүй байхад анхаарах;

5.2 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхдээ анхаарах доорх 5 зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох сургалтыг Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэстэй хамтран цахим хэлбэрээр зохион байгуулах;

Нэг. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа батлагдсан стандарт маягтаар бүрэн мэдээлэх, нөхөн байршуулдаг мэдээллийг шинэчилж байх, "PDF формат"-аар байршуулсан мэдээллийн чанар, агуулгыг анхаарч, мэдээллийг нэвтрэх, хэвлэх, татаж авах боломжтойгоор байршуулах;

Хоёр. "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт байгууллагын санхүүжилтийн орлого, зарлагыг сар бүр тогтмол мэдээлэх;

Гурав. "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан "мэдэгдэл" хэсэгт захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө холбогдох

албан тушаалтан нь гүйлгээ бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг байршуулах;

Дөрөв. “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийн хэсэгт тухайн ажил, гүйлгээний мөнгөн дүнг харгалзахгүйгээр мөнгө, хөрөнгө зарцуулсан болон өглөг, авлагатай холбоотой шийдвэрүүдийг бүрэн мэдээлж, шийдвэрийг “PDF формат”-аар хавсаргах;

Тав. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр санхүүжих, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа байгууллага нь энэ талаарх холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулж байх;

5.3 Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг энэ оны 06 дугаар сарын 20-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

Ч.ЭРДЭНЭБОЛОР

Мэдээллийг нэгж, байршуулсан хугацаагаар нь харуулбал:

№	Нэгжийн нэр	Байршуулах мэдээ	Байршуулсан мэдээ		Хувиар
			Хугацаандаа	Хоцорсон	
1	Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба	149	148	1	99.3
2	Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар	149	149	-	100
3	Эрүүгийн цагдаагийн алба	149	149	-	100
4	Тээврийн цагдаагийн алба	149	149	-	100
5	Мөрдөн байцаах алба	149	133	16	89.3
6	Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба	149	142	7	95.3
7	Экологийн цагдаагийн алба	149	148	1	99.3
8	Эргүүл хамгаалалтын газар	149	148	1	99.3
9	Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар	149	146	3	97.9
10	Цагдаагийн ерөнхий газрын Автобааз	149	141	8	94.6
11	Цагдаагийн ерөнхий газрын Гэрээт хамгаалалт	149	149	-	100
12	Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төв	149	149	-	100
13	Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төв	149	149	-	100

14	Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хороо	149	148	1	99.3
15	Цагдаагийн ерөнхий газрын цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын "Сүүж уул" сэргээн засах сувилал	149	146	3	97.9
16	Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулга	149	149	-	100
17	Дотоодын цэргийн 05 дугаар анги	149	132	17	88.5
18	Дотоодын цэргийн 805 дугаар анги	149	149	-	100
19	Архангай аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
20	Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар	149	139	10	93.2
21	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	149	147	2	98.6
22	Булган аймаг дахь Цагдаагийн газар	149	137	12	91.9
23	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	149	132	17	88.5
24	Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
25	Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
26	Дорнод аймаг дахь Цагдаагийн газар	149	147	2	98.6
27	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	149	145	4	97.3
28	Завхан аймаг дахь Цагдаагийн газар	149	147	2	98.6
29	Орхон аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
30	Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар	149	148	1	99.3
31	Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	149	140	9	93.9

32	Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
33	Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
34	Төв аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
35	Увс аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
36	Ховд аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
37	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	149	148	1	99.3
38	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар	149	149	-	100
39	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	149	149	-	100
40	Дорноговь аймаг Замын Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэс	149	149	-	100
41	Сэлэнгэ аймаг дахь Мандал сумын сум дундын цагдаагийн хэлтэс	149	141	8	94.6
42	Сэлэнгэ аймаг дахь Сайхан сумын сум дундын цагдаагийн хэлтэс	149	139	10	93.2
43	Өвөрхангай аймаг дахь Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтэс	149	149	-	100
44	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	149	145	4	97.3
45	Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар	149	147	2	98.6
46	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар	149	149	-	100
47	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	149	138	11	92.6

48	Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	149	138	11	92.6
49	Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	149	148	1	99.3
50	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар	149	149	-	98.0
51	Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	149	147	2	98.6
52	Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	149	145	4	97.3
53	Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	149	138	11	92.6
НИЙТ ДҮН		7897	7715	182	97.6

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга байгууламжийн ашиглалт, насжилтын байдалд” дотоод аудит

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/НА-2022/01

Аудитын хугацаа: 2022.02.08- 2022.02.28

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа А.Даваасүрэн

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Цагдаагийн ерөнхий газрын Автобааз нь анх 1926 онд Дотоодыг хамгаалах газрын харьяанд “Дожд” маркийн автомашинтай “Дотоодыг хамгаалахын граж” нэртэй байгуулагдсан байна.

1990 онд уг гражыг Нийгмийг аюулаас хамгаалах яамнаас салган “Цагдаагийн ерөнхий газрын Автобааз” гэж нэрлэж эхэлснээс хойш 21 жил болжээ.

Өнөөдрийн байдлаар ЦЕГ-ын Авто бааз нь Баянгол дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Дунд гол”-ын далангийн хойд талд “Уран ган” ХХК-ны зүүн талд байрлаж байна.

Тус авто баазад одоо данс бүртгэлтэй, хувийн хэрэг нээсэн 10 барилга, байгууламж байна. Үүнд:

1.Төв конторын барилга: 1968 онд ашиглалтад орсон, 54 жил ашиглагдаж байгаа, 2540 м2 талбайтай, чулуун суурь, даацын тоосгон хана, модон хучилт, шувуу нуруу бүхий нимгэн төмөр хучлага дээвэртэй 2009 онд 185.790.000 /нэг зуун наян таван сая долоон зуун ерэн мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, ашиглалтын хугацааг 36 жилээр тогтоон орлогод авсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолоор төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны жишигт нийцүүлэн үнэлж, данс бүртгэлд тусгах ажлын хүрээнд Автобаазын даргын 2018 оны А/04 тушаалаар хөрөнгийн дахин үнэлгээг хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, уг барилгыг Сангийн сайдын баталсан “Аргачлал батлах тухай” 2018 оны 207 дугаар тушаалын дагуу цаашид ашиглах жилийг 11 жилээр, үнэлгээг 248.089.958.63 /хоёр зуун дөчин найман сая наян есөн мянга есөн зуун тавин найман төгрөг жаран гурван мөнгө/ төгрөгөөр дахин үнэлж, “Уваа-Уул Аудит” ХХК-иар үнэлгээний нягтлан шалгалт хийлгэсэн

гаргасан дүгнэлтийг үндэслэн данс бүртгэлд тусгажээ.

Уг барилгад өнөөдрийн байдлаар 71.419.836.44 /далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга найман зуун гучин зургаан мянга дөчин дөрвөн мөнгө/төгрөгийн элэгдэл тооцогдож, 176.670.122.19 /нэг зуун далан зургаан сая зургаан зуун далан мянга нэг зуун хорин хоёр мянга арван есөн мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй байна.

Барилгын дотор зохион байгуулалтын хувьд нэгдүгээр давхарт албан тасалгаа 9, хувцас солих өрөө 1, нэг, цэгийн үйлчилгээний байр болон спорт заалыг холбосон урт коридортой, коридорын эхэнд цайны газар, ариун цэврийн өрөө 2, хоёрдугаар давхарт албан тасалгаа 3, хурал болон сургалтын танхим 2-ыг бий болгосноор алба хаагчдын ажил, үүргээ хэвийн гүйцэтгэх орчин нөхцөл бүрдүүлсэн.

Төв конторын барилгын “спорт заал” баруун жигүүрт байрлах ба хоёрдугаар давхартаа билльярдны өрөө 1, эмчийн өрөө 1, сэтгэл зүйчийн өрөө 1, ариун цэврийн өрөө 2, агуулах 1, саун 1, нийт 132,09 м² талбайтайгаар алба хаагчдыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлсэн бүрдсэн байна.

2019 оны 11 дүгээр сард тухайн барилгын байдалд “Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хэлтэс”-ийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гаргасан дүгнэлтэд: “Цутгамал бетон шугаман суурийн бетоны бэх нь харилцан адилгүй үзүүлэлттэйгээр шалгагдсан, суурийн бетоны гадаргуу жигд бус арзгар, зарим хэсгүүдэд бетоны дүүргэгч материал /хайрга, дайрга/ ялгарч, гараар хүрэх үед үйрч унаж байгаа нь суурийн бетоны цутгалтын ажил нь “Цутгамал бетон, төмөр бетон бүтэц” БНБД 52-02-05-ын 4 дүгээр бүлэгт заасан технологийн шаардлагыг хангахгүй байна.

Барилгын хаяавч бетонд ан цав, хэв гажилт үүсч зарим хэсгүүд цөмөрсөн, сууринд гадаргуугийн болон дээврээс буусан хурын ус нэвчиж барилгын буурь суурьд нөлөөлж болзошгүй, хаяавч бетоны цөмөрсөн хэсгүүдээр ургамлын үндэс, өвс ногоо, мод, бут ихээр ургадаг нь суурийн тогтвортой байдалд нөлөөлөх аюултай нөхцөл үүссэн...

Барилгын даацын ханын үндсэн материал нь ердийн улаан тоосго, шохойн зуурмаган гагнаас бүхий хийцлэлтэй. Ердийн тоосгоны бат бэх 22.8кг/см², шахалтын бат бэх 61.1кг/см² туршигдсан нь MNS 5610-2011 8х “Тоосгон бүтэц, нүхтэй бетон тоосго. Техникийн шаардлага”-д заасан тоосгоны стандартын шаардлагыг хангахгүй байна.

Зуурмагаас дээж авах боломжгүй гараар хүрэхэд бутарч үйрсэн, их хэмжээний чийглэлттэй тул лабораторийн нөхцөлд дээжийг шинжлэх боломжгүй байгаа нь өрлөгийн зуурмагийн стандартын шаардлага хангахгүй байна.

Дээврийн битүүмжлэл алдагдаж модон хучилт болон даацын тоосгон хана хоорондын уулзвар заагаар их хэмжээгээр ус нэвчиж, ус чийгийн үйлчлэлд өртсөнөөр гадна ханын уулзвар, булан хэсгүүдэд дусаалын ул мөр ихээр үүссэн, ихэнх хэсгүүдийн гадна өнгөлгөөний будаг шавар

ховхорч унан даацын тоосгон ханын үндсэн материалын чанарыг муутгаж өгөршилд оруулсан байна.

Модон хучилтад дусаалын ул мөр илэрсэн ба хучилтын банзан бамбайнуудын холбоос суларч, тухайлсан хэсгүүд ус чийгийн нөлөөнөөс үүдэн бага хэмжээгээр өгөршилд орсон. Модон хучилтад анкерлалт хийгдсэн боловч ашиглалтын явцад үүссэн физик элэгдлээс шалтгаалан суларч хөдөлгөөнд орсон.

Авто баазын контор захиргааны байрны ашиглалтын төлөв байдалд хийсэн биет хэмжилт судалгаа болон сорилын багаж, тоног төхөөрөмжийн үр дүн, лабораторийн шинжилгээний дүн, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01 /2006-ийн 3.29 дүгээр заалт, “Өрөгт барилга төлөвлөх, барилгын норм ба дүрэм БНБД 3.03.05-90-ын 9.10 дугаар заалт болон хүснэгт 9, “Цутгамал бетон, төмөр бетон бүтэц” БНБД 52-02-05-ын 4 дүгээр бүлэг, “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” БД 22-105-18-ын 1 дүгээр бүлгийн 1.2 дугаар заалт, “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” БД 31-102-00-ын хүснэгт 2 болон хүснэгт 4-т заасан шаардлагуудыг хангахгүй тул тус барилга нь болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй” гэжээ.

2.Ашиглалтын хоёрдугаар хэсгийн битүү зогсоол: 1968 онд ашиглалтанд орсон, 54 жил ашиглагдаж байгаа,1800м2 талбайтай, 68 автомашины багтаамжтай, модон болон тоосгон ханатай, модон карказан нимгэн төмрөөр хучсан дээвэртэй, аж ахуйн аргаар баригдсан “авто граж”-ийн зориулалттай 151.704.000 /нэг зуун тавин нэгэн сая долоон зуун дөрвөн мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, ашиглалтын хугацааг 60 жилээр тогтоон анх орлогод авагдсан барилга.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хүрээнд Автобаазын даргын 2018 оны А/04 тушаалаар хөрөнгийн дахин үнэлгээг хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж уг барилгын цаашид ашиглах хугацааг 11 жилээр, үнэлгээг 211.777.875 /хоёр зуун арван нэгэн сая долоон зуун далан долоон мянга найман зуун далан таван/ төгрөг байхаар дахин үнэлэн “Уваа-Уул Аудит” ХХК-иар үнэлгээг нягтлан шалгуулж гаргасан дүгнэлтийг үндэслэн данс бүртгэлд тусгажээ.

Өнөөдрийн байдлаар уг барилга нь 60.966.357,92 /жаран сая есөн зуун жаран зургаан мянга гурван зуун тавин долоон төгрөг ерин хоёр мөнгөн/ төгрөгийн элэгдэл тооцогдож, 150.811.517.08 /нэг зуун тавин сая найман зуун арван нэгэн мянга таван зуун арван долоон төгрөг найман мөнгө/-төгрөгний үлдэх өртөгтэй байна.

Барилгын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэхэд: барилгын эргэн тойрон хаяавч бетон зарим хэсгүүдэд газрын түвшингээс доош суусан, тухайлсан хэсгүүдэд дутуу хийгдсэн, ан цав, хэв гажилт үүсч цөмөрсөн, сууринд гадаргуугийн болон дээврээс буусан хурын ус нэвчиж, хаяавч дээрхи газрын гадаргууд ус чийгийн нөлөөгөөр өвс ургамал ихээр ургасан байгаа нь барилгын буурь, суурийн тогтвортой

байдалд нөлөөлж болзошгүй аюултай байдал үүссэн.

Хэмжилтээр модон татангад өөрийн хавтгайгаас хажуу тийш хэв гажилтад орохоос хамгаалсан бэхлэгчүүд хийж гүйцэтгэсэн боловч татангын доод бүсний палкнуудад бага хэмжээний цууралтууд үүссэн, модон дам нурууны бат бэх хангалтгүй, даацын тоосгон хананд дээрээс ирэх хучилтын ачаа нэмэгдсэнээс тоосгон хана шахалтад орж хөндлөн чиглэлдээ гулзайлт үүссэн мөн хаалганы амлагаа хэсгийн шавардлага ховхорчдаацын тоосгон ханийн ташуу чиглэлд хагарал үүссэн, хэмжилтээр эргэн тойрон барилгын буурь хөрсний шинж чанараас хамааран сууринд суулт өгснөөс зогсоолын бетон шал газрын түвшингээс доош суусан.

Дээврийн битүүмжлэл алдагдаж модон хучилт болон даацын тоосгон хана хоорондын уулзвар заагаар их хэмжээний ус нэвчиж, ус чийгийн үйлчлэлд өртсөнөөр гадна ханийн уулзвар, булан хэсгүүдэд дусаалын ул мөр ихээр үүссэн, даацын тоосгон ханын үндсэн материалын чанарыг муутгаж өгөршилд оруулсан, хучилтын банзан бамбайнуудын холбоос суларч, тухайлсан хэсгүүд нь ус чийгийн нөлөөнөөс үүдэн өгөршилд орсон, модон хучилтад анкерлалт хийгдсэн боловч ашиглалтын явцад үүссэн физик элэгдлээс шалтгаалан суларч, хөдөлгөөнд орсон байна.

2019 оны 11 дүгээр сард “Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хэлтэс”-ийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гаргасан дүгнэлтэд: “Цагдаагийн ерөнхий газрын харьяа авто баазын ашиглалтын хоёрдугаар хэсгийн битүү зогсоолын барилгын ашиглалтын төлөв байдалд хийсэн биет хэмжилт судалгаа болон сорилын багаж, тоног төхөөрөмжийн үр дүн, лабораторийн шинжилгээний дүн, ”Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм” БНБД 50-01-16-ийн 11.1.9 дүгээр заалт, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01*/2006-ийн 3.29 дүгээр заалт “Өрөгт бүтээц” БНБД 3.03.05-90-ын 9.10 дугаар заалт болон хүснэгт 9, “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” БД 22-105-18-ын 1.2.7 дугаар заалт “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” БД 31-102-00-ын хүснэгт 2 болон хүснэгт 4-т заасан шаардлагуудыг хангахгүй тул тус барилга нь болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй болно” гэжээ.

3. Ашиглалтын гуравдугаар хэсгийн битүү зогсоол нь 1968 онд ашиглалтад орсон, 54 жил ашиглагдаж байгаа, 1800м² талбайтай, үүнээс агуулахын зориулалтаар 84м², албан тасалгааны зориулалтаар 59м² талбай ашиглагдаж, 1219м² талбайд нь 80-85 автомашинуудыг байрлуулдаг, модон болон тоосгон өрлөг ханатай, модон карказ, нимгэн төмрөөр хучсан дээвэртэй аж ахуйн аргаар баригдсан “авто граж”-ийн зориулалттай, 151.704.000 /нэг зуун тавин нэгэн сая долоон зуун дөрвөн мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, ашиглалтын хугацааг 60 жилээр тогтоон анх орлогод авагдсан барилга байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хүрээнд Автобаазын даргын 2018 оны А/04 тушаалаар байгуулагдсан

хөрөнгийн дахин үнэлгээг хийх үүрэг бүхий ажлын хэсгээс уг барилгыг цаашид ашиглах жилийг 11 жилээр, үнэлгээг 211.777.875 /хоёр зуун арван нэгэн сая долоон зуун далан долоон мянга найман зуун далан таван/ төгрөг байхаар дахин үнэлэн “Уваа-Уул Аудит” ХХК-иар үнэлгээний нягтлан шалгаж, гарсан дүгнэлтийг үндэслэн данс бүртгэлд тусгажээ.

Өнөөдрийн байдлаар уг барилга нь 60.966.357,92 /жаран сая, есөн зуун жаран зургаан мянга, гурван зуун тавин долоон төгрөг ерэн хоёр мөнгө/төгрөгийн элэгдэл тооцож, 150.811.517,08 /нэг зуун тавин сая найман зуун арван нэгэн мянга таван зуун арван долоон төгрөг найман мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй байна.

Барилгын эргэн тойронд ан цав, хэв гажилт үүсч цөмөрсөн, сууринд гадаргуугийн болон дээврээс буусан ус нэвчиж хаяавч дээрх газрын гадаргууд ус чийгийн нөлөөгөөр өвс ургамал ихээр ургасан байгаа нь барилгын буурь суурийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн.

Модон татангийн холбоос банзны өргөний хэмжээ татангийн бүсний доод үед 130 мм, дээд үед 240 мм байгаа ба бэхэлгээний боолтыг модны ширхгийн дагуу хөндлөн чиглэлдээ даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийж гүйцэтгэсэн боловч боолт нэвт гарсан хэсгийн хэмжээ хангалтгүй байна.

Барилгын даацын тоосгон дотор хананд дээрээс ирэх хучилтын ачаа нэмэгдсэнээс тоосгон хана шахалтад орж хөндлөн чиглэлдээ 12мм орчим хэмжээтэй гулзайлт үүссэн.

Хаалга цонхны амлагаа хэсгийн шавардлага ховхорч унасан, даацын тоосгон хананд хөндлөн болон ташуу чиглэлд хялгасан ан цав ихээр үүссэн, дээврийн битүүмж алдагдсанаас модон хучилтад дусаалын ул мөр илэрсэн ба хучилтын банзан бамбайнуудын холбоос суларч, тухайлсан хэсгүүд нь ус чийгийн нөлөөнөөс үүдэн өгөршилд орсон, ашиглалтын шаардлага хангахгүй байна.

2019 оны 11 дүгээр сард “Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хэлтэс”-ийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гарсан дүгнэлтэд: “Ашиглалтын гуравдугаар хэсгийн битүү зогсоолын барилгын ашиглалтын төлөв байдалд хийсэн биет хэмжилт судалгаа болон сорилын багаж, тоног төхөөрөмжийн үр дүн, лабораторийн шинжилгээний дүн, “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм” БНБД 50-01-16-ийн 11.1.9 дүгээр заалт, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01*/2006-ийн 3.29 дүгээр заалт, “Өрөгт бүтээц” БНБД 3.03.05-90-ын 9.10 дугаар заалт болон хүснэгт 9, “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” БД 22-105-18-ын 1.2.7 дугаар заалт, “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” БД 31-102-00-ын хүснэгт 2 болон хүснэгт 4-т заасан шаардлагуудыг хангахгүй тул тус барилга нь болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй болно” гэжээ.

4. Засварын конторын барилга : Угсармал төмөр бетон гулдмайн суурьтай, угсармал багана тоосгоор өрсөн ханатай, металл дам нуруу, угсармал хавирган хавтан хучилт дээвэртэй, 1667 м2 талбайтай, автомашин засварлах зориулалтаар 1968 онд ашиглалтад орсон, 54 жил ашиглагдаж байгаа, 2009 онд 236.234.800.000 /Хоёр зуун гучин зургаан сая хоёр зуун гучин дөрвөн мянга найман зуу/төгрөгийн анхны өртөгтэй, ашиглалтын хугацаа 60 жилээр тогтоон анх орлогод авагджээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хүрээнд Автобаазын даргын 2018 оны А/04 тушаалаар байгуулагдсан хөрөнгийн дахин үнэлгээг хийх үүрэг бүхий ажлын хэсгээс уг барилгын цаашид ашиглах жилийг 23 жилээр, үнэлгээг 589.413.661,82 /таван зуун наян есөн сая дөрвөн зуун арван гурван мянга зургаан зуун жаран нэгэн төгрөг наян хоёр мөнгө/ байхаар дахин үнэлж “Уваа-Уул Аудит” ХХК-иар үнэлгээний нягтлан шалгалт хийлгэсэн дүгнэлтийг үндэслэн данс бүртгэлд тусгасан.

Өнөөдрийн байдлаар 81.151.15.650 /наян нэгэн сая нэг зуун тавин нэгэн мянга нэг зуун тавин зургаан төгрөг тавин мөнгө/ төгрөгийн элэгдэл тооцож, 508.262.505,32 /таван зуун найман сая, хоёр зуун жаран хоёр мянга таван зуун таван төгрөг гучин хоёр мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй байна.

Уг барилга нь контор, засварын заал, түүний залгаа тос, тосолгооны материалын агуулах болон цехүүдтэй.

Засварын зааланд автомашин засварын зориулалттай 4 хөлтэй өргөгч тайл 1 ширхэг, 2 хөлтэй өргөгч тайл 5 ширхэг, шалны түвшингээс доош байрлах 6 ширхэг сувгуудыг ашиглан автомашин засах засвар, үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэдэг.

Конторын барилга нь алба хаагчдын өрөө 4, хувцас солих өрөө 1, ариун цэврийн өрөө 1, усанд орох өрөө1, хувцас хэрэглэл угаах өрөө 1, автомашины хяналт техникийн үйлчилгээний 2 өрөөтэй ашиглагдаж байна.

Барилгын дээврийн битүүмжлэл алдагдаж, угсармал хавиргат хавтан хучилтын болон даацын тоосгон хана хоорондын уулзвар заагаар их хэмжээгээр ус нэвчиж, ус чийгийн үйлчлэлд өртсөнөөр гадна ханын уулзвар булан хэсгүүдэд дусаалын ул мөр ихээр үүссэн, ихэнх хэсгүүдийн гадна өнгөлгөөний будаг шавар ховхорч унан, даацын тоосгон ханын үндсэн материалын чанарыг муутгаж өгөршилд оруулан барилгын даацын бүтээцийн чанарт сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Барилгын хаяавч бетоноос дээш хөвөө хэсгийн шавардлага зарим хэсгүүдэд ховхорсон, барилгын хаяавч болон хөвөө хоорондын уулзвар хэсгүүдэд ан цав үүсэж битүүмж алдагдсан, хөндлөн болон ташуу чиглэлдээ хэмжээгээр ан цав үүссэн, хананы тоосгонууд бутарч үйрсэн байгаа нь барилгын суурийн тогтвортой байдалд нөлөөлөх “аюултай” нөхцөл байдал үүссэн.

Дээврийн битүүмжлэл алдагдсанаас угсармал хавиргат хавтан

хучилтын бүтээц хоорондын тусгаарлагч давхарга чийгэнд ханасан, зарим хэсгүүдийн шавар хөндийрч гэмтсэн. Цонхны дээд талын холбоос дам нуруу, хучилтын хавтангийн зах хэсэг ус чийгнээс мөөгөнцөртөж, замаск будаг ховхорсон байна. Барилгын угсармал хавтан хучилтын тухайлсан хэсгүүдэд мөөгөнцөр үүссэн, дээврийн ус алдалтаас шалтгаалан даацын тоосгон хананы ирмэг дагуу зарим хэсгийн шохой, замаск хуурч, ховхорсон зэргээр ашиглалтын шаардлага хангахгүй байна.

2019 оны 11 дүгээр сард “Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хэлтэс”-ийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гарсан дүгнэлтэд: Цагдаагийн ерөнхий газрын харьяа авто баазын техник үйлчилгээ, засварын байрны ашиглалтын төлөв байдалд хийсэн биет хэмжилт судалгаа болон сорилын багаж, тоног төхөөрөмжийн үр дүн, “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм” БНБД 50-01-16-ийн 11.1.9 дүгээр заалт, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01*/2006-ийн 3.29 дүгээр заалт, “Өрөгт бүтээц барилгын норм ба дүрэм” БНБД 3.03.05-90-ын 9.10 дугаар заалт болон хүснэгт 9, “Цутгамал бетон, төмөр бетон бүтээц” БД 52-02-05-ын 4 дүгээр бүлэг, “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” БД 22-105-18-ын 1 дүгээр бүлгийн 1.2 дугаар заалт, “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” БД 31-102-00-ын хүснэгт 2 болон хүснэгт 4-т заасан шаардлагуудыг хангахгүй тул тус барилга нь болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй болно гэжээ.

5. Авто угаалгын газар нь :1968 онд ашиглалтад орсон,54 жил ашиглагдаж байгаа, 208 м2 талбайтай, 4 автомашин зэрэг угаах хүчин чадалтай 1 давхар, чулуун бетонон суурьтай, тоосгон өрлөгтэй, модон хучилтан дээвэртэй, гадна тал шавар өнгөлгөөтэй 13.860.000 / арван гурван сая найман зуун жаран мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, ашиглалтын хугацааг 36 жилээр тогтоон орлогод авагдсан, төвийн цэвэр бохир, дулаан, цахилгааны шугам сүлжээнд бүрэн холбогдсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хүрээнд Автобаазын даргын 2018 оны А/04 тушаалаар байгуулагдсан хөрөнгийн дахин үнэлгээг хийх үүрэг бүхий ажлын хэсгээс уг барилгыг цаашид ашиглах жилийг 11 жилээр, үнэлгээг 11.424.895,50 /арван нэгэн сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга найман зуун ерэн таван мянга тавин мөнгө/ байхаар дахин үнэлж, “Уваа-Уул Аудит” ХХК-иар үнэлгээний нягтлан шалгалт хийлгэсэн дүгнэлтийг үндэслэн данс бүртгэлд тусгажээ.

Өнөөдрийн байдлаар уг барилга нь 3.288.984,36 /гурван сая хоёр зуун наян найман мянга есөн зуун наян дөрвөн мянга гучин зургаан мөнгө/ төгрөгний элэгдэл тооцогдож, 8.135.908,14 /найман сая нэг зуун гучин таван мянган есөн зуун найман мянга арван дөрвөн мөнгө/ төгрөгний үлдэх өртөгтэй байна.

Барилгын хаяавч бетон цөмөрч, ан цав ихээр үүссэн, барилгын анхны зориулалт нь агуулах боловч одоогоор автомашины угаалгын

байрны зориулалтаар ашиглаж байгаа тул тоосгон хана байнга ус чийгийн үйлчлэлд өртсөнөөр гадна ханын уулзвар булан хэсгүүд хүйтний улиралд мөстөж цантан, хөгц мөөгөнцөр, хөвд /ургамал/ ихээр үүссэн, ихэнх хэсгүүдийн гадна өнгөлгөөний будаг, шавар ховхорч унан даацын ханын үндсэн материалын чанар муудаж өгөршилд орсон байна.

2019 оны 11 дүгээр сард “Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар аюулгүй байдлын хэлтэс”-ийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гарсан дүгнэлтэд: “Цагдаагийн ерөнхий газрын харьяа авто баазын угаалгын байрны ашиглалтын төлөв байдалд хийсэн биет хэмжилт судалгаа болон сорилын багаж, тоног төхөөрөмжийн үр дүн, лабораторийн шинжилгээний дүн, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01 /2006-ийн 3.29, 3.37, 3.39 дугаар зуултууд, “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохих” БНБД 50-01-16-ийн 11.1.9 дүгээр заалт, “Өрөгт бүтээц” БНБД 3.03.05-90-ийн 9.10 дугаар заалт болон 9-р хүснэгт, “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” БД 22-105-18-ын 1.2 дугаар заалт, “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” БД 31-102-00 Хүснэгт-2 болон хүснэгт 4-ийн шаардлагуудыг хангахгүй тул тус барилга нь болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй” гэжээ.

6. Автобаазын нэгдүгээр хэсгийн битүү зогсоол : 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ашиглалтад орсон, 10 жил ашиглагдаж байгаа, 7104 м2 талбайтай, 9 жил 8 сар ашиглагдаж байгаа, 186 автомашины зогсоолтой, 3 давхар байгууламж бөгөөд төвийн цэвэр, бохир, дулаан, цахилгааны шугам сүлжээнд бүрэн холбогдсон, автогражийн зориулалттай, 2.858.429.835 /хоёр тэрбум найман зуун тавин найман сая дөрвөн зуун хорин есөн мянга найман зуун гучин тав/ төгрөгийн анхны өртөгтэй, ашиглалтын хугацаа 60 жилээр тогтоогдон орлогод авагдсан.

Өнөөдрийн байдлаар 440.674.599,84 /дөрвөн зуун дөчин сая зургаан зуун далан дөрвөн мянга таван зуун ерэн есөн төгрөг наян дөрөв мөнгө/ төгрөгийн элэгдэл тооцогдож, 2.417.755.235,16 /хоёр тэрбум дөрвөн зуун арван долоон сая долоон зуун тавин таван мянга хоёр зуун гучин таван төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийн үлдэх өртөгтэй байна.

Барилга байгууламжийг анх барихдаа бороо, цас ороход дээврийн усыг бохирын худаг руу хоолойгоор зайлуулах, хөрсний ус нэвчилтийн техникийн шийдлийг хийгээгүйгээс 2014 оны 5 дугаар сараас эхлэн зорийн давхар руу ус нэвтэрч шалнаас /бороо орсон үед/ хөрсний ус барилгын 1 давхрын ус зайлуулах шугам, суурь, хана хэсгээс гарч эхэлсэн байна.

Бороо болон хөрсний усыг тухай бүр техникээр соруулж, зайлуулж байгаа хэдий ч өвлийн улиралд суурь бетон хийц хөлдөөд, хаврын улиралд гэсэх үед битүү зогсоолын үндсэн хийцэд нөлөөлж, цууралт үүссэн байна.

2014 онд нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын

ахлах байцаагчаас “Цахилгаан, тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын бэлэн байдлыг хангах, барилгын зураг төсөл, улсын комисст хүлээлгэн өгсөн акт, протоколыг бүрдүүлж шалгуулах, дулаан хуваарилах үзелийн өрөөнд нэвтэрч буй хөрсний ус зайлуулах байгууламж бий болгох, техникийн шийдлийн зураг төслийг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргаж, байгуулах, галын дохиоллын системийн алдагдсан ажиллагааг хэвийн болгох, ерөнхий самбарын болон аянгаас хамгаалах газардуулгын байгууламжийг шинээр хийх, гадна, дотно цахилгаан угсрах гүйцэтгэлийн зураг хийлгэх” тухай 02-07-98/565 тоот албан шаардлага ирүүлсэн байна.

2015 онд нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчаас “Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар баригдсан Автогражийн зoorьтой, 2 давхар барилгын ашиглалтын явцад гарсан дээрх нөхцөл байдлууд нь Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “Хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх”, 16 дугаар зүйлийн 16.1.3-д “Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад өөрийнх нь буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн чанарын зөрчлийг өөрийн зардлаар арилгах” гэсэн заалтын хэрэгжилт хангахгүй байна.

Тус барилгын ашиглалт, одоогийн төлөв байдалд Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Барилгын чанарын баталгаат хугацаа” 3 жил байна, 12.5 дахь хэсэгт / Энэ хуулийн 12.4-т заасан хугацаа дуусгавар болох үед ашиглагч, гүйцэтгэгч, өмчлөгч хамтран үзлэг хийж шаардагдах арга хэмжээ авснаар баталгаат хугацаа дуусгавар болно./ гэсэн заалт, мөн “Барилга ашиглалтын дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.5.5 дахь / Барилга байгууламжийн баталгаат хугацаа /3 жил/ дуусгавар болсон тохиолдолд “Барилгын тухай хуулийн” 12.5-д заасны дагуу хамтарсан үзлэг хийж, холбогдох арга хэмжээг авах, Баталгаат хугацаа дуусгавар болж, хуулийн дагуу хамтарсан үзлэг хийгээгүй нөхцөлд барилга байгууламжид үүссэн хохирлыг зөвхөн өмчлөгч хариуцна./... гэсэн заалтын хэрэгжилтийг хангах, барилгад илэрсэн зөрчил дутагдлууд болон галын дохиоллын системд гарсан эвдрэл гэмтлийг арилгуулж, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангуулах, барилгын үндсэн хийц, бүтээцэд үүссэн хагарал, гэмтлүүдийг Нийслэлийн барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэст хандаж, бүтээцийн чанар үнэлгээ хийлгүүлэх талаар арга хэмжээ авч, хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн 02-07-92/1941 тоот дүгнэлт гаргасан байна.

2018 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 02-07-089/582 тоот дүгнэлтэд : “Барилгын төлөв байдлыг 5.2 кодтой “Барилга байгууламжийн ашиглалтыг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад дунд эрсдэлтэй” гэж үнэлсэн байдаг.

2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн Нийслэлийн мэргэжлийн

хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 02-07-089-951 тоот дүгнэлтээр:

“Засварын заалны барилгын хучилтын төмөр ферм нь баганын босоо тэнхлэгийн төвд жигд ачаалал өгөхөөр суурилагдаагүй тул фермд ямар нэгэн нэмэлт ачаалал өгөхгүй байх, суурилуулсан тал, зам төмрийг буулгах нь зүйтэй, барилгуудын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварын үнэлгээг Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэст хандан гаргуулах,

Үүссэн эвдрэл, гэмтлийг Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолын хавсралт”, Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн 3.7-д “Ашиглагч барилга байгууламжид хийсэн үзлэгээр илэрсэн эвдрэл гэмтлийг тухай бүх цаг алдахгүй арилгуулах арга хэмжээ авна” гэж заасны дагуу арилгуулах, модон хийцүүдэд галын эсрэг түрхлэг хийлгэх нь зүйтэй,

Төв контор, Ашиглалтын 1,2,3 дугаар хэсгүүд, засварын хэсгийн барилгуудын 0,4кв-ын оролтын самбарын ашиглалтын байдал нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, 30.1.8 дахь хэсэгт заасныг хангахгүй байна гэсэн дүгнэлт гаргасан байна.

7. Агуулах байр: нь 81 м2 талбайтай, 1970 онд баригдсан 52 жил ашиглагдаж байгаа, тос тосолгооны материалын агуулах чиглэлээр ашиглаж байгаад 2009 оноос аж ахуйн агуулахын зориулалтаар ашиглаж байна. Чулуун бетонон суурьтай тоосгон өрлөг ханатай, модон шувуун нуруутай барилга юм. Төвийн цахилгааны шугамд холбогдсон, цэвэр бохир, дулааны шугам байхгүй байна.

8. Шалган нэвтрэх байр: Жижүүрийн байр буюу шалган нэвтрүүлэх байр нь 2014 онд баригдсан, 100 м2 талбайтай, диспетчерийн, жижүүрийн шалгах механикийн бэлэн байдлын гэсэн ерөөнөөс бүрдэнэ. Бетонон суурьтай блок, тоосго өрлөгөн ханатай модон карказан дээвэртэй, хөөсөнцөр хавтангаар дулаалсан. Төвийн цэвэр, бохир, дулаан, цахилгааны шугамд холбогдсон байна.

9. Техник үйлчилгээ засварын хэлтсийн диспетчерийн байр: Засварын манаачийн байр нь 15 м2 талбайтай, 2018 онд дотоод нөөц бололцоогоо ашиглан аж ахуйн аргаар баригдсан. Бетонон суурь, хөнгөн блокон өрлөгтэй, модон шувуун нуруутай, нимгэн төмөр дээвэртэй. Төвийн цэвэр бохир ус, дулааны шугамд холбогдоогүй, цахилгааны шугамд холбогдсон.

10. Засварын хэлтсийг тусгаарласан засварын бетон суурьт хашаа нь 2001 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад орсон, 74,1 метр.кв урт бетон суурьтай сараалжин төмөртэй хашаа юм.

Байгууллагыг тусгаарласан бетон хашаа нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтанд орсон, 941,6 м.кв урт цутгамал бетон хийцтэй.

Ашиглалтын нэгдүгээр хэсгийн урд талын бетонон талбай нь 2006 оны 09 дүгээр сарын 27-нд ашиглалтад орсон, 2728 метр.кв талбайтай байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.3 дахь хэсэгт заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга, байгууламжийн ашиглалт, насжилтын байдал /стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх/-д дотоод аудит хийж, цаашид учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Автобаазын барилга, байгууламж, түүний ашиглалт, насжилтын байдал нь үйл ажиллагааны стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албаны байр, эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих” /код 802/ журмын хэрэгжилтийн талаарх баримт, мэдээлэл, үйл ажиллагааг аудитын объектод хамруулна.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, Авто баазаас барилга, байгууламжийн ашиглалт, насжилтын байдал, учирч болзошгүй эрсдэл, түүнд тавих хяналтын талаарх мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч, судалсан байна.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, үйл ажиллагаанд ашиглагдаж буй, барилга, байгууламжийн ашиглалт, учирч болзошгүй эрсдэлт байдал бий эсэх, асуудалтай газар дээр нь биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсрууллаа.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга, байгууламжийн ашиглалт, насжилтын байдал нь 1968 оноос эхлэлтэй бөгөөд дийлэнх нь 50 гаруй жил ашиглагдан эрсдэл, хорогдолд оржээ.

3.2 2020 оны төсвийн урсгал санхүүжилтээр Кон-Арч ХХК-тай гэрээ байгуулан спорт заалны барилгын дотор засварын ажлыг 43,920,344 /дөчин гурван сая есөн зуун хорин мянга гурван зуун дөчин дөрөв/ төгрөгөөр хийлгүүлсэн байна.

3.3 2022 оны Хууль зүй дотоод хэргийн яамны урсгал санхүүжилтээр Автобаазын нэгдүгээр хэсгийн зоорийн давхарт хөрсний уснаас хамгаалах байгууламж хийх, автомашин угаалгын байрны засварын зардалд 363.900.000 /гурван зуун жаран гурван сая есөн зуун мянга/ төгрөг шийдвэрлүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/12 дугаар тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хурлаар ашиглалтын нэгдүгээр хэсгийн зоорийн давхарт

хөрсний уснаас хамгаалах байгууламж хийх зардалд 290.900.000 /хоёр зуун ерэн сая есөн зуун мянган/ төгрөг, автомашин угаалгын байрны дотор засварыг 73.000.000 /далан гурван сая/ төгрөгийн төсөвт өртөгт багтаан зохион байгуулахаар тогтжээ.

Уг ажлын хүрээнд тендер шалгаруулалтын урилга, зарыг энэ оны 02 дугаар сарын 08-ны өдөр төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн систем **tender.gov.mn** цахим сайт болон өдөр тутмын сониноор дамжуулан олон нийтэд мэдээлж, 03 дугаар сарын 10-ны өдөр нээлт хийхээр болсон байна.

3.4 Авто баазын ашиглалтын гуравдугаар хэсгийн барилгын суурин дээр баригдах битүү зогсоол, конторын барилгын зураг, төсөв боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулалт Барилга, хот байгуулалтын яамны санхүүжилтээр тус яаман дээр зарлагдаж, одоогоор үнэлгээ хийгдэх шатандаа явагдаж байна.

3.5 Автобаазад данс бүртгэлтэй, хувийн хэрэг нээсэн 10 барилга, байгууламжаас төв конторын барилга, ашиглалтын нэг, хоёр, гуравдугаар хэсгийн битүү зогсоол, *авто угаалгын газар, засварын конторын барилга зэрэг нь* 2019 онд “Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс”-ийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй гарсан дүгнэлтээр ашиглалтын төлөв байдалд хийсэн биет хэмжилт судалгаа болон сорилын багаж, тоног төхөөрөмжийн үр дүн, “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм” БНБД 50-01-16-ийн 11.1.9 дүгээр заалт, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01*/2006-ийн 3.29 дүгээр заалт, “Өрөгт бүтээц барилгын норм ба дүрэм” БНБД 3.03.05-90-ын 9.10 дугаар заалт болон хүснэгт 9, “Цутгамал бетон, төмөр бетон бүтээц” БД 52-02-05-ын 4 дүгээр бүлэг, “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” БД 22-105-18-ын 1 дүгээр бүлгийн 1.2 дугаар заалт, “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” БД 31-102-00-ын хүснэгт 2 болон хүснэгт 4-т заасан шаардлагуудыг хангахгүй тул тус барилга нь болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй....гэсэн дүгнэлт гарсан ч өөр байргүй учир үйл ажиллагаа явагдсаар байна.

3.6 Автобаазын дээрх объектуудад албаны автомашины аюулгүй байдал болон бэлэн байдлыг хангах чиглэлээр 24 цагаар өдөр тутам үүрэг гүйцэтгэж байгаа энгийн жижүүрүүд /диспетчер/-ийн ажлын байр нь агаарт ялгарч буй автомашины утаан дахь нүүрстөрөгчийн дутуу болон давхар исэл, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, кадмий, алдегид зэрэг хорт бодистой хүнд нөхцөлд ажиллаж байна гэж үзэхээр байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Автобаазад ашиглагдаж буй дийлэнх барилга, байгууламж нь насжилт өндөртэй, элэгдэл хорогдолд орсон, зарим объектууд сүүлд баригдсан ч чанар, аюулгүй байдлын хувьд засварлах шаардлага бий болсон байна.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга, байгууламжийн ашиглалт, насжилтын байдалтай холбоотой үйл ажиллагаанд дараах байдлаар сайжруулалт хийх шаардлагатай гэж дүгнэв. Үүнд:

Нэг. Хууль зүй, дотоод хэргийн яамны 363.900.000 /гурван зуун жаран гурван сая есөн зуун мянга/ төгрөгийн урсгал санхүүжилтээр хийгдэх Автобаазын нэгдүгээр хэсгийн зоорийн давхарт хөрсний уснаас хамгаалах байгууламж хийх, автомашин угаалгын байрыг засварлах тендерийн шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, засварын ажлыг эхлүүлэх нь зүйтэй байна.

Хоёр. Барилга, хот байгуулалтын яамны санхүүжилтээр хийгдэх Авто баазын ашиглалтын гуравдугаар хэсгийн барилгын суурин дээр баригдах битүү зогсоол, конторын барилгын зураг, төсвийг хийлгэн батлуулж, төв конторын барилгыг барих санхүүжилтийг 2023 оны төсөвт тусгуулах шаардлагатай байна.

Гурав. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчаас Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэст хандаж дүгнэлт гаргуулахаар заагдсан объектуудад үзлэг, хийлгэн дүгнэлт гаргуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээ авч, үйл ажиллагаандаа ашиглах нь зүйтэй байна.

Дөрөв. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайдын 2004 оны 77, 2011 оны А/26 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтад Автобаазын диспетчерийн ажлын байрыг тусган, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэхэд анхаарах нь чухал байна.

Тав. Тус баазын диспетчерүүд нь энгийн орон тоонд ажилладаг, цалин бага учир 24 цагаар үүрэг гүйцэтгэж ээлжинд гарах үедээ хоолоо өөрсдөө хийж идэж байгаа нь барилга, байгууламжийн галын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд “Хүнсний хангалтын тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/114 дугаартай тушаалаар батлагдсан “шөнийн ээлжид эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын тоо, албан тушаалын жагсаалт”-д тухайн нэгжийн диспетчерийн орон тоог тусгаж, хоолны мөнгийг олгуулах асуудлыг СААА-нд танилцуулж, шийдвэрлүүлэхээр байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1. Автобаазын нэгдүгээр хэсгийн зоорийн давхарт хөрсний уснаас хамгаалах байгууламж хийх, автомашин угаалгын байрыг засварлах ажлыг шуурхай эхлүүлэх / СААА, Автобааз/;

5.2. Авто баазын битүү зогсоол, конторын барилгын зураг, төсвийг хийлгэн, конторын барилгыг бариулах санхүүжилтийг 2023 оны төсөвт суулгаж, шийдвэрлүүлэх /СААА, Автобааз/;

5.3. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчаас Хот

байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэст хандаж дүгнэлт гаргуулахаар заагдсан объектуудад үзлэг, хийлгэн дүгнэлт гаргуулж, заавар чиглэлийг үйл ажиллагаандаа ашиглах/ СААА, Автобааз/;

5.4 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайдын 2004 он 77, 2011 оны А/26 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад Автобаазын диспетчерийн ажлын байрыг тусгуулж, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, Автобааз, Хуулийн хэлтэс/;

5.5 “Хүнсний хангалтын тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/114 дугаартай тушаалаар батлагдсан “Шөнийн ээлжид эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын тоо, албан тушаалын жагсаалт”-д диспетчерийн ажлын байрны нэршлийг оруулж хоолны мөнгийг олгуулах асуудлыг судлаж шийдвэрлүүлэх /СААА, Автобааз, Хуулийн хэлтэс/;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:
.....
.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 03 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Нарстай” дахь хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит.

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/02

Аудитын хугацаа: 2022.02.28- 2022.03.30

Аудитын багийн гишүүд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Д.Борхүү

1.ТАНИЛЦУУЛГА

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Нарстай дахь Хээрийн сургалтын хэсэг нь Нийслэлийн засаг даргын 2004 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 307 дугаартай “Барилгын байршилт тогтоож, газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Цагдаагийн ерөнхий газарт хээрийн сургалтын төв, полигоны зориулалтаар Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх Дархан чиглэлийн авто замын дагуу Хар модтын давааны зүүн талд байршуулан Улаанбаатар хотоос 75 км зайд 1000.0 га газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх эрх олгосон байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 226 дугаар тушаалаар бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр татан буугдсан Дотоодын цэргийн 811 дүгээр тусгай салбарыг Цагдаагийн ерөнхий газрын Сургалт, дадлагын төвийн бүтцэд шилжүүлж, Хээрийн сургалтын хэсэг байгуулагдсан.

Барилга байгууламжийн хувьд 2011 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад орсон 632,671,560 төгрөгийн өртөгтэй, 1160м² талбай бүхий 5 байгууламжтай. Сургалт, дадлагад ашиглагдах 21 галт зэвсэгтэй, хадгалалт, хамгаалалтыг хэсгийн дарга биечлэн хариуцаж, сургалтанд ашигладаг.

Тус хэсэг нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/105 дугаар тушаалаар баталсан “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах журам”, мөн даргын 2018 оны Б/586 дугаар тушаалаар баталсан “Гэрээт, харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх журам”-ын хэрэгжилтийг хангуулж, сургалт, террорист халдлагын болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үеийн хэв журмын хамгаалалт зохион байгуулах, гэмт этгээдийг дайчлан баривчлах дадлага зэрэг хээрийн сургалтуудаас гадна алба хаагчдын ур чадварыг сайжруулах тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж байна.

2014 оноос 2022 он хүртэлх хугацаанд Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, бэлтгэл хангах сургалтуудад давхардсан тоогоор 22000, нийтийн эмх замбараагүй байдлын сургалтад 7518, эрлийн нохой сургах хээрийн сургалтад 77, Тусгай ажиллагааны газрын галт зэвсгийн дадлагад 52, офицерын дамжаа 102, цагдаа дамжаа 305, олон нийтийн

цагдаа бэлтгэх 150 цагдаагийн алба хаагчийг, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны 6281, гэрээт, харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх 772 иргэнийг тус тус сургалтад хамруулсан байна.

Мөн “Хэсгийн байцаагч”, “Хэсгийн төлөөлөгч”, “Шилдэгч мөрдөгч”, “Шилдэг хэрэг бүртгэгч”, “Шилдэг харуулчин”, “Шилдэг нохойн төлөөлөгч”, Мөрдөн байцаах албаны нэрэмжит “Буудлагын тэмцээн”, Санхүү, аж ахуйн албаны даргын нэрэмжит “Буудлагын тэмцээн”, Цагдаагийн байгууллагын аварга шалгаруулах “Буудлагын тэмцээн”, Цагдаагийн ерөнхий газрын марш тактикийн тэмцээн уралдааныг жил бүр амжилттай зохион байгуулж иржээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит марш тактикийн тэмцээнд оролцох цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг жил бүр хүлээн авч, тэмцээнд бэлтгэж амжилттай оролцуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын 2020 оны “Буудлагын аварга” шалгаруулах тэмцээнийг 2020 оны 09 дүгээр сард амжилттай зохион байгуулсан байна.

Уг тэмцээнд Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий 11 байгууллагын 72 алба хаагч, 58 удирдах ажилтнууд оролцсон.

Шинээр 8 буудлагын талбайг байгуулж, 1 тийрийг 100 метр сунгаж, 400 метрээс 1000 метрт буудлага хийх талбай 1-ийг, 500 метрээс 2250 метрт буудлага хийх боломжтой мэргэн буудагчийн суурин талбай 1-ийг тус тус ашиглалтанд оруулснаар орчин үеийн стандартын шаардлага хангасан уралдаан тэмцээн зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хээрийн сургалтын хэсгийн бүтцийн хувьд хэсгийн дарга 1, мэргэжилтэн 1, жолооч-цагдаа 1, тогооч 2, бэлтгэгч 1, үйлчлэгч 1, сахиул 1, малчин 1, галч-сантехникч 4, цахилгаанчин 1 гэсэн 14 орон тоотойгоос жолооч-цагдаа 1, галч-сантехникч 1, тогооч 1 орон тоо дутуу үйл ажиллагаагаа явуулж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.3 дахь хэсэгт заасны дагуу Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Нарстай” дахь хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цаашид учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Нарстай” дахь хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаа, барилга байгууламжийн ашиглалтын байдлыг хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, алба хаагчдад танилцуулж, хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаа, барилга байгууламжийн ашиглалттай холбоотой баримт, мэдээлэл эрх зүйн актууд, алба хаагчдын ажил үүргийн хуваарь, үйл ажиллагааны дэс дараалал, учирч болзошгүй эрсдэл, түүнд тавих хяналтын талаарх мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчидтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, алба хаагчдын ажил, үүргийн гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, Хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаатай биечлэн танилцсан.

Аудитын явцад Сургалт, дадлагын төв болон Хээрийн сургалтын хэсгийн дарга нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, санал хүсэлтийг сонсож, цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан тайланг боловсруулсан.

3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1. Нарстай дахь хээрийн сургалтын хэсэг нь батлагдсан орон тоогоор 14 алба хаагч, ажилтан ажиллаж байгаагаас офицер 2, ахлагч 1, энгийн 11 ажилтан байна.

Улаанбаатар хотоос алслагдсан, цалингийн хэмжээ бага / Энгийн ажилтнууд ТҮ-1-ээс ТҮ-3 хүртэл шатлалаар 406,374-506,498 төгрөгийн цалинтай/, эмнэлгийн түргэн тусламж авахад хүндрэлтэй, ажиллах орчин тав тухгүй зэргээс шалтгаалан алба хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байна. Тухайлбал, Сүүлийн 3 жилийн хугацаанд /2019-2021 онд/ 16 алба хаагч, ажилтан албанаас чөлөөлөгдөж, 19 алба хаагч, ажилтан шинээр томилогдсон байна.

Дээрх хугацаанд тогтмол орон тоо дутуу, мэргэжлийн бус хүмүүсийг ажиллуулж, хэсгийн дарга, мэргэжилтнүүд нь өөрсдөө галч хийж, харуул, хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байна.

3.2. Тус хэсгийн уурын зууханд ажиллаж байгаа ажилтнуудад нүүрсний тоосонцроос шалтгаалсан өвчлөл үүсэх эрсдэлтэй байгааг анхаарч хордлого тайлах сүү, тараг олгох, тоосонцор арьсанд наалдах, харшил үүсэхээс сэргийлсэн хөдөлмөр хамгааллын хувцсыг тавьж олгох асуудлыг судалж шийдвэрлэх шаардлагатай байна.

3.3. Хээрийн сургалтын хэсэг нь байрлалын хувьд урд, баруун, хойд талаараа уулаар хүрээлэгдсэн, баруун болон зүүн хойд талаасаа задгай амтай, замын хаалт, хашлага байхгүйгээс эргэн тойронд байрлах малчдын мал, хүний хөдөлгөөн нь галт зэвсгийн сургалтын үед эрсдэл үүсгэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Дээрх эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 онд хээрийн хэсгийн объектын зүүн хойд талд байрлах задгай хэсгийг дотоод нөөц бололцоогоо ашиглан модон шон, 3 давхар төмөр тор бүхий 400 метр хашааг 3,538,150 төгрөгөөр сэргээн засварласан боловч бусад хэсгээр буюу 5 км орчим газарт хаалт, хашлага хийгдээгүй үлдсэн байна.

3.4. Нийслэлийн засаг даргын 2004 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 307 дугаартай “Барилгын байршилт тогтоож, газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Цагдаагийн ерөнхий газарт хээрийн сургалтын төв, полигоны зориулалтаар олгосон тус хэсгийн 1000.0 га газрын 15 жилийн хугацаа 2019 онд дуусаж сунгуулаагүй, анхнаасаа газар эзэмших гэрчилгээгүй байна.

3.5. Хээрийн сургалтын хэсгийн уурын зуухны халаалтын тогоо нь 2011 оноос хойш ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалтын явцад засвар үйлчилгээ хийгдэж байсан боловч 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр уурын зуухны тогооны дотор талын халаалтын системүүд нь элэгдлээс шалтгаалан ажиллагаагүй болж, байрнуудыг дулаанаар хангах үйл ажиллагаа зогссон байна.

Тухайн үед “Дулааны цахилгаан станц III” төрийн өмчит компаниас хэсгийн дарга өөрийн зардлаар мэргэжлийн 2 хүнийг авчирч, халаалтын системүүдийг засуулж, түр хугацаанд ажилд оруулсан байна.

3.6. 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр “Галт зэвсгийн тухай хууль” шинэчлэн мөрдөгдөж, Хээрийн сургалтын хэсэг мөн оны 09 сараас эхлэн иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны буудлагын дадлага олгох сургалтыг зохион байгуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/14/16 дугаартай “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” тушаалаар нэг иргэнээс 150,000 төгрөгийн төлбөрийг Төрийн сангийн 100900012047 дансанд төвлөрүүлж, цагдаагийн байгууллагаас 9 төрлийн үйл ажиллагааны зардлыг гаргаж, 5 төрлийн галт зэвсэг, 18 сумаар буудлага үйлдүүлж байхаар тодорхойлсон байна.

Гэтэл “7.62x39 мм”, “7.62x54R мм”-ийн сумаар тус бүр 4, нийт 8 ширхэг сумаар иргэдийг буудлагын дадлага хийлгүүлж байгаа боловч 2015 оноос хойш “5.6 мм”, “7.62x51 мм”, “5.56x45 /223/ мм”-ийн сум олгогдоогүйгээс журмаар тогтоосон 3 төрлийн буудлага хийгдээгүй байна.

Уг буудлагыг хийхэд шаардагдах 3 ширхэг галт зэвсгийг шийдвэрлүүлэх хүсэлтийг 2017-2022 онд 5 удаа Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр гаргаагүй байна.

Харин Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/48 дугаартай “Хөрөнгө шилжүүлэх, орлогод авах тухай” тушаалаар “Х-95” загварын хагас автомат буу 1 ширхгийг шийдвэрлэсэн боловч өнөөдрийн байдлаар буудлага үйлдээгүй байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Нарстай” дахь хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагаанд дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж аудитын багаас дүгнэж байна. Үүнд:

Нэг. Нарстай дахь хээрийн сургалтын хэсэг нь батлагдсан орон тоогоор 14 алба хаагч, ажилтан ажиллаж байгаагаас офицер 2, ахлагч 1, энгийн 11 ажилтан байна.

Улаанбаатар хотоос алслагдсан, цалингийн хэмжээ бага, эмнэлгийн түргэн тусламж авахад хүндрэлтэй, ажиллах орчин тав тухгүй зэргээс шалтгаалан алба хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их байна.

Иймд жолооч-цагдаа 1, галч-сантехник 1, тогооч 1 орон тоо дутуу байгааг нөхөн хангалт хийж, энгийн орон тоог цагдаа орон тоонд шилжүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

Мөн галт зэвсгийн сургалт зохион байгуулахад тухайн байгууллагын алба хаагчид албаны галт зэвсэг, сумтайгаа ирдэг боловч авчирсан галт зэвсэг ажиллахгүй, эвдрэлтэй, буудлага үйлдэх үед гацах, нүрш сунах, галын горим алдагдах зэрэг зөрчлүүд байнга давтагдан гардаг байна.

Цаашид албаны бэлэн байдлыг хангуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, галт зэвсгийг засварлах, ашигласан хонгиог дахин цэнэглэх тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах зорилгоор тус хээрийн сургалтын хэсэгт түшиглэн галт зэвсгийн сургалт зохион байгуулах, галт зэвсгийн завсар үйлчилгээ хийх, хонгио дахин цэнэглэх үйл ажиллагааг нэгтгэсэн нэгж байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Хоёр. Тус хэсгийн уурын зууханд ажиллаж байгаа ажилтнуудад эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандарт зөрчигдөх эрсдэл үүсэхээр байгааг анхаарч,

хөдөлмөр хамгааллын хувцас тавьж олгох, хоргүйжүүлэх нэмэлт хүнс олгох зардлыг судалж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Гурав. Хээрийн сургалтын хэсэг нь байрлалын хувьд урд, баруун, хойд талаараа уулаар хүрээлэгдсэн, баруун болон зүүн хойд талаасаа задгай амтай, замын хаалт, хашлага байхгүйгээс эргэн тойронд байрлах малчдын мал, хүний хөдөлгөөн нь галт зэвсгийн сургалтын үед эрсдэл үүсгэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд Нийслэлийн цагдаагийн удирдах газар, албадын нөөц бололцоог ашиглаж, тус хээрийн сургалтын хэсгийн 1000.0 га газрыг хуваарилан өгч, хашаажуулах ажлыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын төвөөс зохион байгуулах нь зүйтэй байна.

Дөрөв. Нийслэлийн засаг даргын 2004 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 307 дугаартай “Барилгын байршилт тогтоож, газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Цагдаагийн ерөнхий газарт хээрийн сургалтын төв, полигоны зориулалтаар олгосон тус хэсгийн 1000.0 га газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх эрх олгосон хугацаа 2019 онд дуусаж сунгуулаагүй, газар эзэмших гэрчилгээ гаргуулаагүй байна.

Тав. Хээрийн сургалтын хэсгийн уурын зуухны халаалтын тогоо нь 2011 оноос хойш ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалтын явцад зуухны дотор талд байрлах зориулалт бүхий ус халаах турбины хана нимгэрч задарснаас халуун ус алдаж, тэсрэлт үүссэн тохиолдол гарсан тул цаашид уг тогоог цахилгаанаар халаах төхөөрөмжөөр сольж, хэвийн үйл ажиллагааг хангах шаардлагатай байна.

Зургаа. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/14/16 дугаартай “Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай” тушаалаар нэг иргэнээс 150,000 төгрөгийн төлбөрийг Төрийн санд төвлөрүүлж, цагдаагийн байгууллагаас 9 төрлийн үйл ажиллагааны зардлыг гаргаж, 5 төрлийн галт зэвсэг, 18 сумаар буудлага үйлдүүлж байхаар тодорхойлсон байна.

Гэтэл 2015 оноос хойш нэг иргэний сургалтанд өнөөдрийн байдлаар 223 сумаар буудлага үйлддэг буу 1 ширхэг байдаг боловч сум олгогдоогүй, 5.6 мм ийн сумаар буудлага үйлддэг сум нь олгогдсон боловч буу нь байхгүй, мөн 7.62x51 сумаар буудлага үйлддэг буу, сум нь байдаггүйгээс журмаар тогтоосон 3 төрлийн галт зэвсэг, 10 сумаар буудлагыг хийгдээгүй тул шаардагдах галт зэвсгийг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

5.ЗӨВЛӨМЖ

5.1. Нарстай дахь хээрийн сургалтын хэсгийн жолооч-цагдаа 1, галч-сантехникч 1, тогооч 1 орон тоо дутуу байгааг нөхөн хангалт хийж, энгийн орон тоог цагдаа орон тоонд шилжүүлж, нөхөн хангалт хийх асуудлыг шийдвэрлүүлэх /ХНХ, ЦДЦСНТ/

5.2. Албаны бэлэн байдлыг хангуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, галт зэвсгийг засварлах, ашигласан хонгиог дахин цэнэглэх тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах зорилгоор тус хээрийн сургалтын хэсэгт түшиглэн галт зэвсгийн сургалт зохион байгуулах, галт зэвсгийн завсар үйлчилгээ хийх, хонгио дахин цэнэглэх үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгж байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, АБХ, ЦДЦСНТ/;

5.3. Тус хэсгийн уурын зууханд ажиллаж байгаа ажилтнуудад эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандарт зөрчигдөх эрсдэл үүсэхээр байгааг анхаарч, хөдөлмөр хамгааллын хувцас тавьж олгох, хоргүйжүүлэх нэмэлт хүнс олгох зардлыг судалж, шийдвэрлүүлэх /CAAA, АБХ, ЦДЦСНТ/;

5.4. Хээрийн сургалтын хэсгийн 1000.0 га газрыг Нийслэлийн цагдаагийн удирдах газар, албадын нөөц бололцоог харгалзан хуваарилалт хийж, хашаажуулах ажлыг зохион байгуулж, дүнг ирүүлэх /НЦУГ, Албад, ЦДЦСНТ/;

5.5. Нийслэлийн засаг даргын 2004 оны 307 дугаартай "Барилгын байршилт тогтоож, газар эзэмшүүлэх тухай" захирамжаар Цагдаагийн ерөнхий газарт хээрийн сургалтын төв, полигоны зориулалтаар олгосон тус хэсгийн 1000.0 га газрын 15 жилийн хугацаа 2019 онд дууссан, газар эзэмших эрхийн гэрчилгээгүй байна. Иймд холбогдох газарт хандан, захирамж, гэрчилгээг гаруулан, нэгж талбарын кадастрын зургийг шинэчлэх ажлыг зохион байгуулж, дүнг ирүүлэх /CAAA, ЦДЦСНТ/;

5.6. Хээрийн сургалтын хэсгийн уурын зуухны халаалтын тогоог цахилгаанаар халаах төхөөрөмжөөр сольж, хэвийн үйл ажиллагааг хангах асуудлыг шийдвэрлэх /CAAA, ЦДЦСНТ/;

5.7. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/14/16 дугаартай "Сургалтын төлбөрийн хэмжээ, зардлын норматив батлах тухай" тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор "5.6 мм", "7.62x51 мм", "5.56x45 мм"-ийн сумаар буудлага хийлгэх зориулалтаар 3 ширхэг галт зэвсэг олгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх /CAAA, АБХ, ЦДЦСНТ/;

5.8. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ
ХОШУУЧ ГЕНЕРАЛ


Даргын өгсөн үүрэг, чиглэл:



Ж.БОЛД

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХЯНАСАН:
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



О.АМАРСАНАА

Д.МАНЛАЙБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭСИЙН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.БОРХҮҮ

Ажлын баримт 3001/
ЦЕГ/ХШДАХ/2022/НА-3

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2021” арга хэмжээний хэрэгжилтэд хийх дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс

Аудитын объект: “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” төслийн үйл явц, үр дүн, санхүүжилт ба зарцуулалтын байдал

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ/ХШДАХ/2022/НА-03

Аудитын хугацаа: 2022.03.01-нээс 2022.04.01-ний өдөр хүртэл

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Лхагважаргал, байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн 3.1.2, Цагдаагийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.16 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа иргэд, жолооч нарт зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөл, хор уршиг, учирч болзошгүй эрсдэлийг таниулах, эрх зүйн боловсрол олгох, жолоочийн хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлгөөний соёл, зөв дадал, хандлагыг төлөвшүүлэх замаар иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюутолгой” ХХК, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс мөн оны 08 дугаар сарын 15-ны хооронд улсын хэмжээнд “Ирээдүйгээ хамгаалъя” уриан дор дээрх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнт тооцсон байна.

Цагдаагийн ерөнхий газар болон “Оюутолгой” ХХК хоорондын хамтран ажиллах гэрээний 1.1 дэх хэсэгт заасны дагуу төслийн санхүүжилт болох 256.500.000 төгрөгийг төрийн сангийн 1009000012412 тоот дансанд шилжүүлжээ.

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Дээрх төслийн үйл явц, үр дүн, санхүүжилтийн байдалд дотоод аудит хийж цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцоход энэхүү аудитын зорилго оршино.

2.2 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, алба хаагчдад танилцуулж, уг арга хэмжээтэй холбоотой баримт, материал, эрх зүйн актуудын талаарх мэдээллийг цуглуулж судалсан.

Дээрх мэдээлэлд тулгуурлан арга хэмжээг зохион байгуулсан нэгжийн алба хаагчид, хамтран ажилласан байгууллагын ажилтнуудтай биечилсэн байдлаар болон утсаар ярилцлага хийж, аудитын зорилгод нийцүүлэн мэдээлэл авч ашигласан.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Ирээдүйгээ хамгаалъя” арга хэмжээний хүрээнд “Кловер гроув технологи” ХХК-тай гэрээ байгуулж, иргэд, олон нийтэд сурталчлах, тэдний эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах чиглэлээр маркетингийн зөвлөх үйлчилгээ авах, 15 постер хийж, иргэд олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгүүлэхээр 11.900.000 төгрөгийг шилжүүлсэн байна.

Гэвч гэрээнд заагдсан ажлыг хүлээн авсан тайлан, гүйцэтгэлийн үр дүнг нотлох баримт байхгүй байгаа нь уг ажил бодитой хэрэгжсэн эсэх нь нотлогдохгүй байна.

3.2 Арга хэмжээний хүрээнд хийгдсэн зурагт постерыг 2021 оны 07 сарын 07-ноос 20-ны өдөр хүртэл хугацаанд “Жэй Си Дэко Монголиа” ХХК-тай гэрээ байгуулж, хотын төвийн 12 автобусны зогсоол, 6 мэдээллийн байгууламж, 3 дижитал дэлгэцэнд нийт 14.014.000 төгрөгөөр байршуулж иргэд, олон нийтэд сурталчилсан байна.

Мөн “Си си ти эс” ХХК –тай 12.000.000 төгрөгийн гэрээгээр зурагт постерыг 2021 оны 07 сарын 05-наас 19-ний өдөр хүртэл хугацаанд хотын төвийн автозам дагуу байрлах “1.07х1.51м” хэмжээтэй 2 талд 40 ширхэг самбарт байршуулж иргэд, олон нийтэд сурталчилжээ.

Дээрх байгууллагууд нь автобусны зогсоол, мэдээллийн байгууламж, дижитал дэлгэцэд сурталчилгаа байршуулдаг өрсөлдөгчгүй, цор ганц бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй олон удаа хамтран ажиллаж байгаа хэдий ч түншлэлийн гэрээ байгуулаагүй, гэрээнд хөнгөлөлт, урамшууллын талаар огт тусгадаггүй зэрэг алдаа байна.

3.3 “Чилагун хөгжил” ХХК-тай 12.100.000 төгрөг, “Колор майнд” ХХК-тай 19.900.000 төгрөгийн гэрээг тус тус байгуулж, бараа, бүтээгдэхүүн

нийлүүлэхээр тохирсон байна.

Санхүүгийн баримтаас харахад, бараа, бүтээгдэхүүн хүлээж авсан акт, зарцуулалтын тайлан байхгүй байна. Тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын санамж бүхий CD 500, хүүхдийн аюулгүй суудал түшлэгтэй 14, хүүхдийн аюулгүйн суудал нярайн 15, хүүхдийн аюулгүйн суудал /том хүүхдийн/ 28, хүүхдийн суудал өндөрлөгч 19, хүүхдийн бүс агшаагч 48 ширхэг нийт 624 ширхэг, автомашинд байрлуулах гар утасны дугаар бичигч “80x150мм” хэмжээтэй 10.000, “140x140” хэмжээтэй 10.000, “88x85мм” 7.100, фодволк 300, наадаг стикер 3.500 ширхэг нийт 30.900 ширхэгийг бэлтгэн нийлүүлсэн гэх боловч зарцуулалтын тайлан, санхүүгийн анхан шатны баримтуудыг бүрдүүлээгүй байна.

3.4 “Гэгээн смарт” ХХК-тай 6.600.000, “Гэртүүн” ХХК-тай 3.300.000, “Сүүн зам фильм” ХХК-тай 3.300.000, “Үнэний ташуур” ХХК-тай 3.300.000, “Гучин тавын хальс продакшин” ХХК-тай 3.300.000 төгрөгийн 4 видео шторк хийлгэх нийт 13.200.000 төгрөгийн гэрээг тус тус байгуулж, видео шторк бүтээлгэж, байгууллагын цахим хаягт байршуулсан байна. Эндээс дүгнэхэд зах зээлийн үнийн судалгааг бодитой хийгээгүй, чанарын шаардлагыг гэрээнд тусгаагүй, санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гаргаагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс нь зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Ирээдүйгээ хамгаалъя” арга хэмжээг иргэд, олон нийтэд сурталчлан, тэдний эрх зүйн боловсролыг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулсан нь сайшаалтай байна.

Уг арга хэмжээний үр дүнд улсын хэмжээнд зам, тээврийн ослын шинжтэй дуудлага мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0, үүнээс осол, хэрэг 5.7, хүний амь хохирсон хэрэг 33.3, хүн гэмтсэн осол 25.5, хүүхдийн амь хохирсон хэрэг 33.3, хүүхэд гэмтсэн осол 1.0 хувиар тус тус буурсан зөрөг үзүүлэлт гарчээ.

Гэвч дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн дүгнэхэд “Ирээдүйгээ хамгаалъя” арга хэмжээг үр дүнтэй, оновчтой зохион байгуулсан хэдий ч санхүүгийн баримтын иж бүрдлийг хангалтгүй бүрдүүлсэн, зах зээлийн үнийн судалгааг бодитой хийгээгүй, чанарын шаардлагыг гэрээнд тусгаагүй, санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гаргаагүй гэж үзэж, дараах сайжруулалт хийх шаардлагатай байгааг илтгэн танилцуулья.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Аудитын багаас тулган баталгаажуулсан мэдээлэл, аудитын үр дүнд үндэслэн цаашид дээрх алдаа, дутагдлыг гаргуулахгүй байх чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

5.1 Цагдаагийн байгууллагад урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөл,

хөтөлбөр хэрэгжүүлэхдээ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулахаас өмнө хуульд заасны дагуу зах зээлийн үнийн судалгааг үнэн бодитоор хийж байх /СААА, УСХ/;

5.2 Хувь хүн, байгууллагатай гэрээ байгуулахдаа хүлээн авах бараа, бүтээгдэхүүний чанар, стандарт, хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал зэргийг тусгаж, хэрэгжилтийг тогтмол дүгнэж байх /УСХ/;

5.3 Худалдах, худалдан авах, ажил гүйцэтгүүлэх гэрээний үр дүн, гэрээг дүгнэсэн акт үйлдэхдээ хүлээн авсан акт, зарцуулалтын тайлан, нотлох баримтад үндэслэсэн байхад анхаарах /УСХ/;

5.4 Цаашид “Си си ти эс” ХХК, “Жэй СИ Дэко Монголиа” ХХК-тай тогтмол хамтран ажиллаж байгаа тул түншлэлийн гэрээг байгуулан хамтран ажиллах, гэрээг Хуулийн хэлтсээр хянуулж байх /УСХ, ХХ/;

5.5 Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг энэ оны 11 дүгээр сарын 15-ны дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Даргын өгсөн үүрэг, чиглэл: _____

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛИЙН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Б.ЛХАГВАЖАРГАЛ

БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

Ч.ЭРДЭНЭБОЛОР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалт, дадлагын төв”-ийн үйл ажиллагаанд дотоод аудит”

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/04

Аудитын хугацаа: 2022.03.07- 2022.03.28

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүдэд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, цагдаагийн хошууч Б.Лхагважаргал.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Цагдаагийн албаны тухай хуулийн 17.1-дэх хэсэгт “Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно”, 17.2 дэх хэсэгт «...мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална» гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 4.2 дахь хэсэгт “Бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлнэ», 4.3 дахь хэсэгт «Монгол Улсын эдийн засгийн бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарийг ... тогтоож, хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уг хуваарийг ...», 4.3.1 дэх хэсэгт “Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд”, 4.3.2 дахь хэсэгт “Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл”, 4.3.3 дахь хэсэгт “Төвийн бүсэд: Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв”, 4.3.4 дэх хэсэгт “Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий” гэж тодорхойлжээ.

Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдээс Өвөрхангай, Хэнтий, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Ховд аймаг дахь цагдаагийн газрууд алба хаагчдын санаачилгаар сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий Сургалт, дадлагын төвийг байгуулсан, Дорнод, Сүхбаатар, Завхан, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрууд төв барих газраа шийдвэрлүүлсэн, бусад

аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд сургалтын төв байгуулаагүй байна.

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.6 дахь хэсэгт заасны дагуу Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагаа, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” /код 118/ журмын хэрэгжилтийн байдлыг аудитын объектод хамруулна.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагааны танилцуулга, мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч, судалсан байна.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор Өвөрхангай, Булган аймагт томилолтоор ажиллаж, цагдаагийн газрын холбогдох нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, сургалт, дадлагад ашиглагдаж буй Сургалт, дадлагын төвийн барилга, байгууламжийн ашиглалт, насжилт, болзошгүй эрсдэл үүсэх нөхцөл байдал бий эсэх, газар дээр нь дээрх үйл ажиллагаатай биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар: Алба хаагчдын бие бялдрын нормитив түвшинг хангах, мэргэжлийн бэлтгэл, албаны болон давтан сургалт зохион байгуулах зорилгоор 2017 онд тус аймгийн Тарагт сумын нутаг дэвсгэрт 2,5 га газрыг шийдвэрлүүлэн авч, Сургалт, дадлагын төвийн байгуулсан байна.

Тус цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн цагдаа-жолоочийн нэг орон тоог Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/456 дүгээр тушаалаар Сургалт, дадлагын төвийн үйл ажиллагаанд хяналт тавих, сургалт хариуцсан мэргэжилтэн болгон өөрчилж, шийдвэрлүүлсэн байна.

Сургалт, дадлагын төвийн бүтээн байгуулалтын талаар: Цагдаагийн газрын тасаг тус бүр хариуцан тоосгон ханатай 5х5 хэмжээтэй нэг бүр нь 7.500.000 /долоон сая таван зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий 6

ширхэг амралтын байр, 4.500.000 /дөрвөн сая таван зуун/ төгрөгийн өртөг бүхий 130 метр цахилгаан шугам дагалдах хэрэгсэл, 2.400.000 /хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 2.700.000 /хоёр сая долоон зуун мянга/ төгрөгийн цахилгаан утас, дагалдах хэрэгсэл, 1.200.000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийн бүтээлэг, цагаан хэрэглэл зэргийг худалдан авсан байна.

Сургалтын төвийн өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлснээр орон нутгийн хөрөнгөөр 25.000.000 /хорин таван сая/ төгрөгийг шийдвэрүүлэн нийт 670 орчим метр урттай блокон суурьтай, төмөр хийц бүхий хашааг 2017 онд барьж ашиглалтанд оруулжээ.

Тус аймгийн Засаг даргын 2018 оны А/42 дугаар захирамжаар Сургалт, дадлагын төвийн зуны 5 байрны 25.000.000 /хорин таван сая/ төгрөг, 5 ханатай монгол гэрийг 5.000.000 /таван сая/ төгрөгөөр худалдан авч, сургалтад хамрагдсан алба хаагчдын хоол, цай болон хэргийн газрын үзлэг хийх зэрэг сургалтын зориулалтаар ашиглаж байна.

Мөн төвд 6x20м хэмжээтэй 7.000.000 /долоон сая/ төгрөгийн өртөгтэй 2 ширхэг хүлэмжийг аймгийн Засаг даргаар шийдвэрлүүлж, 24 төрлийн нарийн ногооны үрсэлгээг суулган тарилан, цагдаагийн газрын болон алба хаагчид хүнсэнд хэрэглэж байна.

Тус төвд цагдаагийн газрын 80 жилийн ойн хүрээнд Арвайхээр сумын Засаг даргын 2019 оны А/110 дугаар захирамжаар 20.000.000 /хорин сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэр сургалтын танхимыг барьж ашиглалтад оруулсан, цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг угтан сүүдрэвч, гар бөмбөг, сагсан бөмбөгийн талбай, усан оргилуур, стандартын шаардлага хангасан бие засах газар, хогийн цэг, тугны суурь, индэр, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний гүүр, жагсаалын талбай, “Бид мартаггүй” цогцолбор хөшөө, “Цагдаа дурсгалын хөшөө” зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгджээ.

Цагдаагийн ерөнхий газар болон орон нутгийн санхүүжилтээр 50,000,000 /тавин сая/ төгрөгийг шийдвэрлүүлэн тус цагдаагийн газрын Сургалт, дадлагын төвийн байр /сургалтын танхим, алба хаагчдын амрах байр/-ыг 2021 оны 04 дүгээр сард бүрэн ашиглалтад оруулсан байна.

Зохион байгуулсан сургалтын чиглэлээр: Тус төвд 2018 онд бүсчилсэн сургалт 1-ийг зохион байгуулж, Өвөрхангай, Архангай, Булган, Баянхонгор, Орхон аймаг дахь цагдаагийн газрын 75, 2020 онд бүсчилсэн сургалт 2-ыг зохион байгуулж, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Дундговь, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын 145 алба хаагчийг тус тус хамруулсан байна.

3.2 Хэнтий аймаг дахь цагдаагийн газар: 2018 онд аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3.21 дэх заалт, мөн даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.3.1.7 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэнтий аймаг

дахь цагдаагийн газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний 2 дугаар зүйлийн 2.6.2 дахь хэсэгт тус тус заалт оруулж 2,0 га газрыг шийдвэрлүүлж, Сургалт, дадлагын төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/35 дугаар тушаалаар тус төвд цэвэрлэгээ, үйлчилгээ, урсгал засвар, эд зүйлийн бүрэн бүтэн байдлыг хариуцсан аж ахуйн ажилтнаар 1 алба хаагчийг томилуулсан байна.

Сургалт, дадлагын төвийн бүтээн байгуулалтын талаар: Аймаг, орон нутгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2018-2020 онд тус сургалтын төвийн бүтээн байгуулалт, тохижилтын ажил 80.0 хувийн гүйцэтгэлтэйгээр сургалтын 2 давхар байр, амралтын 5,5 х 5,5м харьцаатай дүнзэн 6 байшин, жагсаалын болон сагсан бөмбөгийн тус бүр 15 х 30м харьцаатай бетонон талбай, элсний волейболын иж бүрэн талбай, 600 м урттай гадна талын блокон хашаа, төмөр хаалганы хамт, гар худаг, 00, угаалтуур, 380 вольтын сургалтын төвийн цахилгааны холболтыг 600 м газраас газар доогуур сувагчлан хийсэн, 10х7м харьцаатай 3ш хүлэмж, шалган нэвтрүүлэхийн байр, гэрэлтүүлэг, Сургалт, дадлагын төвийн сургалтын байрны 2 давхарыг буудлын зориулалтаар “ОСП” хавтангаар 3 өрөө гарган засварлаж, шатны эргэх талбайг шинэчлэн, нэгдүгээр давхарын сургалтын байрны таазыг өнгөт хавтангаар дүүргэлт хийсэн байна..

Дээрх бүтээн байгуулалтын ажилд 153,998,800.00 / нэг зуун тавин гурван сая есөн зуун ерэн найман мянга найман зуун/ төгрөг төсөвлөснөөс орон нутгийн төсвөөс 33,000,000 /гучин гурван сая/, байгууллагын батлагдсан төсвийн урсгал засварын зардлаас 21,000,000 /хорин нэгэн сая/, аж ахуй нэгж, байгууллагаас санхүүгийн дэмжлэг 4,000,000 /дөрвөн сая/, ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, нийтдээ 73,000,000/ далан гурван сая/ төгрөгийг зарцуулаад байна.

Сургалтын төвийн бүрэн баригдаж дууссан 5 байшинг байгууллагын данс бүртгэлд авч, цагдаагийн газрын төвийн 5 тасагт хариуцуулан алба хаагчдын өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан тохижуулан, эд зүйлийн аюулгүй байдал, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцуулан ажиллаж байна.

Одоогоор сургалтын байрны доторлогоо, гадна хашааны дээд талын хайс хийх бусад тохижилтын ажлуудыг 2022 онд хийж гүйцэтгэн байнгын ашиглалтанд оруулахаар төлөвлөөд байна.

Тус төвд 8,000.000 /найман сая/ төгрөгийн үнэ бүхий хашаа талбай, 1,800,000 /нэг сая найман зуун мянга/ төгрөгийн үнэ бүхий хашааны төмөр хаалга, 1.000.000 /нэг сая/ төгрөгийн өртөг бүхий гүний худаг, тус бүр нь 6,000,000 /зургаан сая / төгрөгийн үнэ бүхий 5 амралтын байр, 1,518,000 /нэг сая таван зуун арван найман мянга/ төгрөгийн өртөг бүхий харуулын байшин, 3,000,000 /гурван сая/ төгрөгийн өртөг бүхий биеийн тамирын

тоног төхөөрөмжтэй талбай, 600,000 /зургаан зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий бие засах газар, 800,000 /найман зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий усны савтай угаалтуур, 500,000 /таван зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий тарьсан модыг тойруулж барьсан хайсан хашаа, 30,000,000 /гучин сая/ төгрөгийн үнэ бүхий сургалтын төвийн дуусаагүй барилга, нийт 77,218,000 /далан долоон сая хоёр зуун арван найман мянга/ төгрөгийн өртөг бүхий 13 объект, 300 ширхэг мод тарьсан байна.

Зохион байгуулсан сургалтын чиглэлээр: Сургалт дадлагын төвийн байр бүрэн ашиглалтад ороогүй тул бүс болон алба хаагчдын дунд явагдах сургалт зохион байгуулагдаагүй байна.

3.3 Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар: 2020 онд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгонд 2,8 га газарт Сургалт, дадлагын төвийг байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

Сургалт, дадлагын төвийн бүтээн байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын 2021 оны А/511 дугаартай “Хөрөнгө зарцуулах” тухай захирамжаар тус сургалтын төвд 30.000.000 /гучин сая/ төгрөгийг шийдвэрлүүлж, сургалт, дадлагын төвийн сургалт явуулах байр, хоолны заал, хашаа, алба хаагчид байрлах байшингуудыг барих модыг бэлтгэхээр Хатгал тосгоны нутаг дэвсгэрт 17.4 га газрыг хуулийн дагуу тусгаарлуулан авч 407 м3 модыг бэлтгэн 2.8 га газрын тойрсон 1.2м өндөр модон хашаа, 50 алба хаагчийг нэг дор хүлээн авах хүчин чадалтай 30,000,000 /гучин сая/ төгрөгийн өртөг бүхий 10х12 метр хэмжээтэй модон хийцтэй хоёр давхар сургалтын төвийн байшин, 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгийн өртөг бүхий 4х4 метр хэмжээтэй шалган нэвтрүүлэх байр барьжээ.

Дотоод нөөц бололцоогоо ашиглан модон материалын худалдан авалт хийж 3,000,000 /гурван сая/ төгрөгийн өртөг бүхий 3х4м хэмжээтэй ариун цэврийн байгууламж, модон материалтай 10х10х1м хэмжээ бүхий монгол гэрийн суурь, 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгийн өртөгтэй иж бүрэн сийлбэр бүхий хүндэтгэлийн монгол гэр, 3,500,000 /гурван сая таван зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг амралтын байрыг барьж байгуулсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны А/17 дугаартай “Хөрөнгө зарцуулах” тухай шийдвэрээр 20.000.000 /хорин сая/ төгрөгийг шийдвэрлүүлэн 7,700,000 /долоон сая долоон зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий суралцагчийн 40 ширээ, 40 сандал, 2,185,000 /хоёр сая нэг зуун наян таван мянган/ төгрөгийн өртөг бүхий проектор, дэлгэц, индэр, 40-50 хүний хоолыг нэгэн зэрэг хийх хүчин чадалтай 6,100,000 /зургаан сая нэг зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий нэг, хоёрдугаар хоолны тогоо, 1,300,000 /нэг сая гурван зуун/ төгрөгийн үнэ бүхий нэг, хоёрдугаар хоолны аяга таваг 80 ширхэг, цайны аяга ширхэг, 80 ширхэг халбага, 80 ширхэг сэрээ, будаа агшаагч зэргийг худалдан авчээ.

Зохион байгуулсан сургалтын чиглэлээр: Энэ хугацаанд ямар нэгэн сургалт зохион байгуулаагүй бөгөөд цаашид ариун цэврийн

байгууламжийн эвдэрсэн тоног төхөөрөмжүүдийг засварлах, суралцагчид хооллох хоолны заалыг барих, бусад модон материалыг бэлтгэж, 2022 оны 08 дугаар сард Сургалт, дадлагын төвийн үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.

3.4 Булган аймаг дахь цагдаагийн газар: 2014 онд Сургалт, дадлагын төвийг аймгаас 7 км зайтай нь 14539 м² хэмжээтэй газарт байгуулсан байна.

Сургалт, дадлагын төвийн бүтээн байгуулалтын талаар: Уг төв нь 12х12 хэмжээтэй, 144м³ тайлбайтай, дүнз модон хийцтэй байшинг 2015 онд барьж ашиглалтад оруулжээ.

Уг байшин нь 2 давхар ба 1 давхартаа 16 м² хэмжээтэй гал тогоо, 96 м² хэмжээтэй сургалтын заалтай, 2 давхартаа 24 м² хэмжээтэй, хоол идэх зориулалт бүхий талбай, 24 м², 16 м², 32 м² хэмжээтэй амралтын 3 өрөөтэйгөөр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 6.000.000 /зургаан сая/ төгрөгийн төсвийн хэмнэлтийн урамшууллаас 13.000.000 /арван гурван сая/ нийт 19.000.000 /арван есөн сая/ төгрөгийг зарцуулан барьжээ.

Сургалтын төвийн хажууд цагдаагийн газрын тасаг тус бүр хариуцан модон ханатай 4х4м хэмжээтэй тус бүр нь 4.500.000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий 8 ширхэг өвлийн зориулалт бүхий амралтын байрыг барьсан байна.

Мөн алба хаагчдын санаачлагаар цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойг угтан сүүдрэвч, гар бөмбөг, сагсан бөмбөгийн талбай, усан оргилуур, хурлын индэр, хүүхдийн тоглоомын болон жагсаалын талбай, стандартын шаардлага хангасан бие засах газар, хогийн цэгийг шинээр хийжээ.

Тус төвд 2.000.000 /хоёр сая/ төгрөгийн үнэ бүхий хашаа, 1.000.000 /нэг сая/ төгрөгийн өртөг бүхий гүний худаг, тус бүр нь 4.500.000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийн өртөг бүхий 8 амралтын байр, 47.000.000 /дөчин долоон сая/ төгрөгийн үнэ бүхий сургалтын байр нийт 86.000.000/ наян зургаан/ сая төгрөгийн өртөг бүхий 9 объект байна.

Зохион байгуулсан сургалтын чиглэлээр: 2016 онд 1, 2017 онд 2 нийт 3 удаа сургалт зохион байгуулж, 163 алба хаагчийг хамруулсан байна.

Энэхүү төв нь байнгын харуул хамгаалалт, техник, тоног төхөөрөмж, урсгал зардлын санхүүжилт байхгүйгээс 2017 оноос хойш ашиглагдаагүй байна.

3.5 Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар. 2015 онд Сургалт, дадлагын төвийг Шаамар суманд байгуулсан.

“Сургалт дадлагын төв”-ийн бүтээн байгуулалтын талаар: Уг төвд 1.711.222 /нэг сая долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөгийн үнэ бүхий палкан 2 өрөө бүхий байр, 6.205.202 /зургаан сая хоёр зуун тав хоёр зуун хоёр/ төгрөгийн үнэлгээтэй сургалтын танхим, тус бүр нь 4.000.000 /дөрвөн сая / төгрөгийн үнэ өртөгтэй амрах

байр 4 ширхэг, 6.000.000 /зургаан сая/ төгрөгний үнэтэй гал тогооны зориулалтаар ашиглаж буй вагончиг, тус бүр нь 1.198.390 /нэг сая нэг зуун ерэн найм гурван зуун/ төгрөгний иж бүрэн 2 ширхэг гэр, 2.500.000 /хоёр сая таван зуун/ төгрөгний үнэ бүхий гадна саравч, 1.658.510 /нэг сая зургаан зуун тавин найм таван зуун арав/ төгрөгний үнэ бүхий харуулын байр, 1.198.390 /нэг сая нэг зуун ерэн найм гурван зуун ерэн/ төгрөгний үнэтэй зуны амралтын байр 1 ширхэг, нийт 35.273.324 төгрөгний өртөг бүхий 10 объект байна.

Зохион байгуулсан сургалтын чиглэлээр: 2015 оноос хойш тус төвд цагдаагийн газрын сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт зориулсан сургалт, цугларалтыг улирал бүр зохион байгуулж байна.

3.6 Ховд аймаг дахь цагдаагийн газар. 2019 онд Сургалт, дадлагын төвийг Буянт суманд 2 га газрыг хашаалж, байгуулсан байна.

Сургалт, дадлагын төвийн бүтээн байгуулалтын талаар: Тус төв нь орон нутгийн төсвөөс 55,000,000 сая төгрөгийг шийдвэрлүүлж, барилгын ажлыг эхлүүлсэн ба одоогийн байдлаар 85 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цагдаагийн газрын тасаг тус бүр хариуцан тоосгон ханатай 5x4м хэмжээтэй тус бүр нь 5.500.000 /таван сая таван зуун мянга/ төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг амралтын байр, 18x8м харьцаатай, 10.000.000 төгрөг /арван сая/ төгрөгний үнэ бүхий сургалтын байр, 18x36м хэмжээтэй жагсаалын талбай, 14x25м хэмжээтэй сагсан бөмбөгийн талбай, 9x18м хэмжээтэй элсны волейболын талбай, 50 автомашины багтаамжтай авто зогсоол, 150 м² тойргийн гүйлтийн талбай, 05x05 хэмжээтэй өнгөт хавтангаар 1x70метр урттай хийсэн явган хүний зам, 12.000.000 /арван хоёр сая/ төгрөгийн өртөг бүхий 2000 метр талбай бүхий тоосгон суурьтай, төмөр хийц бүхий хашааг барьж ашиглалтанд оруулжээ.

2022 оны орон нутгийн төсвөөс 45.000.000 /дөчин таван сая/ төгрөгийг шийдвэрлүүлж, тус төвийг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагааг дараах байдлаар сайжруулалт хийх шаардлагатай гэж дүгнэв. Үүнд:

Нэг. Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоол, Цагдаагийн албаны тухай хуулийн 17.1, 17.2 дахь заалтын хэрэгжилтийг хангахын тулд Төвийн бүсийн төвийг Сэлэнгэ, Баруун бүсийн төвийг Ховд, Хангайн бүсийн төвийг Өвөрхангай, Зүүн бүсийн төвийг Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын дэргэд байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах шаардлагатай байна.

Хоёр. Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын Сургалт, дадлагын төвийн үйл ажиллагааг жишиг болгож, Хэнтий, Сэлэнгэ, Ховд аймаг дахь цагдаагийн газрын дарга нар Сургалт, дадлагын төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх, хүний нөөц, төсөв хөрөнгийн асуудлыг батлагдсан орон тоо, төсөвт багтаан шийдвэрлүүлэх талаар Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөц болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтран зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авах шаардлагатай байна.

Гурав. Өвөрхангай, Хэнтий, Сэлэнгэ, Ховд аймаг дахь цагдаагийн газраас бусад орон нутагт Сургалт, дадлагын төв байгуулах шаардлагагүй бөгөөд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, үл хөдлөх хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, урсгал засварт төлөвлөгдөөгүй зардал гарах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл үүсэхээр байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1 Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоол, Цагдаагийн албаны тухай хуулийн 17.1, 17.2 дахь заалтын хэрэгжилтийг хангахын тулд Төвийн бүсийн төвийг Сэлэнгэ, Баруун бүсийн төвийг Ховд, Хангайн бүсийн төвийг Өвөрхангай, Зүүн бүсийн төвийг Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын дэргэд байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах /СГАСХ, ЦДЦСНТ, Сэлэнгэ, Ховд, Өвөрхангай, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар/;

5.2 Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын Сургалт, дадлагын төвийн үйл ажиллагааг жишиг болгож, Хэнтий, Сэлэнгэ, Ховд аймаг дахь цагдаагийн газрын дарга нар Сургалт, дадлагын төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх, хүний нөөц, төсөв хөрөнгийн асуудлыг батлагдсан орон тоо, төсөвт багтаан шийдвэрлүүлэх талаар Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөц болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтран зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авах /СААА, ХНХ, СГАСХ, ЦДЦСНТ, Сэлэнгэ, Ховд, Өвөрхангай, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар/;

5.3 Өвөрхангай, Хэнтий, Сэлэнгэ, Ховд аймаг дахь цагдаагийн газраас бусад орон нутагт Сургалт, дадлагын төв байгуулах шаардлагагүй бөгөөд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, үл хөдлөх хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, урсгал засварт төлөвлөгдөөгүй зардал гарах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл үүсэхээр байгааг анхаарах /СГАСХ, ЦДЦСНТ/;

5.4 Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

.....

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 13 -ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдалд” хийсэн дотоод аудит”

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/07

Аудитын хугацаа: 2022.04.07- 2022.04.13

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүдэд: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, Д.Борхүү, цагдаагийн хошууч Б.Лхагважаргал.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Мөрдөн байцаах алба нь батлагдсан орон тоогоор 8 хэлтэс, 1 тасаг, 1 хэсэг, нийт 117 алба хаагч, ажилтны орон тоотойгоос албаны дарга 1, дэд дарга 1, хэлтсийн дарга 7, тасгийн дарга 1, хэсгийн дарга 1, хяналт шалгалт хариуцсан чиглэлийн ахлах мөрдөгч 2, чиглэлийн ахлах мөрдөгч 6, чиглэлийн ахлах мэргэжилтэн 4, хяналт шалгалт хариуцсан ахлах мөрдөгч 7, аюулгүй байдал хариуцсан ахлах мөрдөгч 1, эрүүгийн ахлах мөрдөгч 7, ахлах мөрдөгч 33, ахлах мэргэжилтэн 9, мөрдөгч 4, мэргэжилтэн 4, ахлагч 17, энгийн 12 ажилтан байгаагаас энэ оны 03 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар албаны хэлтсүүдэд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 1, Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 1, Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 1, Залилах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс 2, Захиргааны удирдлагын хэлтэст 1, үйлчлэгч 3, ахлагч 2 нийт 11 орон тоо сул байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/173 дугаартай тушаалаар Мөрдөн байцаах албаны бүтэц, орон тооноос Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн 14 орон тоог Экологийн цагдаагийн албанд шилжүүлж, Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийг 9 орон тоотойгоор шинээр байгуулсан.

Нийт 117 алба хаагч, ажилтнаас Мөрдөн шалгах дагнасан чиг үүрэгтэй 6 хэлтэст чиглэлийн ахлах мөрдөгч 6, ахлах мөрдөгч 33, мөрдөгч 3, эрүүгийн ахлах мөрдөгч 7, нийт 49 алба хаагч ажиллаж байна.

Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн

Эрүүгийн цагдаагийн тасгийн 4 эрүүгийн ахлах мөрдөгч Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст үүрэг гүйцэтгэн ажилладаг байна.

Мөрдөн шалгах чиг үүрэгтэй 45 мөрдөгчөөс өнөөдрийн байдлаар 40 мөрдөгч ажиллаж , 5 орон тоо сул байна.

Алба хаагчийг хүйсийн байдлаар авч үзвэл, эрэгтэй 37 буюу 92.5 хувь, эмэгтэй 3 буюу 7.5 хувь, насны ангиллаар авч үзвэл 25-30 насны 8 буюу 20 хувь, 31-36 насны 20 буюу 50 хувь, 37-42 насны 7 буюу 17.5 хувь, 43-48 насны 5 буюу 12.5 хувь, боловсролын зэргээр авч үзвэл магистр зэрэгтэй 26 буюу 65 хувь, эрх зүйч мэргэжилтэй 14 буюу 35 хувь, ажилласан жилээр 5-10 жил ажилласан 17 буюу 42.5 хувь, 11-16 жил ажилласан 12 буюу 30 хувь, 17-22 жил ажилласан 10 буюу 25 хувь, 28 жил ажилласан 1 буюу 2.5 хувь, тухайн албан тушаалд ажилласан жилээр авч үзвэл 1-2 жил хүртэл ажилласан 34 буюу 85 хувь, 3 жил хүртэл ажилласан 6 буюу 15 хувийг тус тус эзэлж байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох” /код 105/ журмын хэрэгжилт, Мөрдөн байцаах албаны 2022 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг аудитын объектод хамруулна.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тоотой холбоотой танилцуулга, мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч, судалсан байна.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь дээрх үйл ажиллагаатай биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

3. Аудитаар илэрсэн асуудал

Мөрдөн байцаах албаны төвийн хэлтсийн алба хаагчдаас Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны А/33, А/85 дугаартай “Гэмт хэргийн

талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурорр хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” тушаалын дагуу харьяалуулсан гэмт хэргийн шинжтэй олонд, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, улсын хэмжээнд үйлдэгдсэн олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, хүнд хэргүүдийг татан авч шалгах, хэргүүдтэй уншиж танилцан зааварчилга хүргүүлж, биелэлтийг тооцох зэргээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж нэгжүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Мөрдөгчдийн шалгасан хэргийн ачааллыг 2021 оны байдлаар авч үзвэл:

д/д	Нэгж	Ажилласан мөрдөгч	Үндсэн харьяаллын хэрэг	Бусад нэгжээс авч шалгасан хэрэг	Нийт шалгасан хэрэг	Жилд дунджаар нэг мөрдөгчид ногдох хэрэг
1	Хүнд ГХМШХ	7	28	96	124	17.7
2	Хулгай ГХМШХ	7	33	97	130	18.6
3	Залилах ГХМШХ	10	270	300	570	57.0
4	ТСҮГХМШХ	7	141	18	159	22.7
5	ХЭМХБЭГХМХ	6	20	11	31	5.2
6	ХЭБХҮГХМХ	5	31	56	87	17.4
Нийт дүн		42	523	578	1101	26.2

Улсын дундаж үзүүлэлтээр нэг мөрдөгч 73.2 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол албаны хэмжээнд 25 хэрэг шалгасан нь тус албаны мэргэжлийн хэлтсийн дарга, алба хаагчид нийт нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахаас гадна олон үйлдэл, холбогдогчтой, хохирол ихтэй, нийтийн анхаарлыг татсан, ээдрээ төвөгтэй, мөрдөн шалгах ажиллагааны цар хүрээ ихтэй хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдагараа онцлогтой байна.

Мөрдөгчдийн шалгасан хэргийн ачааллыг 2022 оны эхний 3 сараар авч үзвэл:

д/д	Нэгж	Ажилласан мөрдөгч	Үндсэн харьяаллын хэрэг	Бусад нэгжээс авч шалгасан хэрэг	Нийт шалгасан хэрэг	Улиралд дунджаар нэг мөрдөгчид ногдох хэрэг
1	Хүнд ГХМШХ	7	10	4	14	2.0
2	Хулгай ГХМШХ	7	12	61	73	10.4
3	Залилах ГХМШХ	8	124	0	124	15.5

4	ТСУГХМШХ	6	64	2	66	11.0
5	ХЭМХБЭГХМХ	5	21	2	23	4.6
6	ХЭБХУГХМХ	4	31	3	34	8.5
Нийт дүн		37	262	72	334	9.0

Энэ оны нэгдүгээр улиралд мөрдөн байцаах алба 262 хэрэг хүлээн авч шалгаж байгаа ба бусад нэгжүүдээс харьяаллын дагуу 72 хэргийг авч, нийт 334 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь нэг мөрдөгч дунджаар 9 хэрэг шалгасан дүн мэдээтэй байна.

3.1 Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс: Улсын Ерөнхий прокурорын А/33 дугаар тушаалаар тус газраас шалгах харьяалал тогтоосон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй Хүнийг алах» /Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гадаадын иргэний үйлдсэн, бусад улсаас шилжүүлэн ирүүлсэн гадаад улсад Монгол Улсын иргэний үйлдсэн хүнд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүтэц, орон тоо: Тус хэлтэс нь хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, ахлах мөрдөгч 6, ахлах мэргэжилтэн 1 /хөдөлмөрийн гэрээгээр/, ахлагч 1 нийт 10 оронтойгоор ажиллаж байна.

Ахлах мөрдөгч нар нь харьяалуулсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, улсын хэмжээнд үйлдэгдсэн олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, хүнд хэргүүдийг татан авч шалгах, хэргүүдтэй уншиж танилцан зааварчилга хүргүүлж, биелэлтийг тооцох, урьд онуудад үйлдэгдсэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүнийг алах хэргийг нөхөн илрүүлж, шийдвэрлэх зэргээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг

Дундаж ачаалал: Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас 2021 онд нийт 230 гомдол, хүсэлт, удирдлагаас ирүүлсэн чиглэлийг хүлээн авч шалгаж, хуулийн хугацаанд албан бичгээр хариу өгч, 29 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас урьд оны үлдэгдэл 12, прокуророос буцсан 3, шинээр хүлээн авсан хэрэг бүртгэлтийн 5, шинээр хүлээн авсан мөрдөн байцаалтын 5, нийт 29 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

Үүнээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 3, шүүхэд шилжүүлсэн 11, мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон 1, хэрэг бүртгэлийн 12 хэргийг хааж шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд үйлдэгдсэн олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, хүнд 96 хэргүүдийг татан авч шалгаж, 55 зааварчилга хүргүүлж, “Шийдвэрлэлт-2021” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэст шалгагдаж буй 79 хэргийг шийдвэрлэсэн байна.

2022 оны эхний 03 дугаар сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон Улсын ерөнхий прокурор, Нийслэлийн прокурорын газраас харьяалал тогтоож ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй нийт 3 гомдол, мэдээллийг хүлээн авч хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлтийн 13, мөрдөн байцаалтын 3, нийт 16 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа нь 1 мөрдөгч 2 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Эдгээр хэргүүд нь 1985-2016 онуудад үйлдэгдсэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүнийг алах, хүний амь нас хохирсон ээдрээ төвөгтэй хэргүүд байна. /1985 онд Д.Төмөр-Очир алагдсан, 2003 онд гурван ченж сураггүй алга болсон, 2006 онд Ховд аймагт Ж.Отгонцэцэг алагдсан, 2007 онд Б.Гантулга хутгалагдаж нас барсан, 2009 онд Ж.Цэдэвсүрэн автомашиндаа алагдсан, 2013 онд Т.Эрдэнэчимэг нас барсан, 2016 онд Ж.Хүнбишийн гавлын яс, хөл олдсон, 2018 онд Д.Мөнхбат Солонгос улсаас ухаангүй ирж нас барсан, 2015 онд М.Л.Клойбер нас барсан, 2019 онд Ж.Должинсүрэнгээр худал мэдүүлэг өгүүлсэн байж болзошгүй гэх мэт маш нууцын зэрэглэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргүүд байна./

Үүнээс гадна Төр нийгмийн зүтгэлтэн С.Зориг бусдад алагдсан хэргийг шалгах ажлын хэсэгт хэлтсийн 50 хувь буюу 4 алба хаагч өдөр бүр уртасгасан цагаар ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, тус албаны даргын тушаалаар ээдрээ төвөгтэй, олны анхаарал татсан “С.Зориг алдагдсан”, “Д.Сэржмядаг сураггүй алга болсон”, “Г.Батхүү төрийн ордонд нас барсан”, “2005 онд Б.Алтансүх”, “2007 онд Н.Наранцэцэг” “2007 онд Н.Мягмар”, “2019 онд Х.Батхуяг”, “2020 онд Н.Мөнхтөр” нас барсан хэргүүдэд “Ажлын хэсэг” байгуулан 7 мөрдөгч буюу 100 хувь хамрагдан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Тус хэлтсийн алба хаагчдаас 2021 онд 21 , 2022 оны нэгдүгээр улиралд 5 удаагийн цогцсын үзлэг, задлан шинжилгээнд оролцож, томилолтоор 2021 онд 12 аймаг руу давхардсан тоогоор 12 алба хаагч 5-14 хоногийн хугацаанд, 2022 оны гуравдугаар сарын байдлаар 1 мөрдөгч 1 аймагт 2 хоногийн хугацаанд тус тус ажилласан байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа 16 хэргээс маш нууцын зэрэглэлд 2, олны анхаарал татсан 2, ээдрээ төвөгтэй, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 13 хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлд заасан нотолбол зохих байдлыг тогтоож энэ онд 5 хэргийг эцэслэн шийдвэрлэхээр ажиллаж байна. Дээрх хэргүүд нь үйлдэгдээд 5-37 жил өнгөрсөн, дунджаар 5-100 хавтас, 1250-24000 хуудас нотлох баримтууд бүрдүүлсэн хэргүүд байх бөгөөд мөрдөгчид 7 хоног бүр мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулсан байна

3.2 Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс: Улсын ерөнхий прокурорын газрын А/33, А/85 дугаартай тушаалаар Улсын ерөнхий

прокурорын газраас харьяалал тогтоосон 3 ба түүнээс дээш аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дамжин үйлдэгдсэн эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан “хулгайлах” эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 2, 3 заасан мал хулгайлах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/07 дугаартай тушаалаар 2 ахлах мөрдөгчийн орон тоог нэмэгдүүлснээр хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, ахлах мөрдөгч 6, дуудлагын цагдаа 1 нийт 9 орон тоотой бөгөөд одоогоор ахлах мөрдөгч 1, цагдаа 1 орон тоо дутуу ажиллаж байна.

Дундаж ачаалал: 2021 онд урд оны үлдэгдэл 16 хүнд холбогдох 99 үйлдэлтэй 3 хэрэг, тухайн оны дугаартай 86 хүнд холбогдох 360 үйлдэлтэй 31 хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 16 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 12 хэргийг бусад хэрэгт нэгтгэн, харьяаллын дагуу 4 хэрэг шилжүүлсэн.

Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс Нийслэлийн нэгжүүдэд шалгагдаж байгаа хэрэг бүртгэлтийн 97 хэрэгт “мөрдөгчийн хэсэг” байгуулан хэргийг бүрэн шийдвэрлэсэн байна.

“Шийдвэрлэлт-2021” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэст шалгагдаж буй 116 хэргийг шийдвэрлэсэн.

Тус хэлтэс нь УЕПГ-аас харьяалал тогтоож ирүүлсэн хэргүүд болон олон үйлдэл, холбогдогчтой, ээдрээ төвөгтэй, хохирол ихтэй, аймаг, нийслэлийн дүүргүүд дамжин үйлдэгдсэн, хэргийн оролцогчид удаа дараа ял шийтгэгдсэн хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа ба 2021 онд 556 үйлдэл, 131 хэрэгт мөрдөн шалгалтын ажиллагаа явуулснаас 427 үйлдэлтэй 32 хэргийг шийдвэрлэсэн нь нэг мөрдөгч 18,7 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар урд оны үлдэгдэл 7 хүнд холбогдох 36 үйлдэлтэй 2 хэрэг, шинээр хүлээн авсан 44 холбогдогчтой, 45 үйлдэлтэй 13 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас шүүхэд шилжүүлэх саналтай 3, нэгтгэсэн 4, харьяаллын дагуу шилжүүлсэн 1, түдгэлзүүлсэн 1 хэрэг байгаа ба хэрэг бүртгэлтийн 1, мөрдөн байцаалтын 6 хэргийн үлдэгдэлтэй байна.

Дүүрэг дэх цагдаагийн газрын харьяа хэлтсийн мөрдөн байцаах тасгууд дээр шалгагдаж байгаа “Хулгайлах”, “Мал хулгайлах” хэргийн нөхцөл байдалтай танилцаад 84 хэрэгт “мөрдөгчийн хэсэг” байгуулж ажилласнаар 61 хэргийг шийдвэрлэжээ.

2022 оны 3 сарын байдлаар тус хэлтэс 81 үйлдэлтэй 15 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, нэгжид 84 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулаад нийт 165 үйлдэлтэй 98 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь нэг мөрдөгч 14 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

3.3 Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс: нь Улсын Ерөнхий прокурорын А/32 дугаар тушаалаар шалгах хэргийн харьяалал тогтоон ирүүлсэн болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүтэц, орон тоо: офицер 9, ахлагч 1 ажиллаж байгаагаас хэлтсийн дарга 1, ахлах мөрдөгч 5, эрүүгийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн мөрдөгч 2, ахлагч 1, одоогоор 1 ахлах мөрдөгчийн орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд тус хэлтэс шүүхэд шилжүүлсэн 16, нэгтгэсэн 1, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 15 буюу нийт 32 хэргийг шалгаж шийдвэрлэсэн бол нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтэс, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 1,2 дугаар хэлтсүүдэд давхардсан тоогоор 9 алба томилогдон ажиллаж шүүхэд шилжүүлэх саналтай 22, нэгтгэсэн 8, хэрэг бүртгэлтийн 16 хааж буюу нийт 87 хэргийг шийдвэрлэсэн нь нэг мөрдөгчид 9.2 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

“Нийслэл дэх дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд 2021 оны 01 дүгээр сараас хойш бүртгэгдсэн хүүхэд өртөж, хохирсон гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх” ажлын удирдамжийн дагуу 2021 оны 05 дугаар сарын 19-нөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын 1, 2, 3 дугаар хэлтэс, Налайх, Багануур, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэст хувиарлагдан ажиллаж, 8-10 заалт бүхий 12-г, нутаг, дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад удаашран шалгагдаж буй 9 буюу нийт 21 хэрэгт зааварчилга хүргүүлж, биелэлтийг тооцсон.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирсон холбогдсон хүүхдэд тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр улсын хэмжээнд “Нуугдмал-2021” нэгдсэн арга хэмжээг 2 үе шаттай зохион байгуулах үеэр мөрдөн шалгах ажиллагааны үеэр гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар төрийн болон төрийн бус байгууллагын 45 төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оны 03 дугаар сараар байдлаар урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 6, мөрдөн байцаалтын 2 хэрэг, Улсын ерөнхий прокурорын газраас харьяалал тогтоож, ирүүлсэн хэрэг бүртгэлтийн 15, мөрдөн байцаалтын 16 хэргийг хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлтийн 1 хэргийг хааж, 10 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шийдвэрлэсэн бөгөөд, 1 мөрдөгч 7 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Тус хэлтсээс бага насны хүүхдүүдтэй фейсбүүкээр танилцан чат бичиж, садар самуун агууламж бүхий дүрс бичлэг илгээн хүүхдийг садар самуунд уруу татсан, хүүхдэд садар самууныг сурталчилсан, зураг, кино, дүрс бичлэг зориуд үзүүлж бэлгийн харьцаанд орохыг санал болгосон, хүчээр бэлгийн харьцаанд орсон, хүчиндсэн гэх Ш.А-д холбогдох 8 үйлдэлтэй эрүүгийн 210800000...дугаартай хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулж дуусган хэргийг шүүхэд шилжүүлсэн.

“Хэрэг бүртгэлтийн хэрэг, шийдвэрлэх” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хан-уул, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын мөрдөн байцаах тасгуудаас нийт 49 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргүүдийг шалгаж шийдвэрлэсэн.

“Хүүхдээ бага наснаас нь өсгөн хүмүүжүүлэх эрхээсээ санаатайгаар зайлсхийсэн эцэг, эхийг олж тогтоох, эрэн сурвалжлах ажлын хүрээнд оршин суугаа газраасаа сураггүй алга болсон 2, тодорхой оршин суух хаяггүй 9 иргэнийг олж тогтоон “Өнөр бүл” хүүхдийн төвийн нийгмийн ажилтан нарт хүлээлгэн өгч асрамжийн газар өсч хүмүүжиж байгаа хүүхдүүдтэй нь уулзуулан эргэх холбоотой байх ажлыг зохион байгуулсан.

3.4 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс: нь Улсын Ерөнхий Прокурорын 2020 оны “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/85 дугаар тушаалаар, мөн оны А/33 дугаартай тушаалын хавсралтын 3.10 дахь хэсэгт заасан Төрийн өндөр албан тушаалтанд холбогдох Авлигатай Тэмцэх Газар, Тагнуулын Ерөнхий Газар, Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба болон Хар тамхитай тэмцэх газарт харьяалуулснаас бусад гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэг, “3.6 дахь хэсэгт, Нийслэлийн нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүний үйлдсэн Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба болон Хар тамхитай тэмцэх газарт харьяалуулснаас бусад гэмт хэрэг буюу төрийн өндөр албан тушаалтан, гадаадын иргэд, харьяалалгүй иргэдийн холбогдсон гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүтэц, орон тоо: Хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 2, ахлах мөрдөгч 3, мөрдөгч 1, цагдаа 1 нийт 8 орон тоотой.

Дундаж ачаалал: Энэ оны 03 дугаар сарын байдлаар 25 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаар 4 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, шүүхэд шилжүүлэх саналтай хүргүүлж, мөн хэрэг бүртгэлтийн 6 хэргийг хаах саналтай харьяа прокурорын газар хүргүүлж, одоо мөрдөн байцаалтын 4, хэрэг бүртгэлтийн 11, нийт 15 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Нийт 25 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан ба нэг мөрдөгч дунджаар 5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

2022 оны нэгдүгээр улиралд улсын хэмжээнд 11182 гэмт хэрэг бүртгэгдсэнээс тус хэлтсийн хариуцсан чиг үүргийн “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” 2628 бүртгэгдэж нийт хэргийн 23.5 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 902 буюу 52.3 хувиар өссөн байна. Олны анхаарал татсан /УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Ж.Мөнхбат, Б.Дэлгэрсайхан, Э.Цэрэндолгор буюу Цэнхэр үст Цэрэн/ нарт холбогдох, МУ-ын шадар сайд С.Амарсайханы нэр төрд халдсан, Д.Мөнх-Эрдэнэ, Э.Энх-Эрдэнэ нар бусдад зодуулсан зэрэг хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна./

3.5 Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс: нь Улсын ерөнхий прокурорын 2020 оны А/33 тоот тушаалаар баталсан “Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” тушаалын хавсралт 3.4 дэх хэсэгт заасан “Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх байгууллагын алба хаагчийн үйлдсэн” гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүтэц, орон тоо: Хэлтсийн дарга 1, тасгийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, ахлах мөрдөгч 10, цагдаа 1, нийт 14 орон тоогоос ахлах мөрдөгчийн 1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд урд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 22 хэрэг дээр, шинээр 106, прокуророос нэмэлт ажиллагаанд буцсан 1 нийт 129 хэрэг бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулснаас 32 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 61 хэргийг хаах санал, 15 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай, мөрдөн байцаалтын урд оны үлдэгдэл 1 хэрэг, шинээр 51, шүүх, прокурорын буцаасан 8 хэрэг хүлээн авч, 60 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 44 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 7 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 6 хэргийг бусад хэрэгт нэгтгэн шийдвэрлэж, Төв, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад албан томилолтоор давхардсан тоогоор 35 алба хаагч 94 хоног ажилласан байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар 189 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 1 мөрдөгч 27 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 64 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан үүнийг 1 мөрдөгч 9 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан.

Төв аймаг, Дорноговь, Хэнтий, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Орхон, аймгуудад албан томилолтоор давхардсан тоогоор 5 алба хаагч нийт 18 хоног ажилласан.

3.6 Залилах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс: нь Улсын ерөнхий прокурорын газраас шалгах харьяалал тогтоосон Эрүүгийн хуулийн

тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Бүтэц, орон тоо: Хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, ахлах мөрдөгч 4, мөрдөгч 3, цагдаа 1, нийт 12 орон тоогоос ахлах мөрдөгчийн 2 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд 74 гомдол мэдээллийг хүлээн авч шалган 47 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 8 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 17 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, нийт 72 гомдол мэдээллийг шийдвэрлэж, 270 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлтийн 111, мөрдөн байцаалтын 110, нийт 221 хэргийг шийдвэрлэсэн. Энэ хугацаанд бусад нэгжээс 300 хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулж нийт 570 хэргийг шалгаснаас 1 мөрдөгч 57 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 28 гомдол мэдээллийг хүлээн авч шалган, 10 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6 эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, 6 хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 2 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, нийт 24 гомдол мэдээллийг шийдвэрлэсэн.

124 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлтийн 37, мөрдөн байцаалтын 32, нийт 69 хэргийг шийдвэрлэснээс 1 мөрдөгч 15.5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

2021 онд тус хэлтсээс болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах тасагт шалгагдсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг, олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, олон хохирогчтой залилах төрлийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, анхаарах зүйлийн мөрдөгч нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 326 хэрэгтэй уншиж, танилцан 2217 заалт бүхий зааварчилгааг бичгээр өгч, 72,6 хувийн биелэлттэй.

Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын харьяа хэлтсийн мөрдөн байцаах тасагт шалгагдаж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” 101 хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 13 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 37 хэргийг хаах, 4 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 4 хэргийг нэгтгэн нийт 51 хэргийг, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасагт шалгагдаж буй 39 хэргийг хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 6 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 21 хэргийг хаах, 1 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 2 хэргийг нэгтгэн, 2 хэргийн харьяаллын дагуу шилжүүлж нийт 32 хэргийг шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй, ээдрээ төвөгтэй шийдвэрлэх боломжгүй 8 хэргийг буцааж, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Мөрдөн байцаах тасагт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан хэрэг бүртгэлт 69 мөрдөн байцаалтын

31, нийт 100 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай 23, нэгтгэсэн 3, харьяаллын дагуу 1, нийт 29 хэрэг, мөрдөн байцаалтын 7 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 11 хэргийг нэгтгэн, 18 хэрэг нийт 47 хэргийг шийдвэрлэсэн байна.

Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нийслэл, хөдөө орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд шалгагдаж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан Залилах төрлийн 6558 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт хэргийн 25.8 хувийг эзэлж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд 161,699,415,611/ зуун жаран нэгэн тэрбум зургаан зуун ерэн есөн сая дөрвөн зуун арван таван мянга зургаан зуун арван нэгэн/ төгрөгийн хохирол, хор уршиг учирсан талаарх судалгааг гаргасан байна.

4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн “Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны асуудлаар аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Мөрдөн байцаах албаны хэмжээнд батлагдсан 117 орон тооноос дутуу байгаа офицер 6, ахлагч 2, энгийн 3, нийт 11 орон тооны нөхөн хангалтыг шийдвэрлэсэнээр алба хаагчдын үйл ажиллагаа хэвийн явагдахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хоёр. Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн мөрдөгчдийн хэргийн шийдвэрлэлт, ажлын ачаалал зэргийг судалгаанаас харахад харилцан адилгүй байгаа хэдий ч Улсын ерөнхий прокуророос харьяалал тогтоосон хүнийг алах, хүчиндэх, залилах, хулгайлах, тусгай субъектээс үйлдсэн, хүүхдээс үйлдсэн болон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаас гадна мөрдөгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүй, тактик, мөрдөн шалгах ажиллагааны явц байдалд дэмжлэг үзүүлж, харьяа нэгжүүдэд шалгагдаж байгаа хүнд, ээдрээ төвөгтэй, олон үйлдэл, холбогдогчтой, олон хүн хохирсон, удааширсан, шийдвэрлэхэд бэрхшээл учирч буй хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Гурав. Тус албаны харьяа зарим хэлтсийн мөрдөгч нь хэргийн үзүүлэлтээр шийдвэрлэсэн хэрэг нь бага байгаа боловч нь маш нууцын зэрэглэлтэй, олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй, олон үйлдэл, холбогдогчтой, олон хүн хохирсон, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, үйлдэгдээд олон жил өнгөрсөн, дунджаар 5-100 хавтас, 1250-24000 хуудастай хэргүүд байх бөгөөд мөрдөгчид тогтмол мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулдаг онцлогтой байна.

Дөрөв. Дээрх нөхцөл байдлаас харахад тус Албаны харьяа

хэлтсүүдийн мөрдөгч нарын орон тоог өөрчлөх шаардлагагүй байна.

5.3ӨВЛӨМЖ

5.1. Мөрдөн байцаах албаны хэмжээнд батлагдсан 117 орон тооноос дутуу байгаа 11 орон тооны нөхөн хангалтыг шуурхай шийдвэрлүүлж, үйл ажиллагааг жигдрүүлэх /ХНХ, МБА/;

5.2 Улсын ерөнхий прокуророос харьяалал тогтоосон хэргүүдийг шуурхай шийдвэрлэхэд хэлтсийн даргын тавих хяналтыг тогтмолжуулж, үр дүнг тооцож байхад анхаарах /МБА/

5.3. Тус албаны харьяа хэлтсийн мөрдөгч нарын ажлын ачаалал, нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, ажлын ачааллыг харгалзан, ачаалал багатай нэгжүүдээс алба хаагчдыг тодорхой хугацаагаар сэлгэн ажиллуулж, үр дүнг тооцох ажлыг тогтмол зохион байгуулах /МБА/

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”-д хийсэн дотоод аудит

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/08

Аудитын хугацаа: 2022.04.17- 2022.04.22

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Орон нутгийн нөхцөл байдлын талаар: Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Хайрхан баг” нь аймгийн төвөөс 340 км, Ханбогд сумаас 133 км, Гашуунсухайт боомтоос 9 км зайтай оршдог.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багт байнгын оршин суух бүртгэлтэй 128 өрхийн 440 хүн, түр оршин суух бүртгэлтэй 417 өрхийн 1031 хүн байна.

“Цагаан хад” суурьшлын бүсэд бөөний махны дэлгүүр 17, барааны дэлгүүр 5, бөөний дэлгүүр 4, үсчин 5, буудал 5, халуун ус 2, цайны газар 39, авто сэлбэгийн дэлгүүр 4, валют арилжаа 4, газ 1, найман нэр болон зургаан нэрийн барааны дэлгүүр 32, нийт 118 аж ахуйн нэгж байгууллагууд худалдаа үйлчилгээ явуулж байна.

“Цагаан хад” суурьшлын бүс болон Гашуунсухайт боомтод төрийн байгууллагын 300 орчим алба хаагчид ажиллаж, амьдарч байна.

Гаалийн хяналтын нүүрс ачиж буулгах талбай 29, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг 157 аж ахуйн нэгжийн 316 битүүмжлэгдсэн багт 4319 жолооч бүртгэлтэй байна.

Хорио цээрийн дэглэм тогтоогоогүй нүүрс тээврийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байх үед Тавантолгойн бүлэг ордоос Гашуунсухайтын боомт хүртэлх уртын нүүрс тээвэрлэлтийн 13.000 орчим жолооч, түүнд үйлчилгээ үзүүлэх 150 гаруй үйлчилгээний цэг нэмэгдэн ажилладаг.

“Цагаан хад” суурьшлын бүсэд одоогийн байдлаар нийт 6807 хүн ажиллаж амьдарч байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтэс нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын цагдаагийн тасгийн харьяанд “Хайрхан” сумын нутаг дэвсгэрт байрлах “Цагаан хад” суурьшлын бүсэд “Нүүрсний зам” ХХК-ийн “Гэрээт замын цагдаагийн хэсэг” нэршилтэйгээр анх 2010 онд байгуулагдан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан чиглэлээр ажиллаж байгаад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 211 дүгээр тогтоолоор Цагдаагийн ерөнхий газар, «Эрдэнэс Монгол» компани, «Гашуун сухайт авто зам» компани гурвалсан гэрээ байгуулж, Цагаан хад дахь гэрээт цагдаагийн тасаг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/38 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын “Гэрээт цагдаагийн тасаг”, мөн даргын 2019 оны А/258 дугаар тушаалаар “Гэрээт цагдаагийн хэлтэс” болон өргөжсөн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар тус хэлтсийг Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын харьяанд шилжүүлсэн байна.

Өнөөдрийн байдлаар хэлтсийн дарга 1, Чиглэлийн ахлах зохицуулагч 1, Ахлах зохицуулагч 1, Зохицуулагч 28, Цагдаа зохицуулагч 4 нийт 35 орон тоотойгоор Өмнөговь аймгийн “Цогтцэций”, “Ханбогд” сумаас “Гашуунсухайт” хилийн боомт хүртэлх хүнд даацын хатуу хучилттай нүүрс тээврийн авто зам дагуу болон Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүс орчимд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан чиглэлээр үүрэг гүйцэтгэж байна.

Одоогийн байдлаар 10 зохицуулагч, 1 цагдаа зохицуулагчын орон тоо дутуу байна.

Тус гэрээт цагдаагийн хэлтсийн 24 алба хаагчдаас 22 алба хаагч буюу 91.6% нь Улаанбаатар хотод, 2 буюу 8.4% нь хөдөө орон нутагт оршин суух хаягтай, гэр бүлийн гишүүдийн 14 буюу 58,3 хувь нь тодорхой эрхэлсэн ажилтай, 10 буюу 41,7 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 11 алба хаагч 0-5 насны хүүхэдтэй, 9 алба хаагч нь 5 дээш насны хүүхэдтэй, 2 алба хаагч хүүхэдгүй, гэр бүл зохиож тусдаа гараагүй байна.

Нийт алба хаагчдын 17 буюу 70.8 хувийг 25-40, 7 буюу 29.2 хувийг 40 дээш насны алба хаагчид байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын гэрээт хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл

ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох” /код 105/ журмын хэрэгжилт, алба хаагчдын амьдрах орчин, ажиллах нөхцөл байдлыг аудитын объектод хамруулна.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тоотой холбоотой танилцуулга, мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч, судалсан байна.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь дээрх үйл ажиллагаатай биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын нөхцөл байдлын талаар: Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Таван толгой” бүлэг ордоос Ханбогд сумын “Гашуунсухайт” хилийн боомт хүртэлх 239 километр хүнд даацын хатуу хучилттай нүүрс тээврийн авто замын дагуу болон Ханбогд сумын “Хайрхан” багийн Цагаан хадны ойр орчимд гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, Цагаан хад суурьшлын бүсэд хорио цээрийн дэглэмийг тогтоох зорилгоор 16 постонд 24/24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Гэрээт цагдаагийн хэлтсийн албаны бэлэн байдлыг хангах зорилгоор үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж: Ханбогд сумын Засаг даргын тамгын газрын эзэмшлийн “Тоёота хайс” маркийн тээврийн хэрэгсэл 1, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын эзэмшлийн “Тоёота Приус-30” маркийн тээврийн хэрэгсэл 1, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшлийн “Ланд круйзер-77” маркийн тээврийн хэрэгсэл 2, “Ланд круйзер-76” маркийн тээврийн хэрэгсэл 1, “Ниссан экстрайл” маркийн тээврийн хэрэгсэл 1, “Ниссан урбан” маркийн тээврийн хэрэгсэл 1, нийт 7 тээврийн хэрэгсэл байгаагаас “Тоёота хайс” маркийн тээврийн хэрэгслийн моторын эд анги эвдэрч хөдөлгөөнд оролцохгүй зогссон байна.

Автомашины засвар, үйлчилгээ, шатахуун, тослох материал зарцуулалт, сэлбэгийн элэгдэл хорогдлын байдлыг хүснэгтээр харуулбал:

д/д	Он	Нэр	Тоо хэмжээ
1	2021 онд	Шатахуун	14.700.000
		Тос	1.200.000
		Сэлбэг	3.000.000
Нийт дүн			18.900.000 зарцуулсан.
2	2022 онд	Шатахуун	14.000.000
		Тос	1.000.000
		Сэлбэг	3.200.000
Нийт дүн			18.200.000 төсөвлөсөн байна.

Гэрээт цагдаагийн хэлтсийн албаны үйл ажиллагаанд ашиглаж байгаа 5 компьютер, 5 принтер, 14 ширээ сандал нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй байна.

Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчид “Гашуунсухайт авто зам” ХХК-ийн эзэмшлийн байранд ажиллаж, амардаг бөгөөд нийт 86,8м² талбай бүхий 7 өрөөнд 35 алба хаагч, 29 орон дээр ээлжлэн амарч, ажиллаж байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалж 24 цагаар жижүүр, эргүүл, хяналтын үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид тайван унтаж, амрах боломжийг бүрдүүлээгүйгээс шалтгаалан ядаргаанд орох, дархлаа сулрах нөхцөл байдал үүсч, 33 алба хаагч 2021 оны 6 дугаар сард Коронавирус /Ковид-19/ цар тахлаар өвчлөн эмчлүүлсэн бөгөөд 9, 10 дугаар саруудад 2, энэ оны 02 дугаар сард 14 алба хаагч /Ковид-19/ -ын халдвар дахин авч эмчлэгдсэн байна.

Мөн албан үүрэг гүйцэтгэхэд өөрийн гэсэн ажлын байр /оффис/ байхгүйгээс шалтгаалан алба хаагчдын амрах байранд гэмт хэрэг, осол зөрчлийн материалыг шийдвэрлэх, хүмүүсээс тайлбар авах ажиллагааг явуулж байна.

Гашуунсухайт хилийн боомтоор Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын багагүй хувь нь гарч үүнийг дагаад хүн ам, тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж “Тавантолгой” бүлэг ордоос Гашуунсухайт хилийн боомт хүртэлх 239 километр хатуу хучилттай авто замаар өдөрт дунджаар 200-300 тээврийн хэрэгсэл зорчиж байна.

Тус нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар: 2021 онд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 375 өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн бөгөөд үүнээс зам тээврийн гэмт хэрэг, ослын нийт 63 дуудлага мэдээлэл хүлээн авснаас зам тээврийн осол хэргийн

улмаас 3 нас барж, 13 хүн гэмтсэн байна.

Зам тээврийн ослын 19 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээсэн, 28 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Гэмт хэргийн шинжтэй 16 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлжээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн 8440 зөрчлийг илрүүлж, согтууруулах ундаа зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 206, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 73 зөрчилд 206 иргэнд хариуцлага тооцсон байна.

Бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй 3533, техникийн үзлэг оношилгоонд хамрагдаагүй 337, бусад 4195 зөрчлийг илрүүлэн 8065 жолоочид 260.595.000 /хоёр зуун жаран сая таван зуун ерөн таван мянган/ төгрөгний торгуулийг бэлэн бусаар шийтгэл ногдуулж ажилласан байна.

Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн 2325 зөрчлийг илрүүлэн, Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэсэн.

Үүнээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 34, эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон 58, бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон 693, техникийн үзлэг оношилгоонд хамрагдаагүй 200, бусад зөрчил 1340 илрүүлж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ тооцон ажилласан байна.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаатай хассан 37, зөрчил гаргасан 2325 жолоочид 79.830.000 /далан есөн сая найман зуун гучин мянган/ төгрөгийн торгуулийг бэлэн бусаар шийтгэл ногдуулж ажилласан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Өмнөговь аймгийн гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны асуудлаар аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Гэрээт цагдаагийн хэлтсийн хэмжээнд батлагдсан 35 орон тооноос 10 зохицуулагч, 1 цагдаа зохицуулагч нийт 11 орон тооны нөхөн хангалтыг шийдвэрлэснээр алба хаагчдын ажлын ачаалал буурч, үйл ажиллагаа хэвийн явагдахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хоёр. Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын удирдлагаас гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого, шийдвэр, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, цагдаагийн газрын даргын тушаал, шийдвэр, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, сахилга ёс зүйн байдалд хяналт шалгалт, дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, нэгжүүдийн ажлын уялдааг сайжруулж, удирдлагыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, байгууллага, алба хаагч, бусад ажиллагсдын эрх, хууль

ёсны ашиг сонирхлыг ханган ажиллах шаардлагатай байна.

Гурав. Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчид “Цагаан хад” суурьшлын бүсэд хорио цээрийн дэглэм тогтоох зорилгоор 16 постонд 24/24 цагаар тасралтгүй 2 жил орчим тулж, үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд сэлгэн амрах ээлж /ростер/ байхгүйн улмаас ажлаас гарах, гэр бүлийн маргаан, үл ойлголцох байдал үүсэх, салалт нэмэгдэх хандлага гарч байгаа тул алба хаагчдийг тодорхой хугацаанд чөлөөгөөр явуулах асуудлыг хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Дөрөв. Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчид “Гашуунсухайт авто зам” ХХК-ийн эзэмшлийн байранд ажиллаж, амьдардаг байдлыг өөрчилж, ажиллах болон амрах байрыг тусад нь бий болгож, ажиллах нөхцөл бололцоогоор хангах талаар холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1 Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн батлагдсан орон тооноос дутуу байгаа 11 орон тооны нөхөн хангалтыг шуурхай шийдвэрлүүлж, үйл ажиллагааг жигдрүүлэх /ХНХ, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.2 Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын удирдлагаас гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, үр дүнг тооцож байх /Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.3. Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг сэлгэн амрах ээлж /ростер/ -ийн асуудлыг холбогдох нэгжид хүргүүлж шийдвэрлүүлэх, алба хаагчдийг тодорхой хугацаанд чөлөөгөөр явуулж байх асуудлыг шийдвэрлэж хэрэгжүүлэх/Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.4. Тус гэрээт хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, ажлын ачааллыг харгалзан, ачаалал багатай нэгжүүдээс алба хаагчдыг тодорхой хугацаагаар сэлгэн ажиллуулж, үр дүнг тооцох ажлыг тогтмол зохион байгуулж байх / Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.5. Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчид “Гашуунсухайт авто зам” ХХК-ийн эзэмшлийн байранд ажиллаж, амьдардаг байдлыг өөрчилж, ажиллах болон амрах байрыг тусад нь бий болгож, ажиллах нөхцөл бололцоогоор хангах талаар холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлүүлэх /Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”-д хийсэн дотоод аудит

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/09

Аудитын хугацаа: 2022.04.17- 2022.04.22

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Орон нутгийн нөхцөл байдлын талаар: Өмнөговь аймгийн Цогтцэций сум 1924 онд байгуулагдсан бөгөөд 72000 м.кв газар нутагтай, Улаанбаатар хотоос засмал замаар 570 километр, аймгийн төвөөс 100 километр оршдог, тус аймгийн Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Цогт-Овоо сумдтай хиллэн оршдог, засаг захиргааны 4 багтай, суурин 8411, хөдөлгөөнт 40.000 орчим хүн амтай.

Тус орон нутагт “Эрдэнэс таван толгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК зэрэг томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлдэг, туслан гүйцэтгэгчээр 37 компани ажиллаж байгаа бөгөөд тухайн компаниуд нь давхар гэрээ байгуулан 150 орчим компанитай хамтран ажилладаг.

“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн 267 км, “Таван-толгой-Зүүнбаян” чиглэлийн 414,6 км төмөр замын цогцолбор төсөл бүтээн байгуулалтын ажлыг Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор байгуулагдсан “Тавантолгой төмөр зам ХХК”, “Бодь интернэшнл ХХК”, “Зэвсэгт хүчин”, “Монголын төмөр зам” зэрэг байгууллагууд гүйцэтгэн ажиллаж байна.

Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 651 дүгээр тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй “цагдаагийн тасаг”, 2013 онд мөн даргын тушаалаар 27 хүний бүрэлдэхүүнтэй “цагдаагийн хэлтэс”, 2018 оны мөн даргын А/02 дугаар тушаалаар “Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэс” болгон орон тоог хэвээр баталж, нэршлийг өөрчилсөн байна.

Өнөөдрийн байдлаар хэлтсийн дарга 1, эрүүгийн цагдаагийн хэсгийн дарга 1, хэсгийн төлөөлөгч 1, эрүүгийн мөрдөгч 1, эдийн засгийн мөрдөгч 1, экологийн асуудал хариуцсан байцаагч 1, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч 1, хэсгийн байцаагч 2, тооцооны нягтлан бодогч 1, эрүүлжүүлэх байрны эмч 1, ахлах зохицуулагч 1, зохицуулагч 3, цагдаа-зохицуулагч 2, ахлах мөрдөгч 1, мөрдөгч 1, жижүүрийн мөрдөгч 3, мэдээлэл хүлээн авагч цагдаа 3, мэдээлэл судалгааны мэргэжилтэн 1, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, цагдаа-жолооч 1, нийт 22 офицер, 6 ахлагчийн орон тоотойгоор ажиллаж байгаа бөгөөд 1 мөрдөгчийн орон тоо дутуу, тооцооны нягтлан бодогч аймгийн цагдаагийн газарт ажиллаж байна.

Тус цагдаагийн хэлтсийн 26 алба хаагчдаас 9 алба хаагч буюу 34.6 хувь нь Улаанбаатар хотод, 10 алба хаагч буюу 38.4 хувь нь Даланзадгад суманд, 4 буюу 15.3 хувь нь Цогтцэций суманд, 3 буюу 11.5 хувь нь бусад аймагт оршин суух хаягтай, 10 буюу 38.4 хувь нь гэр бүлээрээ, 16 буюу 61.5 хувь гэр бүлээсээ тусдаа, 12 алба хаагч буюу 46.1 хувь нь 0-5 насны хүүхэдтэй, 9 алба хаагч буюу 34.6 хувь нь 6-аас дээш насны хүүхэдтэй, 5 алба хаагч буюу 19.2 хувь нь гэрлээгүй байна. Нийт алба хаагчдын 21 буюу 80.7 хувийг 22-40 насны, 5 буюу 19.2 хувь нь 40-өөс дээш насны алба хаагчид байна. Нийт алба хаагчдын 7 буюу 26.9 хувийг эмэгтэй алба хаагчид эзэлж байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал"-д дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

"Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох" /код 105/ журмын хэрэгжилт, алба хаагчдын ажиллах нөхцөл байдал, ажлын ачаалал зэргийг аудитын объектод хамруулна.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, "Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тоотой холбоотой танилцуулга, мэдээлэл болон холбогдох баримт бичгийг гаргуулан авч, судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь дээрх үйл ажиллагаатай биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Тус нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар: Тус цагдаагийн хэлтэс нь 2021 онд гэмт хэргийн шинжтэй 526 гомдол мэдээлэл хүлээн авч, 253 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 257 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна.

Мөн хэрэг бүртгэлтийн 292 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 84 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 146 хэргийг хааж шийдвэрлэсэн ба 62 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалтын 84 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 81 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж 3 хэргийн үлдэгдэлтэй байна.

2022 оны 03 дугаар сарын байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 545 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142 нэгжээр буюу 35,2 хувиар өссөн байна.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 160 буюу 29,3 хувийг гэмт хэргийн шинжтэй, 387 буюу 70,4 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна.

Тус цагдаагийн хэлтэст нийт 89 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 19 нэгжээр буюу 27,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цагдаагийн хэлтэс албаны бэлэн байдлыг хангах зорилгоор үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн талаар: Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын эзэмшлийн “Ланд крузер-200” маркийн автомашин 1, “Ланд крузер 80” маркийн автомашин 1, “Элентра” маркийн автомашин 2, “Киа рео” маркийн автомашин 1, “Приус 30” маркийн автомашин 1, “Пробокс” маркийн автомашин 2, “УАЗ” пургон маркийн автомашин 1, Цогтцэций сумын засаг даргын тамгын газрын эзэмшлийн “Прадо 120” маркийн автомашин 1, ЦЕГ-ын Авто баазын эзэмшлийн “Хундай” маркийн автомашин 1 ширхэг нийт 11 тээврийн хэрэгсэл ашиглаж байна.

Автомашину засвар, үйлчилгээ, шатахуун, тослох материал зарцуулалт, сэлбэгийн элэгдэл хорогдлын байдлыг хүснэгтээр харуулбал;

Д/д	Он	Нэр	Тоо хэмжээ
1	2021 онд	Шатахуун /цагдаагийн газраас/	18,000,000
		Тос	-
		Сэлбэг	-
Нийт дүн			18,000,000 зарцуулсан.

2	2022 онд	Шатахуун	Цагдаагийн газраас	6,000,000
			Цогтцэций сумын ЗДТГ	12,000,000
			Тос	
			Сэлбэг	
Нийт дүн				54,000,000 төгрөг төсөвлөсөн байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас сард 1,500,000 /нэг сая таван зуун мянган төрөг/-ний шатахууны зардал олгодог.

Цагдаагийн хэлтсийн барилгыг 2013 онд өргөтгөн эрүүлжүүлэх байрны нэг хүнд оногдох талбай хэмжээг 2.4 метр квадратаар тооцож, 59.6 метр квадрат талбайтай эрүүлжүүлэх саатуулах байрны эмчийн өрөө 1, эрүүлжүүлэх өрөө эмэгтэй 1, эрэгтэй 1, түр саатуулах өрөө 1, цэвэр бохирт холбогдсон ариун цэврийн өрөө 1-ийг цогц байдлаар ашиглалтад оруулсан.

Уг байр нь төвийн дулааны шугаманд холбогдсон, галын аюулгүй байдал, агааржуулалтын нөхцөл болон “MNS 5527:2019” стандартын шаардлага хангасан үйл ажиллагаа явуулахад бэлэн байгаа боловч хүний нөөцийг шийдвэрлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүйгээс 2021 онд архи, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн 51 иргэнийг 40 удаагийн явалтаар 80 алба хаагч 200 цагийн үүрэг гүйцэтгэж, 8000 км замыг туулж, 2.392.000 /хоёр сая гурван зуун ерөн хоёр мянган/ төгрөгийн шатахуун зарцуулж, аймгийн цагдаагийн газарт хүргэж эрүүлжүүлсэн бөгөөд тээвэрлэлтийн явцад алба хаагчийн аюулгүй байдал болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэдийн бие, эрүүл мэндэд эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн байна.

Тус хэлтэс цагдаа-жолоочийн 1 орон тоотой бөгөөд ажлын шаардлагаар жижүүрийн цагдаа жолоочийн орон тоо байхгүйгээс шалтгаалан дотоод зохион байгуулалт хийж, мөрдөгч, зохицуулагч, хэсгийн байцаагч, цагдаа-зохицуулагч нарыг хоногийн томилгоонд оруулж, үүрэг гүйцэтгүүлэх шаардлага тулгардаг бөгөөд 2021 онд 244 хоногт дээрх алба хаагчид жижүүрийн жолоочоор үүрэг гүйцэтгэснээс гадна “Ханбогд” сумруу прокурорт хэрэг, материал хянуулах, шилжүүлэхээр 46 удаа, 276 цагийн үүрэг гүйцэтгэж, 18400 км замыг туулжээ.

Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, танилцуулга, тухайн онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх биелэлт тооцох, баримт бичгийн жагсаалтын хүрээнд биелэлт, үр дүн тооцох, алба хаагчдаас гаргаж байгаа албан бичгүүдийг төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, монгол хэл бичгийн үгийн болон утга найруулгад нийцэж байгаа эсэхийг хянан гаргах архивч, бичиг хэргийн эрхлэгчийн орон тоо байхгүйгээс өөр алба хаагчаар давхар гүйцэтгүүлж байгаа нь албаны нууцлал алдагдах, хугацаатай бичгийн хөдөлгөөнд тавих хяналт нь сулрах эрсдэл үүсэхээр байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаартай тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ийн 14 дэх хэсэгт “Орон нутаг дахь замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух цагдаагийн хяналтын цэг 150 километр тутамд 1-ээс доошгүй байна”, “...тухайн хяналтын цэгт хоёроос доошгүй алба хаагч үүрэг гүйцэтгэнэ” гэж заасны дагуу 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Цогтцэций-Даланзадгад” чиглэлийн хатуу хучилттай авто замд шинээр баригдаж, ашиглалтад орсон замын хяналтын байнгын постонд үүрэг гүйцэтгэх алба хаагч дутмаг байна.

Тус сум нь Засаг захиргааны нэгжийн 4 багтай бөгөөд 2689 өрх айлд суурин 8619, уул уурхай, төмөр зам, авто замын бүтээн байгуулалтаас шалтгаалсан хөдөлгөөнт 40.000 орчим хүн ажиллаж, амьдардаг байхад 1 хэсгийн байцаагч ажиллаж байгаа нь учир дутагдалтай байна.

Хариуцсан орон нутагт “Тавантолгой” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Энержи ресурс” ХХК зэрэг томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үндсэн болон туслан гүйцэтгэгчээр 37 компани ажиллаж байна.

Тухайн компаниуд нь давхар гэрээ байгуулан 150 орчим компанитай хамтран ажиллаж байгаагаас нутаг дэвсгэрийн 70 орчим хувь нь ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа тул байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч 1 ажиллаж байна.

Тус хэлтсийн 3 жижүүрийн мөрдөгчөөс 2, мэдээлэл хүлээн авагч цагдаагаар 1 эмэгтэй алба хаагч ажилладаг бөгөөд жижүүрийн томилгоотой үедээ гэмт хэрэг, зөрчлийн дуудлагаар очихдоо зөрчил гаргагчийн буруутай үйлдлээс бие эрхтэндээ гэмтэл авах, өртөж, хохирох асуудал 2021 онд 2 удаа, 2022 онд 1 гарсан нь жижүүрийн мөрдөгчөөр эмэгтэй алба хаагч үүрэг гүйцэтгэж, дуудлагаар явах нь эрсдэл үүсэх магадлалтай байна.

Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын орон тоонд шаардагдах бараа, үйлчилгээний зардал, цалин хөлс болон нэмэгдэл урамшил, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын болон холбогдох зардлуудыг тус цагдаагийн газраас олгож байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны асуудлаар аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр нь төвийн дулааны шугаманд холбогдсон, галын аюулгүй байдал, агааржуулалтын нөхцөл болон “MNS 5527:2019” стандартын шаардлага хангасан үйл ажиллагаа

явуулахад бэлэн байгаа боловч эрүүлжүүлэх саатуулах байрны эмч 2, цагдаа 3 орон тоог зохих журмын дагуу шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаартай тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ийн 10 дахь хэсэгт зааснаар “4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч байх”-аар, мөн тогтоолын 14 дэх хэсэгт “Орон нутаг дахь замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух цагдаагийн хяналтын цэг 150 километр тутамд нэгээс доошгүй байна”, “...тухайн хяналтын цэгт хоёроос доошгүй алба хаагч үүрэг гүйцэтгэнэ” гэж заасны дагуу “Цогтцэций-Даланзадгад” чиглэлийн хатуу хучилттай авто замд шинээр баригдаж, ашиглалтад орсон замын хяналтын байнгын постонд үүрэг гүйцэтгэх 2 алба хаагчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гурав. Тус хэлтэс цагдаа-жолоочийн 1 орон тоотой бөгөөд жижүүрийн цагдаа жолоочийн орон тоо байхгүйгээс ажлын шаардлагаар дотоод зохион байгуулалт хийж, мөрдөгч, зохицуулагч, хэсгийн байцаагч, цагдаа-зохицуулагч нарыг томилгоонд оруулж ажиллуулдаг нь алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, ажлын ачаалал үүсэх шалтгаан болж байгаа тул жижүүрийн цагдаа жолоочийн 3 орон тоог шийдвэрлүүлэх шаардлага үүсч байна.

Дөрөв. Хариуцсан орон нутагт “Тавантолгой” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Энержи ресурс” ХХК зэрэг томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үндсэн болон туслан гүйцэтгэгчээр 37 компани ажиллаж байгаа бөгөөд тухайн компаниуд нь давхар гэрээ байгуулан 150 орчим компанитай хамтран ажиллаж байгаагаас нутаг дэвсгэрийн 70 орчим хувь нь ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа тул байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгчийн 1 орон тоог шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Байгууллага орон тооны бичиг хэргийн ажилтантай” байх гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Зургаа. Тус хэлтсийн 3 жижүүрийн мөрдөгчийн 1 орон тоог жижүүрийн ахлах мөрдөгчөөр томилуулах, эмэгтэй алба хаагчдын ажлын байрыг өөрчлөх талаар дотооддоо зохион байгуулж, саналаа холбогдох нэгжид хүргүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1 Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаа нь зохих түвшинд явагдаж байгаа хэдий ч орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт, хүн амын

суурьшил, хөдөлгөөн, тээвэрлэлт зэргээс шалтгаалан алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэж байгаа тул батлагдсан орон тоог нэмэгдүүлэх судалгаа, танилцуулгыг холбогдох нэгжид уламжлан шийдвэрлүүлэх /ХНХ, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.2 Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын удирдлагаас газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, үр дүнг тооцож байх /Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, холбогдох нэгжид уламжлан шийдвэрлүүлэх /ХНХ, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.4. Тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр нь төвийн дулааны шугаманд холбогдсон, галын аюулгүй байдал, агааржуулалтын нөхцөл болон “MNS 5527:2019” стандартын шаардлага хангасан үйл ажиллагаа явуулахад бэлэн байгаа боловч эрүүлжүүлэх саатуулах байрны эмч, цагдаа орон тоог зохих журмын дагуу шийдвэрлүүлэх /ХНХ, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.5. Тус хэлтсийн 3 жижүүрийн мөрдөгчийн 1 мөрдөгчийн албан тушаал /ажлын байр/-ыг жижүүрийн ахлах мөрдөгчийн албан тушаал /ажлын байр/-д шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар/;

5.6. Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтэст шаардагдах төсвийн зардлуудыг тус аймаг дахь цагдаагийн газрын батлагдсан төсөвт зардлаас салган тооцож, шилжүүлэх ажлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар/;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.МАНЛАЙБААТАР

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.НАМГИНЖАВ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтэс

Аудитын объект: Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, алба хаагчдын ажил үүргийн хуваарь ажлын ачааллын байдлыг аудитын объектод хамруулсан.

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/05

Аудитын хугацаа: 2022.04.05-2022.04.21

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Д.Борхүү, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул, байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Дотоод аюулгүй байдлын хэлтэс нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах /код 112/ журам”-ыг тус тус удирдлага болгон ажиллаж байна.

Чиг үүрэг: Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, үнэлэлт дүгнэлт өгөх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, алба хаагчийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг шалгаж шийдвэрлүүлэх, байгууллага, нэгж, алба хаагчдаас хэрэгжүүлж буй дүрэм журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг арилгуулах, сахилга,

ёс зүй, аюулгүй байдлын мэдээнд дүн шинжилгээ хийх, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/134 дүгээр тушаалаар тус хэлтсийн орон тоог дарга 1, тасгийн дарга 1, ёс журмын ахлах байцаагч 8, хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч 4, их эмч 1, сувилагч 1, жижүүрийн цагдаа 8, цагдаа жолооч 2, нийт 26 орон тоотойгоор баталсан байна.

Үүнээс хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч нарыг цолны хувьд авч үзвэл цагдаагийн дэд хурандаа 2 буюу 50.0, цагдаагийн хошууч 2 буюу 50.0, насны хувьд 48-53 насны 2 буюу 50.0, 39-40 насны 2 буюу 50.0, боловсролын хувьд магистр зэрэгтэй 2 буюу 50.0, эрх зүйч-цагдаагийн байгууллагын ажилтан мэргэжилтэй 2 буюу 50.0 хувийг эзэлж байна.

Тус хэлтсийн ахлах байцаагч нарыг ажилласан жилийн байдлыг харуулвал:

/Хүснэгт-1/

№	Овог, нэр	Ажилласан		Мөрдөн байцаах болон санхүүгийн албанд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан		Ээлжийн амралтын хоног	АТТ-д заасан болзол, шаардлагыг хангаж байгаа эсэх
		жил	сар		жил	сар		
1	д/х С.Саранбаатар	26	11	12	2	5	51	Тийм
2	д/х Ц.Нарантуяа	31	8	19	6	7	39	Тийм
3	х/ч Н.Мөнхтулга	16	7	10	4	1	39	Тийм
4	х/ч Б.Гантулга	20	5	8	2	2	42	Тийм

Санхүүгийн хяналт шалгалтын ахлах байцаагч нь харьяа газар хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, алба хаагчаас ирүүлсэн гомдол мэдээлэл болон удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг, батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг явуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар зөвлөгөө, зөвлөмж үүрэг даалгавар өгөх, биелэлтэд дүн шинжилгээ хийх, цагдаагийн төв байгууллага болон нийслэлийн аудит бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг засуулах ажилд хяналт тавих, шинээр томилогдсон нягтлан бодогч, нярав нарыг сурган дадлагажуулахад чиглэсэн сургалт зохион байгуулах, зөвлөгөө, зөвлөмж хүргүүлэх биелэлт үр дүнг тооцох чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагааны тухай баримт, мэдээлэл, алба хаагчдын ажлын ачаалал, түүнд холбогдох бусад үйл ажиллагааг хамрууллаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбоотой эрх зүйн актууд, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны танилцуулга, хийсэн ажлын тайлан, мэдээлэл болон хамааралтай бусад баримт бичгүүдийг гаргуулан авч, судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор тухайн нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь үйл ажиллагаатай биечлэн танилцаж, 2020 онд хийгдсэн ахлах байцаагч албан тушаалын ажлын зураглал, бусад нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1. Тус хэлтэс нь хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагчийн 4 орон тоотой.

Эдгээр алба хаагчаас 1 хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч нь албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу санхүүгийн хяналт шалгалтыг хариуцан ажилладаг.

Харин хяналт шалгалтын бусад 3 ахлах байцаагчаас 1 ахлах байцаагч нь хэлтсийн дотоод ажлыг хариуцан дараах ажлыг хийж гүйцэтгэдэг байна. Үүнд:

Нийслэлийн хэмжээнд сарын сахилгын болон бусад мэдээг нэгтгэх, тайлан, төлөвлөгөөний биелэлт, сахилгын шийтгэлтэй эсэх лавлагаа өгөх, Цагдаагийн ерөнхий газрын 126 тусгай дугаарын утсанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн иргэний гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг холбогдох шатны байгууллагаас албан бичгээр ирүүлснийг хүлээн авч, бүртгэн, хяналт тавьж, удирдлагын шийдвэрээр дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэст шилжүүлэн шалгуулж, дүнгийн талаарх танилцуулга, иргэнд хариу өгсөн албан бичгийн хуулбарын хамт Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн, шалгаж шийдвэрлэсэн материалыг үдэж, архивын нэгж болгох, ирсэн,

явсан бичгийн бүртгэл хөтлөх зэрэг дотоод ажил хариуцахаас гадна алба хаагчид ээлжийн амралт эдлэх, ачаалал ихсэх үед өргөдөл, гомдол шалгаж, албаны шалгалт явуулдаг байна.

Иймд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хяналт шалгалтын 3 ахлах байцаагчийн 1 нь үндсэн ажлаа хийхийн хажуугаар дотоод ажил хариуцаж байгаа нь бусад 2 хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагчийн ажлын ачаалал нэмэгдэх үндсэн шалтгаан болж байгаа бөгөөд 1 нь ээлжийн амралт эдэлсэн тохиолдолд ачаалал илүү нэмэгдэхээр байна.

Дээрх хяналт шалгалтын 2 ахлах байцаагчийн үндсэн чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил болон ажлын ачааллын тоон мэдээллийг дараах байдлаар харуулбал:

/Хүснэгт 2/

1. Г о м д о л .

Мэдээлэл шалгасан талаар: 2020, 2021 он, 2022 оны I улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой нийт 411 гомдол, мэдээлэл хүлээн авч, дунджаар гүйцэтгэлээр жилд нэг ахлах байцаагч 137 гомдол шалгасан байна.

Аудитад хамрагдах он	Шалгасан гомдол мэдээллийн тоо	Нэг байцаагчид ногдох гомдол, мэдээлэл /дундаж/	
		Батлагдсан орон тоогоор	Гүйцэтгэлээр
2020	162	54	81
2021	184	61	92
2022 оны I улирал	65	21.6	32
Дүн	411	136.9	205.5

2. Албаны шалгалтын талаар: 2020, 2021 он, 2022 оны I улирлын байдлаар нийт 288 албаны шалгалтыг явуулж, шийдвэрлэсэн ба жилд нэг байцаагч гүйцэтгэлийн дундажаар 96 албаны шалгалт явуулж, дүүрэгт хийгдсэн хяналт шалгалтын нийт 87 материалыг хянасан байна.

/Хүснэгт 3/

Аудитад хамрагдах он	Өргөдөл гомдлын тоо		Албаны шалгалтын тоо	Дүүрэгт хийгдсэн шалгалтыг хянасан байдал	Нэг байцаагчид ногдох албаны шалгалт /дундаж/	
	Тухайн оны	Урд оны			Батлагдсан орон тоогоор	Гүйцэтгэлээр
2020	162	5	126	38	42	63
2021	184	5	123	40	41	61.5
2022 оны 4.11-ний байдлаар	65	5	39	9	13	19.5
Дүн	411	15	288	87	96	144

3.2 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/318, 2021 оны А/14 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Дүүргүүд дэх

Замын цагдаагийн хэлтсийг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дүүрэг дэх цагдаагийн газрын харьяанд шилжүүлсэн, мөн Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүтцэд Шөнийн эргүүлийн хэлтэс шинээр байгуулагдсантай холбогдуулан офицер 401, ахлагч 160, нийт 561 орон тоо нэмэгдэж, одоогоор Нийслэлийн цагдаагийн хүрээний хэмжээнд 3632 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын хэмжээнд орон тоо нэмэгдсэн хэдий ч Дотоод аюулгүй байдлын хэлтэс нь 26 орон тоотойгоор /орон тоо нь хэвээрээ/ чиг үүргээ хэрэгжүүлж байгаа нь дээрх алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх шалтгаан болсон байна.

/Хүснэгт 4/

Он	Зөрчлийн тоо	Зөрчилд холбогдсон алба хаагчдын тоо
2020 он	298	343
2021 он	379	447
2022 он 1-р улирал	119	140
Дүн	796	930

Энэ мэдээллээс үзэхэд 2021 онд гарсан сахилгын зөрчил, түүнд холбогдсон алба хаагчийн тоотой харьцуулахад 2020 оны мөн үеэс сахилга, ёс зүйн зөрчил 21.4, алба хаагч 23.3, оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс сахилга, ёс зүйн зөрчил 95.1, алба хаагч 97.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн дүгнэхэд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаа зохих түвшинд явагдаж байгаа боловч дараах нөхцөл байдлын улмаас хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч нарын ажлын ачаалал нэмэгдсэн байна гэж дүгнэж байна. Үүнд:

Нэг. Тухайн нэгжийн хяналт шалгалт хариуцсан 3 ахлах байцаагчийн 1 нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээс гадна тухайн хэлтсийн бичиг хэрэг болон дотоод ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа нь хяналт шалгалт хариуцсан алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна;

Хоёр. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж, 561 алба хаагчаар нэмэгдэж, 3632 болсон боловч тус хэлтсийн хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагчийн орон тоог нэмэгдүүлээгүй байгаа нь Нийслэлийн цагдаагийн хүрээний хэмжээнд дотоод хяналтын чанар, үр нөлөөг бууруулах эрсдэлийг үүсгэж байна.

Тус хэлтсийн алба хаагчдын ажлын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй, хүрэх түвшинг оновчтой тодорхойлоогүй байсан тул ирүүлсэн ажлын тайлан, мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргасан болно.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1 Тус хэлтсийн алба хаагчдын ажлын үр дүнг тооцох шалгуур

үзүүлэлтийг боловсруулж, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын хэмжээнд алба хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг гол шалгуур үзүүлэлт болгон тооцож байх /НЦУГ/;

5.2 Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж, 561 алба хаагчаар орон тоо нэмэгдсэнтэй уялдуулан дотоод хяналтын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор батлагдсан орон тоонд нийцүүлэн Дотоод аюулгүй байдлын хэлтэст хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагчийн 1 орон тоог судалж шийдвэрлүүлэх; /ХНХ, НЦУГ/

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

МӨН ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛИЙН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.БОРХҮҮ

АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙНХОШУУЧ

Ё.МӨНХЗУЛ

БАЙЦААГЧ, ЦАГДААГИЙН
АХЛАХ ДЭСЛЭГЧ

Ч.ЭРДЭНЭБОЛОР

Ажлын баримт-3001

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 04-р сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд хийх гүйцэтгэлийн дотоод аудит.

Аудит хийгдсэн нэгж: Санхүү, аж ахуйн алба.

Аудитын объект: Аудитаар Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацааны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа.

Аудитын төрөл, код: Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ/ХШДАХ/2022/06

Аудитын хугацаа: 2022.04.05-2022.04.06

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал.

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзүл, байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2021 оны төсөв батлагдсантай холбогдуулан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-нд тусгуулах Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн саналыг Санхүү, аж ахуйн албанаас нэгтгэн хүргүүлснээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/212, 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/54, мөн оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/249 дүгээр нэмэлт тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтад хөрөнгө оруулалт 8.4 тэрбум, хоёрдугаар хавсралтад урсгал төсөвт 24.3 тэрбум төгрөгөөр батлагдсан байна.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дээрх төлөвлөгөөний хүрээнд 2021 онд төсвийн хөрөнгө оруулалт 8.2 тэрбум, урсгал төсвөөс 22.9 тэрбум, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг

тус тус олгожээ.

Аудитын ажлын хүрээнд хамарсан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны худалдан авах ажиллагааны тайлангаас авч үзвэл:

1.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар:

“Хууль зүй дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтаар төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авах төсөл арга хэмжээний зардалд 2021 онд нийт 8.4 тэрбум төгрөг тусгаж, хөрөнгө оруулалтын 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь буюу 8.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

Барилга байгууламжийн ажлын хүрээнд: Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар болон Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын барилгын ажилд нийт 3.0 тэрбум төгрөг батлагдснаас 2021 онд санхүүжих 2.9 тэрбум төгрөг /шилжих/, Сүхбаатар, Говь-Сүмбэр аймаг дахь цагдаагийн газрын барилга, Өвөрхангай аймгийн Хужирт, Богд сум дахь цагдаагийн тасгийн барилга, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны барилгын ажилд нийт 3.1 тэрбум төгрөгөөр батлагдаж /шинээр/, 2021 онд санхүүжих нийт дүн 3.1 тэрбум төгрөгийг тус тус олгосон нь нийт барилга байгууламжийн 2021 оны санхүүжилтийн гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

Их засварын ажлын хүрээнд: “Сүлд” чуулгын барилгын өргөтгөл, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл хамгаалалтын газар, Дотоодын цэргийн 05 дугаар анги, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн дотор халаалтын систем, гадна цахилгааны кабель шинэчлэл, Хөвсгөл аймгийн цагдаагийн газрын барилгын засвар, Дорнод аймгийн цагдаагийн нэгдүгээр байрны суурийн хэсгийн усны хаяавч шинэчлэн засварлах мөн аймгийн хоёрдугаар байрны дээвэр, гадна пасатын засвар, Цагдаагийн ерөнхий газрын гуравдугаар байрны засварт шинээр 2.0 тэрбум төгрөг батлагдаж, энэ онд олгосон санхүүжилт 2.0 тэрбум төгрөг буюу 100 хувьтай байна.

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж 95.0, их засварын ажлын явц 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тоног төхөөрөмжийн ажлын хүрээнд: Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороонд туулах чадвар сайтай автомашин, суудлын автомашин худалдан авахад 150.0 сая төгрөг /шилжих/, Булган, Увс аймаг дахь цагдаагийн газарт автомашин, мотоцикл худалдан авахад 162.0 сая төгрөг /шинээр/ тус тус батлагдаж, 2021 онд олгосон санхүүжилт 100 хувьтай байна.

1.2.Урсгал төсвөөр:

“Хууль зүй дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-ний хоёрдугаар хавсралтаар төсвийн урсгал зардлаас худалдан авах төсөл арга хэмжээний зардалд 2021 онд нийт 24.3 тэрбум төгрөг тусгаж, 51 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь буюу 22.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

1.3 Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээр:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 11 төсөл арга хэмжээний зардалд нийт 2.9 тэрбум төгрөг тусгасан арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь буюу 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэлийн дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход чиглэгдсэн болно.

2.2 Аудитын хамарсан цар хүрээ

Дээрх зорилгын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бусад холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Санхүү аж ахуйн албаны холбогдох алба хаагчаас ирүүлсэн мэдээллийг аудитын объектод хамрууллаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаа, дотоод цэргийн анги, байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны харилцааг зохицуулсан хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцаж судалсан.

Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”, гүйцэтгэлийн эхний хагас болон жилийн эцсийн тайлан болон холбогдох мэдээллийг авч, түүвэрлэх, нэгтгэх аргыг аудитын тайланд ашиглаж, нотлох баримтыг бэлтгэсэн.

Аудитын дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулахдаа аудитын явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурласан болно.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны батлагдсан төсвийн урсгал зардлаас 817,106.2 мянган төгрөгийн компьютер, техник, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Гэвч 2021 оны төсвийн саналд компьютер, техник, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусгах санал хүргүүлсэн боловч дээд шатны байгууллагаас урсгал зардалд баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “...батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэгт “...батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/324 дүгээр тушаалаар Хар тамхитай тэмцэх газарт шаардлагатай автомашин худалдан авахаар үнэлгээний хороо байгуулагдаж, 2 удаагийн нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул гэрээ шууд байгуулахаар шийдвэрлэн “Таван богд автоматив” ХХК-тай 269,900.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан төсвийн урсгал зардлаас автотээврийн хэрэгсэл худалдан авалт хийсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

3.3 “Сүлд” чуулгын алба хаагчдын уран бүтээлийн тоглолтын хувцасыг 108,766.5 мянган төгрөгөөр худалдан авахаар дээрх төлөвлөгөөнд тусгасан байна.

Уг худалдан авалтыг зохион байгуулахдаа Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны даргын 2021 оны А/58 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэн, 7 аж ахуйн нэгж, байгууллагатай нийт 108,646.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулжээ.

Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж худалдан авах ажиллагааны журмыг сонгох ёстой.

Гэтэл “Сүлд” чуулгын алба хаагчдын уран бүтээлийн тоглолтын хувцас худалдан авах ажлын төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4 дэх хэсэг “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5 дахь хэсэг “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.7.1 дэх хэсэг “...тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасныг зөрчсөн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааны “www.tender.gov.mn” цахим

системд давхардсан тоогоор нийт 43 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем “tender.gov.mn”, “police.gov.mn”, “shilendans.gov.mn”-нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн бөгөөд гүйцэтгэл нь 100 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн дагуу тендерийн үнэлгээний хороонд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөлөгч оролцуулж, хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлж, зохион байгуулсан байна.

Дээд шатны төсөв захирагчаас урсгал зардалд техник, тоног төхөөрөмж, автомашин худалдан авах зардлыг баталж өгсний дагуу зарцуулсан хэдий ч цаашид төсвийн саналд дээрх нэр төрлийн хөрөнгийг худалдан авах зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусгахаар саналаа хүргүүлж байх нь хуулийн шаардлагад нийцэхээр байна.

Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн дүгнэхэд Цагдаагийн ерөнхий газраас 2021 онд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа нь хууль, журмын дагуу хугацаандаа чанартай, бүрэн гүйцэтгэсэн байна.

ТАВ.САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр дараах санал, зөвлөмжийг танилцуулж байна. Үүнд:

5.1 Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон бүрэн, чанартай гүйцэтгэгдэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах /CAAA/;

5.2 Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс тухайн байгууллагын худалдан авах ажиллагаатай холбоотой зарим мэдээллийг татаж авахад боломжгүй байгаа тул цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг бодитой, үр дүнтэй болгох зорилгоор системийн шинэчлэлт, өргөжүүлэлт хийлгэх шаардлагатай байгаа талаарх саналаа холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх /CAAA/;

5.3 Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн дотор Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэст ирүүлэх.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД

Шийдвэр:
.....
.....
.....

ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.МАНЛАЙБААТАР

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Ё.МӨНХЗУЛ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 05-р сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг сүүлийн 5 жилийн байдлаар хамруулав.

Аудитын төрөл, код: , ЦЕГ-ХШДАХ/СА-2022/11

Аудитын хугацаа: 2022.05.02-2022.05.27

Аудитын багийн ахлагч: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Мөн газрын дотоод аудит хариуцсан байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор

НЭГ. ТАНИЛЦУУЛГА:

Манай аудитын баг нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2017-2021 оны хооронд “Хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага”-ын хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 61 төсөвт байгууллага, 2 төрийн өмчит үйлдвэрийн газар нийт 63 байгууллагад 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн 61, төрийн өмчит үйлдвэрийн газар 1 нийт 62 байгууллагад 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.


Цагдаа, дотоодын цэргийн 53, төрийн өмчит үйлдвэрийн газар 1, нийт 54 байгууллагын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийж, 36 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт, Говь-Алтай, Дорноговь аймаг дахь цагдаагийн газруудад “Хязгаарлалттай” дүгнэлт тус тус өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн 54 байгууллагад 2020 оны санхүүгийн

тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийж, 35 байгууллага болон Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын 2021 оны төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газар болон харьяа нийслэл, орон нутгийн аудитын газраас жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

ЦЕГ-ын 2017-2021 оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мян.төг/



ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаснаар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, дахин давтан алдаа, зөрчил гаргахгүй байхад оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад 2017-2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар дүгнэлт өгч, тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлнэ.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба хаагчидтай ярилцлага хийх, тайлбар авах, баримт цуглуулах, түүвэр хийж, тулган баталгаажуулсан болно.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн Төрийн аудитын байгууллага нь нийт 13 асуудлаар 9.800,6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 10 асуудлаар 585.556,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, давхардсан тоогоор 93 асуудлаар 590.262,1 мянган

төгрөгийн зөрчил арилгах зөвлөмжийг цагдаагийн байгууллагад ирүүлжээ.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмжийг боловсруулан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлж, биелэлтийг тухай бүр тооцсон ба өмнөх оноос алдаа, зөрчлийн нийт дүн 34.1 хувиар буурсан байна.

3.2 Цагдаа, дотоодын цэргийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газар болон орон нутгийн аудитын газрын дүгнэлтээр нийт 9 асуудлаар 5.541,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 35 асуудлаар 181.134,4 мянган төгрөгийн албан шаардлага, 65 асуудлаар 383.425,5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлжээ.

Санхүүгийн аудитын шалгалтын дүн болон Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Санхүү, аж ахуйн албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төсөв захирагч, нягтлан бодогч нарын ажлыг дүгнэж, зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг тооцоход 100 хувь байна.

3.3 Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна. Харин Говь-Алтай, Дорноговь аймаг дахь цагдаагийн газруудад “Хязгаарлалттай” дүгнэлт авчээ.

Нийт цагдаагийн байгууллагын хэмжээнд 1.722.062,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, аудитын явцад 10 асуудлаар 322.152,3 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.

Аудитаар 6 асуудлаар 6.407,2 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 10 асуудлаар 61.165,4 мянган төгрөгийн албан шаардлага, 58 асуудлаар 1.654.490,2 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлжээ.

Төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тооцоход, зөвлөмжийн биелэлт 99.0, төлбөрийн акт 100.0, албан шаардлага 99.0 хувийн биелэлттэй байна.

3.4 Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдаж, нийт 2.448.278,7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 6 асуудлаар 18.032,8 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 13 асуудлаар 675.653,3 мянган төгрөгийн албан шаардлага, 64 асуудлаар 1.754.592,6 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлжээ.

Орхон, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс зэрэг 3 байгууллагад нийт 18.032,8 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсан байна.

Нийт алдаа, зөрчлийн 40 орчим хувь буюу 930.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах, татварын цахим и-баримт бүрдүүлэх чиглэлээр өгөгдсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тооцоход, зөвлөмжийн биелэлт 98.0, төлбөрийн акт 100.0, албан шаардлага 99.0 хувийн биелэлттэй байна.

3.5 Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдаж, нийт 10 байгууллагад 364.892,0 мянган төгрөгийн албан шаардлага, 24 байгууллагад 1.482.7229,4 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөн ба Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс зэрэг 3 байгууллагад нийт 4.106,4 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигджээ.

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн акт, зөвлөмж, албан шаардлагаар өгөгдсөн зарим зөрчлөөс дурдвал;

- Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар нь шатахуунаас 1.685.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан асуудалд төлбөрийн акт тавигдсан;

- Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс нь ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан 1 алба хаагчид 320.4 мянган төгрөг илүү олгосон асуудалд төлбөрийн акт тавигдсан;

- Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс нь ээлжийн амралт дутуу эдэлсэн 17 алба хаагчдын цалинг тушаал шийдвэргүйгээр нэмэгдүүлж, ээлжийн амралтын мөнгийг давхардуулан олгосон асуудалд төлбөрийн акт тавигдсан;

- Нийслэлийн цагдаагийн удирдах газар дээр зарим ажилтнуудын цалин хөлсийг зөрүүтэй тооцож, 2,145.6 мянган төгрөгийг авлагаар бүртгэж өглөгтэй гарсан, төсөвт «Ахмадын сан бүрдүүлэх зардал»-ыг тусгаагүй, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлын хэмнэлтийн 23,556.5 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн;

- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын албан бичгийн үндэслэн төсөв тусгагдаагүй байхад тогтмол зардлаас 8,771.0 мянга, нэг удаагийн буцалтгүй тэтгэмжээс 156.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжаас 11,798.6 мянга, нийт 20,725.7 мянган төгрөгийг Цагдаагийн ерөнхий газрын ахмадын санд шилжүүлсэн, “Мал мах 2021” нэгдсэн арга хэмжээний зардлаас хувь хүний эзэмшлийн 10 азарга адуунд хяналтын тоног төхөөрөмж /чип/ бараа материалд бүртгэж, зарлага гаргасан;

- Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газарт ахмадын сангийн дансанд байгууллагын тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бичиг хэрэг шуудан холбоо, эрүүл мэндийн даатгалын хураамжийн зардлаас мөнгө төвлөрүүлсэн, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй мотоцикл нь

тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй, биетээр байхгүй хөрөнгийг тодорхой арга хэмжээ авч шийдвэрлээгүй, хэргийн газарт хохирлын үнэлгээ хийдэг хөрөнгийн үнэлгээний “Дамно” ХХК-тай шууд гэрээ байгуулсан, алба хаагчдад олгосон 5.225.0 мянган төгрөгийн хоолны тооцооны анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг асуудалд зөвлөмж, акт, албан шаардлага өгсөн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн дүгнэхэд Үндэсний аудитын газраас санхүүгийн тайланг баталгаажуулах явцад Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан “Зөрчилгүй” санал, дүгнэлттэй шалгагдаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч материаллаг бус алдаа, зөрчил, дутагдал давтан заагдсан хэвээр байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хөндлөнгийн аудитаар ээлжийн амралт дутуу эдэлсэн алба хаагчдын цалинг тушаал шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн, ээлжийн амралтын мөнгийг давхардуулж олгосон, ажилтнуудын цалин хөлсийг зөрүүтэй тооцсон, төсөвт “Ахмадын сан бүрдүүлэх зардал”-ыг тусгаагүй, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамжийн зардлын хэмнэлтийг ахмадын санд төвлөрүүлсэн, шатахууныг зарцуулахдаа анхан шатны баримтыг дутуу бүрдүүлдэг зэрэг нийтлэг алдаа, зөрчил дахин давтагдан заагдаж байгаа нь цаашид холбогдох хууль, журам болон нягтлан бодох бүртгэлийн стандарт, заавар зөрчигдөх эрсдэл үүсэхээр байгаад дүгнэлт хийн биелэлтийг бүрэн тооцож таслан зогсоох шаардлагатай байна.

Дээрх зөрчлүүд давтагдаж байгаа шалтгаан нь тухайн байгууллагын удирдах ажилтан болон нягтлан бодогч нарын санхүүгийн бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй, төсвийн сахилга бат сул, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэхгүй, санхүүгийн анхан шатны баримтыг иж бүрэн, үнэн зөв, бодитой бүрдүүлж байх зарчмыг хэрэгжүүлдэггүйтэй шууд хамааралтай байна.

Мөн Санхүү, аж ахуйн албанаас зохион байгуулж буй Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа сургалтын чанар хангалтгүй байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.

Иймд тухайн сургалтыг чанаржуулах, үр нөлөөг дээшлүүлэх тал дээр шинэлэг ажил зохион байгуулах, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг цахим гарын авлагатай болгох нь зүйтэй байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4, 5 дүгээр зүйлд

заасан нягтлан бодох бүртгэлийн стандарт, зарчмуудыг мөрдөж ажиллах /CAAA/;

Хоёр. Санхүүгийн эрсдэлийг тогтоолгохоор Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын хэмжээнд хөндлөнгийн аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлт тооцсон дүнг тухай бүр Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт мэдээлж байх /CAAA/;

Гурав. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр илэрсэн алдаа, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, уг алдаа, зөрчил дахин давтан гаргах асуудлыг таслан зогсоох /CAAA/;

Дөрөв. Жил бүрийн санхүү, бүртгэлийн ажилтнуудад зориулан зохион байгуулж байгаа сургалтыг чанаржуулах, үр нөлөөг дээшлүүлэх тал дээр санаачилгатай ажиллаж, цахим гарын авлага бэлтгэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох /CAAA/;

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, дүнг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулъя.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

Ч.ЭРДЭНЭБОЛОР

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 05-р сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудит

Аудит хийгдсэн нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг сүүлийн 5 жилийн байдлаар хамруулав.

Аудитын төрөл, код: ЦЕГ-ХШДАХ/СА-2022/11

Аудитын хугацаа: 2022.05.02-2022.05.26

Аудитын багийн ахлагч: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Мөн газрын дотоод аудит хариуцсан байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Эрдэнэболор

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Манай аудитын баг нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2017-2021 оны хооронд “Хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага”-ын хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 61 төсөвт байгууллага, 2 төрийн өмчит үйлдвэрийн газар нийт 63 байгууллагад 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.


Цагдаа, дотоодын цэргийн 61, төрийн өмчит үйлдвэрийн газар 1 нийт 62 байгууллагад 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.

Цагдаа, дотоодын цэргийн 53, төрийн өмчит үйлдвэрийн газар 1, нийт 54 байгууллагын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийж, 36 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт, Говь-Алтай, Дорноговь аймаг дахь цагдаагийн газруудад “Хязгаарлалттай” дүгнэлт тус тус өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн 54 байгууллагад 2020 оны санхүүгийн тайла, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийж, 35 байгууллага болон Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын 2021 оны төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газар болон харьяа нийслэл, орон нутгийн аудитын газраас жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

ЦЕГ-ын 2017-2021 оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мян.төг/



ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаснаар Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, дахин давтан алдаа, зөрчил гаргахгүй байхад оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад 2017-2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдсэн хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар дүгнэлт өгч, тулгарч буй асуудлыг засаж, сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлнэ.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба хаагчидтай ярилцлага хийх, тайлбар авах, баримт цуглуулах, түүвэр хийж, тулган баталгаажуулсан болно.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн Төрийн аудитын байгууллага нь нийт 13 асуудлаар 9.800,6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт

тогтоож, 10 асуудлаар 585.556,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, давхардсан тоогоор 93 асуудлаар 590.262,1 мянган төгрөгийн зөрчил арилгах зөвлөмжийг цагдаагийн байгууллагад ирүүлжээ.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмжийг боловсруулан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлж, биелэлтийг тухай бүр тооцсон ба өмнөх оноос алдаа, зөрчлийн нийт дүн 34,1 хувиар буурсан байна.

3.2 Цагдаа, дотоодын цэргийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газар болон орон нутгийн аудитын газрын дүгнэлтээр нийт 9 асуудлаар 5.541,3 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 35 асуудлаар 181.134,4 мянган төгрөгийн албан шаардлага, 65 асуудлаар 383.425,5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлжээ.

Санхүүгийн аудитын шалгалтын дүн болон Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Санхүү, аж ахуйн албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төсөв захирагч, нягтлан бодогч нарын ажлыг дүгнэж, зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг тооцоход 100 хувь байна.

3.3 Цагдаагийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна. Харин Говь-Алтай, Дорноговь аймаг дахь цагдаагийн газруудад “Хязгаарлалттай” дүгнэлт авчээ.

Нийт цагдаагийн байгууллагын хэмжээнд 1.722.062,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, аудитын явцад 10 асуудлаар 322.152,3 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.

Аудитаар 6 асуудлаар 6.407,2 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 10 асуудлаар 61.165,4 мянган төгрөгийн албан шаардлага, 58 асуудлаар 1.654.490,2 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлжээ.

Төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тооцоход, зөвлөмжийн биелэлт 99.0, төлбөрийн акт 100.0, албан шаардлага 99.0 хувийн биелэлттэй байна.

3.4 Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдаж, нийт 2.448.278,7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 6 асуудлаар 18.032,8 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 13 асуудлаар 675.653,3 мянган төгрөгийн албан шаардлага, 64 асуудлаар 1.754.592,6 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлжээ.

Орхон, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс зэрэг 3 байгууллагад нийт 18.032,8 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсан байна.

Нийт алдаа, зөрчлийн 40 орчим хувь буюу 930.6 сая төгрөгийн алдаа

зөрчил нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах, татварын цахим и-баримт бүрдүүлэх чиглэлээр өгөгдсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тооцоход, зөвлөмжийн биелэлт 98.0, төлбөрийн акт 100.0, албан шаардлага 99.0 хувийн биелэлттэй байна.

3.5 Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдаж, нийт 10 байгууллагад 364.892,0 мянган төгрөгийн албан шаардлага, 24 байгууллагад 1.482.7229,4 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөн ба Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс зэрэг 3 байгууллагад нийт 4.106,4 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигджээ.

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгөгдсөн акт, зөвлөмж, албан шаардлагаар өгөгдсөн зарим зөрчлөөс дурдвал;

- Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар нь шатахуунаас 1.685.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан асуудалд төлбөрийн акт тавигдсан;

- Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс нь ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан 1 алба хаагчид 320.4 мянган төгрөг илүү олгосон асуудалд төлбөрийн акт тавигдсан;

- Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс нь ээлжийн амралт дутуу эдэлсэн 17 алба хаагчдын цалинг тушаал шийдвэргүйгээр нэмэгдүүлж, ээлжийн амралтын мөнгийг давхардуулан олгосон асуудалд төлбөрийн акт тавигдсан;

- Нийслэлийн цагдаагийн удирдах газар дээр зарим ажилтнуудын цалин хөлсийг зөрүүтэй тооцож, 2,145.6 мянган төгрөгийг авлагаар бүртгэж өглөгтэй гарсан, төсөвт «Ахмадын сан бүрдүүлэх зардал»-ыг тусгаагүй, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлын хэмнэлтийн 23,556.5 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн;

- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын албан бичгийн үндэслэн төсөв тусгагдаагүй байхад тогтмол зардлаас 8,771.0 мянга, нэг удаагийн буцалтгүй тэтгэтгэмжээс 156.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжаас 11,798.6 мянга, нийт 20,725.7 мянган төгрөгийг Цагдаагийн ерөнхий газрын ахмадын санд шилжүүлсэн, “Мал мах 2021” нэгдсэн арга хэмжээний зардлаас хувь хүний эзэмшлийн 10 азарга адуунд хяналтын тоног төхөөрөмж /чип/ бараа материалд бүртгэж, зарлага гаргасан;

- Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газарт ахмадын сангийн дансанд

байгууллагын тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бичиг хэрэг шуудан холбоо, эрүүл мэндийн даатгалын хураамжийн зардлаас мөнгө төвлөрүүлсэн, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй мотоцикл нь тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй, биетээр байхгүй хөрөнгийг тодорхой арга хэмжээ авч шийдвэрлээгүй, хэргийн газарт хохирлын үнэлгээ хийдэг хөрөнгийн үнэлгээний “Дамно” ХХК-тай шууд гэрээ байгуулсан, алба хаагчдад олгосон 5.225.0 мянган төгрөгийн хоолны тооцооны анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг асуудалд зөвлөмж, акт, албан шаардлага өгсөн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн дүгнэхэд Үндэсний аудитын газраас санхүүгийн тайланг баталгаажуулах явцад Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан “Зөрчилгүй” санал, дүгнэлттэй шалгагдаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч материаллаг бус алдаа, зөрчил, дутагдал давтан заагдсан хэвээр байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хөндлөнгийн аудитаар ээлжийн амралт дутуу эдэлсэн алба хаагчдын цалинг тушаал шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн, ээлжийн амралтын мөнгийг давхардуулж олгосон, ажилтнуудын цалин хөлсийг зөрүүтэй тооцсон, төсөвт “Ахмадын сан бүрдүүлэх зардал»-ыг тусгаагүй, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамжийн зардлын хэмнэлтийг ахмадын санд төвлөрүүлсэн, шатахууныг зарцуулахдаа анхан шатны баримтыг дутуу бүрдүүлдэг зэрэг нийтлэг алдаа, зөрчил дахин давтагдан заагдаж байгаа нь цаашид холбогдох хууль, журам болон нягтлан бодох бүртгэлийн стандарт, заавар зөрчигдөх эрсдэл үүсэхээр байгаад дүгнэлт хийн биелэлтийг бүрэн тооцож таслан зогсоох шаардлагатай байна.

Дээрх зөрчлүүд давтагдаж байгаа шалтгаан нь тухайн байгууллагын удирдах ажилтан болон нягтлан бодогч нарын санхүүгийн бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй, төсвийн сахилга бат сул, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэхгүй, санхүүгийн анхан шатны баримтыг иж бүрэн, үнэн зөв, бодитой бүрдүүлж байх зарчмыг хэрэгжүүлдэггүйтэй шууд хамааралтай байна.

Мөн Санхүү, аж ахуйн албанаас зохион байгуулж буй Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа сургалтын чанар хангалтгүй байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.

Иймд тухайн сургалтыг чанаржуулах, үр нөлөөг дээшлүүлэх тал дээр шинэлэг ажил зохион байгуулах, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг цахим гарын авлагатай болгох нь зүйтэй байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4, 5 дүгээр зүйлд заасан нягтлан бодох бүртгэлийн стандарт, зарчмуудыг мөрдөж ажиллах /CAAA/;

Хоёр. Санхүүгийн эрсдэлийг тогтоолгохоор Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын хэмжээнд хөндлөнгийн аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлт тооцсон дүнг тухай бүр Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт мэдээлж байх /CAAA/;

Гурав. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр илэрсэн алдаа, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, уг алдаа, зөрчил дахин давтан гаргах асуудлыг таслан зогсоох /CAAA/;

Дөрөв. Жил бүрийн санхүү, бүртгэлийн ажилтнуудад зориулан зохион байгуулж байгаа сургалтыг чанаржуулах, үр нөлөөг дээшлүүлэх тал дээр санаачлагатай ажиллаж, цахим гарын авлага бэлтгэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох /CAAA/;

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, дүнг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулъя.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

Ч.ЭРДЭНЭБОЛОР

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 05-р сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдалд хийх дотоод аудит.

Аудит хийгдсэн нэгж: Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтэс.

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбоо, техник хэрэгслийн хангамж, нууцлалын тухай баримт, мэдээлэл, алба хаагчдын ажлын ачаалал, түүнд холбогдох бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ-ХШДАХ/ҮА-2022/10

Аудитын хугацаа: 2022.04.28-2022.05.20

Аудитын багийн ахлагч: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав.

Аудитын багийн гишүүн: Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсийн санхүүгийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтсийн үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код 711, 713, 714, 715/ журмаар зохицуулагдаж байна.

Бүтэц, орон тоо, чиг үүрэг.

Цагдаагийн байгууллагын харилцаа холбооны чиг үүрэг бүхий анхны нэгж 1922 онд Дотоодыг хамгаалах газарт “Тусгай шуудангийн алба” нэртэйгээр байгуулагдснаас хойш нэгжийн бүтэц зохион байгуулалтад 26 удаа өөрчлөлт хийгдсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/159 дүгээр тушаалаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албыг байгуулсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/209 дүгээр тушаалаар Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээлэл, шуурхай

удирдлагын болон Мэдээллийн технологи, холбооны төв, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Шуурхай удирдлагын хэлтсийн орон тоог тус албанд шилжүүлэн бүтэц, албан тушаал орон тоо, цалингийн зэрэглэлийг баталсан байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/30 дугаар тушаалаар бүтэц орон тоог өөрчилж, албан тушаал, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталжээ.

Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтэс нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд суурин болон хөдөлгөөнт холбоо зохион байгуулалт, радио болон телефон холбооны төлөвлөлт, угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ, цагдаагийн төв байрны алба хаагчийн харилцаа холбооны техник хэрэгслийн хэвийн ажиллагаа, хурлын болон зөөврийн өсгөгчийн систем, шуурхай удирдлагын штабын техник хэрэгслийн бэлэн байдал, цагдаагийн байгууллагын тусгай шуудангийн үйл ажиллагааг хариуцан офицер 10, ахлагч 8, энгийн 1, нийт 19 орон тоотой ажиллаж байна.

Радио холбооны техник, технологийн өнөөгийн байдлын талаар.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй нийт алба хаагчдын 55.0, автомашины 60.0, суурин болон дахин дамжуулах 53.0 хувь нь хэт богино долгионы радио станцаар хангагдсан байна.

Цагдаагийн байгууллагад хэрэглэж байгаа радио холбоо нь 1996 оны Япон улсын “Kenwood” компанийн 144-174 МГц давтамжид ажилладаг, аналог системийн технологи юм.

Мөн 2013 онд “Motorola” давтамж 380-400 МГц давтамжид ажилладаг, DMR тоон системийн технологийн 380 ширхэг суурин болон автомашины станц, гар станц, 2017 онд 300 гар станцыг нэмж авсан нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед удирдлагын холбоог зохион байгуулахад ашиглаж байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ашиглагдаж буй радио холбоо, технологи, техник хэрэгслийн хангамж, радио холбооны нууцлал, мэдээлэл, алба хаагчдын ажлын ачаалал, түүнд холбогдох бусад үйл ажиллагааг аудитын объектод хамрууллаа.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн холбооны хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны танилцуулга, хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, станцын судалгаа, мэдээлэл болон хамааралтай бусад баримт бичгийг гаргуулан авч, судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор тухайн нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь үйл ажиллагаатай биечлэн танилцаж, бусад нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитын хүрээнд цугларсан мэдээлэл, баримт материал үндэслэн энэхүү тайланд тусгаж, удирдлагад танилцуулан, шийдвэрлэвэл зохих дараах асуудлууд байна. Үүнд:

3.1 Цагдаагийн байгууллагад Япон улсын “Kenwood” компаний хэт богино долгионы 144-174МГц давтамжийн зурваст ажилладаг аналог радио станцыг 1996 оноос өнөөг хүртэл ашиглаж байгаа бөгөөд технологийн шинэчлэлт өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Технологийн шинэчлэлт хийгдээгүй, энэ төрлийн станцын үйлдвэрлэл зогссон, сэлбэг хэрэгслийн олдоцгүй болсноос цагдаагийн байгууллагын өнөөгийн ашиглаж буй богино долгионы радио холбооны тоног төхөөрөмжийн электрон элементүүд ашиглалтын явцад муудаж, гэмтэл, саатал гарах нь ихэсч, холбоо барих алслалт, ярианы түвшин муудсан, техникийн шаардлага хангахгүй байна.

3.2 Мөн ашиглагдаж буй богино долгионы радио холбооны аналог систем нь гадны яриа болон нэвтрүүлгийг сүлжээнд нэвтрүүлэхгүй, станцыг зайнаас удирдах, хянах боломжгүй, хоцрогдолтой байгаа нь алба хаагчаас шалтгаалахгүй нэвтрүүлэг давхардах, доголдол үүсэх, нууцлал алдагдах асуудал гарч байна.

Тухайлбал, Уул уурхай, харуул хамгаалалт, нийтийн тээвэр, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, зарим иргэд /цагдаагийн байгууллагад ажиллаж байхдаа хувийн станц ашиглаж байгаад өндөр насны тэтгэвэрт болон чөлөөлөгдсөн, халагдсан алба хаагч гэх мэт/ цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаатай ижил систем, давтамжийн хэт богино долгионы станцыг өргөнөөр ашиглах болсон нь цагдаагийн албаны станцаар дамжиж байгаа мэдээллийг сонсох, сүлжээнд гадны яриа, нэвтрүүлэг давхардах, дахин дамжуулах төхөөрөмжүүдэд нэмэгдэл ачаалал үүсгэж байгаа нь аудитын явцад тогтоогдсон.

Энэ талаар аудитын явцад хийсэн ярилцлагад “2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Сүхбаатарын талбайд “Монголдоо сайхан амьдаръя”

жагсаал, цуглааны үеийн хэв журмын хамгаалалтын үед радио станцын ажиллагаанд давхцал, доголдол үүссэн” гэж дурьдсан байна.

3.3 Радио станцын хангалт хүрэлцээгүйгээс алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ радио станцыг хувиараа худалдан авч, радио засвар үйлчилгээ, тохиргоог цагдаагийн байгууллагад холбооны инженерээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан, халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчаар болон энэ төрлийн ажил үйлчилгээ эрхэлдэг дурын инженер, техникийн ажилтнаар хийлгүүлж байгаа асуудлыг технологийн хувьд хянах боломжгүй нөхцөл байдал үүссэн нь албаны мэдээ, мэдээллийн нууцлал алдагдах, холбогдох хууль тогтоомжууд зөрчигдөх эрсдэлтэй байна.

3.4 Цагдаагийн байгууллагын харилцаа холбооны чиг үүргийн хэрэгжилт, бүтэц, орон тооны өөрчлөлт, алба хаагчдын ажлын ачааллын байдалд дүн шинжилгээ хийхэд үзэхэд цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын бие бүрэлдэхүүн нэмэгдэж, радио станцын хэрэглэгчийн тоо тогтмол өсөж байгаа боловч тус хэлтсийн радио холбоо хариуцсан инженерийн 2 орон тоо хэвээр байгаа нь алба хаагчдын ажлын ачаалал үүсэх шалтгаан болсон байна.

Дээрх радио холбоо хариуцсан 2 ахлах инженер нь ажил үүргийн хуваарийн дагуу төв, орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа техник, хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахаас гадна радио холбоо болон дагалдах хэрэгсэл, тусгай дуут гэрэл дохиог шуурхай засварлах, угсарч суурилуулах, шинэ техник, технологийн судалгаа хийх, албаны үйл ажиллагаанд шаардлагатай төсөл, хөтөлбөр, санал боловсруулах, холбоо харилцааг зохион байгуулах, шаардлагатай техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж дэмжлэг үзүүлэх, инженер, техникч, ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, албан томилолтоор орон нутагт очиж засвар үйлчилгээ хийх зэрэг ажил, үүргийг гүйцэтгэж байна.

Хүснэгт 1

д/д	Үйл ажиллагааны төрөл	2020 он	2021 он
1	Радио холбооны төвд ирүүлсэн засвар	1752	775
2	Төв байрны техник хэрэгслийн дуудлага	1026	2135
3	Хамгаалалтын холбоо зохион байгуулалт	7	15
4	Тусгай үүргийн нислэгийн холбоо зохион байгуулалт	107	112
5	Орон нутагт томилолтоор	2	6
6	Орон нутагт засвар, үзлэг үйлчилгээ хийсэн техник хэрэгсэл	94	282

Энэ мэдээллээс үзэхэд: 2020, 2021 онд радио холбооны төвд ирүүлсэн засварын тоо буурсан үзүүлэлттэй ч орон нутагт засвар үйлчилгээ хийсэн техник хэрэгслийн тоо, хамгаалалтын холбоо зохион байгуулалтын тоо өссөн үзүүлэлттэй байна.

Иймд нэг ахлах инженер жилд дундажаар 1452 удаа засвар үйлчилгээ хийхээс гадна хамгаалалтын холбоог 120 удаа зохион байгуулжээ. /Хүснэгт 1/

3.5. Тус албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтсийн батлагдсан орон тоонд энгийн жолоочийн 1 орон тоо байгаа боловч, Захиргааны удирдлагын хэлтэст үйлчилж байна.

Захиргааны удирдлагын хэлтсийн дарга нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/32 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн албанд ашиглагдах тээврийн хэрэгсэлд хяналт тавих /код 809/ журам”-ын 809.3.28 дахь хэсэгт “Дуудлагын” автомашиныг Автобааз дээр байршуулж, ажлын хэрэгцээ шаардлага гарсан тохиолдолд маягт “Автомашиныг ажилд гаргах захиалгын бүртгэл /ЦБҮАЖ №803.328/”-ыг бүртгүүлж, Автобазын жижүүрийн шалгах механикт 1 хоногийн өмнө мэдэгдэж, ашиглана... гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

Аудитын объектод хамрагдсан Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Холбооны хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагддаг техник хэрэгслийн элэгдэл, технологийн хоцрогдол, хангамж хүрэлцээгүй байгаа нь санхүү, төсвийн нөхцөл байдлаас шалтгаалсан байна.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас хамгаалалтыг зохион байгуулахад учирч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар удирдлагад танилцуулж, радио холбоог шинэчлэх талаар судалгаа, тооцоолол хийж, холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтанд 2014 оноос хойш тасралтгүй хүргүүлсэнээр 2021 онд Америкийн Нэгдсэн улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Моторола” компанийн техник, тоног төхөөрөмжөөр шинэчлэл хийх талаар шийдвэр гаргуулсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдалд аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

4.1 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ашиглагдаж байгаа аналог технологийн радио холбооны техник хэрэгсэл нь 1996 онд суурилуулагдсанаас хойш техник, технологийн шинэчлэлт хийгдээгүй байна.

Энэ төрлийн станцын үйлдвэрлэл зогссон, сэлбэг хэрэгсэл олдоцгүй болсноор уг тоног төхөөрөмжийн электрон элементүүд ашиглалтын явцад муудаж, сүлжээнд гадны яриа, нэвтрүүлэг давхардах, холбоо барих алслалт, ярианы түвшин муудах, дахин дамжуулах төхөөрөмжүүдэд нэмэгдэл ачаалал үүсэх, гэмтэл, саатал гарах нь ихэсч байгаагаас албаны нууцлал алдагдах эрсдэлтэй байна.

Иймд цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй радио холбооны аналог технологийг яаралтай өөрчлөн “IP” сүлжээ ашиглан яриа болон текстэн мэдээ нэвтрүүлэх боломжтой, байршил тогтоох, станцыг зайнаас хаах, нээх, сонсох, удирдах боломжтой болж, ярианы чанар тод, нууцлал

хангагдсан радио холбооны сүүлийн үеийн дэвшилтэт тоон технологид шилжүүлэх шаардлагатай байна.

4.2 Цагдаагийн байгууллагын харилцаа холбооны чиг үүргийн хэрэгжилт, бүтэц, орон тооны өөрчлөлт, алба хаагчдын ажлын ачааллын байдалд дүн шинжилгээ хийхэд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын бие бүрэлдэхүүн нэмэгдэж, радио станцын хэрэглэгчийн тоо тогтмол өсөж байгаа боловч тус хэлтсийн радио холбоо хариуцсан инженерийн 2 орон тоо хэвээр байгаа нь алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, эмх замбраагүй байдлын үед дотоод холбоо сүлжээнд доголдол үүсэх эрсдэлтэй байна.

Иймд алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, тус хэлтсийн албаны шуурхай байдлыг хангах зорилгоор Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн батлагдсан орон тоонд нийцүүлэн Мэдээлэл технологийн хэлтсийн систем хариуцсан ахлах инженер /сул орон тоо/ орон тоог Холбооны хэлтэст радио холбоо хариуцсан ахлах инженерийн 1 орон тоонд, Холбооны хэлтсийн жолооч /энгийн/-ийн 1 орон тоог тус хэлтэст радио холбооны техникч /ахлагч/ орон тоонд шилжүүлэн томилуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх нь зүйтэй.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1. Радио холбооны системийг сүүлийн үеийн дэвшилтэт тоон технологид нэн даруй шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /CAAA, МДШШУА/;

5.2. Тус төвийн Холбооны хэлтсийн алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, тус хэлтсийн албаны шуурхай байдлыг хангах зорилгоор Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн батлагдсан орон тоонд нийцүүлэн Мэдээлэл технологийн хэлтсийн систем хариуцсан ахлах инженер /сул орон тоо/ орон тоог Холбооны хэлтэст радио холбоо хариуцсан ахлах инженерийн 1 орон тоонд, Холбооны хэлтсийн жолооч /энгийн/-ийн 1 орон тоог тус хэлтэст радио холбооны техникч /ахлагч/ орон тоонд шилжүүлэн томилуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх; /ХНХ, МДШШУА/;

5.3. Радио холбооны шинэчлэлтийн хүрээнд шинэ технологи, түүний ашиглалт, засвар үйлчилгээ, бэлэн байдлыг хангах чиглэлээр Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбоо хариуцсан алба хаагчдыг мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад бүрэн хамруулж, үр дүнг тооцох; /CAAA, СГАСХ, МДШШУА/;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Ё.МӨНХЗУЛ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 06-р сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдалд хийсэн дотоод аудит”

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ- ДХАБГ/ҮА-2022/12

Аудитын хугацаа: 2022.05.26- 2022.06.04

Аудитын багийн ахлагч: Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүдэд: Ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, цагдаагийн хошууч Б.Лхагважаргал

НЭГ.ТАНИЛЦУУЛГА:

Тээврийн цагдаагийн алба нь батлагдсан орон тоогоор 4 газар, 15 хэлтэс, 11 тасаг, нийт 640 алба хаагч, ажилтны орон тоотойгоос албаны дарга 1, дэд бөгөөд Замын цагдаагийн газрын дарга 1, газрын дарга 3, Замын цагдаагийн газрын дэд дарга 1, хэлтсийн дарга 15, тасгийн дарга 11, эрүүлжүүлэх саатуулах байрны дарга, эмч 1, ерөнхий жижүүр 4, чиглэлийн ахлах мөрдөгч 2, чиглэлийн ахлах байцаагч 1, чиглэлийн ахлах ажилтан 4, чиглэлийн ахлах мэргэжилтэн 4, чиглэлийн ахлах зохицуулагч 8, ахлах мөрдөгч 19, эрүүгийн ахлах мөрдөгч 4, ахлах мэргэжилтэн 15, ахлах сэтгэл зүйч 1, ахлах байцаагч 6, ахлах зохицуулагч 22, ахлах инженер 1, ахлах нягтлан бодогч 1, аж ахуйн ажилтан 2, нягтлан бодогч 4, инженер 4, жижүүрийн офицер 8, мөрдөгч 23, байцаагч 33, сэтгэл зүйч 1, мэргэжилтэн 10, эргүүлийн офицер 1, зохицуулагч 98, хүний их эмч 4, ахлагч 274, энгийн 19 байгаагаас энэ оны 05 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар албаны газар, хэлтэс, тасагт ахлах мэргэжилтэн 2, ахлах мөрдөгч 2, ахлах зохицуулагч 1, байцаагч 4, мөрдөгч 1, хүний их эмч 1, мэргэжилтэн 1, инженер 1, зохицуулагч 7, ахлагч 15, энгийн 1 нийт 36 орон тоо сул байна.

Тус алба нь ЦЕГ-ын даргын 2018 оны А/208 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн алба болж, мөн газрын даргын 2020 оны А/173, 2021 оны А/14, А/30, А/89, А/136, А/154, А/163, А/314, А/320, тушаалуудаар тус албаны бүтэц, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар тус албаны албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийн гуравт заасан “Хяналт шалгалтын тасаг”-ийн нэршлийг “Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс” 3.1-д заасан “Тасгийн дарга” албан тушаалын нэршлийг “Хэлтсийн дарга” болгон өөрчилж 4 газар, 15 хэлтэс, 11 тасагтайгаар зохион байгуулагдан МУ-ын нутаг дэвсгэрт хөдөлгөөний

аюулгүй байдлыг хангах, Төмөр зам, Нисэх онгоцны буудлын нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Батлагдсан 640 орон тооны 46.1 хувь буюу 295 алба хаагч /офицер 134, ахлагч 161/-ийг Нийслэлийн авто замын хөгжлийн газар 8, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдын зөвлөл 160, Иргэний нисэхийн үндэсний төв 32, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг 95 зэрэг байгууллагуудаас хамтран ажиллах гэрээгээр 50.8 хувь буюу 325 алба хаагч /офицер 197, ахлагч 128/, 3.1 хувь буюу 20 энгийн ажилтнуудыг төсвөөс санхүүжүүлэн ажиллуулж байна.

Алба хаагчийг хүйсийн байдлаар авч үзвэл, эрэгтэй 531 буюу 82.96 хувь, эмэгтэй 73 буюу 11.40 хувь, насны ангиллаар авч үзвэл 20-25 насны 2 буюу 0.3 хувь 25-30 насны 202 буюу 31.56 хувь, 31-36 насны 186 буюу 29.06 хувь, 37-42 насны 194 буюу 30.31 хувь, 43-48 насны 20 буюу 3.1 хувь, боловсролын зэргээр авч үзвэл магистр зэрэгтэй 70 буюу 10.93 хувь, эрх зүйч мэргэжилтэй 366 буюу 57.18 хувь, ажилласан жилээр 5-10 жил ажилласан 150 буюу 23.43 хувь, 11-16 жил ажилласан 185 буюу 28.9 хувь, 17-22 жил ажилласан 94 буюу 14.68 хувь, 28 жил ажилласан 12 буюу 1.8 хувь, тухайн албан тушаалд ажилласан жилээр авч үзвэл 1-2 жил хүртэл ажилласан 84 буюу 13.1 хувь, 3 жил хүртэл ажилласан 26 буюу 5.6 хувь 5 жил хүртэл ажилласан 53 буюу 8.2 хувийг тус тус эзэлж байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, чиг үүргийн давхардал, бүтэц орон тоо, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох” /код 105/ журмын хэрэгжилтийн байдлыг дотоод аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, бүтэц, орон тоотой холбоотой танилцуулга, мэдээлэл болон холбогдох баримт бичгүүд, судалгаануудыг маягтын дагуу гаргуулан авч, судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн зарим алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь дээрх үйл ажиллагаатай биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Захиргааны удирдлагын газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс нь Замын хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын аюултай бүсийн дэглэм, иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцох, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгжүүдэд хүргүүлэх, албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, тушаал, заавар тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг нэгтгэн тайлагнах, гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийх, харьяа нэгжийн үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Мөн албаны даргын дэргэдэх зөвлөлийн хурал, даваа, лхагва, баасан гарагуудад албаны хэмжээнд зохион байгуулагддаг шуурхай хурал болон цагдаагийн ерөнхий газрын дарга, тус албаны даргын тушаалаар байгуулагдсан ажлыг хэсгүүдийн хурлыг зохион байгуулж, албаны үйл ажиллагаа болон, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан даргын А, Б тушаалуудын төслийг боловсруулж, тухай бүр хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дугаартай тушаалаар тус албаны Захиргааны удирдлагын газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс нэртэйгээр хэлтсийн дарга 1, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн 1, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 1, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн 1, мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн 1, мэдээлэл судалгааны мэргэжилтэн 2, бичиг хэргийн эрхлэгч 1, архивч 1, жижүүрийн цагдаа 4 орон тоотойгоор байгуулагдаж, энэ оны А/13 дугаартай тушаалаар хүний нөөц хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн 1, хүний нөөцийн мэргэжилтэн 1, ахлах сэтгэл зүйч 1 орон тоотойгоор байгуулсан. Мөн энэ оны А/124 дугаартай тушаалаар дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэст мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн 1, мэдээлэл судалгааны мэргэжил 2 орон тоог шилжүүлсэн байна.

Дундаж ачаалал: Цагдаагийн ерөнхий газраас 2022 онд дэвшүүлсэн зорилт, хяналтад авч, биелэлт, үр дүнг тооцох, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх баримт бичгийн жагсаалтын дагуу 54 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган тус албаны энэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, командлагчаар батлуулж, уг төлөвлөгөөтэй уялдуулан харьяа 4 газар, 15 хэлтэс, 3 тасгийн нийт 22 нэгжийн гүйцэтгэлийн

төлөвлөгөөг хянаж, албаны даргаар батлуулах ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулдаг.

Мөн энэ оны эхний 5 сард дээд шатны байгууллага, иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудаас ирүүлсэн 2779 албан бичгийг бүртгэлд авч хэрэгжилтийг хангаж, 1446 албан бичгийг төлөвлөн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, удирдлагуудаас ирүүлсэн 48 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж мэдээлэл, тус албаны даргаас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн 58 удаагийн үүрэг, ажлын чиглэлийн төслийг хянаж, бүртгэлд авах, хэрэгжилтэд хяналтыг тавих ажлыг зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, удирдлагуудад 40 удаагийн танилцуулгыг боловсруулан хүргүүлжээ.

Тухайн албан тушаалтан нь 7 хоногт 40 цаг ажиллах ёстой боловч 56 цаг ажиллаж байна. Ажлын цаг ашиглалттай танилцахад өдөрт дунджаар 10 цаг, амралтын “Ням” гарагт тус албаны 7 хоногийн ажлын танилцуулгыг хянахад 6 цагийг тус тус зарцуулж байна.

3.2 Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналтын хэлтэс нь Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулах, тээврийн хэрэгсэл, авто зам, замын байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэлд тавих хяналтын ажлыг төлөвлөн зохион байгуулах, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааны стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсруулах, боловсронгуй болгох, төв орон нутаг дахь цагдаагийн байгууллагын Замын цагдаагийн нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/53 дугаар тушаалаар Техник, замын хяналтын хэлтэс, 2021 оны А/14 дугаар тушаалаар Зам тээврийн хяналт, зохицуулалтын хэлтэс, 2022 оны А/87 дугаар тушаалаар Зам, тээврийн хяналтын хэлтэс нэршилтэйгээр шинэчлэгдэн хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 2, ахлах зохицуулагч 2, зохицуулагч 2, зураглаач оператор 1 гэсэн нийт 8 орон тоотойгоор, 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Нийслэлийн засаг дарга болон Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан ЦЕГ-2021/110 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Нийслэлийн автозамын хөгжлийн газрын Гэрээт замын цагдаагийн тасгийг байгуулж, тасгийн дарга 1, ахлах зохицуулагч 1, зохицуулагч 6 орон тоотойгоор байгуулан тус хэлтсээс удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байгаа бөгөөд одоогоор ахлах зохицуулагчийн 1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд төв, орон нутгийн хэмжээнд зам тээврийн хяналтын чиглэлээр “Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу чимээ илэрхий зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тээврийн хэрэгсэлд хяналт тавих”, “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэр” зэрэг 2 нэгдсэн арга хэмжээ, Мотоцикл, тусгай дуут дохио зэрэг

хэсэгчилсэн арга хэмжээг 4 удаа зохион байгуулжээ.

Өнгөрсөн онд Улсын хэмжээнд замын хөдөлгөөн зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр 75 ажил хийгдэж, тэмдэг 750 тавигдаж, 2562 тэмдгийн засвар арчлалт, 4279 м.кв тэмдэглэлийг тодруулах ажлыг хийлгэж, шинээр баригдсан зам, зам засвар, нөхөөс арчлалтын ажилд 644 удаа хяналт тавьж, “Улиастай-Чойр” чиглэлийн 20.9 км автозам, Олимпын гүүр, “Улаанбаатар Дархан” чиглэлийн автозам зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажилд хяналт тавьж, төв, орон нутгийн цагдаагийн газрын замын цагдаагийн нэгжийг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн Гэрээт цагдаагийн тасгийн алба хаагчид Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан үүргээ биелүүлээгүй буюу Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаар бохирдлын төлбөр, автозам ашигласны төлбөрүүдийг Нийслэл төсөвт төвлөрүүлэх зорилгоор Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Дүүргүүдийн татварын хэлтсийн алба хаагч нартай хамтран 3 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, нийт 10044 жолоочид 542.642.700 /таван зуун дөчин хоёр, зургаан зуун дөчин хоёр мянга долоон зуун/ төгрөгийн торгууль оногдуулжээ.

Улаанбаатар хотын хэмжээнд шинээр байрлуулах 335, арчлалт, засвар хийлгэх 164, хурааж авах 14 тэмдгийн судалгааг байршил, зураглалын хамт гаргаж энэ оны 14-1/248 дугаар албан бичгээр Нийслэлийн замын хөгжлийн газарт хүргүүлсэн байна.

3.3 Замын хөдөлгөөний бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй гадаадын өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчдийн болон жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үеийн хамгаалалт зохицуулалтын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, гудамж замд хөдөлгөөн зохицуулах, хяналт тавих чиглэлээр үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дугаартай тушаалаар Замын хөдөлгөөний хяналтын хэлтэс нэртэйгээр хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 1, ахлах мэргэжилтэн 2 нийт 4 хүний орон тоотойгоор байгуулагдсан.

Мөн даргын 2022 оны А/13 тушаалаар “Замын хөдөлгөөний хяналтын хэлтэс” нэршлийг “Замын хөдөлгөөний бодлого, төлөвлөлтийн хэлтэс” болгон өөрчилсөн.

Дундаж ачаалал: 2022 оны эхний 5 сарын байдлаар нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй гадаадын өндөр дээд хэмжээний зочин төлөөлөгчдийн болон жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, уламжлалт баяр зэрэг 52 удаагийн хамгаалалт зохицуулалт, 30 удаагийн тусгай үүргийн онгоцоор ирсэн үйл ажиллагааг

нэгтгэн зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дэд дарга болон дээд шатны байгууллагаас Замын цагдаагийн газарт ирүүлсэн 33 удаагийн тушаал шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, 256 албан бичиг, зөвлөмж, мэдээллийг харьяа нэгжүүдэд хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллажээ.

3.4 Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс нь Улаанбаатар хотын хэмжээнд явган болон авто замын уулзваруудад нийт 158 удирддаг гэрлэн дохио, 44 цэгт “ССТV” буюу хяналтын камерын тусламжтайгаар замын хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохиог удирдан, замын хөдөлгөөнтэй холбоотой зөрчлийг тухай бүрд нь бүртгэн авч, холбогдох газруудыг шуурхай мэдээ, мэдээллээр ханган замын хөдөлгөөнийг зохицуулж байна.

Тээврийн цагдаагийн албаны дарга, нөгөө талаас “Ачигч автомашинуудын нэгдсэн холбоо” НҮТББ-ын тэргүүн нар 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан 20/02 дугаар хамтран ажиллах гэрээний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ын 9.5, 9.6 дахь хэсэгт заасны дагуу тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн, түр саатуулсан талаарх мэдээллийг иргэнд лавлах утсаар буюу ухаалаг утасны апп, мессеж үйлчилгээгээр дамжуулан хүргэх, тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагын / Тээврийн цагдаагийн албаны Жижүүрийн шуурхай удирдлагын хэлтсээс бусад/ өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэхтэй холбоотой ажил, арга хэмжээг 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс эхлэн Нийслэлийн хэмжээнд хариуцан зохион байгуулж байна.

Бүтэц, орон тоо: Хэлтсийн дарга-1, чиглэлийн ахлах зохицуулагч-1, гэрлэн дохионы зохицуулалт хариуцсан ахлах зохицуулагч-1, телекамерын хяналт хариуцсан ахлах зохицуулагч-1, гэрлэн дохионы зохицуулалт хариуцсан зохицуулагч-5, телекамерын хяналт хариуцсан зохицуулагч-8, бичээч-1 нийт 18 орон тоотой бөгөөд одоогоор телекамерын хяналт хариуцсан зохицуулагчийн 1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд нийслэлийн гудамж замд байрлуулсан хэмжилт хяналтын төхөөрөмж ашиглан, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн нийт 564760 зөрчлийг илрүүлэн, баталгаажуулж бэлэн бус хэлбэрээр 16.479.530.000 /арван зургаан сая, дөрвөн зуун далан есөн мянга, таван зуун гучин мянган/ төгрөгийн торгууль оногдуулсан бөгөөд 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар 393056 зөрчил илрүүлэн баталгаажуулж, бэлэн бус хэлбэрээр 10.659.460.000 /арван сая, зургаан зуун тавин есөн мянга, дөрвөн зуун жаран/ төгрөгийн торгууль оногдуулсан байна.

Удирдлагаас ирүүлсэн хугацаатай 249, хугацаагүй 466 нийт 715 үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, мэдээ, мэдээллийг хүлээн авч, биелэлт, үр

дүнг тооцож ажилласан байна.

3.5 Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын дарга, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хамтран ажиллах гэрээгээр нийслэл хотод Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж дүрэм, журам, холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулах, хөдөлгөөний дэг журмыг сахиулах, зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дугаартай тушаалаар хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 2, ахлах зохицуулагч 4, зохицуулагч 55, цагдаа зохицуулагч 80, 142 орон тоотой бөгөөд 3 зохицуулагч, 6 цагдаа зохицуулагчийн орон тоо дутуу байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын энэ оны 03 дугаартай тогтоолоор замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллах олон нийтийн цагдаагийн орон тоог 90 орон тоогоор нэмэгдүүлж, 54 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж байгаагаас 36 олон нийтийн цагдаагийн ажилтны орон дутуу байна.

Дундаж ачаалал: Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөн зохицуулах, ачааллыг бууруулах чиглэлээр 6 дүүргийн нутаг дэвсгэрт 66 уулзвар гарцыг 2 ээлжээр хяналтад авч, ачааллын үед цагийн менежментийн нэмэгдлээр 51 уулзвар гарцыг хяналтад авч, үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Энэ оны 05 дугаар сарын байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нийт 196.341 жолоочид 3.930.932.073 төгрөгийн бэлэн бус торгууль оногдуулж, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 5 дахь заалтыг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон явсан 283 зөрчил, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 1 дахь заалтыг зөрчиж журамлагдсан 146 зөрчил, Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “Асап” санд бүртгэлтэй 95 этгээдийг саатуулж, зарлагдсан тээврийн хэрэгсэл 25-ыг илрүүлж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүлээлгэн өгч, Замын хөдөлгөөний дүрмийн 14.8 дахь заалт зөрчиж зогссон 10.157 тээврийн хэрэгслийн дүрэм зөрчсөн үйлдлийг фото зураг, дүрс бичлэгээр баримтжуулж зөрчлийг Замын хөдөлгөөний удирдлагын төвд хүргүүлсэн байна.

3.6 Орон нутгийн замын хяналтын хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/154 тоот тушаалаар шинэчлэн баталсан ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтын зорилго, зорилтод заагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг орон нутаг, тууш замын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, 21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн Замын цагдаагийн тасаг/хэсэг/-ийг мэргэжил, арга зүйн удирдлагаар

хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний хяналт, зохицуулалттай холбогдон гарсан хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-д заасны дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын техник, тусгай хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлэх, Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2019-2023)”-т тусгагдсан “Зам, тээврийн ослын тоо, ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэлийг тус бүр 50 хувиар бууруулах, Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах”-аар заасан зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дугаар тушаалаар хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 1, ахлах зохицуулагч 1, зохицуулагч 8, Тууш замын хяналтын тасагт тасгийн дарга 1, ахлах зохицуулагч 1, зохицуулагч 5 орон тоотойгоор ажиллаж байна.

Дундаж ачаалал: Орон нутаг дахь Замын цагдаагийн нэгжийн дарга нарт орон нутгийн замд гарч буй гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх чиглэлээр 40, мотоциклын хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, хөдөлгөөнийг хязгаарлах тухай 3, байнгын хяналтын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, байнгын эзэнтэй байлгах чиглэлээр 12, өвөлжилтийн бэлтгэл хангуулах чиглэлээр 2, хамгаалалт зохицуулалттай холбоотой 9, “Цагийн менежмент”-ийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 7, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, ёс зүйг сайжруулах, иргэд, жолооч нартай хэрхэн харилцах чиглэлээр 5, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллах талаар 6 нийт 82 удаагийн мэдээлэл, үүрэг, ажлын чиглэл хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.

Энэ оны эхний 05 сарын байдлаар орон нутаг дахь Замын цагдаагийн нэгжийн дарга нарт орон нутгийн замд гарч буй гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, “цагийн менежмент”-ийн хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үйл ажиллагааг эрчимжүүлэх, мотоциклын хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр албаны даргаас 22, дэд бөгөөд Замын цагдаагийн газрын даргаас 15, замын цагдаагийн газрын дэд даргаас 4, хэлтсийн даргаас 6 нийт 47 удаагийн мэдээлэл, үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн биелэлт үр дүнг тооцсон байна.

Аймаг дахь цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжүүдийн үйл ажиллагааг шалгах, зам тээврийн хэрэг, ослыг бууруулах, байнгын постын үйл ажиллагааг сайжруулах, замын хөдөлгөөн зохицуулах техник

хэрэгслүүдийн стандартыг хангуулах зорилгоор 2-3 хоногийн хугацаатай 22 удаа хяналт шалгалтыг зохион явуулсан байна.

3.7 Замын цагдаагийн газрын Хамгаалалтын хэлтэс нь Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалт, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын 2021 оны МН-1а/17, А/мн/17 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам”-ын хэрэгжилтийг хангаж, 10 цэгийг хяналтад авч, хамгаалалт, хөдөлгөөн зохицуулалтыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах зохицуулагч 1, хамгаалалтын төлөвлөлт хариуцсан ахлах зохицуулагч 1, ахлах зохицуулагч 4, зохицуулагч 6, цагдаа зохицуулагч 27 нийт 40 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд цагдаа зохицуулагчийн 4 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: Төрийн өндөр албан тушаалтан замын хөдөлгөөнд оролцох үеийн хамгаалалт зохицуулалтад уртасгасан цагаар ажилладаг учраас Хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар 7 хоногт 507 цаг, зохицуулагч нар 7 хоногт 432 цаг, цагдаа зохицуулагч 27 алба хаагч 7 хоногт 1173 цагийн үүрэг гүйцэтгэж байна .

Дээд шатны байгууллага албан тушаалтнаас энэ оны эхний 5 сарын байдлаар 387 албан бичиг, үүрэг даалгавар, хөтөлбөр төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь, мэдээ, мэдээлэл ирүүлснээс хугацаатай 239 албан бичгийн биелэлт үр дүнг тооцсон байна.

3.8 Мэдээллийн технологи, холбооны хэлтэс: Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны «Цагдаагийн байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйл ажиллагаа /код-700/ -ны журам»-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/13 дугаартай тушаалаар Мэдээллийн технологи, холбооны хэлтэс нэртэй болж, хэлтсийн дарга 1, радио холбоо хариуцсан ахлах инженер 1, телехяналтын систем хариуцсан инженер 1, программ хангамж хариуцсан инженер 1, мэдээлэл, холбооны инженер 2, нийт 6 орон тоотой бөгөөд одоогоор программ хангамж хариуцсан инженерийн 1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан мэдээллийн төрөлжсөн сан, системийг бий болгох, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, хяналтын цэг /пост/-ийг камержуулах, хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэхээр 75 санал, 4 чиглэлийн 31 ажлын санал, 25 төсөл, хөтөлбөрийг дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Тус албаны 1500 гаруй техник хэрэгслийн бэлэн байдал, техникийн өдөр тутмын үзлэг, үйлчилгээ, засварыг 4 алба хаагч хариуцаж байгаа нь 1 инженерт 400 гаруй техник, хэрэгслийг хариуцаж, ажлын ачаалал нь өнгөрсөн онтой харьцуулахад 52.8 хувиар өссөн байна.

Дээд шатны байгууллагаас ирүүлсэн 32 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж мэдээлэл, тус албаны даргаас харьяа нэгжүүдэд хүргүүлсэн 22 удаагийн үүрэг, ажлын чиглэлийг бүртгэлд авч хэрэгжилтийг хангаж, 29 танилцуулгыг холбогдох нэгжид хүргүүлсэн.

3.9 Мөрдөн шалгах газрын Зөрчил шалгах хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж тус газарт Зөрчил шалгах нэгжийг шинээр байгуулжээ.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дүгээр тушаалаар хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах байцаагч 1, байцаагч 8 нийт 10 орон тоотойгоос 2 байцаагчийн орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: Энэ оны эхний 5 сарын байдлаар 210 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаж, 14 материалд зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, 10 иргэнийг шүүхээр баривчлуулж, 45 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 196 хүнд 23.500.000 /хорин гурван сая таван зуун мянган/ төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулсан байна.

Мөн хэлтсээс “Цахим замын цагдаа” сайтад иргэд, жолооч нараас замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 258 үйлдлийг гэрэл зургаар баримтжуулсныг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулахаар харьяа дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэс рүү шилжүүлж, шийдвэрлүүлсэн байна.

3.10 Мөрдөн шалгах газрын Мөрдөн шалгах хэлтэс нь Улсын Ерөнхий Прокурорын газраас харьяалал тогтоосон болон Тээврийн цагдаагийн албаны хэмжээнд шалгагдаж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар бүлэг “Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Б/609 дугаартай тушаалаар Тээврийн цагдаагийн албаны бүтцэд өөрчлөлт оруулж, Жижүүрийн шуурхай удирдлагын хэлтсийн 8 мөрдөгчийн орон тоог тус хэлтэст шилжүүлсэн ба өнөөдрийн байдлаар хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, ахлах мөрдөгч 17, мөрдөгч 4, дуудлагын цагдаа 1 нийт 24 орон тоотойгоос 1 ахлах мөрдөгчийн орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд гэмт хэргийн шинжтэй 1228 гомдол, мэдээллийг хүлээн авч, хэрэг бүртгэлтийн 348 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан 304 хэргийг шийдвэрлэсэн, мөрдөн байцаалтын 359 хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулснаас 356 хэргийг 99.1 хувийг

шийдвэрлэсэн байна.

Энэ оны эхний 05 сарын байдлаар нийт 745 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгаснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай 63, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 196, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай 417, бусад газар шилжүүлсэн 5 нийт 681 гомдол, мэдээллийг шийдвэрлэж одоо 64 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй ба нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 91.4 хувийг шийдвэрлэсэн байна.

Урьд сарын үлдэгдэл 28 хэрэг дээр шинээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 196, бусад 20 нийт 244 хэрэгт бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулснаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 51, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай 68, бусад газар шилжүүлсэн 2 нийт 196 хэргийг буюу 80.3 хувийг шалгаж шийдвэрлэсэн. Одоо 48 хэргийн үлдэгдэлтэй байна.

Урьд оны үлдэгдэл мөрдөн байцаалтын 60, шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 207 нийт 267 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, эрүүгийн 245 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлж, хэрэгсэхгүй болгосон 3 нийт 248 хэргийг шийдвэрлэж шалгасан мөрдөн байцаалтын хэргийн 92.8 хувийг шалгаж шийдвэрлэсэн ба одоо 19 хэргийн үлдэгдэлтэй байна.

Сард 3-4 удаа жижүүрийн мөрдөгчийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж, хоногийн хугацаанд нэг мөрдөгч дунджаар 10-15 гэмт хэргийн дуудлага мэдээлэл хүлээн авч маргаааш нь өглөө нь тухайн хүлээн авсан хэрэг материалд шалгалтын ажиллагааг явуулж байна.

Энэ оны эхний 5 сарын байдлаар 1063 хэрэг, материалд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь нэг мөрдөгч дунджаар 49-52 хэрэг, материал шалгасан байна.

3.11 Мөрдөн шалгах газрын Эрүүгийн цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын 1991 оны Б/96 дугаар тушаалаар эзэн холбогдогч нь тогтоогдоогүй зам тээврийн гэмт хэрэг, автомашины хулгайн гэмт хэргийг илрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/208 тоот тушаалаар тус эрүүгийн тасгийг Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах газрын Эрүүгийн цагдаагийн хэлтэс болгож, хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн ахлах мөрдөгч 1, мөрдөгч 7 гэсэн бүтэц, орон тоотойгоор баталжээ.

Дундаж ачаалал: 2022 оны 05 дугаар сарын байдлаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас нийт 39 өргөдөл, гомдол хүлээн авч шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлсэн 26, гэмт хэргийг илрүүлэн мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн 9, харьяаллын дагуу шилжүүлсэн 1, хуулийн хугацаанд үлдэгдлээр шалгагдаж байгаа 3 гомдол, мэдээлэл байна.

Урьд онд үйлдэгдсэн хэрэг бүртгэлтийн 7, харьяаллын дагуу ирүүлсэн 4 нийт 11 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 4 хэргийг шийдвэрлэсэн ба үлдэгдэл 7 хэрэг байна.

Эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байсан оргодол 5, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 66, шүүхээс даалгасан хүн 23, оршин суугаа газраас алга болсон хүн 26, зөрчил үйлдсэн этгээд 12, цогцос 5, тээврийн хэрэгсэл 18, эд зүйл 23, нийт 178 эрэн сурвалжлалтыг олж тогтоожээ.

Нийслэл хотод Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт автомашин хулгайлах гэмт хэргийн шинжтэй нийт 248 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн алба хаагч нартай тухай бүр холбогдож, эрэн сурвалжлах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж нийт 28 тээврийн хэрэгслийг олж тогтоон, 12 гэмт хэргийг илрүүлсэн байна.

Сүхбаатарын талбай болон бусад газарт зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаан, суулт, олон нийтийг хамарсан төр, засгийн байгууллагуудын үйл ажиллагааг эсэргүүцэж, иргэдийг өдөөн турхирсан үйлдлүүдийн талаар 38 мэдээ, мэдээллийг цуглуулж, холбогдох нэгжид шилжүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Интерполын үндэсний товчооны даргын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн баталсан “CARBACK” тусгайлсан нэртэй олон улсын арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2022 оны А/09 дугаартай тушаалаар “Арлын дугаар-2022” нэгдсэн арга хэмжээг 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 22, эрэн сурвалжлах “ASAP” санд тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг үйлдэн эрэн сурвалжлагдаж байсан этгээд 3, алдагдсан тээврийн хэрэгсэл 50 олж тогтоон илрүүлсэн ажлын үр дүнтэй байна.

3.12 Мөрдөн шалгах газрын Жижүүрийн шуурхай удирдлагын хэлтэс нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, Төмөр замын аюултай бүсийн дэглэм, Иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст мөрдөгдөх хууль тогтоомжийг зөрчих гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авах хойшлуулашгүй ажиллагааг шуурхай явуулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, эрэн сурвалжлах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, удирдлагыг мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/14 дугаартай тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах газрын бүтцэд оруулж, хэлтсийн дарга-1, ерөнхий жижүүр-4, жижүүрийн техникийн ахлах мэргэжилтэн-4, жижүүрийн техникийн мэргэжилтэн-4, мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаа-12, жижүүрийн цагдаа жолооч-8, тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны жижүүрийн цагдаа-4 нийт 37 орон тоотойгоор батлагдсан байна.

Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны, жижүүрийн цагдаагийн-3

орон тоог Тээврийн цагдаагийн албаны бусад орон тоо руу шилжүүлж, одоогийн байдлаар нийт 34 орон тоотойгоос жижүүрийн техникийн мэргэжилтэн-1, мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаа-1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: 2021 онд иргэд, аж ауй нэгж байгууллагаас 87247 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн шинжтэй дуудлага 5564, эд материалын хохиролтой зам тээврийн ослын 62608, согтуу жолоочийн мэдээлэл 10553, бусад 7371 дуудлага мэдээлэл хүлээн авсан нь урьд оноос 5.0, замын хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн шинжтэй дуудлага 10.0, эд материалын хохиролтой зам тээврийн ослын дуудлага 6.2 хувиар тус тус өссөн, согтуу жолоочийн мэдээлэл 7.2, бусад дуудлага 5.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 5 сарын байдлаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас 44111 дуудлага мэдээлэл хүлээн авснаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн шинжтэй дуудлага 2446, эд материалын хохиролтой зам тээврийн ослын 30083 согтуу жолоочийн мэдээлэл 10001, бусад 1581 дуудлага мэдээлэл хүлээн авчээ.

Мөн Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтэс тасгийн алба хаагчдын гудамж замд ажиллах үедээ илрүүлсэн /согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцсон 10001, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ автомашин жолоодсон 1578 зөрчлийг бүртгэлд авч, бусад байгууллагаас зарлуулсан 315 тээврийн хэрэгслийг нэгдсэн бүртгэлд бүртгэн авч, зарлан мэдээлсэн байна.

3.13 Төмөр зам дахь цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үндсэн чиг үүрэгтэйгээс гадна Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар Төмөр замын хариуцсан 1115 км төмөр зам дагуух 5 аймаг, 3 дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 16.000 төмөр замчин, жилд давхардсан тоогоор 3,5 сая иргэд болон жуулчдад цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг хуульд заасан хүрээнд хүргэн төмөр замын хэвийн үйл ажиллагааг хамгаалах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих, хамтарсан нийгэмлэгийн өмч хөрөнгийг халдлагаас хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/208 тоот албан тушаал, орон тоо, цол цалингийн зэрэглэл баталсан тушаалаар 6 тасаг, төсөвт 48 офицер, 49 ахлагч, энгийн 8 ажилтан, гэрээт орон тоонд офицер 35, ахлагч 60 ахлагч, нийт 200 орон тоотойгоор ажиллаж байна.

Эрүүгийн цагдаагийн тасгийн харьяанд Замын-Үүд зангилаан дахь хэсэг, Сайншанд зангилаан дахь хэсэг, Дархан зангилаан дахь хэсэг, Сүхбаатар зангилаан дахь хэсэгтэй. Хэсгүүдэд Чиглэлийн ахлах ажилтан-4, хэсгийн төлөөлөгч-2, хэсгийн байцаагч-9, зохицуулагч-1, цагдаа-33 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Тус цагдаагийн газрын төв байр нь Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаагийн нутаг дэвсгэрт байрладаг, бүтцийн хувьд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газарт хамаардаг. Алба хаагчид салбар зам дагуу өртөө, зөрлөгт сууринд ажиллаж, Улаанбаатар хотоос өдөр бүр орон нутгийн 9 чиглэлийн суудлын галт тэргэнд давхардсан тоогоор долоо хоногт 100-102 цагдаагийн алба хаагч 24-48 цагийн үүрэг гүйцэтгэдэг.

Дундаж ачаалал: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/47 тоот тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах баримт бичгийн жагсаалтаас өөрийн байгууллагад хамаарал бүхий 69 ажил, арга хэмжээний биелэлтийг гаргаж, хугацаанд нь холбогдох нэгжид хүргүүлсэн байна.

Шинээр хэрэг бүртгэлтийн 38 хэрэг нээн шалгаж хэрэгсэхгүй болгох саналтай 20, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай 14 хэргийг тус тус Тээврийн прокурорын газарт шилжүүлсэн ба гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санд алба хаагчдаас шивж оруулсан 14139 мэдээлэлд хяналт тавин төвлөрсөн тоо бүртгэлд авчээ.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсүүдээс цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд бүртгэгдэж зарласан оргодол 7, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 67, сураггүй алга болсон хүн 13, шүүхээс даалгасан хүн 50, тээврийн хэрэгсэл 5, хэн болох нь тогтоогдохгүй цогцос 2, зөрчил үйлдсэн этгээд 4-ийг олж тогтоон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсүүдэд хүлээлгэн өгч, эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Одоо 1988-2018 оны хооронд зарлагдсан хэн болох нь тогтоогдоогүй цогцос 17, галт зэвсэг 1-ийг цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд зарлан мэдээлж, хүн амины хэрэгт нээсэн 1, хэн болох нь тогтоогдоогүй цогцосонд нээсэн 13, галт зэвсэг алдагдсан хэрэгт нээсэн 1, нийт 15 мөрдөн сурвалжлах хэрэгт шалгалтын ажиллагаа явуулж байна.

Иргэд байгууллагаас 128 гомдол, мэдээлэл хүлээн авч Монгол улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Зөрчлийн хэрэг нээсэн 60, хуульд заасны дагуу гомдол, мэдээлэл хүлээн авахаас татгалзсан 4, харьяаллын дагуу шилжүүлсэн 57, хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн 33, Баянгол дүүргийн Эрүүгийн анхан шатны шүүхээр 1 холбогдогчийг 20 хоног баривчлуулж, 1 холбогдогчийг торгуулсан, 1 зөрчлийн хэргийг Сэлэнгэ аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлүүлж холбогдогчийг 14 хоног баривчлуулсан ба Зөрчлийн тухай хуулийг зөрчсөн 557 хүнийг 10,657,000 төгрөгөөр торгож шийтгэл оногдуулсан байна.

Эрүүлжүүлэх байранд Нийслэлийн 6 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс хүргэгдэн ирсэн нийт 4574 эмэгтэйг хүлээн авч эрүүлжүүлэн 4001 хүнээс үйлчилгээний төлбөр болох 19,361,050 төгрөгийг хураан авч төрийн сангийн дансанд тушаасан.

3.14 Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс нь Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа газар хэлтсүүд болон “Чингис

хаан”, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал орчимд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/13 дугаар тушаалаар “Ахлах зохицуулагч”-ийн орон тоог “Төлөвлөлт, зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн”, Гэрээт замын цагдаагийн тасгийн “Зохицуулагч” 1 орон тоог “Ахлах зохицуулагч” болгон өөрчлөгдсөнөөр хэлтсийн дарга 1, тасгийн дарга 2, эдийн засгийн ахлах мөрдөгч 1, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 1, ахлах зохицуулагч 1, ахлах мөрдөгч 1, төлөвлөлт, зохион байгуулалт, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 1, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч 1, эрүүгийн мөрдөгч 1, эргүүлийн офицер 1, жижүүрийн офицер 4, мэдээлэл хүлээн авагч-жижүүрийн цагдаа 4, бичиг хэргийн эрхлэгч, бичээч-архивч 1, нягтлан бодогч 1, цагдаа жолооч 2, зохицуулагч 5, цагдаа зохицуулагч 10, эргүүлийн цагдаа 19, үйлчлэгч 1 нийт 58 орон тоотой бөгөөд одоогоор зохицуулагч 2, эргүүлийн цагдаа 1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: Энэ оны эхний 5 сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас нийт 16 өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 10 буюу 62.5 хувь нь гэмт хэргийн, 6 буюу 37.5 хувь нь зөрчлийн шинжтэй байна.

Хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн шинжтэй 10 гомдол, мэдээллийн 4 буюу 40 хувийг шийдвэрлэж 6 буюу 60 хувь нь ажиллагаанд шалгагдаж байна.

Хэрэг бүртгэлтийн 5 хэрэг шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгж буюу 66.6 хувиар өссөн байна.

Нийт шалгасан хэргээс 3 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, одоо ажиллагаанд 2 хэрэг бүртгэлтийн хэрэг шалгагдаж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас нийт 5.620.000 төгрөгийн хохирол учирснаас 390.000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн ба хохирол нөхөн төлүүлэлт 6.9 хувьтай байна.

Цагдаагийн нийтлэг үүргийн хүрээнд 8 хэрэг, зөрчил, Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байгаа гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 2, шүүхээс даалгасан хүн, тээврийн хэрэгсэл 8, оршин суугаа газраасаа алга болсон хүн 1, эд зүйл 3 нийт 14 эрэн сурвалжлалтыг олж тогтоон харьяа цагдаагийн газар, хэлтэст шилжүүлсэн.

Нийт 19585 зөрчил бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 14362 нэгж буюу 3.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан Монгол улсын 19518 иргэн, 67 гадаадын иргэнийг 453.058.500 төгрөгөөр торгож, 4 хүний жолоодох эрхийг 12 хүртэлх хоногоор хасах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гудамж замын хөдөлгөөнд оролцсон 54, жолоодох эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 53 жолоочид бэлэн бус торгуулийн арга авч, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж хуулийн хүрээнд шийдвэрлүүлсэн.

Мөн энэ оны эхний 5 сард дээд шатны байгууллага, иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудаас ирүүлсэн 1018 албан бичгийг бүртгэлд авч, 358 албан бичгийг боловсруулж хүргүүлсэн байна.

Улсын Онцгой комиссын шийдвэрээр гадаад улс орнуудаас Монгол Улсын иргэдээ татан авах 30 удаагийн чартер нислэгээр 3128 иргэн ирэх үеийн хамгаалалт, “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд олон улсын 935, орон нутгийн 1173 нислэг үйлдэгдэх үеэр хамгаалалт, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын зорчих үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах 18 удаагийн хамгаалалтад тус тус хяналт тавьж ажилласан байна.

3.15 Урьдчилан сэргийлэх хэлтэс нь Зам тээврийн болон Төмөр замын аюултай бүс, Иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст үйлдэгдэх гэмт хэрэг, осол, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд төлөвлөн, зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Цагдаагийн ерөнхий газрын даргын А/14 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэс нэртэйгээр байгуулагдаж, хэлтсийн дарга-1, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах зохицуулагч-2, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн-2, Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч-2, цахим хуудас хариуцсан мэргэжилтэн-1, Зураглаач, цагдаа -1, офицер 8, ахлагч 1, нийт 9 орон тоотой ажиллаж байна.

Дундаж ачаалал: Энэ оны 05 дугаар сарын байдлаар зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Уусан бол бүү жолоод”, “Гар утас”, “Гэрлээр анхааруулья”, “Хамгаалах малгай”, “Явган зорчигч-Сургууль орчмын бүс-Хүүхэд” гэсэн нэртэй 10 төрлийн нөлөөллийн ажил арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцжээ.

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 41 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн 13402 ажилтнуудад 38 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Дээд шатны байгууллага, иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудаас ирүүлсэн 587 албан бичгийг бүртгэлд авч, 549 албан бичгийг боловсруулж хүргүүлжээ.

Удирдлагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн хүрээнд 178 удаагийн танилцуулгыг боловсруулж, холбогдох нэгжид хүргүүлжээ.

Тус албанаас “Тээврийн цагдаагийн алба” сайт, цахим хуудас, твиттер мөн “Цахим замын цагдаа” цахим хуудас, “Ангараг” дотоод

хаалттай, группуудийг хөтлөж, Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор долоо хоног, амралтын өдрүүдийн нөхцөл байдлын мэдээ, сэрэмжлүүлэг зэргийг бэлтгэж, өргөн нэвтрүүлгийн 72 телевизэд 173 төрлийн мэдээллийг 324, богино долгионы 13 “FM” радиод 87 төрлийн мэдээллийг 126, албаны болон бусад цахим 112 сайтад 102 төрлийн мэдээллийг 333 удаа тус тус хүргүүлсэн байна.

Тээврийн цагдаагийн албаны цахим хуудсаар иргэд, жолооч нарт нийт 826 мэдээ, мэдээлэл хүргэснийг нийт давхардсан тоогоор 6.443.469 хүн үзсэн байна. Мөн зорилтод 7 нэвтрүүлэг, 21 төрлийн видео контентыг, 4 удаагийн подкаст, ярилцлагыг бэлтгэн иргэд, олон нийтэд цахим хуудсаар хүргэжээ.

3.16 Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /Код-110, 112, 707, 702, 914, 929.31а/ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт шалгалтыг зохион байгуулах, бодлогын баримт бичиг, үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагыг үнэн зөв, бодитой мэдээлээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц, орон тоо: Тээврийн цагдаагийн албаны Хяналт, шалгалтын тасгийн нэршлийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/124 дүгээр тушаалаар Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтэс болгон өөрчилж хэлтсийн дарга-1, хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч-2, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн-2, мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн-1, мэдээлэл судалгааны мэргэжилтэн-1, хөдөлмөр аюулгүй байдлын байцаагч, хүний их эмч-1 нийт 10 орон тоотойгоос хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэний 1 орон тоо дутуу байна.

Дундаж ачаалал: Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /Код-110, 112, 707, 702, 914, 929.31а/ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт шалгалт явуулж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээс гадна, Засгийн газрын “11-11” төвд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан 298 гомдол, хүсэлтийг “Ulaanbaatar ERP” цахим хаягаар хүлээн авч, харьяа нэгжийн дарга нарт харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Тус албаны алба хаагчдын сахилгын мэдээг Цагдаагийн ерөнхий газрын “ICS” санд шивж, сахилгын мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэх, сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг зохион байгуулах, үр дүнг тооцох ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

3.17 Захиргааны удирдлагын газрын Санхүү аж ахуйн тасаг нь Цагдаагийн албаны, Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, заавар, журам, Улсын секторын нягтлан

бодох бүртгэлийн олон улсын стандарт, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн бүртгэл хөтлөх, алба хаагчдын цалин хөлсийг бодож, хууль, заавар, журмын дагуу нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татвар ноогдуулан тайлагнах, эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллогын ажлыг зохион байгуулах, тооцоог бодох, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалтанд бүртгэлээр хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Бүтэц орон тоо: Ахлах нягтлан бодогч бөгөөд санхүү аж ахуйн тасгийн дарга-1, цалин хөлс хариуцсан нягтлан бодогч-1, хөрөнгө бараа материал хариуцсан нягтлан бодогч-1, аж ахуйн ажилтан-1, эд хариуцагч нярав-2, үйлчлэгч-7, цахилгаанчин-1, сан техникч-3 буюу офицер 4, ахлагч 2, энгийн 11, нийт 17 алба хаагчийн орон тоотойгоор ажиллаж байна.

Албаны нягтлан бодогч нарын цалингийн шатлал “Төрийн тусгай 9”, Ахлах нягтлан бодогч бөгөөд санхүү аж ахуйн тасгийн даргын шатлал “Төрийн тусгай 12” шатлалаар цалинжиж байгаа нь бусад албадын ижил албан тушаалын алба хаагчдаас 1 шатлал доогуур байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Тээврийн цагдаагийн албаны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг тодорхой бус, албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулахад үндэслэл болгох ажлын байрны шинжилгээ урьдчилан хийгдээгүйн улмаас бүтцийн нэгжийн алба хаагчдын ажлын ачаалал, чиг үүргийн давхардлыг бүрэн, бодитой тодорхойлох боломж хязгаарлагдмал, хугацаа давчуу байсныг дурьдах нь зүйтэй.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн тус албаны чиг үүргийн давхардлыг арилгах, **бодлого**, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, ажлын уялдаа холбоог хангах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Тээврийн цагдаагийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, орон тооны байдалд аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Тус албаны Дэд бөгөөд Замын цагдаагийн газрын дарга албан тушаалын нэршлийг Замын цагдаагийн газрын дарга болгон өөрчлөх;

Хоёр. Мөн албаны чиг үүргийн давхардлыг арилгах, бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанар, бүтцийн нэгжүүдийн ажлын уялдаа холбоог хангах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Захиргааны удирдлагын газрын дарга албан тушаалыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга болгон өөрчлөх;

Гурав. Мөн албаны Захиргааны удирдлагын газрын дарга болон Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын захиргааны чиг үүргийн давхардлыг арилгаж, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын албан тушаалыг төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан чиглэлийн

ахлах мэргэжилтэн болгож Захиргааны удирдлагын хэлтэст нэгтгэх;

Дөрөв. Тус албаны Замын цагдаагийн газрын Дэд дарга албан тушаалыг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийслэлийн Замын цагдаагийн газрын дарга болгон өөрчилж, түүний эрхлэх асуудлын хүрээнд байсан Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах /гэрээт/ хэлтэс /142 орон тоо/, Замын хөдөлгөөн удирдлагын /гэрээт/ хэлтэс /18 орон тоо/-ийг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүтцэд шилжүүлэх;

Тав. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан ажлын байрны тодорхойлолтоор цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын ангилал, зэрэглэл нь “ТТ 9-10” байхаар тусгасан байх тул тус албаны нягтлан бодогч нарын цалингийн шатлалыг “ТТ-10”, тус албаны бусад чиг үүргийн тасгийн дарга “ТТ-13” шатлалаар батлагдсан байх тул үүнтэй уялдуулан ахлах нягтлан бодогч бөгөөд Санхүү, аж ахуйн тасгийн даргын цалингийн шатлалыг “ТТ-13” болгон өөрчлөх;

Зургаа. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийхээс өмнө байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээг хийн, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, бодит судалгааны дүнд үндэслэн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоонд өөрчлөлт оруулж байх шаардлагатайг анхаарах.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

5.1. Тус албаны Дэд бөгөөд Замын цагдаагийн газрын дарга албан тушаалын нэршлийг Замын цагдаагийн газрын дарга болгон өөрчлөх, мөн албаны Захиргааны удирдлагын газрын дарга албан тушаалыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга болгон өөрчлөх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ЗУГ, ХНХ, ТЦА/;

5.2. Мөн албаны Захиргааны удирдлагын газрын дарга болон Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын захиргааны чиг үүргийн давхардлыг арилгаж, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын албан тушаалыг төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн болгож өөрчлөх асуудлыг шийдвэрлүүлэх /ХНХ, ТЦА/;

5.3 Тус албаны Замын цагдаагийн газрын Дэд дарга албан тушаалыг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийслэлийн Замын цагдаагийн газрын дарга болгон өөрчилж, түүний эрхлэх асуудлын хүрээнд байсан Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах /гэрээт/ хэлтэс /142 орон тоо/, Замын хөдөлгөөн удирдлагын /гэрээт/ хэлтэс /18 орон тоо/-ийг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүтцэд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, НЦУГ, ТЦА/;

5.4 Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан алба хаагчдын цалингийн зэрэглэл, албан тушаалын шатлалыг бууруулахгүй, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарах /ХНХ, ТЦА/;

5.5 Тус албаны нягтлан бодогч нарын цалингийн шатлалыг “ТТ-10”, мөн албаны ахлах нягтлан бодогч бөгөөд санхүү, аж

ахуйн тасгийн даргын цалингийн шатлалыг “ТТ-13” болгон өөрчлөх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /СААА, ХНХ/;

5.6 Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийхээс өмнө байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээг хийн, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, бодит судалгааны дүнд үндэслэсэн байхад анхаарах /ХНХ, ТЦА/;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.МАНЛАЙБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Б.ЛХАГВАЖАРГАЛ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 08-р сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь “Цагаан шонхор” амралтын газрын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит”

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ- ДХАБГ/ҮА-2022/13

Аудитын хугацаа: 2022.07.07- 2022.08.08

Аудитын багийн ахлагч: Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүн: Ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь “Цагаан шонхор” амралтын газар нь Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Жанхайн “Ардгийн ам” хэмээх газарт байрлах бөгөөд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн цагдаагийн газрын эзэмшилд байгаа Хөвсгөл далайн эрэг дээрх 80м2 талбайтай 41.200.000 /дөчин нэгэн сая хоёр зуун мянган/ төгрөгийн балансын өртөгтэй 286.103 /хоёр зуун наян зургаан мянга нэг зуун гурав/ төгрөгийн элэгдэлтэй амралтын барилгыг Цагдаагийн ерөнхий газрын “Сүүж уул” амралтад шилжүүлснийг Төрийн өмчийн хорооны 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 249 тоот тогтоолоор “үндсэн хөрөнгийг бүртгэлд авах” зөвшөөрөл олгосноор балансаас балансад шилжүүлэн, үндсэн хөрөнгийн дансанд орлогод авч, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/74 дүгээр тушаалаар тус сувиллын харьяа “Цагаан шонхор” салбар амралтыг байгуулсан байна.

Уг амралт нь Улаанбаатар хотоос Хөвсгөл аймгийн Мөрөн сум хүртэл 671 км, Мөрөн сумаас Хатгал тосгон хүртэл 100 км, Хатгал тосгоноос Жанхайд байрлах “Цагаан шонхор” амралт хүртэл 25 км, нийт 796 км, Хөвсгөл нуурын хойд эргээс 250 м зайд байрладаг бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт 2 га газар ашиглах 2010/35 дугаартай гэрчилгээ олгогдож, мөн яамны сайдын 2018 оны А/44 тоот тушаалыг үндэслэн газар ашиглах эрхийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай сунгажээ.

Тус амралт нь 2015-2019 он хүртэл бүтээн байгуулалт, тохижилт, сайжруулалтыг хийж, 2019 оны 07 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд анх балансаас балансад шилжин ирэх үед гал тогоо, хоолны заал бүхий 80м² талбайтай барилга 1 ширхэг, Увс, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Ховд аймаг дахь цагдаагийн газруудаас байршуулсан 5 ханатай 6 гэртэй байжээ.

Өнөөдрийн байдлаар тус амралт нь 10.62 метрийн өргөнтэй, 13.94 метрийн урттай төмөр хашаатай, балансаар шилжин ирсэн 5 ханатай гэр 6 ширхэг, байгууллагын дансанд бүртгэлтэй 6 ханатай сийлбэртэй гэр 1 ширхэг, 5 метрийн урттай, 4.1 метрийн өргөнтэй модон шовгор байр 5 ширхэг /1 шовгор байранд нь аж ахуйн, засварын материал хийж агуулахаар ашиглаж байна/, Хаан банкны хандив тусламжаар дүнзэн модоор барьсан 7x8 хэмжээтэй 2 давхар, 2 ширхэг байр нийт 182.348.457 /нэг зуун наян хоёр сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуун тавин долоо/ төгрөгийн өртөг бүхий 15 байранд зуны улиралд нэг ээлжиндээ 40-50 хүн хүлээн авах хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус амралтад зохион байгуулагч 1, тогооч 1, аж ахуйн туслах ажилтан 1 нийт 3 ажилтан жил бүр “Сүүж уул” сэргээн засах амралт, сувиллын алба хаагчдаас томилогдон, орон нутгаас 1 иргэнийг үйлчлэгчээр түр хугацаагаар гэрээгээр авч ажиллуулж байна.

Зохион байгуулагч нь амрагчдын захиалга авах, амрагчдыг хүлээн авах, баримт бүрдүүлэх, төлбөр тооцоо хийх, угаалга, цэвэрлэгээ хийх, тогооч, аж ахуйн туслах ажилтан нарын өдөр тутмын үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж, дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлыг “Сүүж уул” сэргээн засах амралт, сувиллын даргад танилцуулж, шийдвэрлүүлдэг байна.

Үйл ажиллагаа эхлэхээс өмнө ахлах нягтлан бодогчоос төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зааварчилга, зөвлөмж авч, амралтад шаардлагатай бараа материалын судалгаа гаргах, худалдан авч бэлтгэх, амралтын үйл ажиллагаа дууссаны дараа хөрөнгө, бараа материал зарцуулсан тухай тайлан, баримтын бүрдлийг үндэслэн тайлан гаргаж санхүүд өгч, тооцоо нийлж иржээ.

Тогооч нь амрагчдад захиалгаар хоол хийх, амралтын байрууд болон гал тогооны цэвэрлэгээ, ариутгал бусад бүх аж ахуй засвар үйлчилгээний ажлыг хариуцан хийж байна.

Слесарь нь барилга байгууламж, сантехник, цахилгааны бүхий л засвар үйлчилгээг хийж бусад аж ахуйн цэвэрлэгээ, ариутгал, ундны усыг нуурын уснаас цахилгаан насосоор татах, бохир усыг орон нутгийн бохирын машинд төлбөртэйгөөр соруулах зэрэг ажлуудыг хариуцан зохион байгуулдаг байна.

Манаач нь жилийн 4 улиралд тус амралтын тоног төхөөрөмж, бараа материал, барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь “Цагаан шонхор” амралтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

Хөвсгөл аймаг дахь “Цагаан шонхор” амралтын газарт жил бүрийн 06 дугаар сарын 15-наас 08 дугаар сарын 25-ны хугацаанд ажилладаг алба хаагчдын ажлын ачаалал, зохион байгуулалт, үйл ажиллагааг дотоод аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, “Цагаан шонхор” амралтын газрын алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, ажлын ачаалал, ажиллаж байгаа нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчдаас ирүүлсэн материалтай танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Тус амралт нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүрийн 06 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд амрагчдын хүлээн авч үйлчилдэг байна.

2019 онд 2.936.300, 2020 онд 15.406.250, 2021 онд 15.014.100, 2022 онд 21.922.500 төгрөгийн орлоготой ажиллажээ.

3.2 Уг амралтын үйл ажиллагаатай газар дээр нь энэ оны 07 дугаар сарын 07-ны өдөр очиж танилцахад зохион байгуулагч, тогооч, туслах ажилтан, үйлчлэгч гэсэн 4 ажилтантайгаар үйл ажиллагааг эхлүүлсэн байх бөгөөд 2 гэр, 1 модон байр, 1 байшинд амрагч хүлээн авчээ.

Амралтын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулагчаар ажиллаж байгаа “Сүүж уул сэргээн засах амралт, сувилал”-ын маркетинг, олон нийт хариуцсан ажилтан, П.Долгорсүрэн /99222014/-тэй уулзаж ярилцахад, “Одоогоор амрагчид ихээр ирээгүй бөгөөд баяр наадмын үеэр ачаалал ихэсдэг, цагдаагийн алба хаагчдаас өөрийн сонголтоор гэр, шовгор байшин, модон байрнаас шалтгаалан нэг өдрийн 40.000-100.000 төгрөгөөр, иргэдийг 60.000-200.000 төгрөгөөр тооцож амраадаг.

Амралтын үйлчилгээний орлогыг өөрийн хувийн дансаар авч, дараа нь байгууллагын төрийн банкны дансанд шилжүүлдэг, бэлэн мөнгөөр тооцоо хийх тохиолдолд бэлэн мөнгөний орлогын баримт бичиж, нэг хувийн иргэнд өгч, нэг хувийн авч үлдэж, тооцоо нийлдэг, “Хатгал” тосгон

руу замын таксигаар явж, банкнаас байгууллагын данс руу шилжүүлдэг” гэж ярьсан.

3.3 2020 онд “Бидком ХХК”-тай 4.100.500 /дөрвөн сая нэг зуун мянга таван зуун/ төгрөгийн үнийн дүнтэй худалдан авах гэрээ хийж, тус амралтын газрын гал тогооны өрөөнд 1, хоолны заалнаас гэрүүд рүү харсан 1, хүүхдийн талбай руу харсан 1, хаус байр руу харсан 1, хаус нэгдүгээр байрны дээд өнцөгт 2 ширхэг /баруун, зүүн тийш харуулан байрлуулсан/, хаус хоёрдугаар байрны дээд өнцөгт 1 нийт 7 камер суурилуулсан байна.

Камерын хяналтын 21 инчийн дэлгэцийг гал тогооны өрөөнд байрлуулж, 24 цагийн асаалттайгаар үйл ажиллагааг хянадаг боловч баруун талын хэсгийг бүрэн хянах боломжгүй, гэрэл гэрэлтүүлэг хангалтгүй байна.

Цаашид камерын болон гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж, зайнаас хянах, мэдээлэл солилцох системийг ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг “Бидком ХХК”-тай хамтран зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх нь зүйтэй.

3.4 Тус амралтын газрын ажилчдын амрах байр нь 7х5 метр хэмжээтэй 2 давхар модон байшин байх бөгөөд амралтын барилга, байгууламжийг тойруулж барьсан төмөр хашааны гадна баруун урд буланд байрлаж байна.

Уг ажилчдын байрны шал нь газар хөдлөлтийн улмаас 4.5х3.2 метр хэмжээтэй цөмөрч, байшинд гажилт үүссэний улмаас зуух нь галлах боломжгүй болж хүн амьдрахад эрсдэлтэй болсон тул ажилчдын байрыг шинээр амрагчдын байрны хажууд шилжүүлэн барих шаардлагатай болжээ.

Мөн 2 ширхэг давхар модон байрны хананы углуургад гажилт үүссэн, гал тогооны байранд засвар үйлчилгээ хийгдээгүй, наад захын хүнсний зүйлс хадгалах тавиур, ус ундаа хийх хөргөгч байхгүйгээс 5 модон шовгор байрны нэгийг нь агуулахын зориулалтаар ашиглаж байгаа нь хүнсний бүтээгдэхүүн муудах эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

3.5 Нийтийн бие засах газрын бохирын цооног 5 тонн, 2 ширхэг давхар модон байрны бохирын цооног 2 тонны багтаамжтай бөгөөд ачаалалтай үед бохир нь дүүрч 7 хоногт 1 удаа зориулалтын машин хөлсөлж соруулдаг байна.

Амралтын газар ажиллах хугацаанд бохир соруулах зардалд 1.900.000-2.200.000 төгрөгийн зардал гардаг байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь “Цагаан шонхор” амралтын газрын үйл ажиллагааг жигдрүүлэх, ажилчдын ажиллах нөхцөл бололцоогоор хангах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор

аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Тус амралтын газар нь 2019 онд ажиллаж эхэлснээс хойш 55.279.150 төгрөгийн орлого олсон боловч уг амралтын үйл ажиллагааг сайжруулах, барилга байгууламжийг шинэчлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийгдээгүй байна. Иймд амралтын газрын менежментийг сайжруулах, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг онцлогт нь уялдуулан оновчтой, үр өгөөж өгөхүйц зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Мөн амралтын газрын үндсэн хөрөнгөнд тооллого хийж, газар хөдлөлт, цэвдгээс шалтгаалан цууралт, эвдрэл үүссэн барилга байгууламж, бороо усанд норж, дахин ашиглах боломжгүй болсон монгол гэрийн элэгдэл, хорогдлыг тооцож, үндсэн хөрөнгөнөөс хасаж, алба хаагчдын болон амрагчдын ая тухтай байдлыг бий болгох зорилгоор зөөврийн, угсардаг сууцаар үе шаттайгаар хангах асуудлыг судалж, шийдвэрлэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай байна.

Гурав. Амралтын газрын үйл ажиллагааг жигд, хэвийн явуулах, удирдлагаас тавих зайны хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор камерын болон гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж чанаржуулах, зайнаас хянах, мэдээлэл солилцох системийг ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж шийдвэрлэх нь зүйтэй.

Дөрөв. Мөн далайгаас цэвэр ус татах төмөр труба нь зэвэрч, гэмтсэн тул үйл ажиллагаа зогссон тохиолдолд зөөвөрлөн авч явах боломжтой цэвэр усны PPR хуванцар хоолойгоор солих, Улаанбаатар хотоос хүнсний бүтээгдэхүүн болон бусад бараа материалыг автомашинаар татаж байгаа нь эдийн засгийн хувьд зардлыг өсгөж байгаа тул Санхүү, аж ахуйн албанаас дотоод зохион байгуулалт хийж, 2 сарын хугацаанд Автобаазаас автомашиныг жолоочийн хамт ажиллуулж, холбогдох бараа материалыг Хөвсгөл аймгаас авч байхаар зохицуулалт хийх нь оновчтой байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

5.1. Амралтын газрын менежментийг сайжруулах, улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг онцлогт нь уялдуулан оновчтой, үр өгөөж өгөхүйц зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж, үр дүнг тооцох /CAAA/;

5.2. Мөн амралтын газрын үндсэн хөрөнгөнд тооллого хийж, газар хөдлөлт, цэвдгээс шалтгаалан цууралт, эвдрэл үүссэн барилга байгууламж, бороо усанд норж, дахин ашиглах боломжгүй болсон монгол гэрийн элэгдэл, хорогдлыг тооцож, үндсэн хөрөнгөнөөс хасаж, алба хаагчдын болон амрагчдын ая тухтай байдлыг бий болгох зорилгоор зөөврийн, угсардаг сууцаар үе шаттайгаар хангах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /CAAA/;

5.3. Амралтын газрын үйл ажиллагааг жигд, хэвийн явуулах, удирдлагаас тавих зайны хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор камерын болон

гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж чанаржуулах, зайнаас хянах, мэдээлэл солилцох системийг ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах /CAAA/;

5.4. Мөн далайгаас цэвэр ус татах төмөр труба нь зэвэрч, гэмтсэн тул үйл ажиллагаа зогссон тохиолдолд зөөвөрлөн авч явах боломжтой цэвэр усны PPR хуванцар хоолойгоор солих, амралтын газарт 2 сарын хугацаанд Автобаазаас автомашиныг жолоочийн хамт ажиллуулж байх асуудлыг судалж, шийдвэрлэх /CAAA, Автобааз/.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 10-р сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит”

Аудитын төрөл, код: Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ-ХШДАХ/ГА-2022/14

Аудитын хугацаа: 2022.09.07- 2022.10.05

Аудитын багийн ахлагч: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

Аудитын багийн гишүүдэд: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Түмэнбаяр, Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч З.Мөнх-Өлзий.

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/104 дүгээр тушаалаар Аюулгүй байдлын хэлтсийн бүтцэд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл, мэнд сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсгийг 9 орон тоотойгоор байгуулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны А/141 дүгээр тушаалаар Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасаг болгон өөрчилж, тасгийн дарга 1, Хөдөлмөрийн аюулгүй байдлын байцаагч, хүний их эмч 2, чиглэлийн ахлах сэтгэл зүйч 1, ахлах сэтгэл зүйч 1, сэтгэл зүйч 3, сувилагч 1 орон тоотойгоор ажиллаж байна. Дутуу орон тоо байхгүй.

Цагдаа, дотоодын цэргийн 43 анги, байгууллагад 180 эмч, эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн тухай хууль, эмнэлгийн тусламж үйлчилгээний журам, стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаас хүний их эмч 46, бага эмч 94, сувилагч 29, бусад 11 /эх баригч, эм зүйч/ мэргэжилтэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 305, 2009 оны 60, 2020 оны А/352, 2021 оны Б/104, Б/308 тушаалаар сэтгэл зүйчийн орон тоог нэмсэнээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад 56 сэтгэл зүйчийн орон тоо бий болж, өнөөдрийн байдлаар орон нутагт 4,

Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газарт 1 орон тоо дутуу байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/102 дугаар тушаалаар баталсан “Сэтгэл зүйчийн албан тушаалын тодорхойлолт”-д зааснаар удирдах ажилтны удирдлагын болон харилцааны хэв маягийг тодорхойлох, мэргэжлийн нөлөө үзүүлэх, санал асуулга авч, шинжилгээ хийх, алба хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, нийт алба хаагчдыг сэтгэл зүйн дарамт, стрессээс урьдчилан сэргийлэх, тэдэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн судалгаа, сэтгэцэд оношилгоо хийх, сургалт, мэдээлэл хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал хийх, гэрч, хохирогч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх, мэргэшлийн сонгон шалгаруулалт, албан тушаал дэвшихэд нь сэтгэл зүйн ярилцлага хийх гэсэн нийтлэг ажил, үүрэг гүйцэтгэхээр тодорхойлжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/78 дугаар тушаалаар Нийслэлийн цагдаагийн газрын бүтцийн зураглалын “Хяналт, шалгалт, үнэлгээ, ёс журмын хэлтэс” гэснийг “Дотоод аюулгүй байдлын хэлтэс” болгон өөрчилж Хөдөлмөр, аюулгүй байдлын байцаагч, хүний их эмч орон тоо 1, сувилагч 1 орон тоотойгоор ажиллаж байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго:

“Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ:

“Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Алба хаагчид сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх” /код-938/ журам, “Алба хаагчийг сувилах, эрүүл мэндийг нөхөн сэргээх” /код-939/ журмын хэрэгжилтийн талаарх баримт, мэдээлэл, үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт:

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа дүүрэг дэх цагдаагийн газрын удирдлага, холбогдох алба хаагчдад танилцуулж, холбогдох эрх зүйн актууд, алба хаагч руу чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдал, зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнд хүрсэн дүгнэлт болон үйл ажиллагааны танилцуулга, мэдээлэл болон холбогдох баримт бичгүүдийг гаргуулан авч, судалсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа дүүрэг дэх цагдаагийн газрын удирдлага, алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийж, газар дээр нь уг үйл ажиллагаатай биечлэн танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ:

3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.2-т ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулахаар тусгажээ. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг нь ажилтны эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт үед илрүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, улмаар өвчлөгсдийг нарийн мэргэжлийн эмч нарын хяналтанд авч эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах цогц ажиллагаа гэж тодорхойлсон байна.

3.2 Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгаас Цагдаагийн байгууллагын Хүний нөөцийн цахим санд “Сэтгэл зүйн мэдээллийн хэсэг” цэс бий болгож, алба хаагчдын сэтгэл зүйн мэдээллийг цахимжуулж, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, өөрийн сэтгэл зүйн байдлыг хянах, тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлсэнээр, сэтгэл зүйн сорилоор 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 08 сар хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 15745 алба хаагч, ажилтныг сэтгэл санааны байдлын судалгаанд хамруулахад сэтгэл гутралтай 2562, сэтгэл түгшилттэй 2458, стресстэй 2953, нойргүйдэлтэй 2562, ажлаас халшрах хам шинжтэй 2657 алба хаагч байсан бөгөөд судалгааны үр дүнгээр алба хаагч нэг бүрт сэтгэл зүйн зөвлөмжийг хүргүүлж, судалгааны заалт тус бүрээр үнэлгээ дүгнэлт өгөх шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, холбогдох статистик мэдээлэл, тайлан судалгааг цуглуулж үнэлгээ хийсэн байна.

- Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчийг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 оны эхний 8 сарын байдлаар 475 алба хаагч, ажилтныг “Сүүж-Уул” сэргээн засах сувилалд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлжээ.

- Монгол Улсын Боловсролын их сургуулийн “Сэтгэл зүйн үйлчилгээний төв”-ийн оюуны өмчөөр баталгаажсан “Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй индекс”-ийн арга зүйг ашиглах эрхийг худалдан авч, үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байгаа нь сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, цахим мэдээллийн тогтолцоог хөгжүүлэн алба хаагчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, үүрэг гүйцэтгэлийн чадавх, хүртээмжийг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн

аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох олон талт бодлого зохицуулалтын хэрэгжилтийг хамтран шийдвэрлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг 4 жилийн хугацаатай 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр байгуулсанаар, “Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж буй хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн санд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 188 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг цахим мэдээллийн сан”-д бүртгэн, хяналт тавин ажиллаж байна.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран 2022 оны 04 дүгээр сард Баянзүрх, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байр, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх, саатуулах төв, Төв, Дорнод аймаг дахь цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байранд ажиллаж байгаа, дарга-эмч, жижүүрийн эмч, цагдаа, цагдаа-жолооч нарын ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн судалгаа, үнэлгээ хийлгэхэд Эрүүлжүүлэх, саатуулах байранд ажиллаж буй 295 алба хаагчдын 54.6 хувь нь ажлаас халшрах хам шинжийн ямар нэг илрэлтэй, 28.4 хувь нь өндөр болон хэт өндөр үзүүлэлттэй байгаа нь тухайн салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц байдал үүсгэж байна.

- Алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлтэд нас, ажилласан жил, албан тушаалын байдал, ажиллаж буй байгууллагын ялгаанаас үл хамаарч байна.

Цаашид алба хаагчдад чиглэсэн урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх эмчилгээг оновчтой зохион байгуулах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна.

3.3 Нийслэлийн цагдаагийн удирдах газар: Алба хаагч, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн багц”-аар харьяа дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлэг, төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлэг болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагуудтай хамтран харьяа дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс, төвийн нийт 1817 алба хаагч, ажилтныг эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулж, нийт алба хаагч, ажилтнуудаас Дотрын өвчний оноштой 486 буюу 26,7 хувь, Мэс засал, гэмтлийн эмгэг 73 буюу 4 хувь, Зүрх судасны эмгэг 242 буюу 13,3 хувь, Арьс харшилтай 92 буюу 5 хувь, Мэдрэлийн эмгэгтэй 35 буюу 1,9 хувь байгааг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээгээр оношилсон байна.

- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр хамрагдсан нийт алба хаагчдын дийлэнх нь дотрын болон зүрх судасны эмгэг өвчлөл эзэлж байгаа нь алба хаагчид ажил үүргийн байдлаас үүдэлтэй буруу хооллолт, ядаргаа, ажлын байрны стресс, биеийн хөдөлгөөний дутагдал, дутуу нойртой явах, доороосоо даарах, ажлын

ачааллаас үүсэх сэтгэл санааны гутрал, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, хүнд агсамж, тусгай хэрэгсэл биедээ авч явах, илүү цагаар ажиллах, нөхөн амралт эдэлдэггүй зэргээс шалтгаалан бөөрний үрэвсэл, ходоодны архаг үрэвсэл, шархлаа, элэгний үрэвсэл, хатуурал, нурууны эмгэг өөрчлөлт, артерийн даралт ихсэх, гүйлсэн булчирхай, залгиур, төвөнхийн үрэвсэл, нойр булчирхайн үрэвсэл, үе мөчний үрэвсэл, уушгины үрэвсэл, мэдрэлийн ядаргаа, шамбарам, шулуун гэдэсний шархлаат үрэвслээр өвчлөх эрсдэл өндөр байна.

- Цаг үеийн шинж чанартай халдварт болон халдварт бус өвчний талаар алба хаагчдад мэдээлэл хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах зорилгоор “Элэгний В, С вирусын шинжилгээ”, “ДОХ-ын шинжилгээ”, “Вакцины тухай ойлголт, ач холбогдол”, “Коронавируст халдвар /КОВИД-19/ илэрсэн объектыг хамгаалах тур журам”, “Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Тусгаарлан үйл ажиллагаа явуулах түр журам”, “Гэр /амрах байр/ тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах журам”, “Халдварт болон халдварт бус өвчний талаар” сэдэвт сургалтыг харьяа дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдэд танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 418 алба хаагчийг хамруулжээ.

3.4 Алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах, эмчилгээ хийлгэх шаардлагатай алба хаагчдыг эрүүл мэндээ хамгаалах нөхцөл бололцоогоор хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүн, зохион байгуулалт нь дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдэд харилцан адилгүй байна.

Тухайлбал; Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар нь дүүргийн эрүүл мэндийн нэгдсэн төвд алба хаагчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан нэгдсэн тоо мэдээ болон өвчлөлөөр нь ялган ангилж, эмчийн дүгнэлтээр эрүүлжүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулснаар, 2 алба хаагчийг төлөвлөгөөт мэс засалд оруулж эмчлүүлсэн нь сайшаалтай байна.

Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газраас алба хаагчид руу чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, болон ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулсан бол Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар нь алба хаагчдаа урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулаагүй, “Сэргээн засах клиник”, “Сүүж-Уул” амралт, сувилалд зарим алба хаагчдыг амрааснаар өөр тодорхой үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар нь алба хаагчдаа урьдчилан сэргийлэх үзлэгийг Дүүргийн эрүүл мэндийн хоёрдугаар төвд хамруулсан боловч өвчлөлийн зэрэглэл, нэгдсэн тоо, алба хаагчдыг эрүүлжүүлэх төлөвлөгөө зэрэг нотломж, дүгнэлт байхгүй байна.

Дотоод аудитын явцад Төв аймаг дахь цагдаагийн газрын удирдлагаас алба хаагчид руу чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалтай харицуулсан байдлаар танилцахад, тус аймгийн Эрүүл мэндийн нэгдсэн төвтэй хамтран 196 алба хаагч буюу нийт алба хаагчдын 96 хувийг “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц”-ын үзлэг шинжилгээнд хамруулсан, түүний мөрөөр 1 алба хаагчийг зүрх судасны нарийн мэргэжлийн эмчид хандаж, зүрхний титэм судас тэлэх мэс заслын эмчилгээнд, 2 алба хаагчийг “бөөрний дутагдал” оноштойгоор аймгийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт хэвтэн эмчлүүлсэн нь сайшаалтай байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн “Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлыг дараах байдлаар сайжруулалт хийх шаардлагатай гэж дүгнэв. Үүнд:

Нэг. Алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг үр дүнтэй зохион байгуулахын тулд байгууллагын зүгээс алба хаагчдад жилд нэг удаа 3 хүртэл хоногийн цалинтай чөлөөг олгож, алба хаагчид өөрсдөө эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаж, эрүүл мэндийн байдалдаа дүгнэлт хийх, цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар эмчийн зөвлөгөө авах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх боломжийг олгож байх нь зүйтэй.

Хоёр. Нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүд нь алба хаагч, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн багц”-аар харьяа дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлэг, төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран дотооддоо зохион байгуулдаг хэдий ч үзлэгт хамрагдсан алба хаагчдын хувь харилцан адилгүй, үзлэгийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ үр дүнгүй, нэгдсэн дүн мэдээ, тайлангийн хөтлөлт, өгөгдөл хангалтгүй байна. Иймд нийслэлийн хэмжээнд зохион байгуулж байгаа алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгаас нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэж хөтлөх нь илүү үр дүнд хүрэхээр байна.

Гурав. Алба хаагч, ажилтанд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх зориулалтын өрөө, тасалгаа болон амь тэнссэн үед тусламж үзүүлэх эм, хэрэгсэл дутмаг, Эрүүлжүүлэх саатуулах байранд амьсгал, зүрх зогсоход сэхээн амьдруулалт хийх эм, тариа /адреналин, атропин/ байхгүй, хүчилтөрөгчийн баллон эвдэрхий, цэнэггүй хоосон, дефибрилятор

аппаратыг ашиглаж мэдэхгүй, ариутгал халдваргүйтгэл муу хийгддэг / кварц гэрэл ашигласан тэмдэглэл 2022 оны 04 дүгээр сараас хойш хөтлөгдөөгүй/ зэрэг зөрчил дутагдал нийтлэг байгаа нь Эрүүл мэндийн тухай хууль, эмнэлгийн тусламж үйлчилгээний журам, стандартын шаардлага зөрчигдөж байгааг анхаарах шаардлагатай байна.

Дөрөв. Дүүрэг дэх цагдаагийн газрын хэлтсийн алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн Хөдөлмөр, аюулгүй байдлын байцаагч, хүний их эмч, сувилагч нар нь ажлын ачааллаас шалтгаалан газар дээр нь очиж дэмжлэг үзүүлэх, тогтмол шалган зааварчлах, зөвлөх, дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэхээр байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ:

5.1 Алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг үр дүнтэй зохион байгуулахын тулд байгууллагын зүгээс алба хаагчдад жилд нэг удаа 3 хүртэл хоногийн цалинтай чөлөөг олгох асуудлыг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-934/ журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, шийдвэрлүүлэх /ХХ, ДХАБГ/;

5.2 Нийслэлийн хэмжээнд зохион байгуулж байгаа алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгаас нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэж хөтөлж бай/НЦУГ, ДХАБГ/;

5.3 Алба хаагч, ажилтанд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх зориулалтын өрөө, тасалгаа болон амь тэнссэн үед тусламж үзүүлэх эм, хэрэгсэл дутмаг, Эрүүлжүүлэх саатуулах байранд амьсгал, зүрх зогсоход сэхээн амьдруулалт хийх эм, тариа байхгүй, хүчилтөрөгчийн баллон эвдэрхий, цэнэггүй хоосон, дефибрилятор аппаратыг ашиглаж мэдэхгүй, ариутгал халдваргүйтгэл муу хийгддэг зөрчил дутагдал нийтлэг байгаад дүгнэлт хийж, Эрүүл мэндийн тухай хууль, эмнэлгийн тусламж үйлчилгээний журам, стандартын шаардлагын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг танилцуулах /НЦУГ-ын Дотоод аюулгүй байдлын хэлтэс, Дүүрэг дэх цагдаагийн газар/;

5.4 Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн Хөдөлмөр, аюулгүй байдлын байцаагч, хүний их эмч, сувилагч нар нь ажлын ачааллаас шалтгаалан тогтмол шалган зааварчлах, зөвлөх, газар дээр нь очиж дэмжлэг үзүүлэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул орон тоог нэмэгдүүлэх асуудлыг батлагдсан орон тоонд нийцүүлэн судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, НЦУГ/.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:

.....
.....

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ,
МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАМГИНЖАВ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР**

ТАНИЛЦУУЛГА

**Аудитын зөвлөмжийн хэрэгжилт,
үр дүнг тооцсон дүнгийн тухай**

2022 оны 10-р сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

№09

Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал би Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу “Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдал”-д дотоод аудит хийж, 6 заалт бүхий зөвлөмжийг 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн За/4864 дугаартай албан бичгээр Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Санхүү, аж ахуйн болон Тээврийн цагдаагийн алба, Хүний нөөцийн хэлтэст тус тус хүргүүлсэн.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах /код-112/ журам”-ын 112.3.7, 112.3.8 дахь хэсэг, “Цагдаагийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /код-110/ журам”-ын 110.5.2 дахь хэсэг, “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах /код-141/ журмын 141.4.6, 141.6.1 дэх заалтуудыг удирдлага болгон дотоод аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 6 заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнг нэгж тус бүрээр тооцож үзлээ.

Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ирүүлэх тухай 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 6/7802 дугаартай албан бичгийг Санхүү аж ахуйн алба, Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн мэдээллийг хянан үзэж, үр дүнг нэгтгэхэд, нийт 6 заалтаас 5 заалт нь 100 хувь буюу “Маш сайн”, 1 заалт нь 70 хувь буюу “Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн.

Үнэлгээний нийлбэр дүнгийн дундаж үзүүлэлтээр зөвлөмжийн хэрэгжилт 95.0 хувьтай байна.

ДҮГНЭЛТ:

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу “Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдал”-д дотоод аудит хийж, илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр өгсөн 6 заалт бүхий зөвлөмжийн биелэлт, үр дүн 95.0 хувь буюу “Маш сайн” түвшинд хэрэгжсэн байна.

Цаашид цагдаагийн байгууллагын хэмжээнд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийхээс өмнө байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээг хийж, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, бодит судалгааны дүнд үндэслэсэн хангалттай баримт нотолгоотой мэдээллээр удирдлагыг хангаж, шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлж байхад төлөвлөлт, зохион байгуулалт болон хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжүүд анхаарч ажиллах шаардлагатай байна.

САНАЛ:

Цаашид цагдаагийн байгууллагын хэмжээнд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийхээс өмнө байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээг хийж, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж байх талаар Төлөвлөлт, зохион байгуулалтын болон Хүний нөөцийн хэлтэст зөвлөж, танилцуулгыг хүргүүлэх саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

ШИЙДВЭР:
.....
.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
МӨН ГАЗРЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 11-р сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: “Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит”

Аудитын төрөл, код: Үйл ажиллагааны аудит, ЦЕГ- ДХАБГ/ҮА-2022/16

Аудитын хугацаа: 2022.09.29- 2022.11.07

Аудитын багийн ахлагч: Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв” нь иргэдийг сонсох, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн санал, санаачилгын эргэх холбоог сайжруулах тогтолцоог бий болгох, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэх зорилготойгоор ажиллаж байна.

Программын хэрэглэгч талуудад төрийн байгууллага, оператор, иргэн, төрийн байгууллагын удирдлага болон тухайн байгууллагын дээд шатны удирдлага багтаж байгаа бөгөөд тус систем нь иргэдийн санал, хүсэлтийг утас, facebook, биечлэн, киоск, факс, и-мэйл, мессеж, мобайл, веб сайт, вэб чат, дуут шуудан, twitter, APP, веб чат гэсэн сувгаар хүлээн авч бүртгэн, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилладаг ба тухай бүр шаардлагатай тайлан, мэдээ, мэдээллээр Засгийн газар, яам, агентлагуудыг хангаж, өнөөгийн байдлаар тус системд нийт 75 төрийн байгууллага холбогдон иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж, хариу өгч байна.

Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад 2021 онд 740, 2022 оны эхний 09 сарын байдлаар 1630 өргөдөл, гомдол, талархал, саналыг шилжүүлж шийдвэрлүүлсэн нь өмнөх оноос 55.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тус төвөөс ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэх /код 121/”, “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах /код 112/ журам”-д заасны дагуу шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгч ажиллаж байна.

2022 оны III улирлын байдлаар Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс ирүүлсэн өргөдөл, гомдол, саналын шийдвэрлэлт 94.0 хувьтай байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн төв байгууллагаар дамжуулалгүй шууд албад, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлж байгаа нь шийдвэрлэлтэд тавих дотоод хяналтыг саармагжуулах, цагдаагийн байгууллагад ирүүлсэн нийт өргөдөл, гомдол, саналын тоо мэдээг зөрүүтэй тайлагнах, өргөдөл, гомдол шалгаж байгаа алба хаагчдын ажлын үр дүнг дутуу тооцож үнэлэх, иргэдийн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэхэд хугацаа алдах, цагдаагийн төв байгууллагын удирдлагуудыг зөрүүтэй мэдээллээр хангах зэрэг эрсдэл үүсэхээр байна.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Аудитын зорилго

Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулж боловсронгуй болгоход оршино.

2.2 Аудитын цар хүрээ

“Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, учирч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа дотоод хяналтын үр нөлөө, үр дүнг дотоод аудитын объектод хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, хариуцсан алба хаагчид танилцуулж, Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл явц, дэс дараалал болон иргэдээс цагдаагийн байгууллагад 2021, 2022 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээтэй танилцсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчдаас ирүүлсэн материалтай танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1 Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналын тоог 2021 онд 189, 2022 оны эхний 09 дүгээр сарын байдлаар 262 гэж Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн

2/501, 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 2/390 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан байна.

Гэтэл аудитын явцад Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад 2021 онд 740, 2022 оны эхний 09 сарын байдлаар 1630 өргөдөл, гомдол, талархал, саналыг шилжүүлж шийдвэрлүүлсэн болох нь тогтоогдож байна.

Дээрх тооны зөрүүтэй байдал нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн төв байгууллагаар дамжуулж, нэгдсэн тоо бүртгэлд оруулалгүй Нийслэл, аймгийн Засаг даргын тамгын газраар дамжуулан шууд албад, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлж байгаагаас шалтгаалжээ.

Иймд Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг цагдаагийн төв байгууллага руу шилжүүлэн нэгдсэн тоо бүртгэлд оруулж, харьяалах алба, нэгжид шилжүүлж, шийдвэрлэлтэд нь Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс дотоод хяналтыг хэрэгжүүлэн үр дүнг тооцож, цагдаагийн байгууллагад ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоо мэдээнд оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнаж байх нь зүйтэй.

3.2 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /Код 121/” журмын 121.6.2-т “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад иргэд байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдолд судалгаа хийж, нэг асуудлаар давтан ирж байгаа асуудал, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдөж байгаа, түүний шалтгаан нөхцөлийг тогтоож цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авах үүргийг цагдаагийн төв байгууллагын Дотоод хяналт-аюулгүй байдал хариуцсан нэгж, Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан нэгж, Дотоодын цэргийн штаб тус тус хариуцна” гэж заажээ.

Засгийн газрын 2022 оны “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоолын 1.1-т “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв ирүүлсэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудаст сар бүр мэдээлж ажиллах”, 1.2-т “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, Засгийн газрын хуралдаанд сар бүр танилцуулж байх” талаар эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна.

Иймээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах

11-11 төв"-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг цагдаагийн төв байгууллагын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс нэгдсэн бүртгэлд авч, харьяа алба, нэгжид цахим сүлжээгээр шилжүүлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, сар бүр дүн шинжилгээ хийж, цагдаагийн төв байгууллагын удирдлагыг бодит мэдээлээр хангаж байх шаардлагатай байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр баталсан "Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт"-ын 5 дугаар зорилтын 5.3-т "Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох алба, нэгжийн дарга нарт танилцуулж, шийдвэрлүүлэх, хариу хүргүүлэх", 6.3-т "Цагдаагийн төв байгууллагын удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" гэж заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өргөдөл, гомдлын судалгаа, мэдээг гаргах төдийгөөр хязгаарлах бус, цагдаагийн байгууллагатай холбоотой өргөдөл, гомдолд салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч санал, байгууллагын үйл ажиллагааны доголдол, алдаа дутагдлыг арилгах арга зам, олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаарх сэтгэгдэл, хандлага ямар түвшинд байгаа талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, баталгаажсан мэдээллээр удирдлагыг хангаж, шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байхад анхаарах нь зүйтэй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн "Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаанд дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

Нэг. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналын тоог 2021 онд 189, 2022 оны эхний 09 дүгээр сарын байдлаар 262 гэж Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнасан боловч дотоод аудитаар 2021 онд 740, 2022 оны эхний 09 сарын байдлаар 1630 өргөдөл, гомдол, саналыг цагдаагийн байгууллага шалгаж шийдвэрлэсэн байна.

Дээрх тооны зөрүүтэй байдал нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөс цагдаагийн төв байгууллагаар дамжуулж, нэгдсэн тоо бүртгэлд оруулалгүй Нийслэл, аймгийн Засаг даргын тамгын газраар дамжуулан шууд албад, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад

шилжүүлсэнээс шалтгаалсан болох нь тогтоогдсон.

Иймд Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг цагдаагийн төв байгууллага руу шилжүүлэн нэгдсэн тоо бүртгэлд оруулж, харьяалах алба, нэгжид шилжүүлж, шийдвэрлэлтэд нь Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс хяналт тавьж, цагдаагийн байгууллагад ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоо мэдээнд оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнаж байх шаардлагатай байна.

Хоёр. Засгийн газрын 2022 оны “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоолын 1.1, 1.2 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /Код 121/” журмын 121.6.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдолд салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч санал, байгууллагын үйл ажиллагааны доголдол, алдаа дутагдлыг арилгах арга зам, олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаарх сэтгэгдэл, хандлага ямар түвшинд байгаа талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс шилжүүлсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн өргөдөл, гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн шууд хүлээн авч, нэгдсэн тоо бүртгэлд оруулан харьяалах алба, нэгжид шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилладаг үйл ажиллагааны дэс дараалалд оруулвал тус төвөөс алба, нэгж рүү шууд шилжүүлдэг, нэгдсэн өргөдөл, гомдлын бүртгэлд ордоггүй, тоон мэдээг зөрүүтэй гардаг, алба хаагчдын шалгаж шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоог дутуу мэдээлэх, иргэдийн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэхгүй орхигдуулах, иргэдийн нийгмийн оролцоог хангахгүй байх, цагдаагийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бууруулах боломжтой байна.

Иймд Засгийн газрын 2022 оны “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх /Код 121/” журмын хэрэгжилтийг хангах, иргэдийг сонсох, иргэний нийгмийн

оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн санал, санаачилгын эргэх холбоог сайжруулах тогтолцоог бий болгох, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэх зорилтын хүрээнд Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв” болон Цагдаагийн төв байгууллагын суурин телефон /126/ утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч санал, байгууллагын үйл ажиллагааны доголдол, алдаа дутагдлыг арилгах арга зам, олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаарх сэтгэгдэл, хандлага ямар түвшинд байгаа талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх чиг үүргийг хариуцсан мэргэжилтний орон тоог батлагдсан орон тоонд нийцүүлэн судалж, шийдвэрлүүлэх нь зүйтэй.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

5.1. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, саналыг цагдаагийн төв байгууллага руу шилжүүлэн нэгдсэн тоо бүртгэлд оруулж, харьяалах алба, нэгжид шилжүүлж, шийдвэрлэлтэд нь Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсээс хяналт тавьж, цагдаагийн байгууллагад ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоо мэдээнд оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнаж байх /ТЗБХ/;

5.2. “Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн сахилга, ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдолд салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч санал, байгууллагын үйл ажиллагааны доголдол, алдаа дутагдлыг арилгах арга зам, олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаарх сэтгэгдэл, хандлага ямар түвшинд байгаа талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч, үр дүнг мэдээлдэг байх /ЗУГ/;

5.3. Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв” болон Цагдаагийн төв байгууллагын суурин телефон /126/ утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх чиг үүргийг хариуцсан мэргэжилтний орон тоог батлагдсан орон тоонд нийцүүлэн судалж, шийдвэрлүүлэх /ЗУГ/;

5.4. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

**ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ**

Ж.БОЛД

Шийдвэр:

**ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА**

П.ОРОСТОГОО

**ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА**

Д.МАНЛАЙБААТАР

**ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА**

М.АЗЖАРГАЛ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР**

ТАНИЛЦУУЛГА

**“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр
чөлөөлөгдсөн алба хаагчдын шалтгаан нөхцөлийн байдалд дүн
шинжилгээ хийсэн талаар**

2022 оны 10-р сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

№ 1/241

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргаас өгсөн үүргийн дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, Хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Х.Тулга нар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын шалтгаан нөхцөлийн байдал”-д 2022 оны эхний 10 сарын байдлаар дотоод аудит хийлээ.

НЭГ. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын батлагдсан орон тоо 12097 байгаагаас офицер 6035, ахлагч 5533, энгийн 529 байна.

2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар сул орон тоо 1185 /офицер 587, ахлагч 499, энгийн 99/ байгаа нь батлагдсан орон тооны 9.8 хувь байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ын дагуу 6096 орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн судалгааны дүнтэй холбогдуулан орон тооны саналаа жил бүр Төсвийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснээр 2017 онд 46, 2018 онд 16, 2019 онд 123, 2020 онд 320, 2021 онд 950, 2022 онд 512 нийт 1967 орон тоог байгууллагын хэмжээнд нэмэгдүүлсэн байна.

Жил бүр шинээр нэмэгдүүлсэн болон гарцаас үүссэн сул орон тоог дунджаар 1250 орчим алба хаагчаар нөхөн хангалт хийж ирсэн бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 924 алба хаагчийг томилсон.

Цаашид 300 орчим иргэнийг сонгон шалгаруулан авч нөхөн хангалтыг хийхээр төлөвлөсөн боловч өөрийн хүсэлтээр, тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлөгдсөн алба хаагчдын тоо өндөр байгаагаас сул орон тоог нөхөн хангаж чадахгүй эрсдэл үүсээд байна.

Хүний нөөцийн гарцын хувьд 611 офицер, 589 ахлагч, 145 энгийн нийт 1345 алба хаагч цагдаагийн байгууллагаас гарчээ.

Үүнээс өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдсөн 700, түр чөлөөлөгдсөн 18, цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан 324, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн 7, албанаас халагдсан 148, хүүхэд асрах чөлөө авсан 103, Төрийн албаны тухай хуулийн 44.1, 44.2-т зааснаар шилжсэн болон сэлгэн томилогдсон 35, данс бүртгэлээс хасагдсан буюу нас барсан 10 байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 700 алба хаагчдыг насны ангилал, хүйсээр нь авч үзвэл; 18-25 насны 150 буюу 21.4, 26-30 насны 144 буюу 20.5, 31-35 насны 120 буюу 17.1, 36-40 насны 92 буюу 13.1, 41-45 насны 90 буюу 12.8, 46 дээш насны 104 буюу 14.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүйсийн хувьд 547 буюу 78.1 хувь нь эрэгтэй, 153 буюу 21.9 хувь эмэгтэй алба хаагч байна.

Мөн гүйцэтгэж байгаа чиг үүргийн байдлаар нь авч үзвэл; Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиг үүргийн 195 буюу 27.8, Захиргааны чиг үүргийн 149 буюу 21.2, Тээврийн цагдаагийн албаны чиг үүргийн 139 буюу 19.8, Эрүүгийн цагдаагийн алба /эрүүгийн мөрдөгч/-ны чиг үүргийн 73 буюу 10.4, Дотоодын цэргийн чиг үүргийн 59 буюу 8.4, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиг үүргийн 49 буюу 7.0, Мөрдөн байцаах алба /мөрдөгч/-ны чиг үүргийн 25 буюу 3.5, Санхүү, аж ахуйн албаны чиг үүргийн 9 буюу 1.2, Экологийн цагдаагийн алба /шинжээч/-ны чиг үүргийн 2 буюу 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Албан тушаалын байдлаар нь авч үзвэл; газар, хэлтсийн дарга 2 буюу 0.2, тасгийн дарга 2 буюу 0.2, чиглэлийн ахлах 3 буюу 0.4, ахлах 31 буюу 4.4, байцаагч 235 буюу 33.5, цагдаа 305 буюу 43.9, энгийн 122 буюу 17.4 хувийг тус тус эзэлж байна.

Цагдаагийн албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын 213 буюу 30.4 хувийг офицер, 360 буюу 51.4 хувийг ахлагч, 127 буюу 18.1 хувийг энгийн алба хаагчид эзэлж байна.

Тухайн чөлөөлөгдсөн 700 алба хаагчдын ажилласан жилийн байдлыг авч үзвэл;

Сар	Цагдаагийн албанаас чөлөөлөгдсөн алба хаагчдын ажилласан жил /2022 оны эхний 10 сарын байдлаар/						Нийт
	0-5 жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	26-гаас дээш жил	
2022	300	124	64	103	67	42	700

Одоогийн байдлаар өөрийн хүсэлтээр 700 алба хаагч /сард дунджаар 70/ чөлөөлөгдсөн ба өмнөх 4 жилийн дунджаас 50.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Алба хаагчдын өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн шалтгаан, нөхцөлийг тухайн алба хаагчийн өөрийн өргөдөлд дурдсан утгаар авч үзэхэд;

№	Алба хаагчдын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэд дурьдагдсан шалтгаан	Тоо	Хувь
1	Цалин хөлс бага учраас санхүүгийн байдлаа сайжруулах, хувиараа болон гадаад улс руу гарч хөдөлмөр эрхлэх	293	41.9
2	Өөрийн болон ар гэрийн гишүүдийн эрүүл мэндийн шалтгаанаар	203	29.1
3	Гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах	84	12.0
4	Ажлын ачаалал их, гэр бүлдээ зарцуулах цаг хомс	60	8.5
5	Өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломж байхгүй	51	7.3
6	Удирдах албан тушаалтны дарамт их, удирдлагын арга барил хоцрогдсон	8	1.2
Нийт		700	100

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдсөн алба хаагчдын тоог дүүргүүдээр авч үзвэл, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар 45, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар 35, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар 34, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар 27, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар 23, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар 19, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 11, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 6, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 2 байна /Хавсралт 1-ээс үзнэ үү/.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэмжээнд авч үзвэл; Архангай 8, Баян-Өлгий 4, Баянхонгор 1, Булган 7, Говь-Алтай 1, Говьсүмбэр 4, Дархан-Уул 10, Дорноговь 11, Дорнод 12, Дундговь 6, Завхан 13, Орхон 17, Өвөрхангай 7, Өмнөговь 21, Сүхбаатар 2, Сэлэнгэ 17, Төв 21, Увс 3, Ховд 8, Хөвсгөл 3, Хэнтий 11 байна.

Албадаар нь авч үзвэл; Эрүүгийн цагдаагийн алба 73, Мөрдөн байцаах алба 25, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба 195, Тээврийн цагдаагийн алба 139, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба 49, Экологийн цагдаагийн алба 2, Санхүү, аж ахуйн алба 9, Дотоотын цэргийн штаб 59 байна.

ХОЁР. ДҮГНЭЛТ:

2022 оны нөхөн хангалтын төлөвлөлтийн дагуу 924 орон тоонд нөхөн хангалтыг хийсэн хэдий ч шинээр 512 орон тоо нэмэгдэж, 1345 алба хаагч халагдаж, чөлөөлөгдсөнөөс шалтгаалан одоогоор 1185 орон тоог нөхөн бүрдүүлэх боломжгүй байна.

Хүний нөөцийн хэлтсээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын хувийн байдал, албанаас чөлөөлөгдөх болсон шалтгаан

нөхцөлд дүн шинжилгээ хийгээгүй, ирээдүйд учирч болзошгүй хүний нөөцийн эрсдэлүүдийг оновчтой тодорхойлж, хариу арга хэмжээг төлөвлөөгүй, гол хүний нөөцийн эрсдэлийг тодорхойлох “дата өгөгдөл” болсон хүний нөөцийн цахим сангаас зарим шаардлагатай мэдээллүүд гарах боломжгүй, ачаалал ихсэх үед гацалт, доголдол үүсдэг зэрэг нөхцөл байдлууд дүн шинжилгээ хийх явцад тогтоогдсон.

Иймд хүний нөөцийн орц, гарцын байдалд дүн шинжилгээг улирал тутам хийх, ирээдүйд учирч болзошгүй хүний нөөцийн эрсдэлүүдийг дата өгөгдөлд үндэслэн оновчтой тодорхойлж, хариу арга хэмжээг урт болон богино хугацаатайгаар төлөвлөж, биелэлт үр дүнг тооцдог байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын 293 буюу 41.9 хувь нь “цалин хөлс бага учраас”, 203 буюу 29.1 хувь нь “өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өвчнийг эмчлүүлэх”, 84 буюу 12.0 хувь нь “гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах”, 60 буюу 8.5 хувь нь “ажлын ачаалал их, гэр бүлдээ зарцуулах цаг хомс”, 51 буюу 7.3 хувь нь “өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломж байхгүй учраас”, 8 буюу 1.2 хувь нь “удирдах албан тушаалтны дарамт их, удирдлагын арга барил хоцрогдсон учраас” гэсэн шалтгаанаар чөлөөлөгджээ.

Алба хаагчдын цалин, хөлсийг өнөөгийн инфляц, үнийн өсөлтэй уялдуулан бусад чиг үүргийн байгууллагууд /шүүх, прокурор, АТГ, ТЕГ, ТТХГ/-тай ижил хэмжээнд тогтоож өгөөгүй, алба хаагчдын болон тэдний ар гэрийн гишүүдийн эрүүл мэндийн хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, ажил, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө сулд, алба хаагчдаас өөрийгөө хөгжүүлэх, гадаад, дотоодын их дээд сургуульд хувийн зардлаар суралцах боломжийг бүрдүүлээгүй, байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ хийж, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, ажил, үүргийн давхардлыг арилгахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлээгүй, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, алба хаагчдыг сэдэлжүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн тодорхой бус зэрэг нөхцөл байдлууд нөлөөлсөн гэж үзэж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 5 хүртэл жил ажиллаж байгаад чөлөөлөгдсөн 300 алба хаагч нь нийт чөлөөлөгдсөн алба хаагчдын 43.0 хувийг эзэлж байгаа нь шинээр томилогдсон алба хаагчдыг сурган дадлагажуулах, байгууллагын соёлд төлөвшүүлэх, тэдний нийгмийн баталгааг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах шаардлагатайгаас гадна албанд анх орж байгаа алба хаагчдын хувьд цалингийн хэмжээ нь нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд хүртээмж багатай байна гэж үзэхээр байна.

Цагдаагийн байгууллагын захиалгаар дотоод болон гадаадын цагдаагийн сургуульд суралцаж төгссөн, эрүүгийн мөрдөгч, мөрдөгчөөр ажиллаж байгаад халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчдын эзлэх хувь

жилд дунджаар 10 хувиас их байгаа нь гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээлэл, албаны нууцлал алдагдах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэхээр байна.

Цагдаагийн албанаас өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдсөн алба хаагчдын тоогоор хамгийн их байгаа нь Автобааз 38, Дотоодын цэргийн 805 дугаар анги 27, Нийслэлийн цагдаагийн удирдах газар 26, Дотоодын цэргийн 810 дугаар /гэрээт/ тусгай салбар 24, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар, Төв аймаг дахь цагдаагийн газар тус бүр 21, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс 20, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс 17, Сэлэнгэ, Орхон аймаг дахь цагдаагийн газар 17 байна /Хавсралт 1-ээс үзнэ үү/.

ГУРАВ. САНАЛ:

Цагдаа, дотоод цэргийн байгууллагаас алба хаагчид өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх болсон шалтгаан, нөхцөлийг арилгах, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх дараах ажил, арга хэмжээний саналыг танилцуулж байна. Үүнд:

Нэг. Хүний нөөцийн орц, гарцын байдалд дүн шинжилгээг улирал тутам хийх, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний урт болон богино хугацааны төлөвлөлтийг гаргаж, биелэлт үр дүнг тооцдог байх /ЗУГ, ХНХ/;

Хоёр. Алба хаагчдын цалин, хөлсийг өнөөгийн инфляц, үнийн өсөлтэй уялдуулан бусад чиг үүргийн байгууллагууд /шүүх, прокурор, АТГ, ТЕГ, ТТХГ/-тай ижил хэмжээнд тогтоох, жигд нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх /СААА, ЗУГ/;

Гурав. Алба хаагчдын болон тэдний ар гэрийн гишүүдийн эрүүл мэндийн хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх /ЗУГ, ДХАБГ/;

Дөрөв. Алба хаагчдаас өөрийгөө хөгжүүлэх, гадаад, дотоодын их дээд сургуульд хувийн зардлаар суралцах боломжийг бүрдүүлж, байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлэх /ЗУГ/;

Тав. Хүний нөөцийн хувьд байнгын дутуу орон тоогоор ажиллаж байгаа нь цагдаагийн нийт бие бүрэлдэхүүнд хэт их ачаалал, ажлын цагийн хэтрэлт, алба хаагчдад сэтгэл зүйн дарамт үүсгэж байгаад анхаарч чиг үүргийн давхардлыг арилгах, зохиомол ачааллыг бууруулах, техник технологийг оновчтой шийдлийг үйл ажиллагаандаа ашиглаж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх /ЗУГ/;

Зургаа. Мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага сул, сахилга, ёс зүй, харилцааны шаардлага хангаагүй, алба хаагч нартаа өөрийгөө ойлгуулж чаддаггүй удирдах албан тушаалтан томилогдсоноор ажлаа буруу зохион байгуулах, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдөхгүй байх, албаны нэр хүндийг унагах, алба хаагчдад дарамт шахалт үзүүлэх,

зохиомол ажлын ачаалал үүсгэх эрсдэлтэйг анхаарч чадахуйн /мерит/
зарчмыг баримтлан сонгон шалгаруулалтаар удирдах ажилтныг томилох
ажлыг хэвшүүлэх саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР:

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

МӨН ГАЗРЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2022 оны 11-р сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн нийцлийн аудит.

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагаас түүвэрлэн авсан 25 төсөвт нэгж.

Аудитын объект: Дээрх 25 /төсөвт/ нэгжийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан 2022 оны эхний хагас жилийн мэдээлэл.

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ-ДХАБГ/НА-2022/15

Аудитын хугацаа: 2022.09.26-2022.11.22

Аудитын багийн ахлагч: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал.

Аудитын багийн гишүүн: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул, цагдаагийн ахмад Э.Анхчимэг.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/” журам болон бусад холбогдох эрх зүйн акт, баримт бичгээр Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төсөв санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үйл ажиллагаа зохицуулагддаг.

Цагдаа, дотоодын цэргийн 67 анги, байгууллагаас төсөвт 54 байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж www.shilendans.gov.mn шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулж, Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргэж ажилладаг.

Дээрх байгууллагууд Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 6 төрлийн мэдээллийг жил, хагас жил, сар бүр, тухай бүр, 7 хоног тутам гэсэн хугацааны давтамжтайгаар байршуулдаг.

Дотоод аудитын явцад мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд Цагдаа, дотоодын цэргийн 54 байгууллага 54

улирлын тайлан илгээж, тайлан илгээлт 100 хувь, шилэн дансны нэгдсэн цахим системд 4050 мэдээллийг мэдээлэхээс 100 хувь мэдээлжээ.

Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд энэ оны эхний хагас жилийн байдлаар нэг нэгж 16 төрлийн мэдээг давтамжтайгаар 75 удаа, системийн хэмжээнд нийт 4050 мэдээллийг байршуулахаас хугацаанд нь 4026, хугацаа хоцроон байршуулсан 24 мэдээ байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу аудитын хамрагдах хугацаанд /2022 оны эхний хагас жилээр/ цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын шилэн дансны мэдээлэл хариуцсан 59 албан тушаалтнаас нэгдсэн системд 16 төрлийн мэдээллийг байршуулж, олон нийтэд тайлагнасан байна.

Хүснэгт 1

д/д	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Мэдээлэл оруулах эрхтэй хэрэглэгчийн тоо	Хуулийн үйлчлэл
1	Цагдаагийн ерөнхий газар /төсөвт байгууллага/	54	59	3.1.1
	Нийт	54	59	

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.4 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийж, дүнг цагдаагийн байгууллагын удирдлагад танилцуулан мэдээлээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллагад хүргэж, төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулахад чиглэгдсэн.

2.2 Аудитын хамарсан цар хүрээ

Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагаас түүвэр сорилын аргаар 25 төсөвт нэгжийн 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 06 сарын 30-ны өдрийг дуусталх хугацааны Шилэн дансны нэгдсэн <https://shilendans.gov.mn/> цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хамруулсан.

2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ Шилэн дансны тухай хуулийн 3, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогчид болон холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судлах, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийж, нотломжийг цуглуулж, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

ГУРАВ.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитад хамрагдсан 25 нэгжийн шилэн дансны цахим хуудасны 3 цэсэнд байршуулсан мэдээллийг тулгаж үзэхэд дараах асуудлууд илэрсэн. Үүнд;

3.1 “Төсөв гүйцэтгэл” цэсний төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт болон шалтгааны тайлбарыг 3 байгууллага бүрэн мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний шийдвэрийн хуулбарыг 16 байгууллага дутуу мэдээлсэн. Тухайлбал:

а/Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт, шалтгааны тайлбарыг Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн цагдаагийн газар 1-6 дугаар сар, 1 дүгээр улирал, эхний хагас жилийн байдлаар, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Сум дундын цагдаагийн хэлтэс 1-6 дугаар сар, 1-2 дугаар улирал, эхний хагас жилийн байдлаар мэдээлээгүй;

б/Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийн шийдвэрийн хуулбарыг /гэрээ, захирамж, батлагдсан хуваарь гэх мэт/ Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон аймгийн цагдаагийн газар, Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сумын Сум дундын цагдаагийн хэлтэс гэсэн 16 байгууллага тайлант хугацааны зарим саруудад дутуу байршуулсан зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

3.2 “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” цэсний хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 3 байгууллага, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээг 8 байгууллага мэдээллийг бүрэн байршуулаагүй, мөнгөн дүнг зөрүүтэй, тухай бүр байршуулаагүй бөөн дүнгээр хугацаа хоцроож байршуулсан.

а/Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг Баян-Өлгий, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар нь цахим тендерийн мэдээллийг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын цагдаагийн хэлтэс нь тендер шалгаруулалтын мэдээллийг оруулаагүй;

б/Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн хэсэгт Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар нь “Эрчим Баян Өлгий” ХХК-нд шилжүүлсэн 1.7 сая төгрөгийн мөнгөн дүнг буруу мэдээлсэн, Өвөрхангай аймгийн цагдаагийн газар дээрх мэдээллийг сар бүр мэдээлээгүй 6 дугаар сард бөөн дүнгээр, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын цагдаагийн хэлтэс нийт 206 мэдээллийг

байршуулаагүй байгаа нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан "... мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д заасан "...тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн зарчмыг тус тус баримтлаагүй.

3.3 "Бусад" гэсэн бүлгийн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд үнэлгээний хорооны дарга, гишүүдийн мэдэгдэлийг байршуулсан боловч уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар захиргааны шийдвэр гаргах, хяналт шалгалт хийх, гэрээ байгуулах, хэлэлцэх, гэрээ дүгнэх, түүнд бэлтгэхэд оролцсон албан тушаалтны гаргасан мэдэгдлийг 23 байгууллага дутуу болон мэдээлээгүй зөрчил түгээмэл байна.

Мөн "...бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэх аливаа шийдвэр" гэсэн мэдээлэлд 13 байгууллага "байхгүй" гэсэн утгыг оруулсан, бүрэн мэдээлээгүй нь хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан "...мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" зарчмыг баримталж ажиллаагүй байна.

ДӨРӨВ.ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын мөрөөр "Шилэн дансны мэдээллийг хугацаа алдаж байршуулсан 12 нэгжид сануулж, цаашид уг зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарах" чиглэлээр 3 заалт бүхий зөвлөмжийг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар тооцож үзэхэд 80.0 хувийн биелэлттэй байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

5.1 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд шилэн дансны цахим системд бүрэн хамрагдаж мэдээллийг цахимаар хуульд заасан мэдээллийг хугацаа хоцролттой хэдий ч олон нийтэд мэдээлсэн байна.

5.2 Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим"-ыг баримтлаагүй, 6 дугаар зүйлийн зарим заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- "Төсөв гүйцэтгэл" цэсний төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт болон шалтгааны тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний шийдвэрийн хуулбарыг дутуу мэдээлсэн;

- "Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт" цэсний хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн

нэр, хаягийн мэдээг бүрэн байршуулаагүй, мөнгөн дүнг зөрүүтэй, тухай бүр байршуулаагүй бөөн дүнгээр хугацаа хоцроосон;

-“Бусад” гэсэн бүлгийн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар “захиргааны шийдвэр гаргах, хяналт шалгалт хийх, гэрээ байгуулах, хэлэлцэх, гэрээ дүгнэх, түүнд бэлтгэхэд оролцсон албан тушаалтны гаргасан мэдэгдэл”-ийг дутуу байршуулсан, мэдээлээгүй зөрчил түгээмэл гарсан.

-“...бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, емч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэх аливаа шийдвэр”-ийг байршуулахдаа “байхгүй” гэсэн утгыг оруулсан, мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

5.3 Өмнө хийгдсэн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчил давтагдан гарсаар байна.

5.4 Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн дүгнэхэд байгууллагуудаас аудитын хамрагдсан хугацаанд Завхан аймгийн цагдаагийн газар Шилэн дансны тухай хууль, журмын дагуу хугацаандаа чанартай, бүрэн гүйцэтгэсэн байна.

Цаашид дотоод аудитад хамрагдсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагууд шилэн дансны нэгдсэн “<https://shilendans.gov.mn>” цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа холбогдох хууль, эрх зүйн акт, дээд шатны байгууллагаас хүргүүлсэн зөвлөмж, зааварчилгааг баримтлах, мэдээллийн бүрэн эсэхийг сайтар хянаж, цаг хугацаанд нь байршуулах шаардлагатай байна.

ЗУРГАА.САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дараах санал, зөвлөмжийг танилцуулж байна. Үүнд:

6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг стандартын дагуу, үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх /ЦДЦАБ/;

6.2 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон бүрэн, чанартай гүйцэтгэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах /СААА/;

6.3 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд захиргааны шийдвэр гаргах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, дүгнэх, хэлэлцэх, бэлтгэх, түүнд оролцсон албан тушаалтны мэдэгдлүүдийг байршуулж хэвших, мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан тохиолдол илэрсэн нөхцөлд заавал мэдээлж байх /ЦДЦАБ/;

6.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн олон төрлийн мэдээлэл нэг дор байршуулсан нь зарим байгууллагад ойлголтын зөрүү гарч төсөв, өмч хөрөнгө зарцуулсан шийдвэр мэдээлэгдэхгүй орхигдох зөрчил үүсэж байгаад анхаарч төсөв хөрөнгө зарцуулсан шийдвэрийг бүрэн мэдээлж байх /ЦДЦАБ/;

6.5 Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын шилэн дансны нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт мэдээллийг байршуулахдаа дансны хуулга, анхан шатны баримт, мөнгөн гүйлгээний журналтай тулгалт хийж хэвших /ЦДЦАБ/;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД

Шийдвэр:
.....
.....

ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.МАНЛАЙБААТАР

ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Ё.МӨНХЗУЛ

ЦАГДААГИЙН АХМАД Э.АНХЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,

Цахим шуудан: info@police.gov.mn,

Цахим хаяг: www.police.gov.mn

2022.11.30 № 3/427

танай _____-ны № _____-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЦОЛМОН ТАНАА**


Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны жилийн эцсийн эрсдэлийн үнэлгээний тайланг хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 26 хуудастай.

ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

П.ОРОСТОГОО



1522 07 6362

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗАР



ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД
2022 ОНД ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР
ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН



**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД
2022 ОНД ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 12-р сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

**НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/141 дүгээр тушаалаар Аюулгүй байдлын хэлтэс, Хяналт, шалгалт, дотоод аудитын хэлтэс, Төрийн нууцын хэлтсийн гүйцэтгэх, чиг үүрэг, бүтэц, орон тоог нэгтгэн Дотоод хяналт-аюулгүй байдлын газар байгуулагдаж газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч 1, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч 4 байхаас 1 алба хаагчийн орон тоо сул байна.

Дотоод аудит хариуцсан алба хаагчид нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн хэрэгжилтэд нийцлийн, гүйцэтгэлийн, үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод аудит хийх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайн оны “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аудитын төлөвлөгөө”-г боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн хянуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцсон.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах” /код- 141/ журмыг шинээр батлуулан мөрдөн ажиллаж байна.

Тус газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн болон ахлах байцаагч нараас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 3, Дэд даргын тушаалаар 4 ажлын хэсэгт орж ажилласан ба, 5 өргөдөл шалгаж, 11 албаны шалгалт явуулж, төлөвлөгөөт, хэсэгчилсэн болон гүйцэтгэлийн 8 шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан байна.

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө”-нд 15 ажил, арга хэмжээ тусгаж хэрэгжүүлснээр биелэлт 98.0 хувьтай байна.

Төлөвлөгөөт 9 дотоод аудитыг хэрэгжүүлж, дотоод аудитад хамрагдсан нэгжүүдэд 43 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна. Үүнд;

-“Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга байгууламжийн ашиглалт, насжилтын байдал”,

-“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт”,

-“Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагаа”,

- “Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Нарстай дахь хээрийн сургалт дадлагын төвийн үйл ажиллагаа”,

-“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдал”,

-“Орон нутгийн замын хөдөлгөөний соёл-2021 арга хэмжээний хэрэгжилт”,

-“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт”

-“Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь “Сүүж-уул-2” амралтын газрын үйл ажиллагаа”

-“Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдал”

-“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдал” сэдвээр нийт 10 дотоод аудитыг хэрэгжүүлсэн. Үүнд:

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус 9 дотоод аудитыг хэрэгжүүлж, дотоод аудитад хамрагдсан нэгжүүдэд 38 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж биелэлт, үр дүнг тооцон ажилласан. Үүнд:

- “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл”,

- “Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаа”,

- “Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”,

- “Өмнөговь аймгийн цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”,

- “Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал”,

- “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдал”,

- “Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдал”

- “Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаа”

- “2022 оны эхний 10 сарын байдлаар Цагдаа, дотоодын цэргийн

байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын шалтгаан нөхцөлийн байдал” сэдвээр төлөвлөгөөт бус 9 дотоод аудитыг хэрэгжүүлсэн.

ХОЁР. БУСАД АЖИЛ

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас 2021, 2022 онд хэрэгжүүлсэн дотоод аудитын тайлангийн эмхэтгэлийг цахим хэлбэрээр бэлтгэн гарган, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод сүлжээнд байршуулах ажлыг зохион байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 14/1055, Үндэсний аудитын газарт 2022 оны 14/1054 дугаартай албан бичгээр хүргүүлж, тайлагнасан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн 2022 оны 3 дугаар улирлын хэрэгжилтийн тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 3/364 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хэмжээнд дотоод аудитын олон улсын стандартыг хэрэгжүүлсэн байдал, дотоод аудитын ажлын үр дүнгээрээ 2017 оноос хойш манлайлан ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дотоод аудит хариуцсан 5 алба хаагчийг Монголын Үндэсний Дотоод Аудиторын холбооноос зохион байгуулсан “Аудитын тайланг үр дүнтэй бичих нь” сэдэвт мэргэшүүлэх сургалтад бүрэн хамруулсан.

Тус газрын дотоод аудит хариуцсан алба хаагчдаас 2022 онд “Дотоод аудитын ойлголт”, “Эрсдэлийн удирдлага”, “Шилэн дансны хуулийн хэрэгжилт” сэдвээр цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 8 нэгжид 16 цагийн сургалтыг зохион байгуулж, 180 алба хаагчийг хамруулсан байна.

Дотоод аудитын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор салбарын эрдэмтэн судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, яам, цагдаагийн байгууллагын холбогдох алба хаагчдыг оролцуулан 40 минутын мэдээлэл сурталчилгааны нэвтрүүлгийг бэлтгэж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын энэ оны 10 дугаар сарын 10-ны өдрийн баталсан “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу энэ оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 28-ны өдрүүдэд “Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн цэрэг, цагдаагийн цол олголтын үйл ажиллагаанд дотоод аудит хийх” үүрэг

бүхий ажлын хэсэгт 2 алба хаагч ажиллаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа дотоод аудитын ажлын сайн туршлага, хууль эрх зүй, дотоод журам, олон улсын стандартын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар танилцуулж ажилласан.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөний биелэлт 98.0 хувьтай хэрэгжсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус дотоод аудитыг хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

Дотоод аудитын мөрөөр өгсөн 81 заалт бүхий 19 зөвлөмжийн биелэлтээс хугацаанд нь 15 зөвлөмжийн биелэлтийг тооцоход 85.0 хувьтай байна.

Тус газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн болон ахлах байцаагч нараас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 3, Дэд даргын тушаалаар 4 ажлын хэсэгт орж ажилласан ба, 5 өргөдөл шалгаж, 11 албаны шалгалт явуулж, төлөвлөгөөт, хэсэгчилсэн болон гүйцэтгэлийн 8 шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах” /код-141/ журам”-ыг шинээр батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дотоод аудит хариуцсан 5 алба хаагчийг Монголын Үндэсний Дотоод Аудиторын холбооноос зохион байгуулсан “Аудитын тайланг үр дүнтэй бичих нь” сэдэвт мэргэшүүлэх сургалтад бүрэн хамруулсан.

Тус газрын дотоод аудит хариуцсан алба хаагчдаас 2022 онд “Дотоод аудитын ойлголт”, “Эрсдэлийн удирдлага”, “Шилэн дансны хуулийн хэрэгжилт” сэдвээр цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 8 нэгжид 16 цагийн сургалтыг зохион байгуулж, 180 алба хаагчийг хамруулан тодорхой мэдээлэл өгсөн байна.

ДӨРӨВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

1. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөөг гарган, хагас бүтэн жилээр биелэлт, үр дүнг тооцож, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнах;

2. Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж, зөвлөмж боловсруулан холбогдох нэгжид хүргүүлэн, үр дүнг тооцох;

3. Аудитаар зөрчил дутагдлыг илрүүлж, буруутанд хариуцлага тооцоход бус аудитад хамрагдсан объектын үйл ажиллагааг сайжруулах,

үр ашиг, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, тухайн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох талаар өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулахад анхаарч ажиллах.

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР:

.....
.....

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН :
МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ БАЙЦААГЧ
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.НАМГИНЖАВ

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ТООЦСОН БАЙДАЛ

2022.12.05		Улаанбаатар хот				
д/д	2022 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний дагуу хийгдсэн аудитын нэрс	Аудит хийсэн алба хаагч	Зөвлөмж хүргүүлсэн огноо, дугаар	Зөвлөмжийн биелэлт тооцох хугацаа / зөвлөмжийн заалт/	Зөвлөмжийн хэрэгжилтийг тооцсон үнэлгээ	Тайлбар
1	"Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга байгууламжийн ашиглалт, насжилтын байдал"	х/а Б.Намгинжав	2022.02.23-ны өдрийн 3а/1475 дугаартай албан бичгээр 4 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 06 дугаар сарын 25 /5 заалттай /	88.0	
2	"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдал"	а/д Ч.Эрдэнэболор	2022.01.11-ний өдөр Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн.	2022 оны 06 дугаар сарын 20 /3 заалттай/	80.0	
3	Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал"	х/а Б.Намгинжав,	2022.04.20-ны өдрийн 3б/3314 дугаартай албан бичгээр 1 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 09 дүгээр сарын 10 /3 заалттай/	93.3	Төлөвлөгөөт бус
4	"Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалт, дадлагын төв -ийн үйл ажиллагаа"	х/а Б.Намгинжав х/ч Б.Лхагважаргал	2022.04.18-ны 3б/3215 дугаартай албан бичгээр 8 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 09 дүгээр сарын 25 /3 заалттай /	80.0	
5	Өмнөговь аймгийн цагдаагийн газрын Цогцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал"	х/а Б.Намгинжав	2022.04.21-ны өдрийн 3б/3355, албан бичгээр 4 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 08 дугаар сарын 30 /6 заалттай /	70.0	Төлөвлөгөөт бус

6	Өмнөговь аймгийн цагдаагийн газрын "Гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал"	х/а Б.Намгинжав	2022.04.22-ны өдрийн 36/3323 дугаартай албан бичгээр 2 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 08 дугаар сарын 30 /5 заалттай /	84.0	Төлөвлөгөөт бус
7	Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн "Нарстай хээрийн сургалтын хэсгийн үйл ажиллагааны байдал"	х/а Ц.Борхүү	2022.04.05-ны өдрийн 3/147 дугаартай албан бичгээр 4 нэгжид хүргүүлсэн	2022 оны 12 дугаар сарын 20 /7 заалттай/	88.0	
8	"Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2021" арга хэмжээний хэрэгжилтэд хийх дотоод аудит	х/ч Б.Лхагважаргал а/д Ч.Эрдэнэболор	2022.04.18-ны өдрийн 36/3216 дугаартай албан бичгээр 3 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 11 дүгээр сарын 15 /5 заалттай/	90.5	
9	Нийслэлийн цагдаагийн удирдах газрын "Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаа" -нд хийх дотоод аудит	х/а Д.Борхүү х/ч Ё.Мөнхзүл а/д Ч.Эрдэнэболор	2022.04.02-ны өдрийн 36/3499 тоот албан бичгээр 1 нэгжид хүргүүлсэн.	2022 оны 11 дүгээр сарын 01 /2 заалттай/	85.0	Төлөвлөгөөт бус
10	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа -нд хийх дотоод аудит	х/ч Ё.Мөнхзүл а/д Ч.Эрдэнэболор	2022.04.27 36/3577 тоот албан бичгээр 1 нэгжид хүргүүлсэн.	2023.01.31 /3 заалттай/	Биелэлт тооцох хугацаа болоогүй.	
11	"Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдал"	х/а Б.Намгинжав х/ч Ё.Мөнхзүл	2022.05.30-ны өдрийн 3а/4581 тоот албан бичгээр 2 нэгжид хүргүүлсэн. .	2022.08.30 /3 заалттай/	80.0	Төлөвлөгөөт бус
12	"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнтэй аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдал"	а/д Ч.Эрдэнэболор	2022.05.31-ны өдрийн 3а/4579 албан албан бичгээр 1 нэгжид хүргүүлсэн.	2022.12.22 /4 заалттай/	Биелэлт тооцох хугацаа болоогүй.	
13	"Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, эрсдэлийн байдалд хийсэн дотоод аудит"	х/а М.Ажаргал, х/а Б.Намгинжав, х/ч Б.Лхагважаргал	2022.06.08-ны өдрийн 3а/4864 албан бичгээр 4 нэгжид хүргүүлсэн.	2022.10.01 /6 заалттай/	95.0	Төлөвлөгөөт бус

14	Цагдаагийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь "сүүж-уул-2" амралтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит	х/а М.Азжаргал, х/а Б.Намгинжав,	2022.08.17-ны өдрийн 6/6545 албан бичгээр 2 нэгжид хүргүүлэв.	2022.12.12 /4 заалттай/	80.0	
15	Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит	х/а М.Азжаргал, х/а Б.Намгинжав	2022.11.03-ны өдрийн 6/9036 албан бичгээр 9 нэгжид хүргүүлсэн.	2023.03.01 /4 заалттай/	Биелэлт тооцох хугацаа болгоогүй.	
16	"Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"- өс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаа"	х/а М.Азжаргал	2022.11.08-ны өдрийн 6/9178 албан бичгээр 2 нэгжид хүргүүлсэн.	2022.11.28 /3 заалттай/	80.0	Төлөвлөгөөт бус
17	"2022 оны эхний 10 сарын байдлаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын шалтгаан нөхцөлийн байдал"	х/а М.Азжаргал	2022.11.03-ны өдрийн 6/9036 албан бичгээр 2 нэгжид хүргүүлсэн.	2022.11.22 /6 заалттай/	90.0	Төлөвлөгөөт бус
18	"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас гэрээт хамгаалалтад авах аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээний нөхцөлүүдийн байдал"	х/а Б.Намгинжав а/х Э.Анхчимг	2022.11.16-ны өдрийн 6/9472 албан бичгээр 3 нэгжид хүргүүлсэн.	2023.01.20 /4 заалттай/	90.0	Төлөвлөгөөт бус
19	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийх дотоод аудит	х/ч Ё.Мөнхзул	2022.11.25-ны өдрийн 9/9839 албан бичгээр 53 нэгжид хүргүүлсэн	2023.03.31 /5 заалттай/	Биелэлт тооцох хугацаа болгоогүй	
	Нийт 19 заалтаас заасан хугацаанд нь биелэлт тооцсон 15, биелэлт тооцох хугацаа болгоогүй 4 заалт байна..					

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ
ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022.12.05

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Биелэлт	Хувь
Төлөвлөлтийн зорилт 1.Цагдаагийн байгууллагын дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх				
1.1	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод аудитын чиглэлээр сургалт зохион байгуулах	Жилдээ	2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Мөдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны ирүүлсэн хүсэлтийн дагуу "Дотоод аудитын ойлголт", сэдвээр 45 минутын сургалтыг 55 алба хаагчдад зохион байгуулж, тэдний сонирхсон асуултад хариулт өгсөн. Тус газрын дотоод аудит хариуцсан алба хаагчдаас 2022 онд "Дотоод аудитын ойлголт", "Эрсдэлийн удирдлага", "Шилэн дансны хуулийн хэрэгжилт" сэдвээр цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 8 нэгжид 16 цагийн сургалтыг зохион байгуулж, 180 алба хаагчийг хамруулсан байна.	100
1.2	Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн, ач холбогдлыг цагдаагийн байгууллагын дотоод болон гадаад орчинд сурталчлах	Жилдээ	Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас 2021, 2022 онд хэрэгжүүлсэн дотоод аудитын тайлангийн эмхэтгэлийг цахим хэлбэрээр бэлтгэн гарган, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод сүлжээнд байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан.	100
1.3	Дотоод аудиторуудыг чадваржуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын Үндэсний дотоод аудиторуудын холбоо, бусад байгууллагаас зохион байгуулах сургалтуудад хамруулах	Жилдээ	Монголын Үндэсний Дотоод Аудиторын холбооноос зохион байгуулсан "Аудитын тайланг үр дүнтэй бичих нь" сэдэвт сургалтад дотоод аудит хариуцсан 5 алба хаагч 2022 оны 05 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд хамрагдаж "Батламж" авсан.	100
1.4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тухайн оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг гаргаж, ХЗДХЯ-нд хүргүүлэх	Хагас, бүтэн жилд	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөний төслийг боловсруулан, 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулж, бүтэн жилийн байдлаар биелэлт, үр дүнг тооцоход хувьтай дүгнэгдэж, дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулахаар хүргүүлсэн.	100
Төлөвлөлтийн зорилт 2. Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, байгууллага, алба хаагчийн хэрэгцээ шаардлага, тухайн аудитын ач холбогдол, үр дүнг харгалзан дотоод аудитыг хэрэгжүүлэх				

2.1	Нийслэлийн дүүрүүд дэх цагдаагийн газрын хаагчдад эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	9 дүгээр сард	95.0	"Нийслэлийн дүүрүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж, "Аудитын тайлан"-г гарган, газрын даргаар хянан баталгаажуулж, ЦЕГ-ын Дэд даргад танилцуулж, ЦЕГ-ын даргаар баталгаажуулж, Хүний нөөцийн хэлтэст 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 6/8245 дугаартай албан бичгээр ХХ, ХНХ, НЦУГ, Дүүрэг дэх цагдаагийн газрууд зэрэг 9 нэгжид 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдөр тооцохоор байна.
2.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс сонгон дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	3 дугаар сард	100	
2.3	Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга байгууламжийн ашиглалт, насжилтын байдал /стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх/-д дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	2 дугаар сард	100	Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын барилга байгууламжийн ашиглалт, насжилтын байдал /стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх/-д дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 6 заалт бүхий зөвлөмжийг 2022.02.23-ны өдрийн 3а/1475 дугаартай албан бичгээр Санхүү аж ахуйн алба, Хүний нөөцийн хэлтэс, хуулийн хэлтэс, авто баазад тус тус хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор тооцон, хэрэгжилтэд үнэлгээ хийж, 88.0 оноо буеу "Сайн" үнэлж, Тэргүүн дэд даргад танилцуулан баталгаажуулсан.
2.4	Цагдаагийн байгууллага, нэгжээ Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	10 дугаар сард	95.0	"Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021, 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний 2.12, 2.4-т заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага дахь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд энэ оны 1 болон 11 дүгээр сард дотоод аудит хийж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулсан. Үүнд: 1.Өмнөх оны цагдаа дотоодын цэргийн байгууллагын дотоод аудитын төлөвлөгөөний 2.12-т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд энэ оны 01 дүгээр сард хийж, аудитын мөрөөр "Шилэн дансны мэдээллийг хугацаа алдаж байршуулсан 12 нэгжид сануулж, цаашид уг зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарах" чиглэлээр 3 заалт бүхий зөвлөмжийг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар тооцож үзэхэд 80.0 хувийн биелэлттэй. 2.Энэ оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 11 дүгээр сард дотоод аудит хийж, удирдлагад танилцуулан, аудитын мөрөөр 5 зөвлөмжийг ДХАБ-ын даргын 11 дүгээр сарын 25-ны өдрийн 6/9839 дүгээр албан бичгээр ЦДЦАБ-ын 53 нэгжид, биелэлтийг 2023 оны оны 03 дугаар сарын 31-ний өдөр тооцохоор хүргэсэн. /Биелэлт тооцох хугацаа болоогүй/

2.5	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Нарстай дахь хэзрийн сургалт дэдлагын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	3 дугаар сард	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Нарстай дахь хэзрийн сургалт дэдлагын үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 7 заалт бүхий зөвлөмжийг 2022.04.05-ны өдрийн 3/147 дугаартай албан бичгээр 4 нэгжид тус тус хүргүүлж, мөн оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор тооцохоор байна.	95.0
2.6	Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж санал зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	5 дугаар сард	Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 3 заалт бүхий зөвлөмжийг 2022.04.18-ны 36/3215 дугаартай албан бичгээр Санхүү аж ахуйн алба, Цагдаа дотоодын цэргийн нэгдсэн төв, Хүний нөөцийн хэлтэс, Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэс, Сэлэнгэ, Ховд, Өвөрхангай, Хэнтий аймаг дахь цагдаагийн газарт тус тус хүргүүлж, мөн оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тооцон, хэрэгжилтэд үнэлгээ хийж, 80.0 оноо буюу "Сайн" үнэлж, ЦЕГ-ын даргаар баталгаажуулж дээрх нэгжүүдэд 10 дугаар сарын 04-ны өдрийн 6/7942 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	100
2.7	Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь "Сүжиг-Уул-2" амралтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	6 дугаар сард	Цагаан шонхор" амралтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 4 заалт бүхий зөвлөмжийг 2022.08.17-ны өдрийн 6/6545 дугаартай албан бичгээр Санхүү аж ахуйн албанд хүргүүлж, мөн оны 12 дугаар сарын 12-ны өдрийн дотор тооцохоор байна.	95.0
2.8	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	5 дугаар сард	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтэд дотоод аудитын тайланг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, 4 заалт бүхий зөвлөмжийг 2022.05.31-ны өдрийн 3а/4579 тоот албан бичгээр Санхүү аж ахуйн алба, хүргүүлж, мөн оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор тооцохоор байна.	95.0
2.9	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах	Хагас бүтэн жил	Үндэсний аудитын газар болон орон нутаг дахь аудитын газарт цагдаа, дотоодын цэргийн 54 йнүдсэн зэрэглэлтэй 1 байгууллага/байгууллагаас 2021 оны санхүүгийн тайланг хүргүүлснээс 35 байгууллага түвэрлэгдэн шалгардаж, 56 зөвлөмж, 3 акт, 11 албан шаардлага, нийцлийн аудитаар 2 албан шаардлага, 11 зөвлөмж авсан. Хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гарган СААА-наас энэ оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 14/1055 дүгээр албан бичгээр ХЗДХЯ-нд, 06 дугаар сарын 25-ны өдрийн 14/1054 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт тус тус хүргэж ажилласан.	95.0

2.10	Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах	Улирал бүр	100 "Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах" ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны 1-3 дугаар улирлын тайлан, мэдээг нэгтгэн гаргаж, хуулийн хэрэгжилтийг хангах талаар цагдаагийн байгууллагаас хийсэн ажлын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 3/12, 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/157, 10 дугаар сарын 17-ны өдрийн 3/364, Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын даргын 6/5933 дугаар албан бичгээр, мөн ирүүлсэн маягтын дагуу мэдээллийг боловсруулан нэгтгэж ХЗДХЯ-ны Хяналт-шинжилгээ, Үнэлгээ, дотоод аудитын газарт цахим болон бичгээр хүргэсэн.
2.11	Санхүүгийн аудит Цагдаагийн удирдлагын төлөвлөгөөт бус дотоод аудитыг хэрэгжүүлэх	жилдээ	100 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар "Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гүйцэтгэл", "Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаа", "Мөрдөн байцаах албаны харьяа хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал", "Өмнөговь аймгийн цагдаагийн газрын гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал", "Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчдын ажлын ачаалал, орон тооны байдал", "Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын радио холбооны өнөөгийн байдал, техник хэрэгслийн хангамж, нууцлалын байдал", "Тээврийн цагдаагийн албаны харьяа хэлтсийн чиг үүргийн давхардал, бүтэц, орон тооны байдал", "Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөс цагдаагийн байгууллагад шилжүүлсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх үйл ажиллагаа", "2022 оны эхний 10 сарын байдлаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн алба хаагчдын шалтгаан нөхцөлийн байдал" зэрэг төлөвлөгөөт бус дотоод аудит хийж, Тайланг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, зөвшөөрсний дагуу 35 заалт бүхий зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлж, заасан хугацаанд нь үр дүнг тооцсон байна.
	Нийт 15 заалтаас 100 хувийн биелэлттэй 9, 95 хувийн биелэлттэй 6 заалт байна.		98.0

ТАНИЛЦСАН:
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.АЗЖАРГАЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
МӨН ГАЗРЫН АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.НАМГИНЖАВ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ГАЗАР



ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2022 ОНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР**

ТАНИЛЦУУЛГА

2022 оны 11-р сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

№ 1-270

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын
үйл ажиллагааны 2022 оны эрсдэлийн
үнэлгээний тайлан

Тус газар нь 2022 онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эрсдэлийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/224, 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-ыг удирдлага болгон цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, эрсдэлийн үнэлгээ тооцох аргачлалын дагуу гаргаж ирүүлсэн тайлан мэдээг үндэслэн хийж, дүнг нэгтгэлээ.

Эрсдэлийн үнэлгээний зорилго: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны зорилго, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийн талаар удирдлагад мэдээлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээг нэгтгэн ажилласан.

Эрсдэлийн үнэлгээний ажлын хүрээ: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нийт 49 нэгжээс эрсдэлийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт, журамд заасан аргачлалын дагуу өөрийн байгууллагын эрсдэлийн бүртгэлийн санд үндэслэн тодорхойлж ирүүлсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багийн үйл ажиллагаа, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сүүлийн 3 жилийн эрсдэлийн үнэлгээний тайлан, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцох, 2023 онд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, үнэлэх байдлаар эрсдэлийн үнэлгээг хийсэн.

Эрсдэлийн үнэлгээг хийхдээ цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020, 2021 оны эрсдэлийн үнэлгээний тайлан, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус баг, байгууллагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн даргын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 36/3642, 12 дугаар сарын 20-ний өдрийн 36/9979 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн зөвлөмж, ажлын чиглэл, алба, нэгж, нутаг дэвсгэр болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга нарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр өмнөх онуудад хүргүүлсэн 3 удаагийн ажлын чиглэл, 2 удаагийн мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмж, М.Азжаргал “Цагдаагийн байгууллагын эрсдэлийн удирдлага” сургалтын ном болон бусад холбогдох материалуудыг ашигласан болно.

НЭГ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР:

1.1 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг зохицуулан удирдах зорилгоор цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 оноос эрсдэлийн мэдээллийг санг ашиглаж эхэлсэн бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эрсдэлийн удирдлага, үнэлгээний тогтолцоог мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна.

Энэ онд тус газраас мэдээллийн сангийн ашиглалт болон “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” /Код-137/ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, эрсдэлийг үнэн зөв тодорхойлж бүртгэх, үнэлэх, эрсдэлийн түвшнийг тодорхой тогтоох, ач холбогдлын зэрэглэлийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүний үр дүнд хяналт-шинжилгээ хийх, дахин эрсдэлээ тооцох, мэдээллийг сан /ICS/-гийн хөтлөлт, бусад анхаарах асуудлуудын талаар ЦЕГ-ын Дэд даргын 2020 оны 11 дүгээр сарын 09-ний 3/248, Аюулгүй байдлын хэлтсийн даргын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 36/3642, 12 дугаар сарын 20-ний өдрийн 36/9979, Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 6/8839 дугаартай албан бичгүүдээр цагдаа, дотоодын цэргийн бүх анги, байгууллагад зөвлөмж, үүрэг, ажлын чиглэл хүргүүлсэн.

Үүрэг, ажлын чиглэлийн дагуу харьяа нэгж, байгууллагууд эрсдэлийн мэдээллийн сангаа үндэслэн эрсдэлийн магадлал, нөлөөллийг эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, эрсдэлийн үнэлгээний тайланг эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус баг, байгууллагынхаа зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, дүнг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны дотор бүрэн ирүүлсэн.

1.2 Нэгжүүдийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багуудын тухайн нэгж дээрээ эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлж байгааг эрсдэлийн бүртгэл, үнэлгээг мэдээллийн санд бүрэн

оруулж, баяжилт хийсэн эсэх, эрсдэлийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу бодитой, үнэн зөв хийсэн эсэх, үнэлгээний мөрөөр эрсдэлийн менежментийн төлөвлөгөө гаргасан эсэх, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцсон эсэх, жилийн эцэст дахин эрсдэлээ үнэлсэн эсэх, орон тооны бус ажлын хэсэг байгуулсан эсэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэх зэрэг 8 үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэлээ. /Хавсралт-2/

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-ын 137.4.4-т заасны дагуу эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан 49 нэгжүүдийг өөрийн байгууллагын түвшинд эрсдэлийн удирдлагыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлсэн байдлыг харгалзан дээрх 8 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгөхөд 8 оноотой 35 нэгж, 8-аас доош оноотой 14 нэгж байна.

Цаашид 8-аас доош оноотой нэгжүүдийн хувьд дотоод хяналтын орчныг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг идэвхжүүлэх, хариуцсан алба хаагчдаа чадавхжуулж, үйл ажиллагаагаа “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэсэн. /Хавсралт-2/

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, мэдээг үндэслэн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээг хийж, Цагдаагийн байгууллагын удирдлагад танилцуулах шаардлагатай “Ач холбогдлын зэрэг”-ээрээ “Их” эрсдэлтэй буюу 20-25 оноотой нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын 2, үйл ажиллагааны 29, төсөв, санхүүгийн 5, гадаад хүчин зүйлсийн 4, нийт 40 эрсдэлийг байгууллагад үзүүлэх нөлөөллийн түвшин, давтагдах магадлал, чанарын түвшнийг харгалзан нэгтгэн танилцуулж байна. /Хавсралт-1/

1.3 Мөн энэ жилээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дотоод аудитын алба хаагчийг чадавхжуулах, харилцан туршлага солилцох ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу анги, байгууллагуудаас ирүүлсэн үнэлгээ, саналыг нэгтгэн цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ирэх 2023 онд учирч болох эрсдэлийг урьдчилан тооцож, үнэлгээ хийн анги, байгууллагад хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тухайн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж эхлээд байна. /Хавсралт-3/

ХОЁР. ДҮГНЭЛТ:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажилласан.

2.1 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2014-2022 онуудад

нийт 12 удаа эрсдэлээ тодорхойлж, үнэлгээ хийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэн тооцуулсан.

2.2 Энэ онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/224, 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-ыг хэрэгжилтийг хангаж, нэгжүүдээс хагас жилээр төлөвлөгөөний биелэлтийг гаргуулан хянаж, бүтэн жилээр төлөвлөгөөний биелэлт, үнэлгээний тайланг авч, эрсдэлийг санг бүрдүүлэн тооцож, үнэлэн ажиллалаа.

2.3 Энэ оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дотоод аудитын алба хаагчийг чадавхжуулах, харилцан туршлага солилцох ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу анги, байгууллагуудаас ирүүлсэн үнэлгээ, саналыг нэгтгэн цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ирэх 2023 онд учирч болох эрсдэлийг урьдчилан тооцож, үнэлгээ хийсэн.

2.4 Эрсдэлээ тодорхойлж, үнэлж ирүүлсэн 49 байгууллагын эрсдэлийн үнэлгээний тайланг хянаж үзэхэд учирч болзошгүй онцлог эрсдэлийг тооцон үнэлж, эрсдэлүүдийг тодорхойлж байгаа боловч эрсдэл гарсан тохиолдол бүрийг үнэн зөв бүртгэх, эрсдэлийн түвшнийг тодорхой тогтоох, ач холбогдлын зэрэглэлийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үр дүнд хяналт-шинжилгээ хийх, дахин эрсдэлээ тооцож, хэлбэлзлийг өмнөх жилүүдтэй харьцуулж хянахад чиглэсэн эрсдэлийн бүртгэлийг үнэн зөв, бодитой хөтөлж хэвшүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэхээр байна.

2.5 Нэгжүүдийн үйл ажиллагаанд эрсдэлийн мэдээллийн сан үүсгэх, үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийн санд үндэслэн үнэн зөв, бодитой хийн, үнэлгээний мөрөөр эрсдэлийн менежментийг төлөвлөн, гүйцэтгэлийн биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон мэдээллийн санд баяжилт хийн дахин эрсдэлээ үнэлэх, орон тооны бус баг байгуулан шинэчлэх, тайланг тогтоосон хугацаанд ирүүлэх гэсэн 8 шалгуур үзүүлэлтээр байгууллагын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдалд үнэлэлт өгсөн.

2.6 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2023 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээгээр “Их” түвшинд үнэлэгдсэн 20 эрсдэлийг бууруулах арга хэмжээний саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, бусад 21 эрсдэлийг байгууллага дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ. /Хавсралт-3/

ГУРАВ. ЭРСДЭЛ, ҮНЭЛГЭЭ:

3.1 Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчид нь эрсдэлийн удирдлагыг ойлгож хэрэгжүүлэх, тооцон үнэлэх, эрэмбэлэн төлөвлөх ажил арга хэмжээ, хяналтад тодорхой ахиц гарж байгаа хэдий ч алба хаагчдын шилжилт хөдөлгөөн, дотоод аюулгүй байдлуудын хүчин зүйлүүдийг мэдрэн үнэлэх чадамжаас шалтгаалан мэдлэг олгох, мэдээлэлд анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

ДӨРӨВ. САНАЛ:

4.1 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2023 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ их түвшинд тодорхойлогдсон, ХЗДХЯ, дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлж, бууруулах боломжтой гэж үзэж байгаа нийцлийн, үйл ажиллагааны, төсөв санхүүгийн, гадаад хүчин зүйлийн 20 эрсдэлийг бууруулах арга хэмжээний саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

4.2 Урьдчилсан үнэлгээнд тусгагдсан байгууллагын хэмжээнд дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн бууруулах боломжтой гэж үзэж байгаа стратегийн, үйл ажиллагааны, нийцлийн, гадаад хүчин зүйлийн 21 эрсдэлийг бууруулах арга хэмжээний саналыг ЦЕГ-ын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлж, цагдаа, дотоодын анги, цэргийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулах.

4.3 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ирэх 2023 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээг цагдаа, дотоодын цэргийн бүх анги, байгууллагад хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тухайн нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний болон гүйцэтгэлийн шат шатны төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих.

4.4 Эрсдэлийн үнэлгээний тайлан мэдээ, төлөвлөгөөний биелэлт, мэдээллийн сангийн ашиглалттай холбоотой цаашид анхаарах асуудлуудын талаар зөвлөмж, ажлын чиглэл боловсруулж, 2022 оны эрсдэлийн үнэлгээний энэхүү тайлан мэдээ, хавсралт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” зэргийн хамт бүх анги, байгууллагад мэдээлэл болгон хүргүүлэх.

4.5 Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан /хавсралтын хамт/, 2023 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлж, мэдээллийг Хууль зүй дотоод

хэргийн яамны эрсдэлийн үнэлгээний цахим мэдээллийн санд оруулах.

4.6 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багуудад 2022-оны 12 сарын 25-нд багтаан цахимаар дотоод аудит хариуцсан алба хаагч, чиглэл хариуцсан ахлах байцаагч нар хамтран 2-оос доошгүй цагийн сургалт зохион байгуулах.

4.7 “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-ын 137.4.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах зэрэг саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ТАНИЛЦСАН:
ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Шийдвэр:
.....
.....

ХЯНАЖ ЗӨВШӨӨРСӨН:
ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

НЭГТГЭН ҮНЭЛЖ, ТАНИЛЦУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
АХЛАХ БАЙЦААГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

И.БАТЧУЛУУН

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2022.11.25.

Улаанбаатар хот

Зорилго нь: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтыг хангах, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал, үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг үнэн зөв, бодитой тодорхойлж, бууруулах, арилгах, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-ын хэрэгжилтийг хангаснаар байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн эрхийг хүндэтгэх, алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, тогтвор суурьшилтай мэргэшин ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Цагдаа, дотоодын цэргийн бүх анги, байгууллагууд / алба хаагч, ажилтан бүр/

Зохион байгуулалт: “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-аар зохицуулагдсан орон тооны бус баг, ажлын хэсэг хэрэгжилтийг хариуцна.

Үнэлж, тооцох хэлбэр: Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус үнэлгээний баг, ажлын хэсэг хяналт-шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийж, тооцон, эрсдэлийн удирдлагын үүссэн, үүсэж болох асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэсэн, бууруулсан байна.

Хариуцлага, үр дүн: Байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд үүссэн, үүсэж болох эрсдэлүүдээс урьдчилан сэргийлж, ажил, үүргийн ачааллыг тэнцвэржүүлэх замаар сахилга, ёс зүй, хариуцлагад хандлагын эерэг өөрчлөлт гарч, үүрэг гүйцэтгэлийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж, чадавх дээшилсэн байна.

Ач холбогдол: Алба хаагчдад хүрч, үүрэг гүйцэтгэлийн эргэх холбоо сайжирч, дараагийн шатанд авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, төлөвлөлт тодорхойлогдоно.

Эрс- дэлийн код	Тодорхойлсон эрсдэл	Марадтал	Нөлөөлөл	Эрсдэлийн Үнэлгээ	Эрсдэлийг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал	Нотломж
А.Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл						
1	Тусгай ажиллагааны газрын алба хаагчдын галт зэвсэг хэрэглэх талаарх хууль эрх зүйн зохицуулалт байхгүйгээс албан үүргээ гүйцэтгэсний төлөө алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдох /ТАГ/	5	4	20	Цагдаагийн албаны тухай хуульд болон бусад хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг хийж, алба хаагчийн эрх ашгийг хамгаалах, галт зэвсэг хэрэглэх үндэслэлийг боловсронгуй болгох санал боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлэх	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
2	Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шинж байдлын албан ёсны тайлбар, чиглэл байхгүйгээс шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл учрах /ЭкоЦА/	5	5	25	Нотлох баримт цуглуулах, бөхжүүлэх, хууль хэрэглэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж боловсруулан, алба хаагчдад хүргэх.	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
Б.Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл						
3	Хорио цээрийн, олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлсөн нөхцөл байдлын үеийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах хүн хүчний тооцоог бодитой оновчтой төлөвлөөгүйгээс байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа алдагдах, алба хаагчдын ажил үүргийн гүйцэтгэлийн хэвийн үйл ажиллагаа, ачаалаал, эрүүл мэнд, ар гэр, нийгмийн харилцаанд нь сөрөг нөлөө үзүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа алдагдах, сөрөг ойлголтыг бий болгох	5	4	20	Хорио цээр, олон нийтийн аюулгүй байдлын үеийн өндөржүүлсэн бэлэн байдал, хяналт, хамгаалалтад ажиллах алба хаагчдын хүн хүчний тооцоо, цагийн менежментийг зөв тодорхойлж гаргах, алба хаагчдын болон байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, алба хаагч, иргэдэд үүсэх чирэгдэл, хүндрэлээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтыг авч, хүн хүчний хүртээмжийг бодитоор үнэлж байх	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

4	Б2	Алба хаагчдын цалин хөлсийг баталгаажих түвшин, ажлын ачаалал, хууль сахиулах байгууллагуудын цалингийн сүлжээтэй уялдуулж тогтооноггүйгээс цагдаагийн алба хаагчийн хараат бус, бие даан шийдвэр гаргах, хэрэг, зөрчлийг шийдвэрлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, алба хаагч авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдох, албаны итгэл үнэмшил нь сулрах, хүний нөөцийн дутагдалд орох	5	5	25	Цагдаагийн алба хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	2017-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
5	Б3	Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ын хэмжээнд хүрэхгүй байгаа, орон тоо хангалтгүйгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжтэй байдал алдагдах, алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх	5	5	25	Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын хэрэгжилтийг жил бүр хүн амын өсөлт, суурьшил, эрүү, хэв журмын болон олон нийтийн аюулгүй байдлын нөхцөл байдлыг үнэлж шийдвэрлэдэг урт хугацааны /5-8 жилээр тооцон/ хэрэгжилтийн шийдвэрийг төсвийн төсөөллийн хамт гаргуулах бодлогын хэрэгжилтийг баримтлах	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
6	Б4	Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалд алба хаагчдыг дэвшүүлэн томилходоо алба хаагчийн мэдлэг, мэргэжил, ажлын туршлага, ур чадвар, чадамж, гургасан амжилт, хувийн болон мэргэжлийн ёс зүйг үндэслэн, албан тушаал эрхлэх шат дараалаар томилж зарчмыг баримтлаагүйгээс алба хаагчдын албандаа хандах ачллага суларч, цагдаагийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах /Баян-Өлгий, Ховд/	5	4	20	Цагдаагийн албаны тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах, баримтлах. Ингэснээр Улс төрөөс ангид байх, сөрөг үүсэх олон нөлөөлөөс хамгаалагдах гүйцэтгэлийг анхаарч байх бодлогын зарчим баримтлах	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
7	Б5	Цагдаагийн алба хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад иргэдийн зүгээс үйл ажиллагаатай нь холбоотойгоор цахим сүлжээнд шууд бичлэг /лайв/ хийж, алба хаагчийг гүгтэх, доромжлох үйлдэл гаргаж байгаа нь алба хаагчийн болон албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх /МБА/	5	5	25	Алба хаагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах нэгжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтэц, хамаарал харьяаллыг оновчтой болгоход анхаарах.	2019-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

8	Б6	Цагдаагийн байгууллага Япон улсын "KENWOOD" маркийн 150-174 МГц давтамжтай, аналого системийг 1996 оноос хойш 26 жил ашиглаж, ашиглалтын хугацаа дууссан бөгөөд эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, БНХАУ-д дахин засварлагдсан, хямд радио станцаар бага хэмжээний нөхөн хангалт хийсэн боловч гэмтэл саатал их гарах, нийтийн хэрэглээний давтамж /150-174МГц/-аас тусгай хэрэглээний давтамж /350-400МГц/-д шилжүүлэггүйгээс радио станцаар дамжидаж байгаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл алдагдах үйл ажиллагааны саатал, доголдол үүсэх /МДШШУА/	5	5	25	Радио холбооны техник хэрэгслийг шинэчлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх, төрийн байгууллагуудын цахим өгөгдлүүдтэй холбоход анхаарах, нууцлал аюулгүй байдлыг хангасан тоон технологиор шинэчлэх /Зардал 24.6 сая ам.доллар/	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан.
9	Б7	Серверүүдийн үйл ажиллагаа доголдох /МДШШУА/	5	5	25	Техник, хэрэгслийг шинэчлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг 5-8 жилээр урт хугацааны төсвийг шууд Улсын төсөвт заах өгөгдлөөр шийдвэр гаргуулж төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, мэргэжилтнүүдийн хүний нөөцийг тооцсон байх. Эрсдэлийг бууруулах чиглэлээр шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлын тооцоог гарган, Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, суурилуулж, тохируулах. "back up дата бааз" үүсгэн серверийн хэвийн үйл ажиллагааг хангаж, урьдчилан сэргийлэх	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан.
10	Б8	Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн сан, програм хангамжид хяналт тавих мониторингийн систем байхгүйгээс мэдээллийн аюулгүй байдал алдагдах /МДШШУА/	4	5	20	Төсөв хөрөнгийг шийдвэрлүүлж, мониторингийн системийг нэвтрүүлэх	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

11	Б9	Алба хаагчид цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санд шаардлага хангахгүй, буруу мэдээлэл оруулснаас үнэн зөв мэдээ, мэдээллээр хангагдахгүй байх /МДШУА, МБА/	4	5	20	Алба хаагчдыг чадавжуулах клиник сургалтыг үе шаттай зохион байгуулж, үр дүнг тооцох	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
12	Б10	Сүлжээний үндсэн төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссанаас цагдаагийн байгууллагын хэмжээнд сүлжээ тасрах эрсдэлтэй /МШУТ/	5	5	25	Сүлжээний төхөөрөмжийн зардлыг шийдвэрлэх талаар дээд шатны байгууллагад танилцуулга хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
13	Б11	Алба хаагчдын ажлын онцлогоос шалтгаалан хөдөө орон нутагт үүрэг гүйцэтгэхэд цаг агаарын болон байгалийн гамшигт үзэгдэлд өртөх, бэртэж гэмтэх, эрс тэс уур амьсгалтай, агаарын бохирдол ихтэй үед үүрэг гүйцэтгэх нь эрүүл мэндэд нөлөөлөх /ТЦА, ЭкоЦА, МБА/	5	5	25	Алба хаагчдад хамгаалалтын хувцас, хэрэгслийг хэрхэн ашиглах, ариутгах талаар болон аюулгүй ажиллагааны зөвлөмж, зааварчилгааг тогтмол өгч байх. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, даатгалд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
14	Б12	Гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын биед халдах, гугаан доромжлох /ТЦА/	4	5	20	Дэд зөвлөл болон Орон тооны бус ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх, гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг гугаан доромжилсон, биед халдсан иргэнд арга хэмжээ авсан талаарх мэдээллийг иргэд олон нийтэд мэдээлэх, алба хаагчдыг эрх ашгийг хамгаалах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
15	Б13	Алба хаагчид иргэдтэй харьцахдаа үйлчилгээний стандарт, сахилга, ёс зүйн дүрмээ баримтлаагүйгээс иргэдийг бухимдуулах, цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх, сахилга, ёс зүйн зөрчилд холбогдох /ТЦА, МБА/	5	4	20	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол сургалт зохион байгуулах /Ярилцлага, дадлага ажил хийх мэтээр үр дүнд хүрэхүйц аргаар сургалт зохион байгуулах/	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
16	Б14	Алба хаагчид галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мөх хэрэглэх заавар буруу хэрэглэж зөрчилд холбогдох /ТЦА, МБА/	5	4	20	Галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэх талаарх сургалтыг улирал тутам зохион байгуулах /сургалтыг онол, практик хослуулсан хэлбэрээр зохион байгуулах/	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

17	Б15	Алба хаагчид энгэрийн камергүй, тусгай хэрэгсэл, гар станцууд эвдрэл гэмтэлтэй, хувцасны шүүгээгүй, ажил тарах үедээ албаны хувцсаа сольж чадахгүй байна. Алба хаагчдын ажиллах орчин нөхцөл хангагдахгүй байгаа нь /албаны компьютер, бусад тоног төхөөрөмж өрөө, тасалгаа хангалтгүй байдал/ бичиг хэргийн хангалт муу, өөрсдөө хувисаа эд зүйл худалдаж авч албанд хэрэглэдэг, албан үүргээ гүйцэтгэх анхаарал төвлөрөл, ажлын бүтээмж хангалтгүй, алдаа дутагдал гаргах, албаны нууцлал алдагдах /НХЖХОНАБХ/	5	5	5	25	Энгэрийн камер, хувцасны шүүгээ, компьютер, бусад тоног төхөөрөмж, шаардлагатай эд зүйлийн төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
18	Б16	Тайзны механизмын ашиглалтын хугацаа дууссан, штанкетын трос, орс, түгжигч элэгдэлд орсноор ажил, арга хэмжээний үед эвдрэх, унах аюултай нөхцөл байдал үүссэн /Сүлд чуулга/	5	5	5	25	Тайзны механизмыг шаардлагын түвшинд яаралтай солиулах, засварлах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
19	Б17	Концертын их танхимд урдаг соёлын үйл ажиллагаа явуулахад заалны дуу чимээний техник хэрэгсэл стандарт бус дуугаралт үзэгчдэд сонсох эрхтнээр дамжин таагүй нөхцөл байдал үүсэх /Сүлд чуулга/	5	5	5	25	Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх, солих төсөв, хөрөнгийг шийдвэрлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
20	Б18	Мэргэн буудагчийн галт зэвсэг, хэрэгслийг шинэчлэх, одоо ашиглагдаж байгаа гал зэвсэг байндаа оновчтой туслахгүй байгаа нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх /ТАГ/	5	5	5	25	Цагдаагийн ерөнхий газрын төсөвт тусгах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
21	Б19	Буудлагын дадлага сургалтад ашиглах сум хүрэлцээгүй, тогмол буудлагын дадлага сургалт хийж чадахгүй байгаагаас шалтгаалан хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай гүйцэтгэхгүй байх /ТАГ, МБА/	5	5	5	25	Шаардагдах сум галт хэрэглэлийн зардлыг Цагдаагийн ерөнхий газрын төсөвт тусгах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

22	Б20	SWAT-ын алба хаагч нарт зориулан чанарын өндөр түвшинд тусгайлан үйлдвэрлэгдсэн галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгсэл. Тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангагдаагийн улмаас тусгай ажиллагаанд саад учрах, эсвэл алба хаагч, иргэдийн амь нас эрүүл мэндэд аюул үүсэж болзошгүй /ТАГ/	5	5	25	Шаардлагатай хувцас хэрэглэл, галт зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгслийн судалгааг гаргаж, дээд шатны байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
23	Б21	Албаны бичиг баримт болон нууц бичиг баримт хадгалах хадгалах зориулалтын сейф, цаас устгагч байхгүйгээс бичиг баримт алдагдах, хуулбарлах, нууц алдагдах /ХМТ/	5	5	25	Бичиг баримт хадгалах шүүгээ, сейф, цаас зүсэгчийн асуудлыг удирдлагад танилцуулж дотооддоо шийдвэрлүүлэх боломжтой	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
24	Б22	Нууцхамгаалах ажилтанд зориулалтын зориулалтын компьютер, техник хэрэгсэл байхгүйгээс шалтгаалах нууц алдагдах /ХМТ/	5	5	25	Нууцны ажилтанд зориулагдсан компьютерын асуудлыг удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх, нууцны жагсаалтад хамаарах баримт бичигт аудит хийлгэн жагсаалтыг шинэчлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
25	Б23	Албаны нохойтой харьцдаг алба хаагчид нохойд хазуулах, бэртэж гэмтэх, хувцас шулс, ялгадас, нүд, хамар, амны салстаар бохирлогдон нохойноос хүнд халдварлах халдварт өвчин /ЦДЦСНТ/	5	4	20	Хамгаалах хувцас хэрэглэл, урьдчилан сэргийлэх тарилга, эм, хэрэглэлийн төсвийг төсөв, хөрөнгийг нөөцөөр тооцон тасралтгүй шийдвэрлэхэд анхаарах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
26	Б24	Шинээр сургууль төгссөн, шинээр томилогдсон офицер алба хаагчдаас ажлын ачаалал даах чадвар сул, ур чадвар дутмаг, ажлаас шантрах, чөлөөлөгдөх, шилжих хүсэлт тогтмол гаргаж байгаа нь хүний нөөцийн бодлогод сөрөг нөлөө үзүүлэх /Архангай/	5	5	25	Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын байранд сургаж дадлагажуулах, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн цогц ажлыг эрчимжүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
27	Б25	Тус цагдаагийн газарт сүүлийн 10 жилийн хугацаанд 43 алба хаагчийн орон тоо нэмэгдэж, одоо нийт 156 алба хаагч, ажилтан үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд сургалт, хурлын танхимд алба хаагчид багтахгүй, албан тасалгааны хүрэлцээгүй байдал үүссэн. Алба хаагч, ажиллагсад, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, хөдөлмөрлөх, үйлчлүүлэх баталгаа алдагдах, иргэдийн сэтгэл ханамжийг сөргөөр нөлөөлөх, алба хаагчдын ажлын бүтээмж буурах эрсдэлтэй. Цагдаагийн газрын төв байр нь 1987 онд 60 алба хаагч ажиллах нөхцөлөөр баригдсан байна /Баян-Өлгий/	5	5	25	Барилга, байгууламжид шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

28	Б26	Хариуцсан нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамааглах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг хөдөлгөөнт эргүүлгийн машины шатахууны хүрэлцээ хангалтгүй байгаа нь үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй/ИЦУГ/	5	5	25	Шатахууны лимитийг бодитойгоор тогтоолгож, шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
29	Б27	Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын тусгай хэрэгслийн хангалт дутуу байгаагаас үүрэг гүйцэтгэхэд эрсдэл үүсэх /Iрав, бороохой, цахилгаан бороохой/, /ДЦШ/	5	4	20	Дотоодын цэргийн анги, байгууллагод шаардлагатай тусгай хэрэгслийг ЦЕГ-ын дарга, ДЦК-д хүргүүлж шийдвэрлүүлэх.	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
30	Б28	3 ээлжээр үүрэг гүйцэтгэж байгаа жижүүр, харуулын болон Цогтцэций сум дахь Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаа, жолоочийн орон тоонд бусад алба хаагчдыг дотоод зохион байгуулалтаар томилон ажиллуулж байгаа нь байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулах, ажлын ачааллыг үүсгэх /Өмнөговь, Сэлэнгэ-Сайхан ЦХ/	5	5	25	Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хэвийн ажиллах нөхцлийг бий болгох зорилгоор зарим шаардлагатаа орон тоог нэмэгдүүлэх санал, танилцуулгыг аймаг, орон нутгийн удирдлага, ЦЕГ-ын удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх	2019-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
31	Б29	Аймгийн цагдаагийн газрын орон тооны хүрэлцээ дутмаг, ажил, ачаалаас шалтгаалан ээлжийн амралтыг бүрэн эдлүүлдэггүй, улс оронд үүссэн зарим нөхцөл байдлаас шалтгаалсан ажлын ачаалал хэт их зэргээс сэтгэл зүйн байдалд сөрөг нөлөө үзүүлж, ажлын үр дүн буурах, тогтвор суурьшилгүй ажиллах. /Сүхбаатар/	5	5	25	Орон тоог нэмэгдүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх. Алба хаагчдын ээлжийн амралтыг бүрэн олгох талаар тасийн дарга нар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, ажлаа зөв оновчтой төлөвлөх.	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
В.Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл							
32	В1	Эрүүлжүүлэх, саатуулах байрууд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартыг хангахгүй байгаагаас иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох, байгууллага, алба хаагчийн нэр хүнд алдагдах, субъектив бус байдлаар гэм буруугайд тооцогдох, хэвийн үйл ажиллагаа алдагдахад нөлөөлөх /Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ/	5	5	25	Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5527:2019 стандартад нийцсэн нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих асуудлыг судалж, төсвийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

33	B2	Халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчдаас дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн тооцоог бүрэн барагдуулахгүй бол санхүүгийн зөрчил үүсэх/СААА, НЦУГ/	4	5	20	Байгууллага бүр дотоодоо үүссэн өр, авлагыг тухай бүр барагдуулах ажлыг зохион байгуулж хэвших, өр барагдуулах, тооцох арга замыг боловсронгуй болгон шийдвэрлэх	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
34	B3	Батлагдсан төсөв нь үнийн өсөлт /инфляц/-тэй холбогдуулан өөрчлөгддөггүйгээс тухайн жилийн эцэст зарим төрлийн ажил, үйлчилгээ тасалдах, өглөг үүсэх/ЭкоЦА/	4	5	20	Төсвийн тодотголын төслийг үндэслэлтэй боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, эрх бүхий субъектүүдэд хүргүүлж, шийдвэрлүүлэх	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
35	B4	Төсөв, санхүүгийн хүрэлцээгүйгээс барилга, байгууламж, сумдын цагдаагийн хэсгийн юбаны барилгын засварыг цаг тухайд нь хийх боломжгүйгээс алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин, үүрэг гүйцэтгэх нөхцөл алдагдах, байгууллага, алба хаагчийн соёлд сөрөг үнэлэмжийг бий болгох /Баян-Өлгий, Хэнтий/	5	5	25	Засвар үйлчилгээг тухай бүр хийх, нутаг дэвсгэрийн байгууллагын дэмжлэгийг дүнд хугацаанд авах төсвийн шийдвэрлэлийг тооцон уламжилж шийдвэрлүүлсэн байх зэрэгт анхаарах	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
36	B5	Сантехникч, цахилгаанчны орон тоо байхгүйгээс байгууллагын гэрэл цахилгаан, дулааны шугам, сантехникчийн эвдрэл гэмтэл гарсан үед мэргэжлийн бус хүмүүсээр засвар үйлчилгээ хийлгэснээс шалтгаалж төлөвлөгдөөгүй нэмэлт зардал гарч, өглөг үүсэх./ЭкоЦА/	5	5	25	Хүн, хүч, орон тооны тооцооны судалгааг гаргаж, саналаа ЦЕГ-т уламжилгах	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
Г.Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл							
37	Г1	Олон улсад үүссэн "Ковид-19" цар тахлын дэгдэлийн үед хөл хорио тогтоосон нөхцөл болон хорио цээрийн үед алба хаагчид хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ гүйцэтгэх явцад халдвар авч, өвчлөх	5	5	25	Коронавирус /Covid-19/-ын цар тахлаас алба хаагчдыг урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах, шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх	2019-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
38	Г2	Уул уурхайн олборлолт хийгдэж байгаа газруудад хүн амын бөөгнөрөл үүсэж, хэв журын нөхцөл байдлыг хүндрүүлэх/ЭкоЦА/	5	5	25	Хууль бусаар ашигт малтмал олборлон байгаль экологид хохирол учруулж байгаа иргэд нийтийн хэв журын бүлэглэн зөрчиж, цагдаагийн алба хаагч болон бусдын эрх, эрх чөлөөнд халдах гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

39	Г3	Байгууллагын барилга байгууламж нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн шаардлага хангахгүй, багтаамж хүрэлцэхгүй байх /Нийт 23 байгууллага/	5	4	20	Шинээр баригдах барилга, байгууламжийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар дээд шатны байгууллагад албан бичиг, хүсэлтийг дахин тооцон хүргүүлж шийдвэрлүүлэх Дотоодын цэргийн анги, байгууллагын данс бүртгэлтэй барилга байгууламжид хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг гаргуулах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
40	Г4	Цахилгаан дамжуулах хуваарилах самбар тоноглолууд ачааллаа давахгүй халалт үүсэж, элэгдэл эвдрэлд орох ЛЦА, ЦДЦСНТ, Архангай, Сэлэнгэ/	5	4	20	Шинээр баригдах барилга, байгууламжийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар дээд шатны байгууллагад албан бичиг, хүсэлтийг дахин тооцон хүргүүлж, шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

-2021, 2022 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын цагдаагийн байгууллагын дотоод хяналтын ICS программд шивж оруулсан нийт 3299 эрсдэлийн мэдээлэл, 2022 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нийт 49 бүлэг нэржээс үнэлж, дүгнэж ирүүлсэн эрсдэлийн үнэлгээний тайлан мэдээг үндэслэн тооцож үнэлэв.

-Эдгээрээс “Ач холбогдлын зэрэг”-ээрээ “Их” буюу “Эрсдэлийн тоон түвшин”-ээр 20-25-аар үнэлэгдсэн нийт 40 эрсдэлийг сонгон авч жагсаалтад оруулснаас 20-оор үнэлэгдсэн 14, 25-аар үнэлэгдсэн 26 эрсдэлт нөхцөл байдал бүртгэгдсэн байна. Үүнд:

Байгууллагын дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч шийдвэрлэх боломжтой	20	ХЗДХЯ, дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх боломжтой	Шийдвэрлэх арга хэмжээний санал	
	25	Б1, Б4, Б9, Б12, Б13, Б14, Б23, Б27, Б2, Г4 /Бүгд-10/ А2, Б5, Б10, Б11, Б21, Б22, Б24, Б5, Г1, Г2 /Бүгд-10/ 20	А1, Б8, В3, Г3 Б2, Б3, Б6, Б7, Б15, Б16, Б17, Б18, Б19, Б20, Б25, Б26, Б28, Б29, В1, В4 /Бүгд-16/ 20	
Эрсдэлийн түвшин				
НИЙТ				20

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Хавсралт 2-1

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээ /Нутаг дэвсгэр хариуцсан/

Ангилал	Д/д	Шалгуур үзүүлэлт	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	
			ЦЛУГ	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	
Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр	1	Эрсдэлийн бүртгэл хөтөлдөг байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
	2	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багийн гишүүдийг байгууллагын даргын тушаалаар томилсон байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
	3	Эрсдэлийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийн бүртгэлд үндэслэн үнэн зөв, бодитой хийсэн байх	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	4	Эрсдэлийн мэдээллийн сан үүсгэсэн байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	1	1
	5	Эрсдэлийн үнэлгээний мөрөөр эрсдэлийн менежментийн төлөвлөгөө гаргасан байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	6	Төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцсон байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	7	Биелэлт, үр дүнг тооцож эрсдэлийн мэдээллийн санд баяжилт хийсэн байх	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	1	1	0	1	1	0	0	0	0
	8	Эрсдэлийн үнэлгээний тайланг тогтоосон хугацаанд ирүүлсэн байх	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	9	Нийт оноо	8	6	8	8	8	8	8	8	8	8	7	8	8	8	7	8	7	8	7	6	7	7	
	10	ҮНЭЛГЭЭ	100	75	100	100	100	100	100	100	100	100	100	87	100	100	100	100	87	100	100	87	75	87	87

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Хавсралт 2-2

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээ /Алба, харьяа нэгж/

Ангилал	А/д	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18		
		МБА	ЭЦА	ТЦА	НХЖХОНАБХА	ЭкоЦА	СААД	МДШУВА	ХМТ	Хүч спорт хороо	Төв архив	Бүртгэл хяналтын төв	ЦАЦСНТ	ТАГ	ДЦШ	ГХХХ	ХТТ	Сүлд чуулга	Зөрчлийн ХБГ		
Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр	4	1	1	1	1	1	1	1	0	1	1	1	1	0	1	1	1	0	1	1	1
	5	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	6	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	7	1	1	1	1	1	1	1	0	1	0	1	1	0	1	1	1	1	0	1	1
Эрсдэлийн үнэлгээний тайланг тогтоосон хугацаанд ирүүлсэн байх	8	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	9	8	8	8	8	8	8	8	6	8	7	8	8	6	8	8	8	6	8	8	8
	10	100	100	100	100	100	100	100	75	100	87	100	100	75	100	100	100	100	75	100	100

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээ /Тодорхой нутаг дэвсгэр хариуцсан/

Ангилал	д/д	Шалуур үзүүлэлт	1	2	3	4	5	6	7	8	9
Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр	1	Эрсдэлийн бүртгэл хөтөлдөг байх	1	1	1	1	1	1	1	1	1
	2	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багийн гишүүдийг байгууллагын даргын тушаалаар томилсон байх	1	1	1	1	1	1	1	1	1
	3	Эрсдэлийн үнэлгээг шалуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийн бүртгэлд үндэслэн үнэн зөв, бодитой хийсэн байх	1	1	1	1	1	1	1	1	1
	4	Эрсдэлийн мэдээллийн сан үүсгэсэн байх	1	1	1	1	1	1	1	1	1
	5	Эрсдэлийн үнэлгээний мөрөөр эрсдэлийн менежментийн төлөвлөгөө гаргасан байх	1	1	1	1	1	1	1	1	1
	6	Төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцсон байх	1	1	1	1	1	1	1	1	1
	7	Биелэлт, үр дүнг тооцож эрсдэлийн мэдээллийн санд баяжилт хийсэн байх	1	0	0	1	1	0	1	1	1
	8	Эрсдэлийн үнэлгээний тайланг тогтоосон хугацаанд ирүүлсэн байх	1	1	1	1	1	1	1	1	1
9	Нийт оноо	8	7	7	8	8	7	8	8	8	8
10	ҮНЭЛГЭЭ	100	87	87	100	100	100	87	100	100	100

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
БАЙГУУЛЛАГАД 2023 ОНД УЧИРЧ БОЛОХ
ЭРСДЭЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ**

2022.11.25

Улаанбаатар хот

Зорилго нь: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлэх зорилтыг хангах, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал, үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг үнэн зөв, бодитой тодорхойлж, бууруулах, арилгах, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-ын хэрэгжилтийг хангаснаар байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн эрхийг хүндэтгэх, алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, тогтвор суурьшилтай мэргэшин ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Цагдаа, дотоодын цэргийн бүх анги, байгууллагууд / алба хаагч, ажилтан бүр/

Зохион байгуулалт: “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журам /Код-137/-аар зохицуулагдсан орон тооны бус баг, ажлын хэсэг хэрэгжилтийг хариуцна.

Үнэлж, тооцох хэлбэр: Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус үнэлгээний баг, ажлын хэсэг хяналт-шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийж, тооцон, эрсдэлийн удирдлагын үүссэн, үүсэж болох асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэсэн, бууруулсан байна.

Хариуцлага, үр дүн: Байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд үүссэн, үүсэж болох эрсдэлүүдээс урьдчилан сэргийлж, ажил, үүргийн ачааллыг тэнцвэржүүлэх замаар сахилга, ёс зүй, хариуцлагад хандлагын эерэг өөрчлөлт гарч, үүрэг гүйцэтгэлийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж, чадавх дээшилсэн байна.

Ач холбогдол: Алба хаагчдад хүрч, үүрэг гүйцэтгэлийн эргэх холбоо сайжирч, дараагийн шатанд авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, төлөвлөлт тодорхойлогдоно.

Д/д	Эрс-дэлийн код	Тодорхойлсон эрсдэл	Матраал	Нөлөөлөл	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний санал	Нотломж
А. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл							
1	A1	Тусгай ажиллагааны газрын алба хаагчдын галт зэвсэг хэрэглэх талаарх хууль-эрх зүйн зохицуулалт байхгүйгээс албан үүргээ гүйцэтгэхийн төлөө алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдох /ГАТ/	5	4	20	Цагдаагийн албаны тухай хуульд болон бусад хууль тогтоомжид холбогдох өөрчлөлийг хийж, алба хаагчийн эрх ашгийг хамгаалах, галт зэвсэг хэрэглэх үндэслэлийг боловсронгуй болгох санал боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хурруулан шийдвэрлүүлэх	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
Б. Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл							
2	B1	Алба хаагчдын цалин хөлсийг амьжиргааны баталгаажих түвшин, ажлын ачаалал, хууль сахиулах байгууллагудын цалингийн сүлжээтэй уялдулж тогтоолоогүйгээс цагдаагийн алба хаагчийн хараат бус, бие даан шийдвэр гаргах, хэрэг, зөрчлийг шийдвэрлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, алба хаагч авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдох, албаны итгэл үнэмшил нь сулрах, хүний нөөцийн дутагдалд орох	5	5	25	Цагдаагийн алба хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	2017-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
3	B2	Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ын хэмжээнд хүрэхгүй байгаа, орон тоо хангалтгүйгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжтэй байдал алдагдах, алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх	5	5	25	Цагдаагийн алба хаагчийн дундаж цалин хөлс нь прокурор, тэнгүүний байгууллагаас 2 дахин, шүүгч, Авлигатай тэмцэх газрын алба хаагчдаас 3-4 дахин бага байна./	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

4	Б5	Цагдаагийн байгууллага Япон улсын "KENWOOD" маркийн 150-174 МГц давтамжтай, аналогий системийг 1996 оноос хойш 26 жил ашиглаж, ашиглалтын хугацаа дууссан бөгөөд эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж, БНХАУ-д дахин засварлагдсан, хямд радио станцаар бага хэмжээний нөхөн хангалт хийсэн боловч гэмтэл саатал их гарах, нийтийн хэрэглээний давтамж /150-174МГц/-аас Тусгай хэрэглээний давтамж /350-400МГц/-д шилжүүлээгүйгээс радио станцаар дамжидаж байгаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл алдагдах, үйл ажиллагааны саатал, дотогдол үүсэх /МДШУА/	5	5	25	Радио холбооны техник хэрэгслийг шинэчлэхэд шаардлагад төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх, төрийн байгууллагуудын цахим өгөгдлүүдтэй холбоход анхаарах, нууцлал аюулгүй байдлыг хангасан тоон технологийор шинэчлэх /Зардал 24.6 сая ам.доллар/	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан.
5	Б6	Серверүүдийн үйл ажиллагаа доголдох /МДШУА/	5	5	25	Техник, хэрэгслийг шинэчлэхэд шаардлагад төсөв, хөрөнгийг 5-8 жилээр урт хугацааны төсвийг шууд Улсын төсөвт заах өгөгдлөөр шийдвэр гаргуулж төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, мэргэжилтнүүдийн хүний нөөцийг тооцсон байх. Эрсдэлийг бууруулах чиглэлээр шаардлагад тоног төхөөрөмжийн зардлын тооцоог гарган, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, суурилуулж, тохируулах. "back up data бааз" үүсгэн серверийн хэвийн үйл ажиллагааг хангаж, урьдчилан сэргийлэх	2018-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан.
6	Б7	Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн сан, програми хангамжид, явцан тавих мониторингийн систем байхгүйгээс мэдээллийн аюулгүй байдал алдагдах /МДШУА/	4	5	20	Төсөв шийдвэрлүүлж, мониторингийн системийг нэвтрүүлэх	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

7	Б13	Алба хаагчид энгэрийн камергүй, тусгай хэрэгсэл, гар станцууд эвдрэл гэмтэлтэй, хувцасны шүүгээгүй, ажил тарах үедээ албаны хувцсаа сольж чадахгүй байна. Алба хаагчдын ажиллах орчин нөхцөл хангагдахгүй байгаа нь /албаны компьютер, бусад тоног төхөөрөмж, өрөө, тасалгаа хангалтгүй байдал/ бичиг хэргийн хангалт муу, өөрсдөө хувцасаа эд зүйл худалдаж авч албанд хэрэглэдэг, албан үүргээ гүйцэтгэх анхаарал төвлөрөл, ажлын бүтээмж хангалтгүй, алдаа Дутагдал гаргах, албаны нууцлал алдагдах /НХХЖОНАБХ/	5	5	25	Энгэрийн камер, хувцасны шүүгээ, компьютер, бусад тоног төхөөрөмж, шаардлагатай эд зүйлийн төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
8	Б14	Тайзны механизмын ашиглалтын хугацаа дууссан, штанкетын трос, олс, түжигч элэгдэлд орсноор ажил, арга хэмжээний үед эвдрэх, унах аюултай нөхцөл байдал үүссэн /Сүлд чуулга/	5	5	25	Тайзны механизмьг шаардлагын түвшинд яаралтай солиулах, засварлах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
9	Б15	Концертын их танхимд урдаг соёлын үйл ажиллагаа явуулахад, заалны дуу чимээний техник хэрэгсэл стандарт бус дуугаралт үзэгчдэд сонсох эрхтнээр дамжин тавгүй нөхцөл байдал үүсэх /Сүлд чуулга/	5	5	25	Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх, солих төсөв, хөрөнгийг шийдвэрлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
10	Б16	Мэргэн буудлагчийн галт зэвсэг, хэрэгслийг шинэчлэх, одоо ашиглагдаж байгаа галт зэвсэг байрдаа онцгой тусамгүй байгаа нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх /ТАГ/	5	5	25	Цэгдээгийн ерөнхий газрын төсөвт тусгах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
11	Б17	Буудлагын дадлага сургалтад ашиглах сум буудлагын хүрэлцээгүй, тогтмол буудлагын дадлага сургалт хийж чадахгүй байгаагаас шалтгаалан хуулиар хүлэсэн чиг үүргээ хангалттай гүйцэтгэхгүй байх /ТАГ, МБА/	5	5	25	Шаардлага сум галт хэрэглэлийн зардлыг Цэгдээгийн ерөнхий газрын төсөвт тусгах	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
12	Б22	Тус цагдаагийн газарт сүүлийн 10 жилийн хугацаанд 43 алба хаагчийн орон тоо нэмэгдэж, одоо нийт 156 алба хаагч, ажилтан үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд сургалт, хурлын танхимд алба хаагчид багтахгүй, албан тасалгааны хүрэлцээгүй байдал үүссэн. Алба хаагч, ажиллагсад, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, хөдөлмөрлөх, үйлчлүүлэх баталгаа алдагдах, иргэдийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх, алба хаагчдын ажлын бүтээмж буурах эрсдэлтэй. Цэгдээгийн газрын төв байр нь 1987 онд 60 алба хаагч ажиллах нөхцөлөөр баригдсан байна /Баян-Өлгий/	5	5	25	Барилга, байгууламжид шаардлага төсөв, хөрөнгийг шийдвэрлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
13	Б23	Хариуцсан нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг хөдөлгөөнт эргүүлчийн машины шатахууны хүрэлцээ хангалтгүй байгаа нь үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй /НЦУГ/	5	5	25	Шатахууны лимитийг бодитойгоор тогтоож, шаардлага төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

14	Б25	3 ээлжээр Үүрэг гүйцэтгэж байгаа жижүүр, харуулын болон Цогцэций сум дахь цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаа, жолоочийн орон тоонд бусад алба хаагчдыг дотоод зохион байгуулалтаар томилон ажиллуулж байгаа нь байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулах, ажлын ачааллыг үүсгэх (Өмнөговь, Сэлэнгэ-Сайхан ЦХ)	5	5	25	Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хэвийн ажиллах нөхцлийг бий болгох зорилгоор зарим шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх санааг, танилцууллыг аймаг, орон нутгийн удирдлага, ЦЕГ-ын удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх	2019-2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
15	Б26	Аймгийн цагдаагийн газрын орон тооны хүрэлцээ дутмаг, ажил, ачаалаас шалтгаалан ээлжийн амралтыг бүрэн эдлүүлдэггүй, улс оронд Үүссэн зарим нөхцөл байдлаас шалтгаалсан ажлын ачаалал хэт их зэргээс сэтгэл зүйн байдалд сөрөг нөлөө үзүүлж, ажлын үр дүн буурах, тогтвор суурьшилгүй ажиллах. /Сүхбаатар/	5	5	25	Орон тоог нэмэгдүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх. Алба хаагчдын ээлжийн амралтыг бүрэн олгох талаар тасгийн дарга нар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, ажлаа зөв оновчтой төлөвлөх.	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
16	Б29	Төвийн сүлжээний үндсэн төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан тул цагдаагийн байгууллагын болон дундлага, мэдээлэл хүлээн авах сүлжээний ажиллагаа зогсох эрсдэл. /МШУТ/	5	5	25	Сүлжээний төхөөрөмжүүдийн зардлыг шийдвэрлэх талаар дээд шатны байгууллага албан тушаалтнуудад танилцуулга хүрүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.	2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
/870.0 сая төг/							
В.Хэрэглээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл							
17	В1	Эрүүлжүүлэх, саатуулах байрууд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан "Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, Ерөнхий MNS 5527:2019 стандартыг хангахгүй байгаагаас иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох, байгууллага, алба хаагчийн нэр хүнд алдагдах, субъектив бус байдлаар гэм буруутгайд тооцогдох, хэвийн үйл ажиллагаа алдагдахад нөлөөлөх /Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ/	5	5	25	Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан "Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, Ерөнхий шаардлага" MNS 5527:2019 стандартад нийцсэн нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих асуудлыг судалж, төсвийн болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан

18	B3	Батлагдсан төсөв нь үнийн өсөлт /инфляц/-тэй өөрчлөгддөггүйгээс тухайн жилийн эцэст зарим төрлийн ажил, үйлчилгээ тасалдах, өглөг үүсэх /ЭкоЦА/	4	5	20	Төсвийн тодотголын төслийг үндэслэлтэй боловруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, эрх бүхий субьектүүдэд хүргүүлж, шийдвэрлүүлэх	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
19	B4	Төсөв, санхүүгийн хүрэлцээгүйгээс барилга, байгууламж, сүмдэн цагдаагийн, хасгийн, кобаны, барилгын засварыг цаг тухайд нь хийх боломжгүйгээс алба хаагчдын ажилгаж, амьдрах орчин, үүрэг гүйцэтгэх нөхцөл алдагдах, байгууллага, алба хаагчийн соёлд сөрөг үнэлэмжийг бий болгох Баян-Өлгий, Хэнтий/	5	5	25	Засвар үйлчилгээг тухайн бүр хийж, нутаг дэвсгэрийн байгууллагын дэмжлэгийг дунд хугацаанд авах төсвийн шийдвэрлэлтийг тооцон уламжилж шийдвэрлүүлсэн байх зэрэгт анхаарах	2020, 2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
Г.Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин хүчин зүйлсийн эрсдэл							
20	Г3	Байгууллагын барилга байгууламж нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн шаардлага хангахгүй, багтаамж хүрэлцэхгүй байх /Нийт 23 байгууллага/	5	4	20	Шинээр баригдах барилга, байгууламжийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар дээд шатны байгууллагад албан бичиг, хүсэлтийг дахин тооцон хүргүүлж шийдвэрлүүлэх	2021, 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайлан
						Дотоодын цэргийн анги, байгууллагын данс бүртгэлтэй барилга байгууламжид хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг гаруулах	

-2021, 2022 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын цагдаагийн байгууллагын дотоод хяналтын ICS программд шивж оруулсан нийт 3299 эрсдэлийн мэдээлэл, 2022 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нийт **49** бүлэг нэгжээс үнэлж, дүгнэж ирүүлсэн эрсдэлийн үнэлгээний тайлан мэдээг үндэслэн тооцож үнэлэв.

-“Ач холбогдлын зэрэг”-ээрээ “Их” буюу “Эрсдэлийн тоон түвшин”-ээр 20-25-аар үнэлэгдсэн нийт **41** эрсдэлийг сонгон авч жагсаалтад оруулснаас 20-оор үнэлэгдсэн 14, 25-аар үнэлэгдсэн **27** эрсдэл нөхцөл байдал байгаагаас ХЗДХЯ, дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх боломжтой **20**, байгууллагын дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч шийдвэрлэх боломжтой **21** эрсдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

Байгууллагын дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч шийдвэрлэх боломжтой		Шийдвэрлэх арга хэмжээний санал	
		ХЗДХЯ, дээд шатны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх боломжтой	
Эрсдэлийн түвшин	20	Б3, Б10, Б11, Б12, Б20, Б24, Б27, Б28, В2, Г4 /Бүгд-10/	А1, Б7, В3, Г3, /Бүгд-4/
	25	А2, Б4, Б8, Б9, Б18, Б19, Б21, Б30, В5, Г1, Г2 /Бүгд-11/	Б1, Б2, Б5, Б6, Б13, Б14, Б15, Б16, Б17, Б22, Б23, Б25, Б26, Б29, В1, В4 /Бүгд-16/
НИЙТ		21	20

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

A hand is shown from the bottom, holding a glowing digital network structure. The network consists of white nodes connected by thin white lines, with some nodes emitting a bright blue glow. The word "AUDIT" is written in large, white, outlined capital letters across the center of the network. The background is a dark blue gradient with vertical light streaks.

AUDIT